

П.Одсүрэн, Д.Туяа,
Д.Цэвээндорж, П.Нармандах

УРАН ЗОХИОЛ

IX

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
9 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

DDC 74.2
HAA 373
У-457

Уран зохиол IX: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 9 дүгээр ангийн сурах бичиг. /Одсүрэн П., ба бус; Ред. Дулам С. -УБ. 2017. - 148х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-13-9

ГАРЧИГ

Сурах бичгийн агуулга 4

Бүлэг I. СОНГОДОГ УРАН ЗОХИОЛ

5

1. ЭРТНИЙ ТУУЖ

Гэсэр	6
Жангар	18
Чингисийн эр хоёр загалын тууж	29

Бүлэг II. ЯРУУ НАЙРАГ

39

2. СОНГОДОГ ЯРУУ НАЙРАГ

Сөнидийн Гилүгэдэй баатрын харууслын шүлэг	40
Мандухай сэцэн хатны тангаргийн шүлэг	44
Цогт тайжийн хадны бичиг	48

3. ОРЧИН ҮЕИЙН ЯРУУ НАЙРАГ

Б.Лхагвасүрэн “Боржигины бор тал”	56
Д.Нямсүрэн “Дөрвөн цаг”	65

Бүлэг III. ХҮҮРНЭЛ ЗОХИОЛ

75

4. ТУУРЬ, ӨГҮҮЛЛЭГ

Б.Ринчен “Нууцыг задруулсан захиа” (туурь)	76
Ж.Лхагва “Эвэр” (богино өгүүллэг)	88

5. ТУУЖ, РОМАН

Д.Мягмар “Үер” (туужаас)	94
Д.Цэдэв “Улаан хамбан зодогт буюу тавын даваа” (туужаас)	102
Ч.Лодойдамба “Алтайд” (бэсрэг романаас)	112

Бүлэг IV. ЖҮЖГИЙН ЗОХИОЛ

115

6. ЭНЭТХЭГИЙН ЖҮЖИГ

Шри Галидас “Шакундалааг таних тэмдэг”	130
--	-----

Сурагчийн лавлах 146

Ном зүй 148

Сурах бичгийн агуулга

ЧАДВАР	Бүлэг	I. Сонгодог уран зохиол	II. Яруу найраг		III. Хүүрнэл зохиол		IV. Жүжгийн зохиол
	Суралцахуйн зорилт	1	2	3	4	5	6
	Агуулга						
УНШИХ	Соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээн авах						
	Өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлах						
	Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх						
	Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэх						
	Орчин, нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг дүгнэх						
	Уран дүрийн үгийн сан, уран дүрслэл (бэлгэдэл)-ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах						
	Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, бадаглалын туршлагыг шинжлэх						
БИЧИХ	Зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих						
	Зохиолын сэдэв, утга санаа, дүр дүрслэлээс сонгон, баримт жишээ ашиглан, үнэлж дүгнэж бичих						
	Дүр, орчныг хувирган, үйл явдлыг төгсгөн, богино өгүүллэг зохион бичих						
СОНСОХ - ЯРИХ	Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх						
	Бие даан уншсан зохиолыг бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой арга хэлбэрээр танилцуулга бэлтгэж ярих						



СОНГОДОГ УРАН ЗОХИОЛ

Энэ бүлгээс бид ямар чадвар эзэмших вэ?

- ❖ Монголын эртний туужаас уншиж, утгыг ойлгон унших
- ❖ Зохиолын үйл явдал, дүр, сэдэв, санаа, хэл найруулга, орчин нөхцөлийг судлан, холбоо хамаарлыг тайлбарлах, дүгнэх
- ❖ Санаагаа товч тодорхой, эмх цэгцтэй, илэрхийлж сурахын тулд зохиолын хэл, найруулгаас суралцах
- ❖ Асуудлыг олон талаас харж, дүгнэх чадвараа хөгжүүлэн, үзэл бодлоо жишээ баримттай илэрхийлэх



1. ЭРТНИЙ ТУУЖ

“ГЭСЭРИЙН ТУУЖ”

Уншихын өмнө:

1. Зохиолыг уншихын өмнө дараах асуултын дагуу ярилцаж, санал бодлоо солилцоорой.
 - А. Тууль хайлах талаар юу мэдэх вэ?
 - Б. Баатарлаг тууль гэж ямар туулийг хэлдэг вэ?
 - В. “Гэсэрийн тууж”-ийн талаар юу мэдэх вэ? Бид яагаад мэдэх ёстой вэ?
 - Г. Туулиас юуг тусган хүлээн авч, амьдрал ахуйдаа хэрэглэж болох вэ?
 - Д. “Гэрээ мартсан Гэсэр” гэсэн хэлц үг ямар утгатай вэ?
2. Туулийн тухай дараах мэдээллийг уншаад хамгийн сонирхолтой санагдсан зүйл юу байсан, яагаад? гэдгийг хосоороо ярилцаарай.

Ардын аман зохиолын хамгийн том төрөл нь баатарлагийн тууль юм. Туулийн агуулгад ардын аман зохиолын бусад төрөл зүйл (зүйр цэцэн үг, ерөөл, магтаал, дуу, домог гэх мэт) орсон байдаг онцлогтой.

Тууль хэлдэг аман зохиолчдыг туульч гэдэг. Туулийг товшуур, морин хуурын аялгуунд аялан хэлэхийг “тууль хайлах” гэнэ.

“Монгол ардын баатарлаг тууль бол овог аймгийн хамт олны ялагдашгүй хүч, сайн сайхан шинж чанар мөрөөдөл хүслэнгийн биелэл болсон агуу их баатрын гавьяат үйлс, ололт ялалтыг хайлан хүүрнэсэн төгөлдөр их бүтээл” (*Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв “Монгол ардын аман зохиол”. УБ., 1988, 233 дугаар тал*)

Ц.Дамдинсүрэн “Гэсэр хааны тууж” гэдэг гайхамшигт үлгэр нь Ганга мөрнөөс сэрүүн Сибирийн Амар мөрөн хүртэл, өмнө зүгийн Хатаны голоос хойд хязгаарын Зүлэг мөрөн хүртэл уужим их нутагт түгээмэл дэлгэрчээ. Энэ туужийг Төв Азийн үлгэрчид эрт балар цагаас одоо хүртэл хуурдан дуулсаар ирсэн байна... Ард түмэн гайхамшигт баатар Гэсэр ба түүний хатан Рогмо, гучин баатрыг сонирхож, урвагч Цотон ноёноос жигшиж, бичигтэй нь уншиж, бичиг мэдэхгүй нь сонсож өвлийн урт шөнийг өнгөрөөж байжээ” (*Ц.Дамдинсүрэн, Д. Цэнд “Монголын уран зохиолын тойм” II, УБ., 1977, 5 дугаар тал*)

“Гэсэрийн үйл явдал эхлэхийн гол учир шалтгаан бол ертөнцийн цаг самуун болоход Хурмаст тэнгэр өөрийн дунд хүү Үйл бүтээгчийг доод замбуутивд илгээсэнтэй холбоотой. Энэ нь сонгодог домог зүйн өгүүлэмж (motif) бөгөөд Төв Азийн домог зүйн сан хөмрөгт ч хамаарна. Тэнгэрээс газарт буусан тэнгэр гарвалтны тухай хамгийн сонгодог өгүүлэмж (motif) бол Гэсэрийн туужийн домог зүйн удиртгал мөн билээ” (*С.Дулам “Монгол Гэсэрийн туужийн домог зүйн удиртгал, өгүүлэмжийн бүтэц”. “Монгол судлалын чуулган” УБ., 2017, №22, 123-126 дугаар тал*) гэх мэтээр судлаачид үнэлсэн байна.

Монголын ард түмний соёлын гайхамшигт өв болсон “Гэсэр” тууль нь анх 1716 онд Бээжинд модон бараар барлан хэвлэсэн 7 бүлгээс гадна бичмэл Гэсэрийн олон хувилбартай байдаг юм. Академич Ц.Дамдинсүрэн тэдгээрийг нэгтгэн сонгомол эхийг 9 бүлэгтэйгээр боловсруулж 1986 онд кирил үсгээр хэвлэжээ.

1. Гэсэрийн туужийн агуулгын хураангуй болон 5 дугаар бүлгийн хэсэглэлийг уншина уу. Зохиолыг бүрэн эхээр нь уншсанаа сэргээн санаарай.

“Гэсэрийн тууж”-ийн товч агуулга

1. Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит богд Гэсэр мэргэн алдаршин дуурссан тэргүүн бүлэг

Эрт нэгэн цагт Шигэмуни бурхныг нирваан дүр үзүүлэхийн урьд Хурмаст тэнгэр Бурханд мөргөө гэж очив. Хүрч мөргөсний хойно Бурхан Хурмаст тэнгэрт зарлиг болов. “Таван зуун жил болсны хойно ертөнцийн цаг самуун болох буй. Гэртээ харьж таван зуун жил болоод гурван хөвгүүнийхээ нэгийг илгээ. Тэр ертөнцийн хаан тэр болтугай. Хүчтэн нь хүчгүйгээ барьж идэх буй. Гөрөөс өвөр хоорондоо нэг нэгээ барьж идэх буй...” гэв. “Таван зуун жил жаргалдаа ташуурч суув, чи. Миний зарлигаар үтэр илгээгээрэй” гэв. Хурмаст тэнгэр “Зөв” гэж харьж ирэв. Ирсэн хойноо Хурмаст тэнгэр, бурхны зарлигийг мартаж долоон зуун жил болтол суув.

Сууж байтал Сударсун балгасын их хотын баруун өнцөг нь нэгэн түмэн бээрийн газар эвдрэв. Хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр нар хамаг зэр зэвсгээ авч “Энэ хотыг хэн эвдэв? Бидэнд өшөөт дайсан үгүй билээ. Асур нарын цэрэг эвдэв үү, үүнийг?” гэж хотынхоо эвдэрсэн зүгт очив. Очиж үзэхэд нь хот нь өөрөө эвдэрсэн ажээ. Хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр нар бүгдээрээ ярилцав. Өвөр зуураа: “Энэ хот юунд эвдрэв?” гэж ярилцаж байтал Хурмаст тэнгэр санав: “Шигэмуни бурхныг нирваан дүр үзүүлэхийн урьд мөргөө гэж очиж билээ, би... Би мартаж, жаргалдаа ташуурч, таван зуун жилээс илүү долоон зуун жил илүү сууж байна, би” Хурмаст тэнгэр Үйл бүтээгч гэдэг хүүгээ Замбуутивд явуулж байна.

Хурмаст тэнгэрийн хөвгүүн Үйл бүтээгч тэнгэрээс бууж Төвөдийн Лин оронд Сэнлон ноёны хөвгүүн Гэсэр болж төрөв. Гэсэрийг төрмөгц аав нь Жур гэдэг нэр өгчээ. Лин орны төрийн эрхийг барьж байсан Цотон ноён Гэсэрийн эцэг эхийг түүнийг тэнгэрээс буухаас өмнөхөн хойт хязгаарын элсэн цөл газар хөөж явуулсан үе тул тэр эхээс төрөхдөө хар овоохойд төрж ядуу зүдүү амьдарч байсан. Гэсэрийг төрснөөс хойш өвсгүй газар өвс ногоо ургаж, элсэн цөлд ус булаг урсаж байв. Гэсэр хувилгааны чадлыг гаргаж өвсөөр цохиж, мал сүргээ өсгөн үржүүлж элбэг амьдрах болсон. Гэсэр, Лин орны ноён авга Цотонтой тэмцэж ялаад тус орны хаан болов. Гэсэр үзэсгэлэнт сайхан Рогмо гоо, эрэлхэг дайчин Ажу мэргэн, Арлан гоо (Түмэнжаргалан) нарыг гэргий болгож авав. Долоон албиныг дарж, нутаг орноо амаржуулав.

2. Арван таван насандаа арван зүгийн эзэн Гэсэр хаан гучин баатраа дагуулж умар зүг дэх уулын чинээ хар эрээн барс мангасын хувилгааныг алсан нөгөө бүлэг

Тэр цагт умар зүгт Мангасын хувилгаан уулын чинээ хар эрээн барс байжээ. Байх бие нь зуун бээрийн газрыг эзлэх ажээ. *[Өндөр нь их гэсэн уулаас үлэмж их гэнэ. Сүүл нь таван зуун алдын хар болд илд шиг хоёр иртэй, ийш тийш шарвахад тэнгэрийн цахилгаанаас нэн үлэмж гэнэ.]* Баруун самсаанаас нь гал мандан шатаж, зүүн самсаанаас нь утаа бургилж байна. Хүнийг хоногийн газраас үзээд үдийн газраас өрөвхийж залгина гэнэ. Гэсэр гучин баатартайгаа явж, хүн иддэг хар эрээн барсыг алж, арьсаар нь хуяг дуулганы гэр хийв.

3. Хятадын Гонма хааны төрийг зассан гутгаар бүлэг

Хятадын Гонма хааны хатан нь нас баржээ. Хаан гашуунд дарагдаж "Боссон хүн боссоор уйл. Суусан хүн суусаар уйл..." гэж зарлиг буулгав. Ард олон нь их зовж байв. Энэ үед тэр хааны долоон хожгор дархны их ах Саваагүй сахруу хожгор нь "Арван зүгийн эзэн ачит Гэсэр мэргэн хаан сэргээж эс чадвал түүнээс өөр хэн чадах билээ" гэж хэлсэн байдаг. Тийн Гэсэрийг аваачдаг. Гэсэр эрдэм чадлаа гаргаж хааныг нь унтуулж, хатныг нь салгаж авч, орон даяар зарласан уй гашууг тайлна. Хятадын хаан хилэгнэн Гэсэрийг хорлох гэсэн боловч Гэсэр амь гарч, Гонма хааны охин Гүнэ гоог хатан болгож аваад нутагтаа буцав.

4. Арван зүгийн эзэн Гэсэр хаан арван хоёр толгойтой мангасыг аливаа төрөлтэй нь тасалж, Арлан гоо хатнаа авч, алтан суваргын дэргэд амарлин суусан дөрөвдүгээр бүлэг

Гэсэр хааны бие чилээрхэв. Цотон ноён Арлан гоод золгоод: "Ай хайран сайхан бэр минь. Арван зүгийн Гэсэр хаан гэж чамд сүүдрээ үзүүлж явна, тэр. Хятадын Гонма хааны төрийг засаж Гүнэ гоог авч гурван жил сууж ирэв. Одоо Рогмо гоогийн дэргэд сууна. Чамд ирэхгүй байна. Цааш харвал түмэн хүн инээх мэт ийм өнгө дүртэй хайран авай минь чи зовж байна. Чамайг би авъя" гэв. "Эвүү, эвүү. Цотон авгай минь, энэ чинь ямар үг вэ? Түмэн Цотон ноён хурж ирэвч ганц шөнийн Гэсэрийн минь зүүд, сүүдэр хоёртой тэнцэж чадахгүй. Энэ үгийг чинь дээр Хөх мөнх тэнгэр сонстугай. Доор хөрст алтан дэлхий Этүгэн эх сонстугай. Хөдлөх амьтан бүгд сонсвол чих нь дүлийртүгэй, нүд нь тэсэртүгэй. Амлаж үл болох үг энэ чинь. Дуугүй сууж, цай шөл зооглож харь" гээд их хурим өглөг өгч явуулав.... Рогмо гоо, Цотон хоёул Арлан гоод элч илгээв. "Гэсэр хаан чилээрхэж байна. Хамаг улсад өвчин тахал чамаас болж гэнэ. Чи явбал Гэсэрийн чилээ сайн болох гэнэ. Үгүй болбол муу гэнэ" гэж хэлэв. Элчид Арлан гоо: "Үгийг чинь мэдэв, би. Энэ нүгэлт үйл Цотонгийнх буй заа. Гэсэр минь намайг үл хөөх билээ. Рогмо, Цотон хоёр намайг хөөж байна. Би явъя. Эрхт мөнх тэнгэрийн хөвүүн эзэн Гэсэр хааны минь чилээ сайн болтугай. Энэ өдөр миний зовсноор юу дутах. Эртний ерөөлийн хүчин болбол эргэж авахаа тэр мэднэ биз" гээд Арлан гоо явав. Арлан гоо гашуудаж, зовж зүдэж явсаар арван хоёр толгойт мангасын эхнэр болов. Гэсэр хаан өвчнөөс эдгээд, Арлан гоо хатнаа нэхэж, мангасын оронд очоод түүнийг сөнөөв. Арлан гоо хатан Гэсэрт алтан аяганд баг нэрт хар өнгөт идээг хийж барив. Гэсэр түүнийг зооглоод аливаа бүгдээ мартан, есөн жил жарган суув.

5. Шарайголын гурван хааны төрийг авсан тавдугаар бүлэг (хэсэглэл)

Лин оронтой зэргэлдээ байдаг Шарайгол оронд Цагаан гэрт, Шар гэрт, Хар гэрт гэж гурван хаан байжээ. Тэр цагт Шарайголын гурван хаан чуулган чуулав. Чуулгандаа Цагаан гэрт хааны Цагаан эрх хатнаас төрсөн Алтангэрэлт тайжид ийм сайхан авгай хаанаас авч өгье гэж чуулган чуулуулав. "Энэ ахуйн хаадын охидыг тоолж үзье" гэв. "Хүн, морь явж хүрэхгүй" гэж цагаан харцагыг туулайн махаар бордож, "Дээд тэнгэр нарын охид сайхан уу? Үзэж ир!" гэж илгээв. Уран дуут тотийг хорхойгоор бордож, "Хятадын хааны охин сайхан уу? Үзэж ир!" гэж илгээв. Үзэсгэлэнт тогосыг жимсээр бордож, "Балбын хааны охин сайхан уу? Үзэж ир!" гэж илгээв. Үнэгийг шир шөрмөсөөр бордож, "Энэтхэгийн хааны охин сайхан уу? Үзэж ир!" гэж илгээв. Хон хэрээг муу сайн идээгээр бордож "Төвөдийн хааны охин үнэн сайхан уу? Үзэж ир!" гэж илгээв. Чингээд тэд бүгд явав... Хон хэрээ гурван жил болтол эс ирэв. Хойд жил нь ирэв. "...За Төвөдийн газарт арван зүгийн эзэн ачит богд

Гэсэр мэргэн хаанд хүрэв, би. Хатны эцэг нь Жало хаан гэнэ. Түүний хатан Рогмо гоо гэж байна. Рогмо гоогийн босоо бие нь ургамал нарс модыг ханхуй нэрт магнаг торгоор бүрсэн мэт. Суугаа бие нь таван зуун хүн суух орд цагаан гэр мэт. Баруун мөрөн дээр нь алтан шумуул эргэж байна. Зүүн мөрөн дээр нь мөнгөн шумуул эргэж байна. Баруунтаа наранд суувал хайлах мэт. Зүүнтээ сарны сүүдэрт суувал царцах мэт. Шөнийн гэрэлд нь зуун мянган агт манах мэт. Ийм цаглашгүй сайхан байна... Гэсэр хаан эзгүй. Арван хоёр толгойтой мангасаас Арлан гоо хатнаа авахаар нэхэж явсаар ирээгүй гэнэ. Дээд тэнгэр нар, дунд Асур нар, доор Лусын хаад эд гурвуулын охид байх боловч Рогмо гоотой тэнцэх нь үгүй байна" гэв. Шарайголын гурван хаан Рогмо гоог булааж авах гэж байлдсан боловч амжилт муутай байв. Гэтэл Цотон ноён Шарайголын гурван хааныг тосож байлдаад олзлогдов. Цотон ноён Шарайголын гурван хаанд урваж хуйвалдаад нутагтаа ирж "Шарайголын цэргийг ухарч буцав" гэж худал хэлээд Гэсэрийн баатруудыг тараав. Шарайголын гурван хаан, Цотон ноёнттой хэлэлцэж тогтсон ёсоор гэнэт дайрч Лин орныг эзлээд Рогмо гоог булаан авч, Цотон ноёныг Лин орны ноён болгов. Энэ тулалдаанд Алтангэрэлт тайж Ажу мэргэн хатны харвасан суманд оногдож алагдана.

...Рогмо гоо, Цасын нэгэн суманд бичиг бичив. Бичихдээ: "Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит богд Гэсэр мэргэн хаан минь! Үхэв үү, чи? Хэрвээ үхсэн бол яана, би? Амьд бол зургаан насан дээр учирсан Жало хааны охин Рогмо гоо би, Цас Чихэр тэргүүлэн гучин баатар чинь арван гурван эрдэнэт сүм чинь, цагаан суварга, чандмань эрдэнэ чинь алтаар бичсэн Ганжуур, Данжуур хоёр хөлгөн ном чинь эд бүгдээсээ хагацав уу, Гэсэр минь? Тулалдаж үхэв, гучин баатар чинь. Уулганд дайрагдаж баригдав, би. Ай Богд минь! Ирж өшөөгөө ав" гээд сумаа хувилгаанаар илгээв. Илгээсэн сум нь Гэсэрийн суух мангасын хотонд Гэсэрийн ховдонд тусав. "Эвүү, ховд минь юунд хангир хийв? Арлан гоо ховдыг минь өг" гэв. Арлан гоо ховдыг өгөв. Гэсэр хаан ховдоо нээж үзэв. Үзээд Цасын сумыг танив. "Эвүү, эвүү! Энэ Цасын минь сум байна" гээд бэлэг бичгийг үзэв. "Үнэхээр Рогмо гоо минь, эрдэнэт Цас Чихэр, гучин баатар минь, эд бүгд минь бий билээ. Би яагаад мартав? Тэд бүгдэд минь дайсан ирээд байна. Над хэн хүн халдсан бол түүний элгэнд тус" гээд сумыг зүлгэж гэдрэг илгээв. Гэсэрийн илгээсэн сум Цагаан гэрт хааны Эрх хатны элгэнд тусав. Хатан үхэв. Гурван хааны цэрэг бүгдээрээ хэний сум болохыг хэлэлцэж, айн дутаав. Рогмо гоогийн дотор баясах сэтгэл төрөв. Арван зүгийн эзэн Гэсэр хаан амьд байна. Илгээсэн сум нь нэгэн өшөөт хүнд тусаж алав. Рогмо гоо, мөн тэр суманд бас бичиг бичив.

...Сумыг илгээсний хойно Арлан гоо: "Аюух мэт богд минь, өлсөв үү?" гээд мартуулах баг хар идээг өгөв.

...Рогмо гоо хэлэв: "Авай богддоо энэ сумыг аль бүр илгээх вэ, би?" гэж сумаа илгээхээ байв.

...Гэсэр хаан хойд өдөр нь бас хотын асар дээр гарч суутал Гэсэрийн Амин сахигч ах нь хэрээ болж хувилаад очив. Үдийн цагт баруунтаагаас нэг хэрээ нисэж айсуу. Арван зүгийн Гэсэр хаан тэр хэрээг үзээд угтаж зарлиг болов: "Ай хөөрхий, энэ хэрээ нутгийн баас шээс, тэмээний даарь бээр олж идье гэж яарч явна" гэв. Хэрээ хэлэв: "Арван зүгийн Гэсэр хааны энэ зарлиг зөв. Төрсөн газар минь хотын зүүнтээх суварга билээ. Баруунтаа идээшлэхээр очиж билээ. Би идэш олоод хоносон газраа хоноё гэж ирэх минь энэ. Энэ замбуутивийн эзэн Гэсэр хаантай адил амандаа шавар чихүүлсэнгүй, би. Төрсөн Төвөдийн газар чинь, хувилгаанаар авсан Рогма гоо чинь энд бий юу? Рогма гоо хатан чинь, Цас Чихэр тэргүүлэн

гучин баатар чинь, эрдэнэт Нанчүн чинь тэд бүгд чинь хаана байна? Эд бүгдийгээ алуулахыг алуулаад, авхуулахыг авхуулаад, ай намайг элэглэвч гайгүй ажээ" гээд нисээд явав.

Гэсэр хаан зарлиг болов: "Эвүү, хэрээний үг нь үнэн байна. Би яагаад мартлаа?" гээд гэртээ гүйж оров. Арлан гоо хэлэв, бас урьд ёсоор: "Аюух мэт Богд минь өлсөв үү?" гээд баг идээгээ өгөөд мартуулав. Гэсэр хааны гурван эгчийн сахиус гурван тогоруу шувуу болон ирж, огторгуйгаар эргэж үзэв..."Эвүү, Гэсэр хаан минь үхэв үү, яав? Хэрвээ үхээгүй бол энэ бичгийг минь түүнд өгөөрэй. Тэр минь мэднэ" гээд тогорууны хүзүүнд уяж өгөв. Тогоруу төдий явж Гэсэр хааны суух хотод хүрэхэд Арлан гоо Гэсэр хаан хоёул хотын асар дээр сууж байв. Арлан гоо Гэсэр хааныг гарвал гарч, орвол орж Гэсэрийн нутгаа санахыг мэдэж гэтэж явах ажээ. Тогоруу огторгуйгаар эргэцэж явах зуур санав: "Энэ бичгийг минь Арлан гоо үзэх байна. Гэсэр хааныг минь Арлан гоо арга хийж үл явуулах байна" гэж мэдээд хувилгаанаар мөндөрт бороо оруулав. Арлан гоо бороо ороход гэртээ гүйж оров. Гэсэр хаан өвөр дээрээ унасан рашааны нэгэн мөндрийг авч залгиад баг идээгээр бөөлжив. Тогоруу ирээд хүзүүн дэх бичгээ орхиж, өгөөд одов. Гэсэр хаан бичгийг үзээд: "Эрдэнэт Цас Чихэр, гучин баатар, Рогмо гоо гэж бий билээ л. Ай яаж мартлаа?" гэж дуу гаран хайлав.

Гэсэр хааны билгийн хээр морь нь Гэсэр хаанд аливаа юм тоолж хэлэхийг нь Арлан гоо мэдэж арвай буудайгаар аргадан тэжээж их мухар битүү байшинд оруулж төмөр чөдрөөр чөдөрлөж, төмөр ногтоор ногтолж, аварга модноос уяж, зарим өдөр өвс ус өгч, зарим өдөр хоосон хорьж байв. Гэсэр хааныхаа уйлах дууг сонсоод билгийн хээр морь уураа багтаан ядаж төмөр чөдрөө тас тийрч, төмөр ногтоо тас татаж, битүү байшингийн хаалтыг хага түлхэж гарч, Гэсэрт гүйж очиж уйлан үг хэлэв. Гэсэр мартсанаа сэрж, Арлан гоо хатны хамт нутагтаа ирэв. Шарайголын гурван хааныг сөнөөж, Рогмо гоо хатнаа аваад, Цотон ноёныг шийтгэж, нутаг орноо тохинуулав.

Дараа нь Гэсэр Шарайголын Цагаан гэрт хааныд очиж Олзвой нэртэй хөвгүүн болж хувилгаад, Чоймсон гоо охинтой холбоо тогтоож түүгээр дамжуулан Цагаан гэрт хааны элдэв шид чадлыг мэдэж аваад түүнийг улмаар устгаж доройтуулсны дараа Гэсэр чухам биеэр хувилж, Шарайголын гурван хааныг сөнөөж, Рогмо гоо хатнаа аваад нутагтаа буцаж ирэв.

6. Арван зүгийн эзэн Гэсэр хаан арслан мэт гучин баатраа эдгээж аваад ахуй бүгдээ төгсгөж амгалан жарган суусан зургаадугаар бүлэг

Гэсэр нутагтаа ирээд сүйдсэн орноо сэргээн тохинуулав. Гэсэр хаан Шарайголын байлдаанд алагдсан баатруудынхаа хүүр дээр ирж гашуудан уйлав. Гэсэрийн хувилгаан гурван өхий (эгч) нь явж Хурмаст тэнгэрт очиж хүн амьдруулах рашааныг олж ирэв. Гэсэр тэр рашааныг алагдсан баатруудын ясан дээр дусааж баатруудаа сэргээн амьдруулав. Бүгдээр уулзаж, баярлан цэнгэв. Гагцхүү Цас Чихэр тэнгэрт төрсөн тул тэндээ үлдэв.

7. Арван зүгийн эзэн Гэсэр хаан Аваргасын хаан Нандуламыг доройтуулсан долоодугаар бүлэг

Гэсэрийн харьяат таван муж улсаас элч ирж, тэднийг Нандулам хаан эзлэв гэж мэдээлэв. Гэсэр Нандулам хаантай байлдаад ялав. Энэ байлдаанд Гэсэрийн ах Цас Чихэр тэнгэрээс бууж ирээд Гэсэрт туслав.

8. Арван зүгийн эзэн Гэсэр хаан, мангасын хувилгаан ламыг дарсан наймдугаар бүлэг

Нэгэн мангас лам болж хувилаад, хоёр шавиа дагуулж Гэсэрийн оронд ирэв. Рогмо гоо ламаас авшиг ав гэж Гэсэрт хэлэв. Лам, Гэсэрт муу увдусаар адис тавьж Гэсэрийг илжиг болгож хувилгав. Тэгээд тэр мангас Рогмо гоог авч хариад илжгээр олон таар будаа тээрэмдэж зовоож байв. Гэсэрийн Ажу мэргэн хатан мангасын эгч болон хувилж очоод илжгийг гуйж авав. Хурмаст тэнгэр тэр илжгийг рашааны хүчээр Гэсэр болгож хувилгав. Гэсэр мангасыг сөнөөж Рогмо гоо хатнаа авч нутагтаа ирэв.

9. Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит Богд Гэсэр мэргэн хааны хамаг дайсныг доройтуулж, хамаг амьтныг жаргуулсан есдүгээр бүлэг

Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит богд Гэсэрийн илжиг болоод мангаст зарцлагдаж байх үест ээж нь санаа зовж бэтгэрсээр үхсэн байв. Гэсэр хаан эхийнхээ сүнсийг олох гэж дээд тэнгэрт гарч сураглан явсаар эс олдог. Гэсэр тамд очиж Эрлэг хааныг зодож шийтгээд эхийн сүнсийг тамаас гаргаж авдаг. Эхийнхээ сүнсийг олмогцоо гурван эгчдээ хүргэж, гурван эгч нь хурмастын тэнгэр ахайд аваачиж өгчээ. *(Товчлон авае)*

Эх сурвалж: Ц.Дамдинсүрэн “Гэсэр” УБ., 1986

Үгийн тайлбар:

Шигэмуни буюу Шагхамуни - Шагжа нь бурхан багшийн овог, мүни нь чадагч, дийлэгч гэсэн утгатай үг ажээ. Бурхан шашны номлол ёсоор энэ ертөнцөд сайн цагийн мянган бурхан ирэхээс эдүгээ бидний амьдран байгаа энэ цагийн бурхан нь Будда Шигэмуни гэдэг.

(Ш.Чоймаа нар “Монгол хүний нэрийн толь” УБ., 2013)

Хурмастын Сударсун балгас- Нэжгээд нэжгээд талдаа хоёр зуун тавин бээр бөгөөд дээш тэнгэрийн балгадаас хагас лугаа таван бээр мандсан дөчин баганатай, дотроо урт өргөн нь тус бүр тавин бээрээр хүрээлсэн ялгамжит цөөрөм сэлт байх болой.

(Д.Энхтөр “Монголын бурхан шашны түүхэн сурвалж”, УБ., 2004)

Асур нар - Хэдий тэнгэр мөн боловч башир хуурмаг ихтэй болоод тэнгэрийн эрдмийг үнэхээр авч оршдоггүй тул “тэнгэр бус” буюу “асури” хэмээн нэрлэсэн. *(Эх сурвалж: www.budda.mn)*

Хурмаст тэнгэр - Гучин гурван тэнгэрийн эзэн тэнгэр

Бээр - 1. Газрын хол ойрын хэмжээ; 1,5 -2 км зай;

2. Яр шархны идээр, ялзармаг

Даарь - Морь, малын нуруу зэргийн нухагдан гарсан яр шарх

Замбуутив - 1. [шашин] Бурхан шашны ном сударт өгүүлдэг дөрвөн тивийн нэг;

2. Манай дэлхий ертөнцийн нэр, замбуулин

Албин - Үлгэр домогт гардаг нэгэн зүйл ад чөтгөр *(Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>)*

Соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээн авъя

1. Гэсэрийн туужид байгаа хам сэдвийн утгыг дүгнэж, түүгээр дамжуулсан далд утгыг тайлбарлаарай. Жишээ нь: Нийгмийн ямар асуудлыг дүрсэлсэн байгааг дүгнэхдээ туулийн зангилаа нь “Хүний ертөнцөд хүчтэн нь хүчгүйгээ барьж идэж, гөрөөс хүртэл өөр хоорондоо нэг нь нэгийгээ барьж идэх болсноос

Хурмаст тэнгэр нэг хүүгээ газарт илгээж тэр үймээн самууныг даруулах болсон” гэснээс эхлээд тухайн нийгэмд ямар ямар бусармаг үйл явдал өрнөж, жирийн ард түмний амьдралд саад болсон. Тэр бүхнийг Гэсэр амар тайван болгож байгаа нийгмийн хам сэдэв дүрслэгдсэнийг тайлбарлах

Мөн

- Шашны хам сэдэв
 - Соёлын хам сэдвийг тайлбарлаарай.
2. Тавдугаар бүлгийн хэсэглэлийг уншаад үйл явдал нь 4 ба 6 дугаар бүлгийн үйл явдалтай хэрхэн холбогдож байгаа болон нийгмийн хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь: 4 дүгээр бүлэгт Гэсэр Арлан гоо хатнаа олж авчрахаар яваад эзгүй байсан үед тавдугаар бүлгийн үйл явдал өрнөж байна. Энэ нь...
 3. Тавдугаар бүлгийн үйл явдлыг товч төлөвлөгөө болгон бичээд, энэ бүлгийг уншаад ямар сэтгэгдэл төрж байгааг хэсэг тус бүрд бичээрэй. Жишээ нь:

1. Хон хэрээ элчийн мэдээ	2. Шарайголын хаад ганга шувууг илгээв.	3.
[Сэтгэгдэл]	[Сэтгэгдэл]	[Сэтгэгдэл]
Шувуу хүний хэлээр ярьж, бас гурван тивийг туулан хүүхнүүдийн сайн сайхныг танин мэдэж, хамгийн сайхан үгээр дүрслэн хэлж байгаа нь их сонин, үлгэр уншиж байгаа юм шиг сэтгэгдэл төрүүллээ гэх мэт.

Өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлая

1. Эх зохиолоо бүрэн уншиж, нэгдүгээр бүлгийн 20-22 дугаар хэсгийн үйл явдлын өгүүлэгдэхүүний бүтцийн дарааллыг гүйцээн бичээд, өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргыг олж тайлбарлаарай.

№	Өгүүлэгдэхүүний бүтэц	Нэгдүгээр бүлгийн 20-22 дугаар хэсэг
1	Эхлэл	Жало хааны охин Рогмо гоо нөхөр сонгох болсон.
2	Зангилаа	Рогмо гоогийн тавьсан болзол
3	Өрнөл	
4	Туйл	Журын гэргий Рогмо гоо үхэх шийдвэр гаргасан.
5	Тайлал	

2. Рогмо гоогийн эрчүүдэд тавьсан болзлыг “Хан Харангуй” туульд гардаг

болзолтой харьцуулан адил ба ялгаатай талыг тоочин бичээрэй. Энэхүү болзол нь дараагийн ямар үйл явдал өрнөх шалтгаан, зөрчил болох вэ?

Рогмо гоогийн анх тавьсан болзол: “Гурван харвах мэргэд, гурван барилдах бөх эд бүгдийг минь ялсан хүнд очно, би”, “Энэ манай хүн өглөөгүүр харвавал гэдрэг харж хэвтээд сумаа бууж ирэхэд толгойгоо зайлуулдаг буй. Толгойн оронд сумаа тусгадаг буй. Бид тийм хүнийг мэргэн гэж тоодог буй...”

(“Гэсэр” тууж, 41 дүгээр тал)

Журд очих болсон тул дахин нэг болзол тавьсан нь: “Түмэн хүнд намайг буруу хандах зуур далан хонины хавьс, нэг бутан архийг түгээж өгч дуусаад хачир шувууны толгойн чинээ оюу эрдэнийг амандаа багтаан чадсан хүнд би очъё”

(“Гэсэр” тууж, 42 дугаар тал)

Хан Харангуйгаас Тэнгэрийн хүү Эрхэм хард тавьсан болзол: “Морийг ерэн есөн жилийн газраас уралдуулж, есөн сарын газраас бай харвая.

Хонин цагаан чулууг
Хоггүй болтол харваад
Түүний цаана байгаа
Үхрийн чинээ хар чулууг
Үй болтол харвана.
Түүний цаад талд
Жаран хасаг түлээ овоолж
Шүд чигчийлэх юмгүй болтол харвана.
Түүний цаад талд
Алтан мөнгөн тэвнэ хатгана.
Түүний сүвэгчээр гаргаад
Бас цаана нь сүүжний яс хатгаад
Нүхээр нь оруулаад
Түүний цаана хойшоо харсан
Өрвөн хар хадыг
Хасаг тэрэг гарахаар
Онх хөтөл гаргана.
Түүний цаад талд
Бага зэрэг түймэр шатаана.

(“Хан Харангуй” тууль, 36 дугаар тал)

Адил тал:

Ялгаатай тал:

Орчин, нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг дүгнэе

1. “Гэсэрийн тууж”-ийн үйл явдлын өрнөж буй орчныг даалгаврын дагуу тайлбарлаарай.

- А. Хүснэгтэд орчныг илэрхийлсэн нэгээс хоёр жишээ бичээрэй.
- Б. Үйл явдлыг яагаад өөр өөр оронд өрнүүлсэн бэ? Энэ нь аль, аль дүрийн ямар шинжтэй холбоотой вэ?
- В. Үүгээр уншигчдад юу хэлэхийг хүссэнийг тайлбарлаж ярилцаарай.

Орчин	Үйл явдал
Тэнгэрийн оронд	Шигэмүни бурхныг нирвааны дүр үзүүлэхийн урьд Хурмаст тэнгэр бурханд мөргөхөөр очсон.
Хүний ертөнц буюу дунд тивд
Тамын оронд

2. Гэсэрийн дүрийг тодруулахад орчин яаж нөлөөлж байгааг шинжлээрэй.

1. Тэнгэрийн орон дахь орчин:
 2. Хүний ертөнц дэх гэр бүлийн орчин:
 3. Бусад орчин:
3. Өөрт сонирхолтой санагдсан цаг хугацааг заасан 2-3 үгийг сонгож, учрыг тайлбарлаарай.
 4. Цаг хугацаатай холбоотой эшлэлүүдийг уншаад бэлгэдлийн утга, тэнгэрийн орны цагийн талаарх төсөөллөө өөрийн үгээр тайлбарлаж бичээрэй.

Рогмо гоо, мөн тэр сумандаа бас бичиг бичив. Бичихдээ: “Чамайгаа Хатаны гол дээр есөн сар болтол хүлээсү, би. Есөн сар болтол эс ирвэл Цагаан гэрт хааны гэргий болно...” (122 дугаар тал)

Гэсэр хаан зэр зэвээ аваад зарлиг болов: “Ай, өчнөөн есөн жил болтол суусан минь үнэн байна” гээд... (126 дугаар тал)

“...Таван зуун жил болоод гурван хөвгүүнийхээ нэгийг очуул. Тэр ертөнцийг эзлэгч хаан болох буй...” (16 дугаар тал)

Хурмаст тэнгэр, бурхны зарлигийг мартаж долоон зуун жил болтол суув. (16 дугаар тал)
 5. Дараах асуулт, даалгаврын дагуу нөхцөл байдлыг шинжлээрэй.
 - А. Гэсэр ямар нөхцөл байдалд амьдарч байна вэ?
 - Б. Үйл явдал өрнөх тутам нөхцөл байдал яаж өөрчлөгдөж байна вэ?
 - В. Тэр нөхцөл байдалд Гэсэрийн зан төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
 - Г. Энэ өөрчлөлт зохиолын сэдэв, санаанд хэрхэн нөлөөлж байгааг ярилцаарай.

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэе

1. Гол санааг тодорхойлохын тулд дараах асуултын дагуу ярилцаарай.
 - А. Гэсэрийг багаас нь гачигдал зовлонтой, жирийн малчны амьдралтайгаар үзүүлсэн нь ямар учиртай вэ?
 - Б. Гэсэр баатар олон удаа дайтаж яваа нь түүний түрэмгий шинж үү? Аль эсвэл...
 - В. Гэсэрийн ялалт амжилтын эх булаг нь ард олон, баатруудын хүчин туслалцаатай байгаагаар үзүүлсэн нь ямар учиртай вэ?
 - Г. Хаад, ноёд, лам нартай тэмцэл хийж байгаагаар яагаад үйл явдлыг өрнүүлэв?
2. Зохиолд дэвшүүлж буй асуудал юу байна вэ? Үүгээр юу хэлэхийг хүсэв?
3. “Гэсэрийн тууж” бол ард түмний эх орноо хамгаалсан ариун шударга тэмцлийн магтаал бөгөөд энэ ертөнц, энэ дэлхий дээр жаргалтай аж төрөхийг эрмэлзсэн жирийн хүмүүсийн амьдралд зориулагдсан ном юм” гэж академич Ц.Дамдинсүрэн хэлснийг дараах асуултын дагуу зохиолын үйл явдлаар баталж, тайлбарлаарай.

- A. Ард түмний эх орноо хамгаалсан ариун шударга тэмцлийн магтаал гэдгийг юу юугаар нотолж болох вэ?
- B. Жаргалтай аж төрөхийг эрмэлзсэн санаа ямар ямар үйл явдлаар илэрч байна вэ?
- B. Хүмүүс амьдралдаа хэрэгтэй ямар ямар санааг өөрт тусгаж болох вэ?

Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэе

1. Эх зохиолыг дэлгэрүүлэн уншиж, Гэсэртэй холбоотой дүр, шинж байдлыг тодруулаарай.

- 1. Төрж байгаа үеийн онцлог шинж нь:
- 2. Хатад нь:
- 3. Баатрууд нь:
- 4. Зорьсон үйл, байгуулсан гавьяа нь:

2. “Гэсэрийн тууж”-ийн нэгдүгээр бүлгийн “Хурмастын дунд хүү ертөнцөд буух болов” гэсэн гуравдугаар хэсэгт байгаа Гэсэрийн хэлсэн үгийн өнгөний бэлгэдлийн утгыг хүснэгтийн дагуу тайлбарлаарай.

“...Хурмаст тэнгэр ахай минь, над Шүүдрийн гилбэлгээн өнгөт хөө хар хуяг өг. Цахилгаан өнгөт далавчаа өг. Нар, сар хоёрыг хамтаар зэрэгцүүлэн ургуулан хийсэн манлай цагаан дуулгаа өг. Оюун эрдэнэ оньт гучин цагаан сумаа өг. Догшин хар нумаа өг. Билгийн гурван алд хар шор сэлмээ өг. Дуурсахуй нэрт алтан уургаа өг. Ерэн гурван жингээр хийсэн их болд сүхээ өг. Жаран гурван жингээр хийсэн бага болд сүхээ өг. Энэ бүгдийг намайг ертөнцөд төрөхөд буулгаж өгөөрэй” гэж байна.


Өнгө	Эдлэл хэрэглэл	Бэлгэдэл	Уншигчдад үзүүлэх нөлөөлөл
Догшин хар	нум	Ид хав, хүч чадлын бэлгэдэл.	Том, сүрдмээр, дийлдэшгүй мэт санагдаж, тэр тэнгэрийн хүү гэдгийн нотолгоо болсон.

3. Эх зохиолоо уншиж, Гэсэрийн хатдын дүрийг онцлог шинжээр нь харьцуулан дүгнэж бичээд, зохиолын үйл явдлаар баталж, хосоороо ярилцаарай.

Гэсэрийн хатад	Эцэг нь	Онцлог шинж
Ажу мэргэн	Лусын хаан	Дайчин, эрэмгий, мэргэн харвадаг, эршүүд
Арлан гоо	Ма баян	
Рогмо гоо	Жало хаан	
Гүнэ гоо	Хятадын Гонма хаан	
Дүгнэлт	Хатад нь угсаа гарвал сайтай байгаа нь.....	

4. Зохиолын наймдугаар бүлгийн Гэсэр хааны дүрийн өсөлт, бууралтыг графикаар үзүүлснийг ажиглаад, яагаад өсөлт, бууралт гэж тэмдэглэснийг ярилцаарай.

Наймдугаар бүлгийн Гэсэр хааны дүрийн өсөлт, бууралт



Нэгэн мангас лам болон хувирч Гэсэрт ирэв.	Лам мэхэлж Гэсэрийг илжиг болгов.	Ловсгаа Гэсэрийг илжиг болгон элдвээр зовоов.	Ажу мэргэн хатан Гэсэрийг мангасаас салгаж...	Илжиг болсон Гэсэрийг гурван эгч нь Бурханд хүргэж...	Гэсэр есөн өнгийн солонго татуулан бууж ирэв.	Гэсэр Ловсгаа мангасыг дарав.
--	-----------------------------------	---	---	---	---	-------------------------------

5. Аль нэг бүлгийн Гэсэр хааны дүрийн өсөлт, бууралтыг графикаар үзүүлж, яагаад гэдгийг тайлбарлаарай.
6. “Гэсэрийн тууж” болон “Хан Харангуй” туульд баг нэрт хар өнгөт идээг идсэнээр баатруудад ямар ямар сөрөг өөрчлөлт гарсныг жагсаан бичнэ үү. Үүгээр ямар санаа илэрхийлэхийг хүссэнийг тайлбарлаарай. Жишээ нь:
- Өмнөх үеийг мартуулах
 -
7. Бүдүүвчийг гүйцээгээд, дүрүүдийн холбоо хамаарал зохиолд ямар үүрэгтэйг шинжлээрэй.



**Уран дүрийн үгийн сан, уран дүрслэл, бэлгэдлийн үүргийг
нарийвчлан шинжилье.**

1. Гэсэрийн мэндлэх үеийн өвөрмөц шинжийг уншаад, зургаар дүрсэлнэ үү. Бэлгэдлийн үүргийг үйл явдалтай холбон тайлбарлаарай.

Төрсөн шинж	Бэлгэдэл
Баруун нүдээ хялайсан минь	элээ шулмасыг тас хялайсан минь билээ.
Зүүн нүдээ харсан минь	энэ заяа, тэр заяа хоёрыг тэгш харсан минь билээ.
Баруун гараа далайсан минь	эсэргүүцэгч бүгдийг тас далайсан минь билээ.
Зүүн гараа атгасан минь	хамаг бүгдийг эзлэн барих минь билээ.
Баруун хөлөө дээш өргөсөн минь	шашныг мандуулах минь билээ.
Зүүн хөлөө жийсэн минь	тэрс буруу номтныг доройтуулан гишгэсэн минь билээ.
Дөчин таван дун цагаан шүдээ зуусаар төрсөн минь	догшин шулмасын сүрийг тас залгисан минь буюу

2. Очирваань бурхны хөрөг зураг, тайлбарыг дээрх шинжийн адил ба ялгаатай талтай харьцуулна уу. Зохиолч үүгээр юу хэлэхийг хүссэн бол?



Очирваань

Арван хангалын нэг Буддын шашны нууц увдисын хаан гэж алдаршсан. Амаа ангайж, дөрвөн соёог ярзайлган, хэлийг хуйлруулан, догшин гурван мэлмийтэй, баруун мутартаа 5 үзүүрт очрыг огторгуйд далайж, зүүн мутраа зүрхэн тус газраа хумьж, хөх өнгийн цээживч, барын арьсан хормогч өмссөн, зүүн хөлөө сунгаж, хилэнцэт догшин амьтдыг даран гишгэсэн сүрт байдлаар бадарсан их галын дунд бадамлянхуа наран дэвсгэр дээр оршино.

<http://www.zanabazarfam.mn/index.php?language=mongolian§ion=explore&page=khangal>

3. Рогмо гоо хатны өөрийнх нь хэлсэн үг болон тавдугаар бүлэгт хэрээ, хатныг магтсан хэсэгт гоо үзэсгэлэнг дүрслэхдээ уран дүрслэлийн ямар арга ашигласныг тайлбарлаарай.

“Намайг төрөхөд ...наргүй өдөр гэрэл гарч байсан билээ. Үүлгүй өдөр бороо орж байсан билээ. Ноёны тулган дээр минь тоть шувуу донгодож байсан билээ. Хатны тулган дээр минь хөхөө шувуу донгодож байсан билээ. Боолын тулган дээр минь Урангадайн гоо шувуу донгодож байсан билээ. Ийм есөн зүйл төгссөн дагинасын хувилгаан Рогмо гоо охин би билээ”

“ЖАНГАР” (туулиас)

Уншихын өмнө:

1. Зохиолыг уншихын өмнө дараах асуултын дагуу ярилцаж, санал бодлоо солилцоорой.
 - А. Монгол туулийг “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”- д бүртгэн тунхагласны учрыг тайлбарлаж ярилцана уу?
 - Б. “Өвөлгүй хаврын хэвээр
Зунгүй намрын хэвээр Сэр сэр гэсэн салхитай
Даарах хүйтэнгүй Бур бур гэсэн хуртай
Халах халуунгүйгээр Бумбын орон болно”

гэсэн хэсэглэлээс ямар нутаг оронд амьдарч байгаа ямар хүмүүсийн тухай унших гэж байгаагаа таамаглаж ярилцаарай.

2. Туулийн тухай дараах мэдээллийг уншаад хамгийн сонирхолтой санагдсан зүйл юу байсан, яагаад? гэдгийг хосоороо ярилцаарай.

“Монгол туульчдын туурвисан үгийн урлагийн суут бүтээл “Жангар” тууль нь халх монгол, дөрвөн ойрд, ялангуяа Ижил мөрний халимагуудад өргөн дэлгэрчээ... “Жангар” туулийн үүсэл гарлыг ХҮ зууны дунд үетэй холбон үзэж 500 жилийн ойг нь 1940 онд ЗХУ-д тэмдэглэсэн байна” (Д.Цэрэнсодном “Монгол уран зохиол” УБ.,1987, 105)

“Манай соёлын нэгэн чухал дурсгал болсон алдарт “Жангарын тууль” нь Монголын ард түмнээс хүн төрөлхтний соёлын санд оруулсан нэгэн чухал хувь нэмэр мөн гэж үзэх ёстой” (Ц.Дамдинсүрэн нар “Монголын уран зохиолын тойм” УБ.,1977, 236 дугаар тал)

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

1. “Жангар” туулийн агуулгын хураангуй болон эхлэл хэсгийг уншина уу. Зохиолыг бүрэн эхээр нь уншсанаа сэргээн санаарай.

“Жангар” туулийн зарим бүлгийн товч утга санаа

Алтан Цээж, Жангар хоёрын байлдсан бүлэг

Жангарыг таван настай байх үед Бөх Мөнгөн Шигшрэг олзолж аваад хэрэв үүнийг амьд үлдээвэл хожим хойно өөрийнх нь орныг залгаж, ертөнцийг эзлэх их хүчтэн болохыг шинжиж мэдээд устгах гэвэл түүний хүү Араг Улаан Хонгор, Жангарын дээр нь хамгаалж хэвтээд үл хорлуулав гэнэ. Тэгэхлээр нь Бөх Мөнгөн Шигшрэг, Баян Хүнхээн Алтан Цээжийн найман түмэн хөх халзан адууг хөөлгөх юм бол түүний суманд эрх биш өртөн үхэх биз гэж бодоод Аранзал зээрд морийг нь

унуулаад адуу хөөлгөхөөр явуулав. Жангар адууг нь туугаад явтал Баян Хүнхээн Алтан Цээж:

- Миний хөх халзан адууг авдаг хүн хэн байдаг билээ. Бөх Мөнгөн Шигшрэгийн орноос алдарт ноён Жангар ирж, долоон насандаа доройтуулах учиртай билээ. Зургаатайдаа юунд халдав гэж амин голоор нь харвасанд Жангарын ухаан балартжээ.

Гэсэн ч Аранзал зээрд хүлэг нь эзнийгээ Бөх Мөнгөн Шигшрэгийн үүдэнд авчирч байна. Бөх Мөнгөн Шигшрэг үүнийг үзээд хатандаа “Энэ хүүг тахиа, нохой хоёрт өг” гэж хэлээд мордов. Араг Улаан Хонгор Жангарыг урьдын адил хамгаалж ар зоонд нь шаалттай сумыг авч, амь биеийг нь тэнхрүүлж, анд сайн нөхөд болж байна.

Дараагаар нь Жангар, Араг Улаан Хонгор, Бөх Мөнгөн Шигшрэг, Баян Хүнхээн Алтан Цээж дөрвүүл андалдаж, алдарт Жангар нэрээ дуурсгаж, Баян Хүнхээн Алтан Цээж баруун биеийг ахалж, анд нөхөр Араг Улаан Хонгор зүүн биеийг нь ахалж, дөрвөн талдаа байсан дөчин хоёр орныг номдоо оруулж Ар Бумбын орон гэж алдарших болжээ.

Буурал халзан морьтой Булингарын хөвгүүн Догшин хар Саналын бүлэг

Жангар “Би чамайгаа нэг харь газарт зарах гэж байна” гэж Догшин хар Саналд зарлиг болов. “Хүдэр Заарийн Заан тайж хаанд очиж эвтэй бол эвийг нь сонсоод, дайтах бол дайтахыг нь сонсоод миний хэлийг хүргэж ир. Хэрэв найрамдах юм бол тавин жилийн татвар, мянган жилийн алба өгч манайд орох тухай ам тангаргий нь ав. Дайтах бол хар цоохор тугийг нь урж тасдаад, найман түмэн агтыг нь хөөж ир” гэж зарлиг болоод “Заан Цагаан хааны нутаг аль хэр хол билээ?” гэхэд Хүнхээн Алтан Цээж “Энгийн морин дөчин есөн сар яваад эс хүрэх тийм газар байх. Харин Заан Цагаан тайж, түмэн цагаан баатартайгаа өмнө зүгийн гурван тивийг өөртөө оруулав. Одоо дөрөв дэх тивийн орон болох Жангарын нутгийг авах хэрэгтэй гэж ярилцаж байна” гэж хэлдэг. Догшин хар Санал зэр зэвсгийг зэхүүлж Жангарын зарлигаар явж замд дайралдсан хортон дайсныг дараад Заан тайжийнд очиж Жангарын үгийг хэлж байна. Тэгтэл тэдний Одон цагаан, Гунаан хар, Одон Харгай гэдэг баатрууд нь дайрч ирж Догшин Хар Саналыг барих гэж оролдов.

Гэвч тэр хатгалдан тэмцэлдэж Хар цоохор тугийг нь хуучиж хаяад, найман түмэн хар халзан агтыг нь туугаад дутааж байна.

Заан тайж уулын чинээ оготор шар цоохроо унаад түмэн баатраа дагуулж хөөж тулалдаад Догшин Хар Саналыг тогтоож авахын даваан дээр Жангар Зургаан мянга арван хоёр баатраа дагуулан ирж дайсныг дарж Заан цагаан тайж хааны баруун хацарт Хүнд гарт Савар Бумбын улаан тамгыг дарж, алба татвар өгч байх андгай тангаргийг нь авч байна.

Дуут хулын ач, Дуутын хүү алия Монхлой Жангарын түмэн найман мянган цусан зээрд агт хөөсөн бүлэг

Нэг өдөр Жангарынхныг найрлан жаргаж суутал:

Дуут хулын ач

Дуутын хөвгүүн Алия Монхлой:

“Эзэн Ноён Жангарын

Элбэг сайхан адуун дундаас чинь

Эрвэн дэлтэй

Эгц сүүлтэй

Цусан зээрд агтыг чинь

Хөөх гэж ирлээ би” гэж их дуугаар хашхирчээ. Найрлаж суусан олон баатрууд найраа мартан алмайрч, ордон байшин нь оройгоо хүртэл чичирч чухамдаа нэлээн сандарч байна. Тэгтэл баруун талын ахлаач Баян Хүнхээн Алтан Цээж алдарт Жангарынхаа адуун сүргийг хөөлгүүлээд ард нь дуугүй хоцрох юм бол арилшгүй муу нэр бидэнд үлдэнэ. Араас нь хурдан нэхье гэж Араг Улаан Хонгор, Хүнд гарт Савар, Догшин Хар Санал зэрэг баатрууд нь нэхэж тулалдаад Алиа Монхлойд албатаан болгож, Бумбын орны тамгыг дарж, алба татвар авч байхаар болж байна.

Арслангийн Араг Улаан Хонгор, Араг Манзын Бууралтай, Айх Догшин Магнай хаантай байлдсан бүлэг

Нарийхан зээрд морьтой Нарийн Улаан гэдэг баатар Жангарын ордонд хүрч ирж, баруун биеийн дунд сууж хар арз архинаас нь улаан зээрд болтол уугаад босож ирж:

Манай Айх Догшин Магнай хааны зарлиг гээд хэлж байна.

“Аранзал зээрд морийг чинь

Айл дундаа уная

Агай Шавдал хатныг чинь

Авгайнхаа зарц болгоё

Орчлонгийн сайхан Миньяаныг чинь

Айлчин гийчнийхээ сөнч болгоё

Саналын буурал халзан хүлгийг

Адуу манахдаа хэрэглэе

Араг Улаан Хонгорыг чинь

Алс, ойрын зарцаа хийе” гэж хэлүүллээ. Энэ таван юмыг эс өгдөг юм бол Бумбын далайг чинь ширгээнэ. Бурхан шашнаас чинь хагацуулна гэв. Жангар үүнд тулгамдаж яах ч учраа мэдэхгүй Алтан Цээжээс асууж байна.

Алтан Цээж хэлж байна. Эцэг чинь хорин насандаа Айх Догшин Магнай хааны долоотойд тулалдаад гурван шархтай арай зүдүү гарч байсан. Эцэг чинь танаас хоёр илүү тэнхээтэй билээ. Хэлсэн ёсоор нь болговол дээр биз гэсэн утгатай үг хэлж байна.

Ингээд Жангар хүссэн таван зүйлийг ёсоор өгөхөөр болжээ. Тэгтэл Хонгор “Харь газар очиж зарц болсноос Агир хар булгийн хөвөөнд аяга цусаа асгалцана би” гэж хэлээд Жангарын үгээс зөрж, Араг Улаан Хонгор, Оцол хөх Халзан морио унаад зайлж гарав. Хонгор морио шарга даага болгож, өөрөө тархай муу хүү болж хувилаад дайсны хэл санааг мэдээд эр зориг гарган ганцаар тулалдаж, хөдөө хээр хөх чулуу дэрлэн үхэхдийн хэвтэв. Хонгорын эр зоригийн баатарлаг жишээгээр Жангарын бусад баатрууд ирж тулалдаад дайснаа дарж байна.

Хүнд гарт Саварын бүлэг

Жангарын ордонд Догшин Хялган хааны нутгаас урт хар халзан хүлэгтэй Будын улаан гэдэг түшмэл ирж Агай Шавдал Аранзал зээрд, Орчлонгийн сайхан

Миньяан энэ гурваа өг. Эс өгдөг юм бол долоон түмээр ирж бүрхэж барина гэв. Хонгор хариуд нь: “Агир хар булгийн хөвөөнд аяга цусаа асгалцъя” гэж хэл гээд явуулав. Жангар баатрууддаа хандаж:

-Арз эдлээд суухдаа адил боловч аюулт дайсан ирэхэд ам гардаг нь ганц Хонгор болжээ гэсэн үг хэлжээ. Хүнд гарт Савар энэ үгэнд гоморхож:

-Хүнд гарт Савар байна гэх чимээгээр Хүн халдашгүй байдаг эс биш үү? би. Хонгороос юугаараа дутуу юм. Танаас хагацаж Шарай голын гурван хаантай нийлж хариу эргэж тантай байлдана. Тэр цагт та миний тусыг мэдэх биз гэж хэлээд явав. Хүнд гарт Савар Шарай голын хааныд очоод нойрсож байтал шөнө дунд баруун талд юм шөргөөж сэрээв. Тэгсэн хүрэн халзан хүлэг нь:

- Чамайг гарсан хойно Догшин Хялган хаан долоон түмээр бүрхэж ирээд барьжээ.

“Эргээд авдаг элээ минь эс билүү чи
Эрслээд авдаг харцага минь эс бишүү чи
Яльгүй юманд өөлөөд

Яагаад явчив, чи” гэж Жангарын хашхирах дуу гарав. Тэр бас “Хүний начин хүнд гарт Савар минь байвал Хүнд баригдахгүй билээ” гэж уйлан дуудав гэж хэлжээ.

Хүнд гарт Савар тэр шөнөдөө Хүрэн халзан хүлгийн гүйдлээр явж ирж Догшин Хялган хааныг дарж, хадны хонгилд хүлээтэй байсан Жангар зэрэг баатруудынхаа амийг нь аварч байна.

Хошуун Улаан, Баатар Жилган Алиа Шонхор гурвын бүлэг

Жангар бага залуу насандаа Баатар Бадамын Улаан гэдэг эрд дийлэгдэж, эр хүний гурван гомдол байдаг гэж амь гуйж гарчээ. Тэр үед Агай Шавдал хатнаа аваад найман сар болоогүй байв. Тэр, дараа нэхэж байлдъя гэсэн тэр цаг боллоо яах вэ? гэж байна. Үүнийг сонсоод Алтан Цээж хэлж байна.

“Шорооноос нягт
Шоргоолжноос олон хүнд
Атаа маргаан авам
Аргатай хүү гарсан биз

Жангарын магтаал тавьж дуудлага хийе” гэв. Тэгээд Хүүхэн Цагаан ноён ард олны дотор:

“Эзэн ноён Жангарын
Төр шажин хоёр нь
Гар дээрээс нь алдагдах гэж байна.
Энэ Бумбын оронд
Аргатай хөвүүн гарсан болбол

Нэг тэмдэг өгөгтүн” гэж хэдэн өдөр зарлаж явав. Тэгтэл нэг хонгор шар үстэй хүү Жангарын дууллыг сонсон сонирхож хойноос дагаад явжээ. Тэр ноён хоосон очсоноос гэж бодоод нөгөө хонгор шар үстэй хүүгээ Жангарын ордонд авч ирэв. Тэгтэл Араг Улаан Хонгор босож ирээд хүүгийн гараас татаж авч гарах гэсэн боловч тэр хүү хөдөлсөнгүй. Хонгор буруу харан уйлаад “Толгойд тулсан үйл биш үү. Эзэн Жангарын Хар Жилган хөвгүүнийг дагуулж яв. Чамайг мэдэж зарлуулсан Хүнхээн Алтан Цээжийн Араг Шонхорыг дагуулж яв” гэж хэлээд гарав. Тэр, гурван хүүгийн унаа хүлгийг нь бэлдээд Баатар Бадамын Улааныг дарахаар явуулав. Араг Улаан

Хонгорын хүү Хошуун Улаан баатар хорт могой болон хувилж, Баатар Бадамын байшинд ороод дөрвөн мөчийг нь хүлж Их шар туламд хийж авч ирж Жангарын үүдэнд хаяж байна.

Баатар хар Жилган хаантай байлдсан бүлэг

Араг Улаан Хонгор арзанд согтоод эр чадлаа гайхуулсанд Жангар “Чи тийм сайн бол Баатар хар Жилган хааныг барих уу” гэхэд Хонгор “Барина” гэв. Араг Улаан Хонгор амласан ёсоор явж арга чадал хэрэглэж Баатар хар Жилган хааны ордонд шөнө орж очив. Хатныг нь барьж авч голыг нь гогодож хааныг алах илд хаа байна гэхэд амь тэмцэхийн эрхэнд дэрний хөндийд ахар хар илд байна гэв. Тэгээд Баатар Хар Жилган хаантай барилдаж ноцоод үүрийн харанхуйгаар дийлж туламд хийж ганзагалаад авч ирэв. Хар Жилган хааны дөрвөн мөчинд нь төмөр гадас шаагаад архи дарс болоод, арзанд согтоод унтжээ. Шөнө дүлийн эхэнд Хар Жилган дөрвөн төмөр гадсыг хуга татан босоод Жангарын ордонд орж Хонгорыг аваад явбал хонзон саналаа гэх биз. Жангарыг аваад явбал ховдоглов гэх, Агай Шавдалыг аваад явбал авгай хүүхэнд дуртай гэх муу нэр авна гэж бодоод хэлмэрч Хээ Жилган баатрыг нь аваад явав. Хонгор хойноос нь нэхэж ирээд найрамдаж ах дүү барилдаж байна.

Орчлонгийн сайхан Минъяан хүчтэй Хүрмэн хааныг амьдаар хэл барьж ирсэн бүлэг

Эзэн Жангар бас нэгэн өдөр хар нүдний нулимс цацан уйлж, хар торгон ханцуйгаар арчиж суув. Энэ учрыг мөн хэлмэрч Хээ Жилганаар асуулгаж, Наран гарах зүгээс Хүчтэй Хүрмэн хааных манайд элч илгээх гэж байна. Одоо түүнээс урьдаж хэл барьж ирвэл сайн гээд Орчлонгийн сайхан Миньяан минь:

“Санаанаас дэлэм хурдан

Салхинаас алд хурдан алтан шаргаараа явж хэл барьж ир” гэв. Ингээд Миньяаныг явахад нь Алтан цээж хойноос нь дайсныг хэлж, замыг нь зааж өгч явуулж байна. Алтан Цээжийн урьдаж хэлсэн тэнгэрийн хавсал цагаан буур, шулман хүүхнүүд, хөх түрүү зэрэг хортон дайсныг эндэлгүй гэтэлж, Өл манхан цагаан уулын орой дээр гарч, хүчтэй Хүрмэн хааны орд харшийг олж харав. Тэгээд хурдан шаргаа даага болгож, өөрөө тархай хожгор хүү болж хувилаад үдшийн бүрэнхийгээр хүрч очжээ. Эрт урьд цагт Жангарын хамаатнаас олзлогдсон нэг хүүхэн Орчлонгийн сайхан Миньяаныг ирж явааг мэдээд тосон ирж уулзав. Миньяан тэр хүүхний хэлж зааснаар шөнө Хүчтэй Хүрмэн хааны ордонд хорт могой болон хувилан орж, хялган шар цоохор илдээр нь хатгаж, тэр хааныг их шар туламд хийж үүрээд гарав. Орчлонгийн сайхан Миньяаныг олон цэргийн дээгүүр харайн гарахад нөгөө тус ач болсон хүүхэн шар цоохор алчуур болоод бэлхүүсэнд нь хавчуулагдаад гарчээ. Гараад тав хоног болсон хойно Барс мэргэн баатар гэгч нь нэхэж хөөж иржээ. Түүний амин газрыг хүүхнээр хэлүүлж аваад үүдэн энтэй хөх живэр саадгаар аман хүзүүг нь харваж алаад хүрч ирэв. Жангарын ордонд эмнэг гүүдийн сүү, элбэг хар арзын суурь болж найрлан суутал Алтан Цээж хавтагандаа байгаа шар цоохор алчуураа нааш гарга гэв. Тэр алчуурыг гаргаад тавьсан хойно 16 настай Агай Шавдалыг өнгө үзэсгэлэнгээрээ дарах сайхан хүүхэн болов. Түүнийг Алтан Цээжийн хүү Алиа Шонхорын гэргий болгож байна.

Эх сурвалж: Д.Цэрэнсодном «Монголын уран зохиол» (XIII-XX зууны эх) УБ., 1987

“Жангар” туулиас Эхлэлт

Эрдэнийн эхэн цагт гарсан
Энэ олон бурхдын шажин дэлгэрэх цагт гарсан
Тахь зул хааны үлдэл
Тансаг Бумба хааны ач
Үйзэн алдар хааны хөвгүүн
Үеийн өнчин Жангар билээ
Эрхэн хоёр насандаа
Догшин мангаст нутгаа дайлуулж
Өнчин биеэр үлдсэн
Гурав хүрэх насандаа
Аранзал зээрдийн үрээ цагт
Хөл өргөж мордсон
Гурван их бэхлэлтийн амыг эвдэж
Гулжин шар мангас хааныг номдоо оруулсан
Дөрөв хүрэх насандаа
Дөрвөн их бэхлэлтийн ам эвдэж
Дөрвөн их шар мангас хааныг номдоо оруулсан
Эрхэн таван настайдаа
Тахийн таван шулам хааныг
Олзлон авч номдоо оруулсан
Тэр таван настайдаа
Бөх Мөнгөн Шигшрэгт баригдаж
Олзлогдсон билээ
Зургаа хүрэх насандаа
Зургаан байрын ам эвдэж
Зуун жадын үзүүр хугалж
Зураг болсон байшинтай
Хүнхээн Алтан Цээжийг оруулж
Баатар олон сайчуудын
Барууны ахлаач болгосон билээ
Долоотойдоо доордын долоон орныг доройтуулж
Дуутай Жангар нэрээ дуудуулсан
Аранзал зээрдийнхээ хурдан цагт
Алтан шар цоохор арам жадын хурц цагт
Өөрийн биеийнхээ өсөх залуу цагт
Дөрвөн тивийн хааны хүүхнийг голоод
Дөчин есөн ноёны хүүхнийг бас голоод
Нар гарах үд хоёрын хооронд байдаг
Ном төгс хааны хүүхнийг залсан билээ
Хүлгүүдийн хурдан хамгийг цуглуулсан
Хүний чийрэг бүгдийг цуглуулсан
Дөрвөн талын
Дөчин хоёр нутгийг номдоо оруулсан
Үхэлгүй мөнхийн оронтой

Үргэлжид хорин таван насны дүрээр байдаг
Өвөлгүй хаврын хэвээр
Зунгүй намраар
Даарах хүйтэнгүйгээр
Халах халуунгүйгээр
Сэр сэр гэсэн салхитай
Бур бур гэсэн хуртай
Бумбын орон болно.
Тансаг богдын
Таван сая албат нь
Таван сарын газарт
Арай багтмаар буурилсан байдаг
Өл Манхан Цагаан уул нь
Өндөр хөх тэнгэрийн түшиг болоод
Өргөн шар дэлхийн хүйс болоод
Өглөө гарах нарны хөл доор
Манхайгаад байдаг гэнэ.
Өргөн Шар таг гэдэг далай нь
Өрүү сөрүү хоёр урсгалтай
Өнгөтэй бадмын гэрэл гаргаад байдаг гэнэ.
Эзэн Жангарын өөрийн биеийн уудаг
Хүйтэн Хар Домбо гол нь
Өвөл зунгүй урсгалтай
Үргэлж гадна эргээ балбалан
Булгилан байдаг.
Шатар болсон бумбалбаа нь өөрөө бүтсэн
Шарын дөрвөн төрөө гар дээрээ авсан
Шар наран доорхоо эзэлсэн
Эзэн ноён гэх нэрээ
Их хол тархаасан байдаг(...)
Тал дундуур татуурдаад
Таван их шанаа гаргаад
Гарах тал биеийг нь
Гажиг шилээр өнгөлсөн
Орох тал биеийг нь
Усан шилээр өнгөлсөн
Ар биеэр нь өвөлжсөн улс
Айраг хярмаар мялааг гээд
Алаг бугын арьсаар өнгөлсөн
Өмнө биеэр нь өвөлжсөн улс
Өөх тосоор мялааг гээд
Өл бугын арьсаар өнгөлсөн
Гадаад дөрвөн өнцгийг нь
Гал шилээр нүдэлсэн
Дотоод дөрвөн өнцгийг нь
Догшин болдоор товчилсон
Дуутай Жангарын арван давхар

Есөн өнгө алтан торлог байшин нь
Дөрвөн талынхаа
Дөчин есөн жилийн хортон дайсныг
Даран далбайн, дүнхийгээд байв.
Дугтуй дотроо байхлаараа
Толбон сарны гэрэлтэй
Дугтуйнаасаа гарахлаараа
Долоон нарны гэрэлтэй
Алтан шар цоохор тугийг
Өмнө биед нь хатгасан байв
Тэр бүхнээ эзэлсэн
Эзэн Жангар нь
Дөчин дөрвөн хөлтэй
Дүнхэр сайхан ширээн дээрээ
Дүүрэн гарсан арван тавны сар мэт
Мандаж суудаг болно.
Арван зургаатай
Агай Шавдал хатны
Шар болд хайчаар хайчилж
Шадар сайчуудын хатдаар оёулсан
Хар торгон тэрлэгээ
Ханцуйлалгүй сул нөмрөөд
Хараацайн живэр сахлаа илбэн
Энгийн олон баатрууддаа
Төр шажин хоёроо
Зарлиг болгоод суудаг болно.
Аранзал зээрдийнхээ хурдан цагт
Алтан шар цоохор жадын хурц цагт
Өөрийн биеийнхээ залуу хөөрүү цагт
Дөрвөн тивийн хааны
Дөчин есөн нутгийн
Хүүхнийг голоод
Наран гарах үд хоёрын хооронд байдаг
Ном Төгс хааны хүүхэн
Арван зургаатай Агай Шавдалыг
Авч ирсэн нь ямар дүрээрээ байна гэвэл
Цаашаа харахад нь
Цаад далайн жараахай тоологдом
Наашаа харахад нь
Наад далайн жараахай тоологдом
Цуснаас улаан хацартай
Цаснаас цагаан санчигтай
Уран ээжийн эсгэсэн
Олон хатан зөвлөж оёсон
Цастын цагаан малгайг
Зүүн цох дээрээ тавин суудаг болно.
Сайхан гөрмөл үс нь

Санчгийг нь даган унжаад
Хар торгон шивэрлэг нь
Хацрыг нь даган ганхаад
Тором тэмээний хоргол шиг
Толь мөнгөн сүйх нь
Гүмбэ чихэнд нь дүүжлэгдээд
Гүрээ талд нь гэрэл гаргаад байдаг болно.
Ерэн нэгэн чавхдастай
Ендэр мөнгөн хуураа аваад татахлаар
Хулсан дундаа өндөглөсөн
Хунгийн дуу гаргаад
Нууран дундаа өндөглөсөн
Нугасны дуу гаргаад
Арван хоёр аясаар
Хангинаад гарав гэнэ
Үүнийг алдалгүй дагадаг нь
Хэн бэ? гэвэл
Эзэн богд Жангарын
Эрхэм сайн сөнч
Эрх Тугийн хөвгүүн
Орчлонгийн сайхан Миньяан болно.
Баруун биеийг нь ахалж суудаг нь
Ирсэн ерэн есөн жилийн юмыг
Тоочиж хэлдэг
Ирээгүй ерэн есөн жилийн юмыг тааж мэддэг
Баян Хүнхээн Алтан Цээж
Далан хааны нутгийн төр шажин хоёрыг
Гар дээрээ бариад
Ямар их бэрх зарга ирэвч
Төдөлгүй хагалаад
Хар торгон олбог дээр суудаг гэнэ.
Зүүн биеийг ахалдаг нь
Түвшин Ширхэгийн ач гэнэ.
Бөх Мөнгөн Шигшрэгийн ууган хөвгүүн гэнэ.
Шилтэй зандан Гэрэл хатны
Эрхэн хорин хоёр настайд нь гарсан
Арслангийн Араг Улаан Хонгор гэнэ.
Хайр цагаан далавчаа хавхчиж
Хамаг биеэ хүүчиж
Далай хааны нутгийг
Дангаар оруулж өгсөн гэнэ.
Хонгорын дараа суудаг нь
Тавлан суухлаараа
Тавин хоёр хүний зайд суудаг
Тахийгаад суухлаараа
Хорин таван хүний зайд суудаг
Баатар Бумбын орондоо

Хүйтэн хар шороороо нэр гарсан
Зааны таваг хайсан хар хүлэгтэй
Гүзээн Гүмбэ гэдэг баатар нь
Мянган нэгэн жилийн
Төр шажин хоёрыг
Булаалдан хэлэн суудаг
Хүнхээний дараа суудаг нь
Сая өрхөөр авсан
Хүүхэн хүрэн халзантай
Наян нэгэн алд
Хайв балтыг эгмээсээ салгадаггүй
Залуу чийрэг ямар боловч хүнийг
Морин дээр нь тогтоодоггүй
Хүний начин
Хүнд гарт Савар болно.
Зүүн талын гурав дахь нь
Буян төгс ааваа
Хөвгүүнгүй хаяад...
Арван наймтай
Ангир улаан хатнаа
Ганц бие хаяад
Буурал халзнаараа ирж
Эзэн богдыг дагасан
Булингарын хөвгүүн
Догшин хар Санал болно
Эд мэт баатрууд нь
Энгийн олон сайдуудтайгаа
Эндээ долоон тойрог болоод суудаг
Цал буурал сахалтай
Цагаан өвгөд нь нэг тойрог болоод
Эелдэг улаан эмгэд нэг тойрог болоод
Цуутай цагаан бэрүүд нэг тойрог болоод
Цулцгар улаан хүүхэд нэг тойрог болоод
Эмнэг гүүний айраг
Элбэг арзын найр болоод суудаг гэнэ...
Эрхэн шарын зургаан мянган
Арван хоёр баатар нь...
Дайлалдах дайсан хэзээ учрах вэ?
Гөрөөлөх гөрөөсөн хэзээ учрах вэ? гэж
Таталдаж шүүрэлдэж суудаг болно.

Эх сурвалж: Ц.Дамдинсүрэн «Монгол Жангарын тууль» УБ., 2008

Соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээн авах

Туульд байгаа хам сэдвийн утгыг дүгнэж, түүгээр дамжуулсан далд утгыг тайлбарлаарай. Жишээ нь: Монголчуудын уламжлалт соёлоос юу юуг тусгасныг дараах байдлаар гаргаж тайлбарлах

Эдийн соёл:

“...Гарах тал биеийг нь	Гал шилээр нүдэлсэн
Гажиг шилээр өнгөлсөн	Дотоод дөрвөн өнцгийг нь
Орох тал биеийг нь	Догшин болдоор товчилсон
Усан шилээр өнгөлсөн...	Дуутай Жангарын арван давхар
Гадаад дөрвөн өнцгийг нь	Есөн өнгө алтан торлог байшин...”

гэсэн орд өргөөний дүрслэлээс харвал барилгыг уран сайхан барих, гоёж чимэглэх, бэлгэдэл шингээх, бөх үзэмжтэй хийх, үндэсний өвөрмөц онцлогийг шингээсэн гэх мэтээр дүгнэж ярилцах

Хүнд гарт Саварын зэр зэвсгийг дүрслэл:

Гунан шарын арьсаар голлосон	Төмөр болдоор товчилсон
Дөнөн шарын арьсаар бүрсэн	Залуу зандаар ишилсэн
Хорт могойн зоогоор гөрсөн	Залаа торгоор сагалдаргалсан
Хорон шүүгээр шахсан	Айрстын хар элдэнг
Махан болдоор алагласан	Баруун гартаа барин байдаг

гэх мэтээр дүрсэлсэн нь цэргийн зэр зэвсгийн үйлдвэрлэл сайтар хөгжсөн, мөн л бэлгэдэл шингээж, түүнийг эзэмших эзнийх нь хүч чадал, эрхэм зэрэгт нийцүүлж хийдэг байжээ гэх мэтээр дүгнэх.

Оюуны соёл:

Ерэн нэгэн чавхдастай	Хангинаад гарав гэнэ
Ендэр мөнгөн хуураа аваад татахлаар	Үүнийг алдалгүй дагадаг нь
Хулсан дундаа өндөглөсөн	Хэн бэ? гэвэл
Хунгийн дуу гаргаад	Эзэн богд Жангарын
Нууран дундаа өндөглөсөн	Эрхэм сайн сөнч
Нугасны дуу гаргаад	Эрх Тугийн хөвгүүн
Арван хоёр аясаар	Орчлонгийн сайхан Миньяан болно...

гэх мэт дүрслэлээс харвал монголчуудын амьдрал ахуйд нийцсэн өвөрмөц шинжтэй оюуны соёл хөгжсөн байсан нь харагдаж байна гэх мэтээр тайлбарлаарай.

Үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлая

Туульд өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргыг ашигласны учрыг тайлбарлаарай. Жишээ нь:

Бүлгийн нэр	Өнгөрснийг дурссан эшлэл	Ямар зорилгоор
Арслангийн Араг Улаан Хонгор, Айх Догшин Магнай хаантай байлдсан бүлэг	Алтан Цээж: Эцэг чинь хорин насандаа Айх Догшин Магнай хааны долоотойд тулалдаад гурван шархтай арай зүдүү гарч байсан. Эцэг чинь танаас хоёр илүү тэнхээтэй билээ. Хэлсэн ёсоор нь болговол...	Аав, хүүгийн хүч чадлыг харьцуулж, байлдаад хэрэггүй, хүссэн зүйлийг нь өгье гэж...
	Үгүйрэхэд минь юм болдог Хонгор билээ Өнчрөхөд минь садан болдог Хонгор билээ Дайсан ирэхэд шивээ болдог Хонгор билээ Дайвалзах цагт түшиг болдог Хонгор билээ	

ЧИНГИСИЙН ХОЁР ЭР ЗАГАЛЫН ТУУЖ ОРШИВ

Уншихын өмнө:

1. Эзэн Чингисийн хоёр морь эзэндээ гомдон нутгаасаа явсан тухай өгүүлнэ. Тэд эргэж ирсэн болов уу?
2. Тэд юуны учир гомдов? Зөв байсан уу? Буруу байсан уу? Эргэцүүлэн уншаарай.



С.Төрбумын бүтээл

Эрт урьд цаг дор Сод Богд
Чингис хааны
Эрмэг цагагч гүүнээс ину
Эр хоёр загал унага төрсөн ажгуу.
Тэр он дор
Арван гүүнээ тэлээлж
Арга хийж онд оруулав гэлээ.
Эзэндээ
Дааган ахуйн цаг дор унуулж
Үрээн ахуйн цаг дор хуяглаж
Тэр хоёр загалыг унаж
Алтай ханыг арлан авлаж
Хөхүй ханыг хөвчлөн авлаж
Их загалыг унаж
Алтай ханыг авлан тавив.
Аргаль угалзыг алж
Аргагүй бардаж ирэхүй дор
Арван түмэн авын хүмүүн
Нэгээхэн бээр эс гайхав.
Бага загалыг унаж
Хөхүй ханыг хөвчлөн тавьж

Хүйлэн хөх чоныг хядан алав.
Өвсний оройгоор
өрвөлзүүлэн ирэхүй дор
Хэдэн түмэн авын хүмүүс
Нэгээхэн бээр эс гайхав.
Хэнтий ханыг хэрэн авлан
Хэдэн түмэн амьтныг
гүйцэж явахуй дор
Хэн ч хүн хэрэглэн эс гайхав.
Онон хатны ой талыг авлаж
Олон амьтныг гүйцэж
Ойр хол бүгдэд адил боловч
Олон бүгд эс гайхав.
Тэр дээр уярах сэтгэл төрж
- Дааган цагт минь давтсан болжээ.
Үрээн цагт минь өргөсөн болжээ.
Хязаалан цагт минь
хянасан болжээ.
Соёолон цагт минь сорьсон болжээ
хэмээн Бага загал нь
Их загалдаа хэлэв:
- Ээ, авгай минь явъя
Алтай ханыг авлахуй дор
Арван түмэн улс эс магтав.
Ай хайран дур минь
Хөхүй ханыг авлахуй дор
Хүй олон улс эс магтав.
Хөвчин хайран санаа минь
Хэнтий ханыг авлахуй дор
Хэдэн түмэн улс эс магтав.
Хэтэрхий хайран дур минь
Энэ бүгдийг маань
Үл магтах юун болов?
Ээ, авгай минь, ер явъя.
Манай одсоны хойно
хаан эзэн минь
Нэг хоёр дурдвал

Нэрийн алдар биш буюу,
- Ээ, авгай минь
Алтай гэгч газар аа
Агь, шаваг өвстэй гэнэ.
Аялан хүрч амарч хэвтье
Авгай минь.
Хөхүй хан гэгч газар аа
Хөвөг шаваг өвстэй гэнэм
Хөөрөм цөөрөм нууртай
гэнэм билээ
Хөдлөн хүрч хөлбөрч барьж хэвтье
Авгай минь бүр явъя.
Хэнтий хан гэгч газар
Хэм үгүй таргатай гэнэм
Хэй хуй болон хүрч
хэжийлэн хэвтье
Авгай минь үтэр явъя.
Онон хатан гэгч газар аа
Урт сайхан устай гэнэм билээ
Ой тал олон гэнэм
Үдлэн хүрч ундаа үгүй хэвтье
Авгай минь бүр явъя.
- Ээ, авгай минь
Ах мэт санагч алцал бор нь буй за
Хөвгүүн мэт санагч хөгшин
шарга нь буй за
Гөжин ширүүн аашлагч чи
бид хоёр буй за
Хатан мэт санагч хар хул нь буй за
Харь дайсан мэт санагч
Авгай, чи бид хоёр буй за
Бүр явъя.
Хүйтэн өдөр барин
Хөндлөн хөх төмөр үмхүүлэн
Хөрсөнт тохмыг хөлстэй тавин
Хүйтэн төмөр үмхэж яахиж аяа
Авгай бүр явъя.
Халуун өдөр барин хаттал уян
Халуун наранд шаран
Хайр шороо үмхүүлэн яахиж аяа.
Авгай бүр явъя.
Бага загал нь их загалдаа
Газар газарлая гэж хэлэв.
- Авай, бор тоором минь, юу гэнэм чи?
Эзэн гэж эзэнд адил эзэн олдох буюу?
Эх гэж эрмэг цагаагч ижийд адил

Эх олдох буюу?
Ер эр хүн баярлах гэж магнай
үл хагарах гэлээ.
Агт морь таргалж арьс үл хагарах гэлээ.
Авай, бор тоором минь, юу гэнэм чи
- Ээ, авгай минь!
Сайн хүнд нөхөр олон биш үү
Сайн моринд эзэн олон биш үү
Өнөр хүнд нөхөр олон биш үү
Өнчин хүнд ноён олон биш үү
Санаат хүнд сэжиг олон биш үү
Сайн моринд газар ойр биш үү
Авгай минь явъя.
- Авай, бор тоором минь!
Этэй хүнд нөхөр олон гэлээ
Ийлсэн моринд уурга олон гэлээ
Эегүй хүнд өстөн олон гэлээ
Эцсэн моринд ташуур олон гэлээ
Хүний гэж хөвчин бүгдээр
үлдэм (хөөнөм) зэ
Дайсан гэж даяар үлдэм зэ
Зэрлэг гэж зэвийн үзүүрт унаганам зэ
Авай, бор тоором минь, юу гэнэм чи?
Хадны өвс хагд идье
Бутны өвс богдой идье
Өсгөн төрүүлсэн өл буурал ахай юугаан
Яаж мартъя гэнэм чи?
Өргөн төрсөн эрмэг цагаагч ижий юүгээн
Яаж мартъя гэнэм чи?
Арван хоёр сар нуруугаа чилтэл өргөсөн
Ангир шар уургаа шимүүлсэн
Ачит цагаан сүүгээ хөхүүлсэн
Амраг эх юүгээн
Яаж мартъя гэнэм чи?
Эвий бор тоором минь, юу гэнэм чи?
Омгоо дараагүйд уушгиа цэрдээгүйд
Яанам болов уу, чи минь
Хайрлан хадгалсан хан эзэн минь
Ханилан өсгөсөн хайран харь
олон эд бүгдийг
Яахин орхин газарлая, гэнэм чи?
Өд үгүйг өсгөн хураахаас тусгүй гэлээ
Байг! гэж хэлэв.
- Сайн хүнд нөхөр олон гэлээ
Сайн моринд газар ойр гэлээ
Бүр явъя гэж бага загал

Ганцаар явсу хэмээн санаж их
загалаа орхиж
Гурван Цавчуурын зүгт явав.
Ах минь нэхэх болов уу
хэмээн санаж
Түрхэн зуур
Алтан улиасны сүүдэрт
хүлээж байн атал
Дөрвөн зүгт нь дөрвөн өнгийн шувуу
Нэгэн эгшгээр донгодов.
Бага загал
Чихээ сэртийж сүүлээ өргөж
Чагнан байв.
Алтан гургалдай шувуу
Алтан улиасны дээр суун жиргэв.
Ах дүү хоёр загал салан
газарлав гэж жиргэв.
Дахин аялгуулан жиргэв.
Хөхөө нэрт шувуу донгодов.
Хөөрхий бага загал
Урван газарлав гэж жиргэв.
Богширго шувуу босон жиргэв.
Богд эзний хайран хоёр загал
Салан газарлав гэж жиргэв.
Хайргана шувуу хадны дээр суун жиргэв.
Хаан эзний хайран хоёр загал
Хагацан газарлав гэж жиргэв.
Тэр дөрвөн өнгийн шувууны
Дууг сонсоод
Бага загал тэсэлгүй явав.
Түргэн түргэн явахад
Түнгэрцгийн чинээ чулуу хөдөлгөж
Аргаар аргаар явахад
Аягын чинээ чулуу хөдөлгөж
Гурван Цавчуурыг зорьсуу
Авгай минь нэхэх болов уу хэмээн санаж
Хөх Өндрийн өвөрт өвс таталж байв.
Их загал нь өглөөн наранд нэхэж
Үдийн наранд хамраа хавчиж
Хар хөлсөө асгарч амиа тэмцэн
гүйцэж ирэв.
- Ээ, бор тоором минь!
Хүний гэж хөвчин үлдэж
Дайн гэж даяар хөөхүй
Зэрлэг гэж зэвийн үзүүрт
Унагах буй за гэж
Их загал нь бага загалдаа хэлэв.

Хоёр загалын одсоны хойно
Нэг шөнө Сод Богд эзэн
Зүүд зүүдлэв.
Эрхт тэнгэр эцгээс заяатай
Эрмэг цагаагч гүүнээс төрсөн
Эр хоёр загал минь
Ийлэн газарлав гэнэм, би
Богд эрхт тэнгэрээс заяатай
Буянт цагаагч гүүнээс төрсөн
Бууралт үгүй хайран хоёр загал минь
Буруулан газарлав гэнэм
Хан эрхт тэнгэрээс заяатай
Хас цагаагч гүүнээс төрсөн
Хайран хоёр загал минь
Гаран газарлав гэнэм, би
Хазаараа эгэлдэрч
Явган явнам гэж зүүдлэв, би
Энэ зүүд минь үнэн буюу худал буюу гэж
Шивэгчнээ зарлиг болов.
- Адуунд орж үз.
Худал болбоос дуугүй ир!
Үнэн болбоос дөрвөн харь
Есөн өнгийн улсыг минь
Эрт цуглуулж ир хэмээн
Зарлиг болов.
Боол Бэчин адуунд орвоос
Өл буурал азарга нь
Өрвөлзөн өрвөлзөн ийн тийн харж
Өнгөлзөж байх ажээ.
Эрмэгч цагаагч гүү эх нь
Ийн тийн харж
Нүднээс нилбус гаргаж байхыг үзэв.
Боол Бэчин яарч
Дөрвөн харь есөн өнгийн улсыг
Манагаар эрт цуглуулж ирэв.
Сод Богд эзэн
Алцал бор морио унаж алтан хуураа авч
Зэл цагаан нумаа дүрж
Аргасун хорчийг хөтөч хийж
Анчин харцагаа барьж
Эхдээ эргэх болов уу хэмээн санаж
Эрмэг цагаагч гүүг хөтлөв.
Төдий морилон явахдаа
Хаан ноён Сод Богд зарлиг болов.
- Хөхүй ханы өврөөр цувъя.
Алтай ханы араар авлая.
Отын хүн урьд яв.

Тахилзуурын хүн тасралтгүй яв.
 Тэр хоёр загалыг минь
 Хэн гүйцсэн нь бүү харва!
 Барьж үз, барьсан хүнд
 Дөрвөн хошуу малаа
 Тэгшхэн хуваах, би хэмээн
 Зарлиг болов.
 Төдий хоёр загал
 Хойд нэхсэн авын барааг харж үзээд
 Их загал нь бага загалдаа хэлэв:
 - Тоором минь, би эс хэлэв үү?
 Хүний гэж хөвчин үлдэх буй за
 Зэрлэг гэж зэвийн үзүүр
 Унагах буй за гэж
 Эс хэллүү би, энэ биш үү гэв.
 Бага загал нь хэлэв:
 - Ээ, авгай минь!
 Эр хүн хэлсэн үгэндээ хүрэх биш үү
 Агт морь зорьсон газартаа
 хүрэх биш үү, явъя
 Яасан эм мэт охорхон
 санаатай билээ чи
 Маныг гүйцэх мориноос болох
 Барааг минь харах буюу гэв.
 Алтай ханы ар ороход
 Аргал угалзыг алхлан бууя.
 Хөхүй ханыг өвөрлөн явахад
 Хөх алаг бугыг гишгэлэн гаръя.
 Төвийн хүнд тоосоо үзэгдье.
 Бүр Гурван Цавчуурыг зорьё гэв.
 Бага загал нь ергөн хөдлөв.
 Их загал шогшин хөдлөв.
 Бага загал нь их загалдаа хэлэв
 - Авгай минь, ах мэт санагч
 Алцал бор морь яах бол гэж хэлэв.
 Төдий дээр түргэн барьсангүй
 Гурван Цавчуур газрыг зорин хүрэв.
 Их загал нь хоёр санааг санаж
 Хайран хаан эзэн минь
 Хайран хас цагаагч эх минь гэж
 Нүднээс нилбус гаргаж
 Өр элгээ өмөрч өвдгөө сөгдөж явав.
 Сод Богд эзэн нь
 Хөх өндөр дээр гарч
 Барааг харж шаналан уярав.
 Болдгийн бор толгойд гарч
 Хаан эзэн нь хайлав.

- Эрийн сайнаар эзэн эс боллоо, би.
 Эрхт тэнгэр эцгийн заяагаар
 Эзэн боллоо, би
 Эрмэг цагаагч гүүнээс төрсөн
 Эр хоёр загал минь
 Ийлэн газарлав уу, чи?
 Эвий минь!
 Эмээлээ барьж яахин харих билээ.
 Эргэж ирэх болов уу, чи?
 Эвий минь!
 Булаан авч эзэн эс боллоо, би
 Богд тэнгэр эцгийн заяагаар
 Эзэн боллоо, би
 Буянт цагаагч гүүнээс төрсөн
 Хайран хоёр загал минь
 Буруулан газарлав уу, чи?
 Эвий минь!
 Хайрлан авч эзэн эс боллоо, би
 Хаан тэнгэр эцгийн хайраар
 Эзэн боллоо би
 Хас цагаагчин гүүнээс төрсөн
 Хайран хоёр загал минь
 Хагацан газарлав уу, чи
 Эвий минь!
 Харьж ирэх болов уу, чи
 Эвий минь!
 Учиртай их уралдаан болоход
 Юугаан хагсаая
 Учирт их ав болоход
 Юугаан уная
 Хайран хоёр загал минь
 Харь олон дайсан болоход
 Юугаан хуяглая
 Хайран хоёр загал минь хэмээгээд
 Төдий Сод Богд эзэн
 Орд харшдаа харьж ирэв.
 Хоёр загал
 Гурван Цавчуурт
 Зорин хүрч
 Дөрвөн он нутаглав.
 Бага загал нь
 Арьсаа язартал таргалав.
 Их загал нь
 Зун зуссан морь мэт хатайртаад
 Өвөл болоход хацарт нь
 Аягын чинээ мөс хөрөв.
 Уй гашуунд уярах сэтгэлийг нь мэдээд

Бага загал нь асуув:
- Ээ, авгай минь!
Өвсийг эрүүгээр иддэг байтал
Усыг уруулаар уудаг байтал
Авгай, арьстай шөрвөстэй хатах чинь
Юу буй хэмээн асуув.
Их загал хэлэв
- Авай, бор тоором минь!
Юу гэж үл мэднэм чи
Хайрлан өсгөсөн хан эзнээ
Ханилан учирсан хайран нөхдөө
Хайран төрсөн эх юүгээ санахул
Хайрт газар туруугаа
Хомоолт газар эрүүгээ хүргэж ядав.
Өсгөн төрсөн эх юүгээ санахул
Өвсөнд эрүүгээ усанд уруулаа
Хүргэж ядав.
Авай бор тоором минь!
Яаж үл мэднэм чи?
Эвий минь гэв.
Тэр цагт бага загал нь:
Зөв харж инээн буруу харж уйлан
Их загалд хэлэв:
- Ээ, авгай минь!
Арьс шөрмөстэй чинь хатаан алж
Арьсыг чинь өмсөм үү, би?
Махыг чинь идэм үү, би?
Ачит авгай минь
Одоо харья гэж хэлэв.
Их загал гурав дахин шилгээгээд
Нэг хоёр өвс татлан байв.
Их загал ергөн хөдлөв
Бага загал шогшин хөдлөв.
Гурван сарын газраа
Гурван гурав хоногт хүрье гэв.
Тэр хоёр загалын
Хүрч ирэхийн шөнө дөлд
Сод Богд эзэн нь
Нэгэн зүүд зүүдлэв.
Эрхт тэнгэр эцгээс заяатай
Эрмэг цагаагчин гүүнээс төрсөн
Эр хоёр загал минь
Ийлэн газарлаж билээ.
Эргэж ирэх болов уу?
Эмээлээ тохож байнам гэж
Зүүдлэв, би гэв.
Энэ зүүд минь үнэн буюу худал буюу

Боол Бэчинийг адуунд орж үз гэв
Хаан эзэн Сод Богдын зарлигаар
Адуунд орвоос
Хоёр загал харьж ирсэн ажгуу.
Өл буурал азарга нь үүрсэн байж
Үүрд хагацав гэж билээ, би
Эдүгээ өдөр ирэв үү та хэмээн
Баярлан байж эвшээн байв.
Эрмэг цагаагчин гүү эх нь
Хоёр нүднээс нилбус гаргаж
Уйлан баярлаж байхыг үзэв.
Эр хоёр загал нь
Эхийнхээ энд тэндээс харж байхыг үзэв.
Боол Бэчин үзээд
Хоёр загалыг барина гэв.
Хоёр загал нь эс баригдав.
Хоёр загал ирж
Өл буурал азаргатай авч ирэв гэж
Хаан эзэн Сод Богдод айлтгав.
Сод Богд хаан эзэн нь
Нэг ханцуйгаа түргэн өмсөн гарав.
- Ээ хоёр загал минь!
Мэнд буюу та гэв.
Бага загал нь
Зэв онтодохын төдий газар аа
байж хэлэв:
- Гурван Цавчуурыг зорьсон хойно
Хоёр загалд юу буй?
Гучин түмэн улсыг эзлэн суусан
Хаан эзэн минь харин мэнд буюу та?
Алтай ханыг зорьсон
Алиа муу хоёр загалд юу билээ?
Арван түмэн улсыг эзлэн суусан
Хаан эзэн минь харин мэнд буюу чи?
Хөхүй ханыг зорьсон
Хөөрхөн аалт хоёр загалд юу билээ?
Хүй олон улсыг эзлэн суусан
Хаан эзэн минь харин
мэнд буюу чи? гэв.
Сод Богд зарлиг болж:
- Ээ хоёр загал минь, юуны тул
Ямар учиртай газарлав, та? гэж асуув.
Их загал дуу эс гарав.
Бага загал
Сод Богд эзэндээ хэлэв:
- Ээ, хаан эзэн минь!
Хоёр загалыг хайрлах болоосой!

Дааган цагт минь давтах билээ, та
Үрээн цагт минь эрэн санах билээ, та
Хязгаалан цагт минь хянан
унах билээ, та
Соёолон цагт минь сорин унах билээ, та
Алтай ханыг авлах цагт
Аргал угалзыг гүйцэн алав
Арван түмэн авын хүмүүн үл магтав.
Хөхүй ханыг хөвчлөн авлах цагт
Хүйлэн хөх чоныг гүйцэж алав
Хэдэн түмэн хүн чинь үл магтав
Хэнтий ханыг хэрэн авлах цагт
Хэдэн түмэн хүмүүн чинь эс магтав.
Онон хатны ой талыг авлахад
Ойр хол адил боловч
Олон түмэн чинь эс магтав
Тиймийн тулд газарлав, бид
Аймаг шувуун донгодов
Хүний хүү газартаа суув
Хүлгийн хүү газраа санав
Хаан эзэн Сод Богд минь, гэв
Тэгэхэд их загал хэлэв:
- Бор тоором минь, байг! гэв
Хаан эзэн минь намайг уна гэв
Тэр үгийг зөвшөөж бага загалыг
Найман жил хурлав,

найман жил хагсаав.
Намрын тэргүүн сард
Авд мордъё гэж авд мордон
Алтай ханыг арлан авлав
Арван түмэн авын хүмүүн магтан гайхав
Хөхүй ханыг хөвчлөн авлав
Хэдэн олон амьтныг гүйцэн авлав
Хэлхү авын хүмүүн гайхан магтав
Хэнтий ханыг хэрэн авлав
Хэдэн олон амьтныг гүйцэн авлав
Хэлхү авын хүмүүн гайхан магтав
Онон хатан мөрний ой талыг авлав
Олон түмэн амьтныг хядан авлав
Хэмжээгүй гайхан магтав.
Хоёр загалын санаа нь
Амран жаргав.
Сод Богд Чингис хаан
Бага загалд хив татаж сэтэрлэв гэлээ.
Хив татахын ёсон бага загалаас
болов гэлээ.
Эзэн Богд Чингис хааны
Эр хоёр загалын тууж төгсөв.

*Эх сурвалж: Ц.Дамдинсүрэн. Монгол уран
зохиолын дээж зуун билиг оршив. УБ., 1959. 60-68
дугаар тал.*

Үгийн тайлбар:

Тэлээлэх - төл мал хоёр болон түүнээс дээш эхийг хөхөж өсөх

Хүйлэн хөх чоно - хар хөх өнгийн чоно

Авай бор тоором минь - Бага загал нь их загалаа эвийлэн дуудаж байна.

Ийлэн газарлах - зайлан холдож газарлах гэсэн утгатай

Үлдэм зэ - хөөнөм зэ

Яахиж ая - яах юм бэ гэсэн утгатай эртний үг

Ахай - насаар ахмад хүнийг хүндэтгэн дуудах үг

Нилбус - нулимс гэсэн сонгодог монгол бичгийн үг

Манагаар - маргааш гэсэн үг

Оту - Отох, гэтэх гэдэг үгээс гарсан бөгөөд "отын хүн" гэж магнайн тагнуулчийг хэлжээ.

Охорхон санаатай билээ чи - холын бодолгүй, богино санаатай

Тахилзуурын хүн тасралтгүй - нэг ч хүн тасрахгүйгээр бөөнөөрөө яв гэсэн утгатай бөгөөд арын сэргийлэгчийг хэлжээ.

Сэтэрлэх - адуу, малыг дахин унаж эдлэхгүйгээр онголон дархлах

Зэв онтодохуй газар - Сум тусгалын газрыг хэлж байна. Харвасан сум арай хүрэхгүй газар зогсож байгаад үгээ хэлжээ.

Хэлхү - цөм, бүгд хамаг

(Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>)


Тайлбар: “Онтодохуй” гэдэг энэ үг XIII зууны эхэн үеийн “Чингисийн чулууны бичиг”-т бас бий. Түүнээс нааших үеийн зохиолд энэ үг бараг үзэгддэггүй тул “Чингисийн эр хоёр загалын тууж”-ийг XIII-XIV зууны үед зохиогдсон гэж үздэг.

Тодруулга: Энэ мэт мэдэхгүй шинэ үгсээ “Монгол хэлний их тайлбар толь”, (УБ., 2013) болон <https://www.mongoltoli.mn> - цахим хуудаснаас олж үзээрэй.

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолыг мэдэрч ойлгож уншъя.

1. Утгыг нь мэдэхгүй үг байна уу? Тэмдэглээд, толь бичгээс хараарай.
2. Эхлэл хэсэгт хоёр загалыг “Арван гүүнд тэлээлж...” гэж яагаад бичсэн бэ? Хоёр загалыг ямар унага байсан гэж бодож байна?
3. Эр хоёр загал юунд Алтай хан руу явахаар болов? Тэд юуны тухай ярилцав?
4. Зохиолоос зөрчлийг мэдэрч уншсан уу?



5. Хоёр загалын хөдөлгөөнөөр дүрийн сэтгэл зүйг ялгаруулан дүрслэхдээ ямар үг сонгож хэрэглэв?
6. Бага загалын шийдвэрийн талаар чи юу хэлэх вэ?
7. Дөрвөн жил болоход бага загалыг таргалсан, их загалыг ядарч цуцсан гэж бичжээ. Яагаад ингэж бичив?
8. Эзэн Чингисийн дүрийг зөвтгөж, саналаа хэлнэ үү. Эсвэл буруутгах уу? Яагаад?

Зохиолын сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг тодорхойлон дүгнэе.

1. Дараах бодомжуудын алинтай нь санал нийлж байна? Мэтгэлцээрэй.
 - Бага загалын дүрээр өөр газар орон руу шунаж байгаа хүний тухай өгүүлсэн.
 - Хоёр морины сэтгэл зүйн зөрчлийн тухай өгүүлсэн.
 - Эзэндээ гомдсон харц ардын тухай өгүүлсэн.
 - Их загалын дүрээр зөөлөн сэтгэлтэй, бусдыг хүндэлдэг хүний тухай өгүүлсэн.
 - Мориндоо хайртай монгол хүний тухай өгүүлсэн.
 - Эзэн Чингисийн зүүдний тухай өгүүлсэн.
 - Өөрийн бурууг олж, бусдыг энэрэн хайрладаг эзэн Чингисийн тухай өгүүлсэн
 - Эх нутгаа, элгэн түмнээ, ээж ааваа гэсэн сэтгэлтэй хүний тухай өгүүлсэн.

2. Дээрх санаануудаас аль нь хамгийн гол, чухал гэж үзэж байна вэ? Яагаад?

Дүрүүдийн холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэе.

1. Бүдүүвч ашиглан, дүрүүдийн холбоо хамаарлыг тогтооно уу. Тэд хоорондоо ямар харилцаатай вэ?

Тэднийг юу холбож байна вэ?

Их загал	}	Бага загал
Хоёр загал		Эзэн Чингис
Хоёр загал		Эрмэг гүү, азарга хоёр

2. Хоёр загалын сэтгэл санааны зөрчлийг зохиолын эхэнд, дунд, төгсгөл хэсэгт хэрхэн гаргав?
3. Зохиолын эхлэлээс төгсгөл хүртэлх дүрийн зан төрхийн өөрчлөлтийг ажиглан, гүйцэтгээрэй.

	Их загал	Бага загал
Хөдөлгөөнийг нь илэрхийлсэн үгийг түүн бичиж, дүгнээрэй.		
Бодсон бодлыг нь түүн бичиж, дүгнээрэй.		
Ярьсан яриаг нь тэмдэглэн дүгнээрэй.		
Гаргасан шийдвэрийг тоочин, зөв, буруу аль нь болохыг дүгнээрэй.		
Хэрэв хүн байсан бол ямар зан төрхтэй гэж үнэлэх вэ?		

4. Тэдний ижил ба ялгаатай талыг задлан шинжилж дүгнээрэй.



Орчин нөхцөл нь дүрийн зан төрх, сэдэв, утгыг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.

1. Зохиолын эхэнд ямар орчин, нөхцөл байдал дунд хоёр загал амьдарч байсан бэ?
2. Нутгаа сольсон орчин нь дүрийн зан төрх, байр байдалд нөлөөлсөн үү?
3. Зохиолын төгсгөлд ямар орчин, нөхцөл байдал дунд амьдрав?
4. Хоёр загалын амьдралын орчин, нөхцөлийг өөрчилснөөр зохиолд ямар асуудлыг дэвшүүлсэн гэж дүгнэж байна вэ?

Бие даан сонгож уншсан зохиолыг бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой байдлаар танилцуулга бэлтгэж ярья.

Д.Намдагийн “Шарайголын гурван хаан” жүжгийг уншаад эсвэл <https://www.youtube.com/watch?v=J47XhTH9fxk> цахим хаягаар орж үзээд “Гэсэр”-ийн туужийн 5 дугаар бүлгийн ижил ба ялгаатай талтай харьцуулан ярина уу.

Танилцуулга бэлтгэхдээ:

- Танилцуулгыг ямар хэлбэрээр бэлтгэхээ сонгох
- Хоёр зохиолоос юуг, яаж харьцуулах тухайгаа төлөвлөх
- Сонирхол татахаар үзүүлж харуулах зүйлээ бэлтгэх (Зохиолын уран дүрслэлт үг хэллэг, сонирхолтой үйл явдал, мэдээлэл, жүжгийн үйл явдлыг харуулсан зураг, диаграмм, хүснэгт ашиглах)

Ярихдаа:

- Яриагаа хянаж, итгэлтэй, товч, тодорхой ярих
- Сонсогчидтой биеийн хэлэмж болон үг яриагаараа сайтар холбоо тогтоох
- Сонсогчдын сонсох чадварыг үнэлж асуулт тавих, сэтгэгдлийг сонсох, цөөн сорил бөглүүлэх гэх мэт.

Зохиолын дүрд үнэлгээ, дүгнэлт өгч, сонирхолтой арга хэлбэрээр илэрхийлж ярья.

Уншсан зохиолууд болон даалгавраас сонгож хийгээрэй.

Үнэлгээ, дүгнэлт өгөхдөө:

- ✓ Дүрийг хэлсэн үгээр нь дүгнэх
- ✓ Дүрийг хийсэн үйлдлээр нь дүгнэх
- ✓ Дүрүүдийн холбоо хамаарлаас дүгнэх
- ✓ Орчин, нөхцөл байдал нь дүрийг тодруулахад ямар үүрэгтэйг дүгнэх
- ✓ Бэлгэдэл нь дүрийг тодруулахад ямар үүрэгтэйг дүгнэх
- ✓ Дүрийг бүтээхдээ ямар үг хэллэгийг ямар зорилгоор сонгосныг дүгнэх

Зөвлөмж:

Сонирхолтой арга хэлбэрээр илэрхийлэхдээ:

Жишээ нь: Хятадын Гонма хааны төрийг зассан гуравдугаар бүлэгт “...Зэс илжгэнд унуулж дөрвөн зүгээс их хөөрөгчнөөр хөөрөгдүүлж алья» гэв. Гэсэр хаан морины толгойн чинээ цавгүй хар нүүрсийг биедээ нухаж түрхэж байв. Хөөрөгчин ирж дөрвөн зүгээс их гал тавин хөөрөгдвөл гал хүрч ирэхэд биеэсээ хувилгаанаар ус урсаад галыг унтрааж орхив” гэх мэт Гэсэрийн хийсэн үйлдлээс зарим сонирхолтой хэсгийг сонгож түүвэрлэнэ.

Түүнийгээ зураг болон компьютер ашиглан хөдөлгөөн оруулж сонирхол татахуйц болгоно.

Тухайн хэсгээр зохиолч юу хэлэхийг хүссэнийг ангийнхнаасаа асууж саналыг сонсоод дараа нь өөрийн дүгнэлтийг хэлэх гэх мэт.

БИЧИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолын сэдэв, утга санаа, дүр дүрслэлээс сонгон, баримт жишээ ашиглан, үнэлж дүгнэж бичье.

1. Уншсан 3 зохиолоос сонгоно уу.
2. Сонгосон зохиолынхоо сэдэв, утга санаа, дүр, дүрслэлийн алиных нь тухай бичихээ бодоорой.

Дэмжлэг:

Сэдэв, утга санааны тухай сонгосон бол ямар асуудлыг дэвшүүлснийг жишээгээр батлах, соёл, түүх, нийгмийн хам сэдвийг хөндсөн бол зохиолоос жишээ татах, ямар сэдэвтэй зохиол гэж үзсэнээ дүгнэж бичээрэй. Ингэхдээ түүх, нийгэм судлал, соёлын тухай мэдлэгтэй холбож, жишээ баримтаар өргөжүүлж болно.

Б. Дүр, дүрслэлийн тухай сонгож бичихээр бол ямар дүрийг ямар үг хэрэглэн, дүрсэлснийг зохиолоос жишээ татан бичих, зохиолын эхнээс аваад дуусах хүртэлх дүрийн зорилго, зан төрхийн өөрчлөлт зэрэгт үнэлгээ дүгнэлт өгч бичээрэй. Жишээ нь,

Бага загалын зорилго нь байсан учраас зохиолын эхэндийм дүр төрх, зан байдалтай байсан. Харин зохиолын гол хэсэгт бодол нь ийнхүү өөрчлөгдсөн учраас ...ийм шийдвэр гаргасан, энэ нь миний хувьд зөв эсвэл буруу санагдлаа. Учир нь зохиолд бичжээ. Дүрийг тодруулахад ...энэ үг их хүчтэй сэтгэгдэл төрүүллээ гэх мэтээр бичиж болно.

3. Ноороглож туршаарай.
4. Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаа байгаа эсэхийг хянаарай.
5. Дахин сийрүүлж бичээрэй.

Бичих чадвараа үнэлэх шалгуур

Шалгуур	Тийм	Үгүй	Сайжруулах шаардлагатай
Зохиолд дэвшүүлсэн асуудал болон соёл, нийгэм, түүхийн тухай асуудлыг тусгасан жишээг зохиолоос олж сонгож чадсан уу?			
Зохиолын сэдвийг тодорхойлж, дүгнэж чадсан уу?			
Дүрийг тодруулсан үг хэллэг, уран дүрслэлийг зохиолоос авч хэрэглэн, бичиж чадсан уу?			
Зохиолын эхнээс дуусах хүртэлх үйл явдлаас дүрийн зан төрх, зорилгын өөрчлөлтийг ажиглаж, дүгнэж чадсан уу?			
Үнэлгээ дүгнэлт чинь жишээ баримтаар батлагдсан байна уу?			
Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагүй байна уу?			



ЯРУУ НАЙРАГ

Энэ бүлгээс бид ямар чадвар эзэмших вэ?

- ❖ Яруу найргийн зохиолыг мэдэрч уншин, үгийн урлагийг биширч бахархсанаа илэрхийлэх
- ❖ Үг хэллэгийн сонгосон шалтгааныг тайлбарлах, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг тодорхойлох, нарийвчлан шинжлэх замаар үгийг оновчтой сонгохыг ухаарч ойлгох
- ❖ Зохиолын сэдэв, хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэх
- ❖ Зохиолын сэдэв, утга, дүр, үг хэллэгээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх



2. СОНГОДОГ ЯРУУ НАЙРАГ

СӨНИДИЙН ГИЛҮГЭДЭЙ БААТРЫН ХАРУУСЛЫН ШҮЛЭГ

Уншихын өмнө:

1. Гилүгэдэй баатар юунд харуусаж шүлэглэсэн юм бол? Мэдэрч уншаарай.
2. Ийм төрлийн өөр ямар шүлэг зохиол мэдэх вэ?

Харууслын шүлэг зохиол нь:

- ▶ Болж өнгөрсөн үйл явдалд бодитой үнэлэлт дүгнэлт өгдөг.
- ▶ Алдаа санамжаасаа бүтээлчээр суралцах боломж олгодог.
- ▶ Эргэцүүлэн бясалгасан гүн ухааны аястай.
- ▶ Холын ирээдүйд сэрэмж, залуур болдог онцлогтой.

Гашуудлын шүлэг нь:

Хүний сэтгэлийн гуниг догдлолыг гүн бөгөөд огцом хурц илэрхийлсэн байх ба голдуу нийтээр хүлээн зөвшөөрсөн гарамгай, баатарлаг хүмүүсийн гэнэтийн болон цаг бус үхэл, сүйрэлд харамсан гашуудаж байгаагаа илэрхийлсэн байдгаараа ерийн гунигт шүлгээс ялгаатай.

Эдгээр ойлголтдоо тулгуурлан Гилүгэдэй баатрын харууслын шүлэгт ажиглалт хийцгээе.

Сөнидийн Гилүгэдэй баатар магтруун:

“Халих харцагайн жигүүр болон одов уу, чи эзэн минь!
Хангинах тэрэгний тээш болон одов уу, чи эзэн минь!
Туулих харцагайн жигүүр болон одов уу, чи эзэн минь!
Тойрох тэрэгний тээш болон одов уу, чи эзэн минь!
Жиргэх шувууны жигүүр болон одов уу, чи эзэн минь!
Жирхирах тэрэгний тээш болон одов уу, чи эзэн минь!”

гэж магтаж иртэл Мунын Хөөвөрт хүрээд, *1-р хэсэг*

Хар буур хавирга чинээ (хүртэл) шигдэж
Хасаг нь бул чинээ (хүртлээ) шигдэж
Хөдөлгөн ядахуйд
Таван өнгийн хөлгүүдийг хөлж гарган ядаж
Гүр улс зовохуйд

Сөнидийн Гилүгэдэй баатар мөргөн өчвэй. *2-р хэсэг*

“Хөх мөнх тэнгэрээс заяагаар төрсөн
Хөлөг богд эзэн минь
Гүр их улсаан орхиж
Хүрвэй чи, дээд төрөлдөө
Төвшнөө байгуулсан төр чинь
Төрлөн байгуулсан улс чинь
Төрүүлсэн хатан, хөвгүүд чинь
Төрсөн хан газар ус чинь тэнд бөлгөө
Ариунаа байгуулсан төр чинь

Албалан байгуулсан улс чинь
Амраг хатад хөвгүүд чинь
Алтан орд харш чинь тэнд бөлгөө
Урнаа байгуулсан төр чинь
Учралдсан хатад хөвгүүд чинь
Урьд зөөсөн олон улс чинь
Ураг элгэн чинь тэнд бөлгөө
Ургамал улс иргэн чинь
Угаасан ус цасан чинь
Олон монгол улс чинь
Ононы Дэлүүн болдог
Төрсөн газар чинь тэнд бөлгөө
Хээр азарганы хөхлөөр
Гөрж хийсэн туг сүлд чинь
Хэнгэрэг бүрээ уриа чинь
Хэлхү бүгд улс чинь
Хэрлэний Хөдөө арал
Хаан суусан газар чинь тэнд бөлгөө.
Бүтэхийн урьд учирсан
Бөртэгэлжин сэцэн хатан чинь
Буянт хан газар нутаг ус чинь
Боорчи, Мухулай хоёр амраг нөхөр чинь
Бүрэн их ёс чинь тэнд бөлгөө
Хувилгаанаар учирсан
Хулан хатан чинь
Хуур, цуур, хөг дуун чинь
Хотол бүгд их улс чинь тэнд бөлгөө
Харууна ханыг дулаан гэж
Хатан Гүрвэлжинийг гоо гэж
Харьтан Тангад улсыг олон гэж
Хуучин Монголоо ийн тэвчив үү чи, эзэн минь
Хайрт амь чинь гарваас
Хас эрдэнэ мэт хүүрийг чинь авч харья
Хатан Бөртэгэлжинд чинь үзүүлье
Хамаг улсад чинь хүргэе
Хамгийн мөнх цагаан гэрийг авч
Хан их газарт чинь хүргэж байгуулъя” хэмээн өчвөөс, 3-р хэсэг
Хан эзэн энэрэн соёрхвой.
Хасаг тэрэг хангирсан хөдөлбэй
Хар буур сүйлэн гүйв
Хамаг улс баясгалант болбой
Хан их газраа тэнд хүргэвэй.
Хамгийн мөнх хөөр тэндээс үүсгэж
Хан зайсангуудын тулга болж
Хамаг улсын шүтээн болоод
Хамгийн мөнх хадаасан
Найман цагаан гэр болбой за.

Эзэн эндээс эчихүйд, бахархан зарлиг болсны шалтгаанаар
 Эдүгээ тугаар хасаг тэрэг бул чинээ (хүртлээ) шигдвэй. **5-р хэсэг**
 Энэ их улсад хотол тунхаг өгч, өмссөн цамц, өргөө гэр, өрөөсөн оймсыг тэнд
 онголов. Үнэн хүүрийг нь заримууд Бурхан Халдунд онголов гэх. Заримууд Алтай
 ханы ард, Хэнтий ханы өвөрт Их өтөг нэрт газраа онголов гэх буюу.

Эх сурвалж: “Хаадын үндсэн хураангуй алтан товч” УБ., 2002. 58-60-р тал.

Үгийн тайлбар:

Чинээ - хүртэл, хүртлээ

Эчихүй - очихуй

Тугаар - сая, саяын

Хэлхү - бүгд, олонх

(Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>)

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛБЕ.

Зохиолыг мэдэрч ойлгож уншъя.

1. Гилүгэдэй баатар ямар үед шүлэглэсэн бэ?
2. Гилүгэдэй баатар юунд гашуудаж шүлэглэв?
3. Шүлгээс сэтгэл хөдлөлийн ямар өнгө аяс мэдрэгдэж байна вэ?
 - Харууссан өнгө аяс
 - Гашуудсан өнгө аяс
 - Бахархсан өнгө аяс
 - Аргадсан өнгө аяс
 - Гуйсан өнгө аясаас илүү мэдрэгдсэн нь аль нь вэ?
4. Гилүгэдэй баатар юуг эргэцүүлэв? Хэддүгээр хэсэгт эргэцүүлсэн өнгө аяс мэдрэгдэж байна вэ?
5. Гилүгэдэйн сэтгэлийн гуниг, догдлол огцом хурц илэрсэн мөрүүд хэддүгээр хэсэгт байна вэ? Яагаад ингэж үзэв?

Шүлгийн сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг тодорхойлон дүгнэе.

1. Эзэн Чингисийг тэнгэрт халихад Их Монгол даяар харуусан гашуудсаны учир юу вэ?
2. Шүлгийн хэсэг бүрт ямар утга илэрч байна вэ? 58 дугаар хуудсанд буй түлхүүр нэр томьёо та бүхэнд тусална.

	Юуны тухай өгүүлсэн бэ?	Тайлбар
1-р хэсэг	харуусан магтсан
2-р хэсэг	
3-р хэсэг	
4-р хэсэг	
5-р хэсэг	өгүүлэгчийн хүүрнэл

- Эзэн хааныг тодруулж буй дүрүүдийг тоочин бичээд, шүлгийн санааг хэрхэн тодруулж буйг тайлбарлана уу.
- Болж өнгөрсөн түүхэн ямар ямар үйл явдлыг энэ шүлэгт дурдсан бэ? Тэрхүү түүхийг сэтгэлийн ямар өнгө аясаар илэрхийлж байна вэ?
- Гилүгэдэй баатрын харууслаас ямар хүн гэж дүгнэж байна вэ? Яагаад?
- Гилүгэдэй баатар дараах үгсийг яагаад чухалчлан сонгож өгүүлэв? Учир утгыг нь та нар юу гэж бодож байна вэ?

№	Эшлэл	Тайлбар	Эшлэл	Тайлбар
I	Хөх мөнх тэнгэр		Туг сүлд	
	Хөлөг богд эзэн		Хэнгэрэг, бүрээ	
	Хүр их улс		Хэрлэний Хөдөө арал	
II	Төр		Бөртэгэлжин хатан	
	Хатан, хөвүүд		Боорчи, Мухулай	
	Төрсөн хан газар ус		Хулан хатан	
	Алтан орд харш		Хуур цуур, хөг дуу	
	Ураг элгэн, улс иргэн			

Шүлгийн шад, бадаглал, холбоцыг тайлбарлая.

Дараах онолын мэдээллийг уншаад, асуулт зохиогоорой.



Түлхүүр нэр томьёо:

Шүлгийн хэлийг яруу сонсголонтой болгох зорилгоор ижил буюу төстэй, эгшиг болон гийгүүлэгч авиагаар гол төлөв мөрийн толгой, сүүлийг эхлэх, төгсгөх зэргээр айзам хэмнэлийг бүтээдэг дүрслэлийн ур маягийг холбоц гэнэ. Бадгийн эхлэл, төгсгөл нь ижил авиагаар холбогдсон бол тэгш холбоц, бадгийн эхлэл төгсгөл нь ижил бус, ойролцоо төстэй авиагаар сөөлжилж холбогдсон бол тэгш бус холбоц гэнэ.

Холбоц нь дараах хэлбэрүүдтэй байна.

ААББ

АБАБ

АББА

АААА

АААБ

- Уншсан шүлгийнхээ холбоцыг ажиглаарай. Аль хэсэг нь яруу сонсголонтой сонсогдож байна вэ? Учир нь юундаа байна?
- Шүлгийн эхэнд адилтган зүйрлэхдээ ямар холбоцыг ашигласан байна вэ?
- Шүлгийн хэмнэл нэгэн жигд үү эсвэл олон хэлбэрээс бүрдэж байна уу?
- Аргадаж шүлэглэсэн хэмнэл ямар үг хэллэгээр илүү илэрч байна вэ?

Аргадсан шүлгийн хэмнэл

...

...

...

Уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжилье.

1. Шүлгээс үндсэн утгаа гээж, шилжсэн утгаар орсон үгсийг түүн бичнэ үү. Яагаад үндсэн утгаа алдсан гэж үзэж байна вэ? Тайлбарлаарай.
2. Чингис хааны биеийг юутай адилтгаж дүрсэлсэн бэ? Ямар шинж байдлыг тодруулж адилтгав? Хэддүгээр хэсэгт байна вэ?

Зохиолчийн үг сонголтыг судалъя.

1. Нэгдүгээр бадагт эзэн Чингисийг юуны жигүүр болов гэж бичсэн бэ? Зохиолч ямар зорилгоор ийнхүү бичив? Эргэцүүлээрэй.
2. “Хасаг тэрэг бул чинээ (хүртлээ) шигдвэй” гэсэн утгыг дахин анзааръя. Хасаг тэрэг өөрөө шигдэж зогссон уу? Эсвэл зохиогч нь зориуд ийнхүү дүрсэлсэн үү? Та нарын бодол?
3. Улсыг “Гүр” улс гэсний учир юу вэ? Толь бичгээс лавлан тайлбарлаарай.
4. Чингис хааныг “Хөлөг богд эзэн” гэж тодруулсныг та нар юу гэж бодож байна? Зохиолчийн үг сонголтын шалтгаан нь юу байв? “Хөлөг” гэж яагаад цоллов?
5. “Хаан эзэн энэрэн соёрхсон” гэж бичсэний учир юунд вэ? Энэ нь ямар утгыг илэрхийлсэн бэ?

МАНДУХАЙ СЭЦЭН ХАТНЫ ТАНГАРГИЙН ШҮЛЭГ

Уншихын өмнө:

1. Мандухай сэцэн хатны тухай хэр сайн мэдэх вэ? Түүхэн эх сурвалжуудыг судлаарай.
2. “Мандухай сэцэн хатны домог”-ийг сэргээн санацгаая. Киноны тухай ярилцана уу.
3. Тангараг гэж юу вэ? Тангаргийн мөн чанар аль үгэн дээр илэрч буйг анзаарч уншаарай.

Мандухай сэцэн хатан Даян хаанд гурван давхар улт гутлыг өмсгөн, алагчуудын үнээний алаг лонхт архи авч, Найман цагаан ордны өмнө очиж, гэрийн ноён Мэнгинээр суут хаан хатны сүлдэнд сацал сацуулж, өөрөө ийн өгүүлбэй.

Хар цагааны зүсэн ялгагдах үгүй
Харь газар бэрлэдэг билээ, би
Хаан чиний үрийг балчир гэж
Хасарын үр авъя гэхэд
Хайрлан тэтгэх өршөөлийг эрж
Хааны ордны дэргэд ирвэй би
Харах нүд минь далдирч байна
Харайх хөл минь сөгдөж байна
Алаг морины зүсэн ялгагдах үгүй
Алс газар бэрлэдэг билээ
Ач нар, үрийг чинь өчүүхэн гэж

Алсын авга авъя гэхэд
Арчлан тэтгэх өршөөлийг эрж
Алтан ордны чинь дэргэд ирвэй би
Айх амь минь алдарч байна
Арчих нүүр минь улайж байна
Өргөн их үүдийг чинь хөнгөн гэж
Өндөр их босгыг чинь нарийн гэж
Өөр хүмүүнд эчвээс
Өөд үгүй нэр над хоцормуй
Балчир үрийг чинь бага гэж
Басаж доромжлох үгүй би
Болд унг их гэж
Богтлогдож очих үгүй би
Уурга чинь урт биш үү
Уургалж ав, өчүүхэн намайг
Хуйв чинь агуу биш үү
Хурааж ав, өчүүхэн намайг
Хав хүч бүрдсэн
Хаан хөвгүүн төрж бөлгөө
Хар биеэн мэдэж эчвээс
Хаа гуяас хагацсу, би
Эзэн Богдоос минь
Эрхэм хөвгүүн төрж бөлгөө
Эрхэм хөвгүүнийг чинь алдав гэж
Эм хүмүүн биеэ мэдэж эчвээс
Эзэн хаан таны өмнө
Эвдүүлсү би, гэж
Үнэн үгсээ өгүүлж
Үүрдийн тангараг өргөөд
Хувь заяаг соёрхож
Хутгийг гуйж залбирсан нь
Энэ үгийг минь зөвшөөх болбоос
Эмэгтэй намайг өршөөх болбоос
Эрхэт хаан эцэг минь
Эши хатан эх минь
Дотоод энгэрт минь
Долоон хөвгүүн төрүүл
Гадаад энгэрт минь
Ганц охин төрүүл
Доорд хатан над
Долоон нуган заяаваас
Долууланд Болд нэр өгч
Гал голомтыг чинь сахиулъя
Газар нутгийг чинь эзлүүлъя” гэж залбираад харив.

Эх сурвалж: “Мандухай сэцэн хатны домог”. “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив” Ц.Дамдинсүрэн, УБ., 1959, 181-183-р тал.

Үгийн тайлбар:

Эчвээс - очвоос

Богтлогдох - хадамд гаргах эртний ёс заншил

Бэрлэх - бэрийн ёс сахих, ёслох

Нуган үр - гал голомт залгах эрэгтэй хүүхэд

(Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>)

Тайлбар. Энэхүү домог нь “Алтан товч”, “Чингисийн цадиг”, Саган сэцэний “Эрдэнийн товч”, Рашипунцагийн “Болор эрх” зэрэг сурвалжид тэмдэглэгдэн эдүгээд өвлөгдөн иржээ.

Энэ домгийн дотор дурдсан Мандухай сэцэн хатан нь түүхэн хүн юм. Тэрээр 1448 онд Түмэд аймгийн Онгуд отгийн Цоросбай Төмөр чинсангийн охин болон мэндэлжээ.

Айлын ганц охин тул эрх танхи өссөн ч ааваараа монгол бичиг заалгаж, уншиж бичиж сурсны зэрэгцээ морь унаж, нум сум харвахад эрэмгий болжээ.

Монгол төрийн төлөө сэтгэл зүрх, зориг чадлаа зориулан бүх цэргийг жанжилж явахдаа дайны тоосон дунд хүүхдээ төрүүлж байв.

Түүхэнд үлдсэн гавьяа: XV зууны үеийн тарж бутарсан овог аймгуудыг нэгтгэж чадсан баатарлаг эмэгтэй, монгол түмний хүндтэй хатан юм. Учир нь 1467 онд Мандуул хаан таалал төгсөхөд өөрийн хайр сэтгэлийг огоорч, алтан ургийн Баянмөнх жононгийн өнчин нялх хүү Батмөнхийг олж авчран, өсгөж, долоон настайд нь хаан ширээнд өргөмжилжээ. Тэрээр задран унаж байсан их улсыг буцаан нэгтгэж, төр улсаа төвхнүүлсэн гавьяатай билээ.

Батмөнх даян хаан бүх Монголыг нэгтгэн захирч, жар гаруй жил төр барьсан нь Мандухай сэцэн хатны холч мэргэн ухаантай холбоотой юм.

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолыг мэдэрч ойлгож уншъя.

1. Хааны ордонд ирэх болсны шалтгаан юу байв?
2. Дараах шүлгийн хэсгийн утгыг сайтар эргэцүүлж, “Өргөн их үүд, өндөр их босго” гэдгээр юуг хэлж байна?
3. Мандухай юунаас айв? Түүний дотоод сэтгэлийг мэдэрч байна уу? Тэр юунд санаа зовж, ямар шийдвэр гаргав?
4. Долоон нуган заяаваас долууланд нь Болд гэдэг нэрийг яагаад өгөх болов?

Шүлгийн сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг тодорхойлон дүгнэе.

1. Ямар түүхэн нөхцөл байдалд амьдарч байсан хүн бэ? Тухайн түүхэн цаг үеийн талаар ямар сэтгэгдэл төрөв?

“Өргөн их үүдийг чинь хөнгөн гэж
Өндөр их босгыг чинь нарийн гэж
Өөр хүмүүнд эчвээс (очвоос)
Өөд үгүй нэр над хоцормуй”.

2. Шүлэгт юуг тангараглав? Тангаргаас ямар утга тодорч байна вэ? Сонгоорой. Тодорхойлоорой.


Хааны удмыг таслахгүй гэсэн санаа	Эр нөхөртөө үнэнч эмэгтэй хүний тухай өгүүлсэн
Өөрийн жаргалыг бус улсынхаа хувь заяанд санаа зовсон хүний тухай өгүүлсэн	Та нарын бодлоор ямар утга илэрсэн бэ?

3. Ард олны дунд домог болон уламжлагдаж ирсний шалтгаан нь юу вэ? Аль хэсэгт илэрсэн бэ?
4. Мандухай хатан яагаад “сэцэн” хэмээн өргөмжлөгдсөн бэ? Тангаргийн мөн чанар аль үгэн дээр хэрхэн илэрч байна вэ?
5. Гол санааг илэрхийлсэн хоёр мөрийг шүлгээс олно уу.

Шүлгийн шад, бадаглал, холбоцыг тайлбарлая.

1. Тангаргийн шүлгийн бүтэц, хэмнэлийн онцлог юунд байна вэ? Холбоц, мөр бүрийн үгийн тоог анзаарсан уу?
2. Шүлгийн аязам хэмнэлийг тодруулж, Мандухайн сэтгэлийг бусдад мэдрэгдэхээр унших дасгал хийгээрэй. Яаж уншихаа 72 дугаар талд байгаа зөвлөмжөөс санаа аваарай.

Уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжилье.



Зохиолчийн үг сонголтыг судалъя.

1. Алтан ураг, Хасарын удам гэсэн ойлголтын ялгааг товч бичнэ үү.	2. Дүрээ тодотгон урлахын тулд хэрэглэсэн үгийг сонгоно уу.	3. Ойролцоо утгатай ямар ямар үгс байна вэ?
Хариулт	Хариулт	Хариулт

ЦОГТ ТАЙЖИЙН ХАДНЫ БИЧИГ

Уншихын өмнө:

1. Цогт хун тайж гэж хэн бэ?
2. Уг шүлгийн зохиогдсон түүхэн цаг үе, байгаль орчныг төсөөлөн бодоорой.
3. Шүлгийн утга санааг тодруулах үүднээс айзам, өргөлтийг анзаарч уншаарай.

Цагаан тахиа жилийн намрын эхэн сарын хорин нэгнээ. Цогт тайж Хангай ханы цэцэрлэгийн хойд ууланд авлан, хуягт халтраа унаад, өндөр дээр гарч байхдаа зүүн зүг харан сэтгэлдээ маш уярч, Халуут авга эгч юүгээн санаж ийн өгүүлээд уйллаа.



“Цогт тайж” (1980) киноны
голд дүрд АЖ Ц.Цэгмэд

Дээр тэнгэр ханы аху хийгээд
Дэлхий дэх хан Богдосын аху газар
Дээр дорын ялгал болбоос бээр (буй боловч)
Жаргал, хайрлал хоёрын агаар нэгэн буй

1-р бадаг

Агнистайн агуй дахь бодисад нар хийгээд
Алтан дэлхий дэх бодь сэтгэлтэн хоёрын
Аху газар ангид болбоос
Асрах нигүүлсэхүйн агаар нэгэн буй

2-р бадаг

Энд Хан Богдосын сайн түшмэд хийгээд
Эрүүлэгч Эрлэг хааны их ноёд хоёрын
Ёс өнгө өөр болбоос
Зөв бурууг ялгахуйн агаар нэгэн буй

3-р бадаг

Олз идэш олон ядагч хүмүүн хийгээд
Уул модонд явагч араатан хоёрын
Аху бие ангид болбоос
Алан идэхүйн агаар нэгэн буй

4-р бадаг

Хол ойроос хулгай хийгч хүмүүн хийгээд
Хотыг эргэн гэтэгч чоно хоёрын
Илт бие дүр өөр болбоос
Идэхүйг хүсэх сэтгэлийн агаар нэгэн буй

5-р бадаг

Онон мөрөнд аху Халуут эгч минь хийгээд
Орхон Туулд агч өвчит бид хоёр
Халх Онигуудын газар хол болбоос бээр
Хайрлан саналцахын агаар нэгэн буй

6-р бадаг

Энэ биендээ эс золголцвоос
Үүнээс хойд төрөл тутамдаан
Эх нь ганц хүүхнээ хайрлах мэт
Элдэв үйлээр туслалцах болтугай”

7-р бадаг

хэмээн хайлан өгүүлснийг нь хамт асан Эрх хиа тогтоож сударлан авсныг
хойно дөрвөн жил болоод мөн хулгана жилийн нэгэн сарын арван наймнаа
Дайчин хиа, Гүен баатар хоёр хаданд бичив.

*Эх сурвалж: “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршиё”
(Шинэ үсэгт буулгасан Д.Цолмон) УБ., 2001, 235-236-р тал.*

Цогт хун тайж хэмээн алдаршсан Түмэнхэн (1581–1637) нь Чингис хааны хөвгүүн Толуйн удам, Батмөнх даян хааны отгон хүү, Гэрсэнз Жалайр хун тайжийн гутгаар хөвгүүн болох Нооноху үйзэн ноёны тав дахь хүү Баарай хошууч баатрын ахмад хөвгүүн ажээ.

Цогт тайж Туул гол орчимд суурьшиж өөрийн эхийн хамт сүм хийд байгуулан улааны шашны ном судар орчуулах, дэлгэрүүлэх үйлсэд хүчин зүтгэсэн бичгийн их хүмүүн, соён гэгээрүүлэгч байв. Түүний байгуулсан “Сэтгэшгүй чандмань” тэргүүтэй 6 сүмийн үлдэц туурийн нэг нь 1601 онд одоогийн Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт бүтээсэн “Цогтын цагаан байшин” юм. Мөн тэрбээр манжийн эсрэг цогтой тэмцэгч, XVII зууны эхэн үед Түшээт хааны дараа хоёрдугаар дэсэд орох Халхын зүүн гарын эрх мэдэлтэн, улс төрийн зүтгэлтэн байв.

(Эх сурвалж: <https://mongoltoli.mn/history/h/96>)

Үгийн тайлбар:

Цагаан тахиа жил - Нийтийн хэлдгээр цагаагчин тахиа жил нь 1621 он юм.

Хуягт халтар - Ан гөрөө, дайн байлдаанд явахдаа хуяг өмсөж унадаг халтар зүсмийн морь байжээ.

Халуут (Халагут) - халуун элгэн дотно

Агаар нэгэн буй - уг чанар, мөн чанар, үүсгэл

Аху - Оршин буйг заах үг

Болбоос бээр - буй боловч

Богдосон - Богд

Ангид боловч - өөр боловч

Агнистай - Самгарди хэлний үг. Бурхан бүхний төгс жаргалант биеийг олох газар орны нэр.

Бодисадва (бодисад) - Бурхны шашны дээд төрөлхтний нэр.

Бодь сэтгэлтэн - чин ариун сэтгэлтэн
Эрүүлэгч - эрүү шүүлт тулгагч

Өвчит - Өөрийн биеийг дорд үзсэн найруулга.

Онигууд - 17-р зууны үед Онон, Хэрлэнгээр нутаглаж, хожим Өвөр Монгол руу нүүсэн овог.

(Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>)

Тайлбар: Дуутын хар чулуу

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт бичиг сийлэхэд тун тохиромжтой, гөлгөр бараан хадан цохионууд байх бөгөөд ямар нэг зүйлээр цохиход хангинах дуу чимээ гардаг учир “Дуутын хар чулуу” хэмээдэг. Тэнд байх олон бичээс, сүг зургийн нэг нь “Цогтын шүлэг” (1624) билээ. Дуутын хадны бичээсийг их бичээс, дунд бичээс, бага бичээс хэмээн нэрлэдэг. Их бичээс нь “Цогтын хадны шүлэг” агаад Дуутын хар чулууны гурван том сэрүүн цохионы баруун зүгт харсан босоо хадны 17 мөр монгол бичээс билээ. Хадны өндөр нь 237 см, өргөн нь 135 см, мөр хоорондын зай 3-4.5 см, мөр бүрийн уртын хэмжээ 79-88 см юм.

Нэмэлтээр унших: Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд “Монголын уран зохиолын тойм” II, УБ., 1976.



Дуутын хадны бичээс



Их бичээс буюу “Цогтын хадны бичиг”
Эх сурвалж: www.urlag.mn

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолыг мэдэрч ойлгож уншъя.

1. Цогт тайж Халуут авга эгчээ санаж шүлгээ бичсэн үү? Эсвэл өөр зорилго байв уу? Чи яаж мэдэв?
2. Цогт тайж юунд санаа зовдог хүн бэ? Ямар үг хэллэгээс зохиолчийн дотоод ертөнцийг таньж болох вэ?
3. Ямар ямар ертөнцийн тухай өгүүлж байна вэ? Эдгээр ертөнцөд оршигчдын чанар нь юу вэ?
4. Зохиолчийг бясалган тунгааж бичдэг гэдэгтэй санал нийлэх үү? Яагаад?

Шүлгийн сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг тодорхойлон дүгнэе.

1. Эхлэлээс төгсгөл хүртэлх агуулгыг харьцуулж хараарай.

	Юугаараа ижил мөн чанартай гэсэн бэ?	Яагаад ингэж өгүүлэв?	Үзэл бодлоо илэрхийлээрэй.
1-р бадаг			
2-р бадаг			
.....			

2. Зохиолч юуны тухай өгүүлсэн бэ? Зохиолч хэнээс, юунаас юуг хүсэж байна вэ? Дүгнэн ярилцаарай.
3. Цогт хун тайжийг амьдарч байх үеийн нийгмийн байгууллын тухай сурвалжлан уншаарай. Шүлгийн утгатай холбон тайлбарлаарай. Дараах шалгуураар өөрийгөө үнэлнэ үү.

Шалгуур	Тийм	Үгүй	Зорилгоо тодорхойлъя. Унших чадвараа сайжруулъя.
XVII зууны үеийн нийгмийн байгууллын тухай сурвалжлан уншсан уу?			
Шүлгийн утга санааг дүгнэсэн үү?			
Нийгмийн онцлогоос шалтгаалж, асрах нигүүлсэх, хайрлан жаргах, зөв бурууг ялгах, алан идэхийн тухай бичих зорилго Цогт хун тайжид байсан уу?			
Шүлгийг задлан шинжлэх нь сонирхолтой байв уу?			

4. Хүний ямар зан байдал, гэм дутагдлыг бичсэн бэ? Энэ талаар бодит амьдралаас жишээ татан саналаа хэлнэ үү.
5. Мэдээллийг уншаад, задалж ярилцаарай.


Аливаа юманд хэлбэрийн ялгаа байвч агуулгаараа ижил юм гэсэн санааг гаргаж, сайн, муу мөн чанараар нь сөргүүлэн утга далдлан бичсэн учраас гүн ухааны өнгө аястай болжээ.

Шүлгийн шад, бадаглал, холбоцыг тайлбарлая.

1. Бадаг бүрийн мөрүүдийг харьцуулан ажиглаарай.
 - Эхний хоёр мөр, гуравдугаар мөр, дөрөвдүгээр мөрийн утгыг харьцуулан эргэцүүлээрэй.
 - Бадаг бүр дэх давтагдсан найруулга нь шүлгийн айзам, хэмнэлд нөлөөлж байна уу?
2. Шүлгийн зохиомжийн онцлогийг тодруулаарай.
 - А. Зохиолч яагаад шүлгээ эхлэхдээ дээр тэнгэрээс гэж эхэлсэн бэ?
 - Б. Дээрээс доошлох тутам утга санаа нь өөрчлөгдсөн үү?
 - В. Шүлгийг дээр тэнгэрээс Онон мөрөн хүртэлх орон зайд зохиомжилсон нь та нарт ямар санагдаж байна вэ?
 - Г. Бусдынхаа саналыг сонсоод, тодруулж асуугаарай.
 - Д. Хамгийн сонирхолтой санал хэлсэн нь хэн байв? Яагаад сонирхолтой байв?

Уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжилье.

1. Шүлгээс үндсэн утгаа гэж, шилжсэн утгаар орсон үгсийг түүн бичнэ үү. Яагаад үндсэн утгаа алдсан гэж үзэж байна вэ? Тайлбарлаарай.
2. “Эх нь ганц хүүхнээ хайрлах мэт Элдэв үйлээр тусалцах болтугай” гэснээс зохиолч үзэл бодлоо илэрхийлэхдээ юуг юутай адилтгасан бэ? Ямар шинжээрээ адилхан байна вэ?
3. Хүснэгтийг ажиглаад ямар шинжээр нь адилтгаж байгааг тайлбарлаарай.



4. Хийсвэр болон бодит юмс үзэгдлийг шинж чанараар нь адилтгасан нь уран сайхны ямар ач холбогдолтой болж байна вэ? Саналаа хэлээрэй.

Зохиолчийн үг сонголтыг судалъя.

1. “Агаар нэгэн буй” гэсэн үгийг олонтоо давтсаны учир юу вэ? Зохиолч ямар зорилгоор энэ үгийг хэрэглэсэн бэ?
2. Зохиолч заавал “чоно, араатан” гэсэн үгийг хэрэглэж, хүнтэй харьцуулдгийн учир юу вэ?
3. Аливаа зүйлийг харьцуулахдаа “ялгаатай” гэсэн санааг шүлэгт ямар үгээр илэрхийлсэн байна вэ?
4. “Аху”, “хийгээд” гэсэн үгс ямар утга илэрхийлж байна вэ?
5. Шинээр ямар ямар үгс мэдэж авав?
6. Дараах асуултад хариулаарай.

	Тийм	Үгүй
Зохиолчийн үг сонголтыг судлах нь ач холбогдолтой юу?		
Үг сонголтоос зохиолчийн санаа бодлыг мэдэрч болох уу?		
Зохиолчийн сонгосон үгс нийгмийг шүүмжилж чадсан уу?		
Зохиолчийн шүүмжлэлт санаатай санал нийлж байна уу?		

Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцье.

Алхам 1. Уншсан шүлэг бүрийнхээ дэвшүүлсэн асуудал болон нийгэм, түүхийн асуудлын талаар дахин эргэцүүлэн бодно уу.

Сонгох даалгавар

- А. Мэтгэлцэх сэдвээ ангиараа тохирч түүх, нийгмийн хичээлтэй холбон, сонгож болно.
- Б. Зохиолын сэдэв, хам сэдвийг дүртэй холбон санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцээрэй. Дараах асуултыг хэрэглэнэ үү.

	Тухайн үеийн нийгэм, орчин, нөхцөл байдалдаа дасан зохицсон байсан уу, эсвэл тэмцэж, өөрийгөө ялж байна уу? Дүрийг үнэлнэ үү.	Энэ дүр ямар нийгэмд амьдарч байсан бэ?	Тухайн үеийн нийгмийн байдлыг одоо үетэй харьцуулж үнэлнэ үү.
Гилүгэдэй баатар	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
Мандухай хатан	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
Цогт хун тайж	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>



Алхам 2. Сэдвийн дагуу судалгаа хийнэ үү. Шүлэг бүрд илрэх нийгэм, түүхийн холбогдолтой мэдээ, баримтыг сурвалжлан дэлгэрүүлэн уншина уу. Баримт, нотолгоог мэтгэлцэхдээ хэрэглээрэй.

Алхам 3. Нотлогч, няцаагч талууд цуглуулсан нотолгоонуудаа боловсруулж, хариултыг бэлдэнэ.

Алхам 4. Мэтгэлцэхдээ нотлогч тал асуудлыг нотолж, няцаагч тал тодруулж асууж болно.

Мэтгэлцэх чадвараа дараах шалгуураар үнэлнэ үү.

Шалгуур	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай гэж бодож байна.
Бусдын саналыг ойлгож, мэдэрсэн үү?			
Мэтгэлцээнд зөрчлийг шийдвэрлэж чадсан уу?			
Нийгэм, түүхийн хам сэдвийн хүрээнд хамгийн үнэ цэнтэй нотолгоог дэвшүүлж чадсан уу?			
Идэвхтэй оролцоотой сонсох чадвартай байж чадсан уу?			
Өөрийн үзэл бодлоо бусдад ойлгуулж чадсан уу?			
Шүлгийн утга, сэдэвтэй холбоотой түүхэн баримтуудыг сурвалжлан уншсан уу?			
Санаа бодлоо нотлох, эсвэл бусдын саналыг няцаахдаа жишээ баримт хангалттай ашигласан уу?			

Алхам 5. Ярихдаа дараах аргаас сонгоорой.

- Ханын сонин бэлтгэх
- Зурагт ном боловсруулах
- Илтгэл боловсруулах
- Хэвлэлд бэлтгэх
- Цахим мэдээлэл бэлтгэх
- Эсээ бичих
- Захидал бичих
- Шүлэг бичих гэх мэтээр өөр ямар арга, хэлбэрээр илэрхийлэхээ бодоорой.

Бие даан гүйцэтгэх даалгавар

1. Өөрийгөө сориорой.

- А. Шинээр мэдэж авсан үг, дүрслэлт үг, өвөрмөц содон санагдсан үгээ жагсаан бичнэ үү.
- Б. “Агаар нэгэн буй” гэсэн үгийг өөр үгээр илэрхийлэн бичнэ үү.
- В. Зэрэгцэх ба салаавчилсан холбоцын ямар жишээг олж харав?
- Г. Ойролцоо ба эсрэг утгатай ямар үгс байна вэ?
- Д. Уран яруу, айзам хэмнэлтэй болгож буй уран дүрслэлийн жишээг бадаг бүрээс түүвэрлэн бичээрэй.
- Е. Ямар нэртэй газар Эзэн хааны “хас эрдэнэ мэт” шарил саатан зогссон бэ?

2. Цахим орчноос шүлэгт холбогдолтой зураг, мэдээлэл татаж судалъя. Хэдэн оны ямар улиралд бичсэнийг олж тэмдэглэнэ үү.

- а) 1702 оны өвөл
- б) 1528 оны хавар
- в) 1621 оны намар
- г) 1823 оны зун

3. ОРЧИН ҮЕИЙН ЯРУУ НАЙРАГ

Уншихын өмнө:

1. Гарчгийн утгыг сайтар бодож эргэцүүлэн, зохиолчийн санааг таамаглан ярилцаарай.
Боржигин.....
Бор
Тал
2. Ийм нэртэй газар орны нэр мэдэх үү? Эсвэл зохиолч утга шингээж, шүлгээ ийнхүү нэрлэв үү?



Төрсөн он, газар: 1944 онд Төв аймгийн Баян-Өнжүүл суманд төржээ.

Боловсрол: 1963 онд Улаанбаатарт Худалдааны техникум төгссөн, 1973 онд Москвагийн Киноны дээд сургуульд суралцжээ.

Уран бүтээл: 1962 оноос уран бүтээл туурвиж эхэлсэн. 4000 мөр бүхий “Тамгагүй төр” эмгэнэлт жүжиг, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулж “Атга нөж” жүжиг туурвисан. 1992 онд УИХ-ын гишүүнээр сонгогдож, соёл урлагийн олон хуулийг санаачилжээ.

“Бүлээн нурам”, “Араатан”, “Хүн чулууны нулимс”, Хүннүгийн тухай “Бор манан” зэрэг кино зохиол бичжээ.

Бавуугийн Лхагвасүрэн

БОРЖИГИНЫ БОР ТАЛ

Санаа алдахад
Эхийн минь сүү тагнайд амтагдаж
Салхины үзүүр залгихад
Агь хоолойд аргасан
Боржигины бор тал минь *1-р хэсэг*
Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог
Тэнгэрийн хэвтэр буурал тал минь *2-р хэсэг*
Таанын цагаан толгойноос өөр
Тайтгаруулах цэцэггүй нүцгэн тал минь *3-р хэсэг*
Нандин эрхэмсэг эгэл боргилын туйл
Нар хур царайчилсан газрын саалтай хормой минь *4-р хэсэг*
Тэнгэр тийчиж, чулуу ханарааж төрөхөд тал минь чи
Торго шиг зөөлөн байсан
Жаргал зовлон хоёрыг амсаж эдэлж

3. Шүлэгт зохиолчийн сэтгэлийн ямар ямар өнгө аяс илэрч байна вэ?
 Баярлаж догдолсон сэтгэл бүхий мөрүүд үг хэллэгүүд
 Гунигласан сэтгэл бүхий мөрүүд үг хэллэгүүд.....
 Санааширсан сэтгэл бүхий мөрүүд..... үг хэллэгүүд
 Бахархсан сэтгэл бүхий мөрүүд..... үг хэллэгүүд
 Өрөвдөж хайрласан сэтгэл бүхий мөрүүд..... үг хэллэгүүд
 Уярч догдолсон сэтгэл бүхий мөрүүд..... үг хэллэгүүд
 Омогшсон сэтгэл бүхий мөрүүд..... үг хэллэгүүд
4. Зохиолчийн дотоод сэтгэлээс ямар хүн гэж мэдэрч хүлээн авч байна вэ? Саналаа солилцоорой.
5. Чи эх орноо хэрхэн хайрладаг вэ? Юунд баярлаж, юуг хараад гуниглаж, юуг бодон санаа алдаж, юугаар бахархаж, юуг өрөвдөж, юунд уярч догдолдог вэ?

Шүлгийн сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг тодорхойлон дүгнэе.

1. Сэдэв, санааг тодорхойлж сурахын тулд жишээг ажиглаарай.

Шүлгийн 1 дүгээр хэсгийн сэдэв, санааны онцлог		Тодорхойлохын тулд дараах асуултыг хэрэглэж болно.
Сэдвийг тодорхойлсон нь	Эхийн тухай, эх орны тухай	Бодит амьдрал, ертөнцийн юмс үзэгдлээс юуг онцолж бичсэн бэ? Ямар асуудлыг хөндөж бичсэн бэ?
Зохиолын санааг тодорхойлсон нь	Ээж болон эх орноо санасан сэтгэлээ илэрхийлсэн Ээж, эх орон хоёр адил юм.	Юуны тухай өгүүлсэн бэ? Зохиолч ийнхүү бичсэнээрээ уншигчдад юуг хэлэхийг хүсэж байна вэ?

2. Онолын тулгуур дохиог ажиглаад, сэдэв, санааг хэрхэн тодорхойлсныг ярилцаарай.



3. Дээрх хүснэгтийн асуултыг хэрэглэн, бусад хэсгүүдийн сэдэв санааг тодорхойлоорой. Зохиолч хэдэн ч сэдэв хөндөж болно.

Шүлгийн 2, 3... дугаар хэсгийн сэдэв, утгын онцлог		Тодорхойлохын тулд дараах асуултыг хэрэглэж болно.
Сэдвийг тодорхойлсон нь	Нэр үгээр тодорхойлно.	Бодит амьдрал, ертөнцийн юмс үзэгдлээс юуг онцолж бичсэн бэ? Ямар асуудлыг хөндөж бичсэн бэ?
Зохиолын санааг тодорхойлсон нь		Юуны тухай өгүүлсэн бэ? Зохиолч ийнхүү бичсэнээрээ уншигчдад юуг хэлэхийг хүсэж байна вэ?

4. Хэрхэн тодорхойлсноо хосоороо ярилцаарай. Бие биеэсээ юуг суралцсанаа илэрхийлээрэй.

Шүлгийн шад, бадаглал, холбоцыг тайлбарлая.

- 43 дугаар талд байгаа онолын мэдээллийг уншин, шүлгийн мөр бадгийг хэрхэн холбосныг ажиглаарай.
- Онолын мэдлэгээ хэрэглэн, холбоцыг тайлбарлахдаа:
 - Шүлгийн толгойг яаж, ямар үсгээр холбосныг ажиглан, тэгш ба тэгш бус болохыг хэлээрэй.
 - Шүлгийн сүүл хэсгийг яаж, ямар үсгээр холбосныг ажиглан, тэгш ба тэгш бус болохыг хэлээрэй.
 - Хэлэхдээ шүлгээс жишээ татна уу.
 - Ийм холбох арга нь шүлгийг айзам хэмнэлтэй болгож байна уу? Тийм бол яагаад гэдгийг тайлбарлаарай.
- Шад бүрийн доторх үгсийн тоо хэмжээ адил тэнцүү байна уу?
- Дүгнэлтүүдийг уншаад, харилцан ярилцаарай.

“Боржигины бор тал” шүлгийн тухай судалгааны дүгнэлтүүд:

Б.Лхагвасүрэн бол монгол яруу найргийн уламжлалыг даган хурц тод, чимэглэл тодотгол ихтэй, уран гоё, цэцэн цэлмэг найруулгаар романтик (тэмүүлэлт) аястай шүлэглэхдээ хэвшмэл ерөнхий бичлэгээс аль болохоор зайлсхийн өвөрмөц сонин адилтгал зураглал бүхий уран тод дүрслэлтэй бичдэг” (Х.Сампилдэндэв, 71 дүгээр тал)

“Төрийн шагналт, яруу найрагч Б.Лхагвасүрэн 1980-аад оны утга уянгын яруу найргийг дорнын сэтгэлгээ, утгын гүнзгийрэлтэй болгон, үгийн утга илтгэх боломжид эрэл хайгуул хийж, яруу найрагт ухаарлыг гүнзгийрүүлсэн. Тэрээр “Боржигины бор тал” шүлэгтээ төрсөн газар, яруу найрагч хоёрын хүйн холбоонд эгэл боргилхон талынхаа далд орших төгөлдөр гоо сайхныг нээн дүрсэлсэн. Монгол ахуй, байгалийн зохирол, хүн бол байгалийн дүрслэгдэхүүн тул эцэстээ түүнд шингэхийн учир утгыг эргэцүүлэн шүлэглэжээ. Төрөхөд нь торго шиг зөөлөн байсан, жаргал зовлонг амсаж эхэлмэгц хатуугаас хатуу болсон гэхчилэн тал “би” баатар хоёрын амьдралын нарийн ширийнийг дүрсэлсэн байдаг” (Утга зохиол шинжлэл, 195 дугаар тал)

“Миний нутаг” гучаад онд, “Би хаана төрөө вэ” жараад онд, “Боржигины бор тал” наяд онд уран бүтээлийн хувьд цагаа эзэлсэн бүтээл болж чадсан. “Боржигины бор тал” шүлгийн гол ололт нь эх орны шүлгүүд нь орон зай, цаг хугацааны ерөнхий хэмжээсэнд бичигддэг байсныг Б.Лхагвасүрэн эх орон гэдэг ойлголтыг ерөнхийгөөс нь салгаж тусгайд тодорхой буулгаж бичсэн учраас эх дэлхийгээс эх орноо, эх орноосоо төрсөн нутгаа тодруулж дүрслэхдээ төрсөн нутаг, эзэн хүн хоёрын холбоог өвөрмөцөөр зураглан, төрсөн нутгаа хайрлах сэтгэлийн мөн чанарыг утга төгөлдөр нээж чадсан юм. Ер нь энэ шүлэг ерөнхийгөөс тусгайд шилжин, гүн ухаан гоо сайхны сэтгэлгээ, уран дүр дүрслэлийн цогц нээлт хийж болохын үлгэрийг үзүүлснээр монголын орчин үеийн яруу найрагт уул ус, өсөж төрсөн нутгаа хайрлан дуулсан олон сайхан дуу шүлэг гарах эх үүдэл болсон юм”.

(Д.Сумьяа, 71 дүгээр тал)

Сэдэв: Эх орон, эх нутаг, амьдралын мөн чанар, сав шим ертөнцийн харилцан холбоо, амьдралын жам ёс, амьдралын гүн ухаан, хүний амьдралын утга учир.

Зохиолын гол санаа: Эх орон, эх нутаг хүнд хамгийн нандин зүйл байдаг тухай, мөн амьдрал хүнийг сургадаг, хүн эх нутагтайгаа салшгүй холбоотой төдийгүй байгаль эхээс төрж байгальдаа шингэдэг гэсэн утга илэрч байна. Хүн эх орон, эх нутгаа ээжтэйгээ адилтган хайрлан дээдлэх учиртай юм, мөнх бус энэ ертөнцөд хүн хийсэн бүтээснээрээ мөнх гэсэн санааг дэвшүүлэн тавьжээ.

5. Шүлгийг айзам хэмнэлтэй болгоход шад бүрт байгаа үгсийн тоо адил байх нь нөлөөлөх үү? Багаар ярилцаарай. Багаар хамтрах чадвараа үнэлэхдээ дараах хүснэгтийг хэрэглээрэй.

Багийг үнэлэх шалгуур	Тийм	Үгүй	Багаар ажиллах чадвараа хэрхэн сайжруулах вэ?
Хэлэлцэж байгаа асуудлаар санал зөрсөн үү?			
Зөрсөн саналаа шийдвэрлэсэн үү? Яаж?			
Санал нийлэхгүй байгаагаа соёлтой үгээр илэрхийлсэн үү?			
Бүх гишүүд бусдыгаа анхааралтай, хүлээцтэй сонссон уу?			
Ээлж дараатай ярилцсан уу?			
Бүх гишүүд оролцож, саналаа нэмэрлэсэн үү?			

Уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжилье.

1. Шүлгээс сонирхол татсан өвөрмөц үгийг жагсаан бичнэ үү.
2. Шүлгээс үндсэн утгаа гээж, шилжсэн утгаар орсон үгсийг түүн бичнэ үү. Яагаад сонгосноо дараах байдлаар тайлбарлаарай. Жишээлбэл,
 - Шууд утгаараа сүү тагнайд амтагдахгүй учраас энэ үгсийг сонголоо. Сонгосон үгийн утга нь шилжиж, өөр санааг илэрхийлсэн байна.
 - Салхины үзүүр шууд утгаараа байдаггүй учир энэ холбоо үгийг сонголоо. “Үзүүр” гэсэн үгийн утга нь шилжиж, өөр санааг илэрхийлсэн байна.
3. Хүснэгтийг нөхөж тайлбараа бичээрэй.

Шүлгээс авсан уран дүрслэлт үг хэллэг	Үндсэн утгаар нь хэрхэн ойлгож байна вэ?	Шилжсэн утгаараа ямар санааг илэрхийлж байна вэ?	Уран дүрслэлийн ямар ур маягаар бүтээснийг тайлбарлахдаа дараах асуултыг хэрэглээрэй.
...сүү тагнайд амтагдаж			
Салхины үзүүр залгихад			Адилтгасан - Юуг юутай адилтгасан бэ? Төлөөлсөн - Тухайн юмстай нягт холбоотой ямар үгээр төлөөлсөн бэ?
Агь хоолойд аргасан		Агь ургамлаар эх нутгаа төлөөлсөн. Эх орноо, эх нутгаа санахаар “агь хоолойд аргасан” мэт санагдах тэр мэдрэмж. Хуурай, гашуун юм хоолойд тээглэсэн мэт санагдах эх орноо санасан сэтгэлийн догдлол, эмзэглэлт санаа илэрчээ. (Төлөөлсөн ур маягаар бүтсэн)	Тойруулсан - Юуг ямар шинж тэмдгээр орлуулан тойруулсан бэ? Хүншүүлсэн - Ямар амьтан, юмсыг хүн мэт болгон дүрсэлсэн бэ? Хэтрүүлсэн-Ямар шинж байдлыг багасгаж, эсвэл ихэсгэн хэтрүүлсэн бэ? Амьдчилсан-Ямар зүйлийг амьд мэт дүрсэлсэн бэ?
Чиний сонгосон үг			Бэлгэдэл - Юуг бэлгэдсэн бэ?

4. Зохиолч уншигчдад юуг хэлэхийг хүсэж адилтгасан (амьдчилсан, хэтрүүлсэн) бэ?
5. Хэрвээ хэлэх гэж байгаа зүйлээ өөр ямар нэгэн зүйлээр адилтгаж (амьдчилж, хэтрүүлж) бичээгүй байсан бол зохиолын хэл найруулга ямар байх байсан бол?
6. Дүгнэлтийг уншаад эргэцүүлээрэй. Яаж тайлбарласныг дүгнэн яриарай.

Үгийн сангийн утга, уран сайхны дүрслэлийн талаас нь авч үзье. “Санаа алдсан” буюу хүн сэтгэл санаа тавгүйрхсэн үедээ ээжийгээ санаж тайтгардаг шиг тэр л үед зохиогчид ээж нь бодогдсоныг “сүү тагнайд нь амтагдаж” хэмээн бичжээ. Сүү, тагнай гэсэн үгийг сонгож ээжтэйгээ ойр байх юм сан гэсэн санааг “сүү”-гээр төлөөлүүлэн тойруулан дүрсэлж, “тагнай” буюу өгүүлэх эрхтэн заасан үгийг хүч нэмэн найруулж бичихдээ сэтгэл зүрх, бие махбодоороо хүртэхийн төдий ээжийгээ үгүйлж байгааг тойруулан орлуулан дүрсэлсэн байна. “Тагнайд” гэдэг үгийн өгөх биш, оршихын утгатай “-д” нөхцөлийн хэлзүйн утгаар “миний зүрх сэтгэлд ээж минь оршдог” гэсэн санааг давхар илтгэхийн зэрэгцээ “тагнай” гэдэг үг нь зохиолчийн сэтгэл зүрх, бие махбодийг төлөөлж байгаа тулгуур утга юм. “Амтагдаж” гэсэн үгийн язгуур утга болон хэлзүйн хэлбэржсэн утгын талаас зохиолчийн санаа өвөрмөц илэрч байгаа юм. “Амтагдах” гэдэг үг толь бичигт үгийн сангийн хувьд “амт, шимт”, “бардах, оморхох” гэсэн утгатай байна. Энэ дүрслэлийн хувьд ээж нь бодогдохоор сайхан зүйлийг амталсан мэт таатай мэдрэмж төрж байгаагаар зохиолч намайг хүнд хэцүү үед ээж минь үргэлж надтай хамт гэсэн санаагаа орлуулан хэтрүүлэн дүрсэлсэн байна.

Зохиолчийн үг сонголтыг судалъя.

Зөвлөмж:

Зохиолчийн дотоод сэтгэлийн ертөнцийг үгийн сонголтоос ажиглахдаа дараах асуултыг өөртөө тавиарай.

- ✓ Зохиолч яагаад ийм үгийг сонгож хэрэглэсэн юм бол?
- ✓ Хэрэв энэ үг байгаагүй бол утга нь яаж илрэх бол?

1. Эхний хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.
 - А. “Салхи үзүүртэй юү? Зохиолч яагаад ингэж бичив?
 - Б. Салхийг залгихын учир юу вэ? Үзүүр гэсэн үгийн үндсэн утга юу вэ?
 - В. Энэ хэсэгт ямар утгаар ямар санаа илэрсэн байна вэ?
 - Г. Яагаад заавал агь гэдэг ургамлыг сонгон хоолойд аргасан мэтээр бичив? Агь гэж ямар ургамал байдаг вэ?
 - Д. Аргасан гэдэг үйл үгээр зохиолчийн сэтгэл санааны эмзэглэл хэрхэн илэрч байна вэ?

“Үзүүр” гэдэг үгийг тайлбар тольд:

- Нарийн горзгор юмны шовх
- Уурганы нарийн талд залгах саваа
- Шилжсэн утгаар - бөх барилдахад үлдэх эцсийн хоёр бөх
- Шилжсэн утгаар - хязгаар туйл, үзүүр хязгааргүй их, сэтгэлийн үзүүрт хэмээн (Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”, 616-р тал) тайлбарлажээ. Монголчуудын зохиосон шүлэг, дууны үг, зүйр үгэнд “Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой” (Миний нутаг), “Тоосны үзүүрээс хүү минь ирнэ” (Ардын дуу), “Сайн санааны үзүүрт тос” (Цэцэн үг) хэмээсэнтэй харьцуулж үзээрэй.

2. Хоёрдугаар хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.
 - A. Сар хээр хонодог хэмээн бичсэний учир юу вэ? Хээр хононо гэсэн үгийн утгыг юу гэж бодож байна вэ?
 - B. Сарыг туулж баралгүй гэж ямар дүрслэлийн ур маягаар санаагаа гаргасан байна вэ?
 - B. Талыг тэнгэрийн хэвтэр гэж бичсэний учир юу вэ? Тэнгэр шиг тал уу? Тал шиг тэнгэр үү? Талыг буурал гэж дүрслээгүй бол утгын хувьд юу нь өөрчлөгдөж байна вэ?
3. Гуравдугаар хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.
 - A. Зохиолч эх нутгийнхаа тухай бичихдээ олон олон цэцэг ногоон дундаас тааныг онцолсон нь ямар учиртай вэ?
 - B. Таанаа харж тайтгарч байгаагаар бичсэний учир юу вэ?
 - B. Нүцгэн тал гэж ямар талыг хэлсэн бэ? Зохиолч чухам юунд сэтгэл нь тайвширдаг вэ? Учир утга нь юунд оршиж байна вэ?
4. Дөрөвдүгээр хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.
 - A. “Яагаад эрхэмсэг юм эгэл байдаг вэ? Нандин мөртлөө яагаад эгэлийн эгэл боргил байдаг вэ? Ингэж бичсэнээрээ зохиолч талын шинжийг хэрхэн туйлд нь хүргэж дүрслээд байна вэ?
 - B. Царайчилсан гэдэг үйл үгийн утга юу вэ? Далд санаа нь юу вэ? Газрыг яагаад эд юмс хормой гэж хэлэв? Газар хормойтой юу эсвэл ээжийн дээлийн хормойг газартай адилтгаад байна уу?
5. Тавдугаар хэсгийн үг сонголтын шалтгааныг тодруулах асуулт зохиогоорой.
6. Зургаадугаар хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.
 - A. “Тал дээр хүн зоны амьдралаас гадна ямар ямар амьдрал өрнөж байна вэ? Сайран дээр өдөлсөн жигүүртний өд нь тал дээр буухын учир юу вэ? Зохиолч үүгээрээ юуг харуулахыг зорьсон бэ?
 - B. Ботго нь үхсэн ингэний бие болон сэтгэлийн байдал, төрхийг шүлэгт бичсэнээр хэрхэн төсөөлөн бодож байна вэ? Борвио хагартал савирсан сүү цусны туяатай байхын учир юу вэ?
 - B. Талыг яагаад чинэсэн хөхий нь амирлуулсан гэж амьдчилж бичээ вэ? Талыг яагаад сүү залгилж, зовлонг хугасалдаг гэж бичсэн бэ?
 - Г. Яагаад талын шарх зүрхний шархнаас хождож аньдаг гэж бичив? Зүрхний шарх гэж юуг хэлж байна вэ? Талыг шархалдаг гэж бичсэний учир юу вэ?
7. Долоодугаар хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.
 - A. Аялгуугаар юуг илтгэж байна вэ? Хөгжмийн аялгуу юу? Хүнээс гарч байгаа аялгуу юу? Амьдралын аялгуу юу? Тэр аялгууг цагаан гэсний учир юу вэ? Юуг бэлгэдэж дүрсэлсэн бэ? Аялгуу хүнийг уяхан болгодгийн учир юу вэ?
 - B. Сартай шөнийн чимээ гэдгийг та нар хэрхэн мэдэрч байна вэ? Тэр чимээнд юу зангирч, үүгээр юу илэрхийлэгдэж байна вэ? Сайхан чиний гандах элэгдэх хоёр гэж юу гэсэн үг вэ? Хүний эрхэм сайхан зүйлийг яагаад гандаж элэгдэж гэж бичсэн юм бол?
 - B. Шүлгийн тайлбарласан хэсгийг уншаад, саналаа нэмэрлээрэй.

Сайхан чиний
гандах элэгдэх хоёр
сартай шөнийн
чинь чимээнд
зангирах цагаан
аялгуу намайг уяхан
болгосон

“Сайхан” гэдэг тэмдэг нэр нь тал нутгийг төлөөлж байгаа утга юм. Тал чинийхээ олон олон он цагийг элээж байгааг харах тусам би уялдаг, нам гүм амарлингуй төрхөнд чинь хоногшиж байгаа зөөлөн намуун өнгө аяс (цагаан аялгуу) намайг уярааж тайвшруулдаг.

Энэ бадгийн гол утга нь хүн - байгаль гэсэн харьцаагаар илэрч байгаа бөгөөд харин дараагийн мөрөнд хүн - хүний хүчинд амьдардаг гэсэн санаагаа илүү тод илэрхийлдэг. Ингэхдээ “нутаг усны минь хаяа өлзийтэй түмэн”, “нуур тойрмын ширхэг чулуу” хэмээн онцолжээ.

8. Наймдугаар хэсэг дэх үг сонголтын шалтгааныг дараах асуултаар илрүүлээрэй.

- А. “Байдуу мянганы уулс” гэж юуг төлөөлөн хэлж байна вэ? Уулсаар хүнийг төлөөлөн бэлгэдэж байна уу? Эсвэл уулыг шууд утгаар нь хэлээд байна уу?
- Б. Яагаад “толгойд буурал сууж” гэж бичив? Үүгээр ямар уран санаа илрэв?
- В. “Багадаа хөхсөн эхийн сүү гадагшлах” гэснээр ямар утга санааг илэрхийлж байна вэ? Яагаад заавал хүний өтөл нас, хөгшрөхийг “сүү гадагшилж” байгаагаар дүрслэв? Зохиолчийн ямар санаа агуулагдаж байна вэ? Хүний насан туршийн амьдрал эхийн сүүтэй холбоотой байдаг уу?
- Г. Шүлгийг “хүн чулуу”-тай зүйрлэсний утга учир юу вэ? Шүлэг үү? Шүлгэн доторх утга санаа нь мөнх үү? “Сүүдрээ дарж унах” гэж дүрслэлийн ямар хэрэглүүрээр утга санааг илтгэж байна вэ?
- Д. “Элгийг чинь” гэж газар нутгийг орлуулан хэлсний учир юу вэ? Шингэх шингэхдээ “цөмлөн шингэнэ” гэсний учир юу вэ?

9. Мэдээллийг уншаад, уншихын өмнөх таамаглалтай харьцуулна уу.

Шүлэгт талыг Боржигины бор хэмээн тодотгосон нь их л учиртай. Боржигин овог бол Чингис хааны овог. Чингис хааны дээд өвөг Бодончар мунхагаас үүсэн гарсан овог юм. Иймээс Боржигин нь монгол хүн бүрт хамаатай болно. Олон овгоос зөвхөн энэ овгийг сонгосон нь монголын их тал нутаг бол Чингис хааны байгуулсан төрөөс оршин тогтнож хүчирхэгжсэн их гүрний газар шороо билээ гэсэн зохиолчийн дотоод бодол, бахархалт үзэл санаатай холбоотой байж болох юм. Бор гэсэн нь чухамдаа шүлэгт өгүүлснээр талын “нандин эрхэмсэг, эгэл боргилын туйл” гэсний бэлгэдэл мэт. Бор хүү минь, бор гэр минь гэвэл бор нь ойр дотно гэсэн утга илтгэнэ. Боржигины бор тал гэхээр нэг талаар эгэл энгийн, нөгөө талаар элгэмсэг дотно гэсэн утга илтгэх ажээ. “Боржигины бор тал” гэсэн нь авианы зохицолтой төдийгүй утгын нийлэмжтэй байна. “Боржигины шар тал”, “Боржигины цэнхэр тал”, “Боржигины уудам тал”... гэвэл ийм утга хэр нийцэлтэй бол?

Уншихын өмнө:

1. Эх орон, эх нутгийнхаа сайн сайхан гэж боддог зүйлээ нэрлээрэй.
.....
2. Дөрвөн цаг, дөрвөн улирал дахь хүний сэтгэлзүйн онцлогийг ярилцаарай.



(1949-2002)

Төрсөн он, газар: 1949 онд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын “Хужиртын гол” гэдэг газар төржээ.

Боловсрол: Бага, дунд сургууль, Багшийн сургууль төгсөж, ардын цэргийн алба хааж, Дорнодын Эрэнцавын төмөр замын өртөөнд амьдран уран бүтээлээ туурвиж байв.

Уран бүтээл: “Сэтгэлийн байгаль”, “Хаврын урсгал”, “Миний шүлгийн хүүхнүүд”, “Аглагхан талаасаа” зэрэг ном хэвлүүлжээ.

Данзангийн Нямсүрэн

ДӨРВӨН ЦАГ

1.

Бороо ганц нэг дусах нь сайхан
Борог өвс норсон байх нь сайхан
Хаврын цас гэр лүү урсах нь сайхан
Хаа нэгтэй шувууд ганганах сайхан

Алтан хараацай дэргэдүүр нисэх сайхан
Аяны хүн манай уяанд буух сайхан
Айлын маань айлд бүсгүй байх сайхан
Айл нүүж ирэх сайхан

Хангайн бороо гэнэт асгах нь сайхан
Харанхуйн дунд цахилгаан гялбах нь сайхан
Хонон өнжин бороо зүсрэх нь сайхан
Холоос гийчин ирэх сайхан

Шаргал талын өвс халиурах нь сайхан
Шанхны үзүүрт салхи сэвэлзэх нь сайхан
Сартай шөнө бухал дээр унтах сайхан
Чамайг зүүдлээд газарт ойчих нь сайхан

Үе үе бороо амсхийх нь сайхан
Өлгөсөн цувнаас ус дуслах нь сайхан
Үүлэн чөлөөнөөс нар гарах нь сайхан
Үүдээр болжморууд нисэн өнгөрөх нь сайхан

Шөнө дөл хүлэг морь янцгаах сайхан
Шүлэг нойрноос сэрж орчлонг бодох сайхан
Өрхний завсраар гэгээ орох сайхан
Өглөө болох сайхан

Цайран цайран бороо орох нь сайхан
Цавьдар морьтой хүн наашаа давхих нь сайхан
Борооноос өмнө ирлээ гэж ярих нь сайхан
Боржигин эмээлээ аваад орж ирэх нь сайхан

Сартай толгодод ингэ гунганах нь сайхан
Шанзны үзүүрт Ай-нан-аа суух сайхан
Шаргал дөл угалзлан гал ноцох нь сайхан
Царай зүс бүдэг бадаг гэрэлтэх нь сайхан

Хөх лонхон тогоруу дуугарах сайхан
Хөдөө цайдам борооших сайхан
Анирхан ахуйд цэцэг дохих сайхан
Аадрын өмнөх байдал сайхан

Тооноор сар гэрэлтэх сайхан
Тогоотой сүүнд тусах сайхан
Шөнө орой гарах сайхан
Чөдөртэй морьд тургилах сайхан

Шиврэн шиврэн бороо орох нь сайхан
Ширэг зүлэг ногоорох нь сайхан
Зүүн өмнө солонго татах сайхан
Зүс бороо гэрэлтэх сайхан

Гэгээн борооны усыг тосох сайхан
Гээг үсээ хүүхнүүд угаах сайхан
Агь хүмлийн үнэр сэнгэнэх нь сайхан
Аясан бодол хол ойрыг санах сайхан

Үдшийн бүрийгээр ирэх сайхан
Үүрийн гэгээгээр явах сайхан
Өнгөт дэлхий нь уяран уйлмаар сайхан
Өргөн хорвоо нь дуулан жаргамаар сайхан

Эх нутаг минь шүлэг шиг сайхан
Эх орон минь дуу шиг сайхан
Эргэх дөрвөн цагт амьд явах сайхан
Эрэнцэвд бороо орох нь сайхан

2.

Өглөө босоход цас орсон байх нь сайхан
Өрхний оосор даялахад тооноор цас унах сайхан
Гадаа уул толгод гялбалзах нь сайхан
Ганц нэг өвс салхинд сэвгэнэх нь сайхан

Үдэш орой айлын гэрэл харагдах сайхан
Үрээ морины хөл хөнгөрөх сайхан
Хонох айлд үеийн бүсгүй байх сайхан
Хоточ нохой сарны гэрэлд хуцах сайхан

Тооноор цас будран орох нь сайхан
Тогооны таган дээр унаад хайлах нь сайхан
Гэрийн хойморт аав суух сайхан
Гэрэлтэй үүдээр ээж орж ирэх сайхан

Хөтлийн оройд нар тусах сайхан
Хөсөг тэрэг гарч ирэх нь сайхан
Тэрэгний дугуй чахран чухран эргэх нь сайхан
Тэргэн дороос шувуу нисэх сайхан

Тэнгэр будангуйрч судайх нь сайхан
Тэртээ холын юм үзэгдэх үгүйтэй нь сайхан
Салхи эргэж, утаа хуйрганах нь сайхан
Цас эргэлдэн эргэлдэн малгайлах сайхан

Зуухны галд нозоорон нойр хүрэх нь сайхан
Зуны орой согтов гэж тэрхэн зуур зүүрмэглэх сайхан
Хээ-н... Цай уу! гэх бүдэг бадаг үг дуулдах нь сайхан
Хэн гуайн эгч гараас зөөлөн татах нь сайхан

Цайдам хоолой цайвалзаж цанхиртах сайхан
Цаад уулс гялс гялсхийн харагдах нь сайхан
Цас шуурч тогтоод гялбас гялбасхийх сайхан
Цагаан өдөр мэлтэс мэлтэсхийх сайхан

Одод тодрох нь сарны ойролцоо илүү сайхан
Онгон талд адуу минь байх шиг сайхан
Он цагийн гурван марал бодол зөгнөх сайхан
Ондоо гарагийн хөлөг ирж явах шиг сайхан

Цас орон орон лавсах нь сайхан
Цаг эргэж ирэх сайхан
Царайлагхан чамайгаа, намайг тоогоогүйг тоосоон гэж бодох сайхан
Цаг гэрт цохисоор байх нь сайхан

Тэргэл сартай шөнө гадаа зогсох сайхан
Тэргэн дээр хураасан бараа сүглийх сайхан
Тэртээх хөндий цайвартаж сүүдэртэх нь сайхан
Тийшээ очмооргүй аймаар санагдах нь сайхан

Явган шуурга гадаа исгэрэх сайхан
Яндан юм уу нэг юм, хаа нэгтээ дар дархийх сайхан
Гэнэт гэнэтхэн нүдгүйлэн харанхуйлах нь сайхан
Гэрийн хаяагаар цас хунгарлах нь сайхан

Айлын гэрээс хүмүүс гарцгаах сайхан
Арилсан тэнгэрт шувуу нисэх сайхан
Уул тал руу гүйх сайхан
Улаан хацартай хүүхдүүд тоглох сайхан

Үдшийн бүрийгээр ирэх сайхан
Үүрийн гэгээгээр явах сайхан
Өнгөт дэлхий нь уяран уйлмаар сайхан
Өргөн хорвоо нь дуулан жаргамаар сайхан

Эх нутаг минь шүлэг шиг сайхан
Эх орон минь дуу шиг сайхан
Эргэх дөрвөн цагт амьд явах сайхан
Эрэнцэвд цас орох нь сайхан!

3.

Цас хайлж ханзрах сайхан
Цаг ирэх сайхан
Чамайг хүлээх сайхан
Цаг харах сайхан

Шувуу ирээд буух сайхан
Чулуун дээр суугаад нисэх сайхан
Харгуй замаар хүн явах сайхан
Хадан дээр би суух сайхан

Айлын бүсгүй усанд явах сайхан
Арын булаг руу дурандах сайхан
Цэнхэр зэрэглээ сүүмэлзэх нь сайхан
Цэнхэр дээл чамд зохих нь сайхан

Толгодын орой зэрэглээтэй сайхан
Торгон салхи сэвэлзэх сайхан
Хөх ногооны униар татах сайхан
Хөх мананд нь ороолгон суух сайхан

Амгалан шөнө нойр хулжих сайхан
Алсын чимээ анирлах сайхан
Бүүр түүр холд нэг юм жингэнэх сайхан
Бүүвэй бүүвэй хорвоо сайхан

Хэн нэгэн ирээд явах сайхан
Хэрэг болгож надаас, гал байна уу гэж асуух сайхан
Ертөнцийг аргадах хийгээд, бусдыг бодох сайхан
Юм бүхнийг хайрлах, гол мөрөн урсах хоёр сайхан

Цөн түрж, гол урсах нь сайхан
Цөмөрвөл, би ч бас урсана даа гэж бодох сайхан
Өглөө голын эрэгт, ганцаархнаа сайхан
Орой голын хөвөөнд чамтайгаа сайхан

Хашаа тэргэн дээр шаазгай үглэх сайхан
Хаанаас хэн ирэх нь зөн шиг сайхан
Дөрвөн зүгээс ураг садан ирэх нь сайхан
Дөтийн замаар хань нөхөд ирэх нь сайхан

Цэнхэрлэж нутгийн бараа харагдах нь сайхан
Цэлэлзэж нүдний нулимс гарах сайхан
Дөрөөн дээр өндийгөөд исгэрэн давхих сайхан
Дөрвөн туурайн хооронд шувуу нисэх сайхан

Хаврын өглөө эрт босох сайхан
Хазаар аваад моринд явах сайхан
Сэрүүн цас үнэртэх нь сайхан
Сэмжин мөснөөс хүлхэх нь сайхан

Он он жил хөдөө суух сайхан
Од мэт хөх дан сууцанд амьдрах сайхан
Дээр яваа сансрын хөлөг эргэж ирэх сайхан
Дээврийн цас хайлж янжуурын цог дээр дусах сайхан

Ургамал цэцэг ургаж ногоорох нь сайхан
Утасны мод хөхөрч гандах нь сайхан
Он жилүүд ирэх сайхан
Он жилүүд одох сайхан

Үдшийн бүрийгээр ирэх сайхан
Үүрийн гэгээгээр явах сайхан
Өнгөт дэлхий нь уяран уйлмаар сайхан
Өргөн хорвоо нь дуулан жаргамаар сайхан

Эх нутаг минь шүлэг шиг сайхан
Эх орон минь дуу шиг сайхан
Эргэх дөрвөн цагт амьд явах сайхан
Эрээнцавд гол урсах нь сайхан

4.

Навч ганц нэг унах нь сайхан
Нар толгодын цаанаас гарах сайхан
Сэв сэв салхи үүсэх сайхан
Сэм сэмхэн хуй босох сайхан

Гол мяралзан урсах нь сайхан
Ганц нэг ялаа долгионд нь суух сайхан
Морины шар хомоол тэрүүхэнд хөвөх сайхан
Модон тэрэгний ганц ялуу урсаж өнгөрөх сайхан

Хол ойрыг санагалзаж уярах сайхан
Хот айлаас хэн нэг нь явахад үг захимаар сайхан
Торолзох барааг харж зогсох сайхан
Торгон алчуур дэрвэх сайхан

Сэмжин цагаан үүл нүүх сайхан
Сэтгэл зүрхэн дундуур хөвөх сайхан
Шивэр авир бороо салхилах сайхан
Шивээн толгой ганхах сайхан

Морьтой хүн давхин одох сайхан
Морин төвөргөөн дуулдах сайхан
Тэнгэрийн хаяаг харах сайхан
Тэрэг хөсөгний зам зураих сайхан

Өмнө зүгт шувуу нисэх сайхан
Үүлсийн дунд ганганах сайхан
Наран шаргалтаж тоорогтох сайхан
Навчсын шар шуурга хаялах сайхан

Шаргал бороо нартай орох сайхан
Шанз ятгын утас буйлах нь сайхан
Шаавай төрсөн Хонгорзул эгчирхэх нь сайхан
Шальдар бульдар дүү минь түүнийг санах нь сайхан
Ган жийжүү дөрөө гадаа дуугарах сайхан
Ганган морьтой хүн буух сайхан
Намрын сарын шинийн гурван ирэх сайхан
Намуун үдэш аргын тооллын сар гарах сайхан

Хууч яриа нойрон дунд сонсдох сайхан
Хуучин сүмийн тууринд... хэмээн ярилцах нь сайхан
Цонхоор сар тусах шөнө үлгэр ярих сайхан
Цоороо аваад дуултал чөтгөр уярчээ гэх сайхан

Сар орой болж хүйтрэх нь сайхан
Салхинд одод зүлгэгдэх нь сайхан
Өдөр шөнө тэнцэх нь хорин хоёрон болох сайхан
Хүлэг хүн хоёр адилхан цаг унтах сайхан

Дэлхийн чулуунд хяруу цавцайх сайхан
Дэрсээр дээр нь шүлэг бичих сайхан
Дээвэр дэвэх салхинд сэтгэл гэгэлзэх нь сайхан
Дэндүү ойрын хайраас холд байх нь сайхан

Модны мөчирт шувуу навчны оронд суух сайхан
Монгол аялгуугаар жиргэх сайхан
Дээр төрийн сүлдний нар мандах нь сайхан
Дэргэд алтан соёмбоны гал ноцох нь сайхан

Хэн нэгэн ирээд дуулах сайхан
Хэн нэгэн одоод гуних сайхан
Эргэх нэгэн хайр зүрхэнд хөгжимдөх сайхан
Ээлжлэн ирэх цаг хонхоо цохих нь сайхан

Үдшийн бүрийгээр ирэх сайхан
Үүрийн гэгээгээр явах сайхан
Өнгөт дэлхий нь уяран уйлмаар сайхан
Өргөн хорвоо нь дуулан жаргамаар сайхан

Алаг нүдний нулимсан дусалд багтсан
Ай миний эх орны дөрвөн цаг
Асгаруулан мэлтэлзүүлэн байна уу даа.
Аяа, хөөрхий гэж....

Эх сурвалж: Д.Нямсүрэн, "Хаврын урсгал", УБ., 1984 он, 21 дүгээр тал

Зохиолын утгыг мэдэрч ойлгож уншъя.

1. Утгыг нь мэдэхгүй үг байвал олоод, тэмдэглэнэ үү. Ойр орчмын үг, өгүүлбэрээс утгыг таамагласны дараа толь бичгээс харан тайлбарлаарай.
2. Зохиолоос юуг мэдрэв? Зохиолч юу юуг харж сайхан гэж бичсэн бэ?
3. Зохиолч юунд сэтгэл нь сэргэж, юунд догдлон санааширч байна вэ? Шүлгээс жишээ татна уу.
4. Зохиолчийн дотоод сэтгэлээс ямар хүн гэж мэдэрч хүлээн авч байна вэ? Саналаа солилцоорой.
5. Чи эх орноо хэрхэн хайрладаг вэ? Эх орныхоо юу юуг сайхан гэж тодорхойлох вэ?

Шүлгийн сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг тодорхойлон дүгнэе.

1. Шүлэгт дараах сэдвүүдээс аль нь илэрсэн болохыг сонгон тэмдэглэнэ үү. Зохиолоос жишээ татаж болно.

Дөрвөн цаг	Зун	Намар	Өвөл	Хавар	Төгсгөлийн дөрвөн мөр
Байгалийн сайхны тухай					
Хүмүүсийн өдөр тутмын амьдралын тухай					
Зохиолчийн сэтгэл зүйн тухай					
Хүмүүсийн сэтгэл зүйн тухай					
Гүн ухааны тухай					
Улс төрийн тухай					
Өөр ямар сэдвийг хөндөн бичсэн бэ? Багаараа хэлэлцээд тэмдэглээрэй.					

Санамж: 58 дугаар хуудасны онолын мэдээллийг дахин харна уу.

2. Өнгөөр тодотгон ялгасан хэсгийн утгыг өөрийнхөөрөө тунгаан бодно уу. Төгсгөлийн бадгийн утгыг хэрхэн хүлээн авч байна вэ?

Шүлгийн шад, бадаглал, холбоцыг тайлбарлая.

1. Шүлгийг айзам хэмнэлтэй болгож байгаа зүйл юу байна? Дараах үгээс зөвийг олно уу.
Зэрэгцүүлэх холбоц, толгой холбоц, мөр бүрийн үгийн тооны хэмнэл, сүүл холбоц, давталт
2. 43 дугаар хуудсан дахь онолын мэдлэгтээ тулгуурлан, холбоцыг тайлбарлахдаа:
А. Шүлгийн толгойг яаж, ямар үсгээр холбосныг ажиглан, тэгш ба тэгш бус болохыг хэлээрэй.

- Б. Шүлгийн сүүл хэсгийг яаж, ямар үсгээр холбосныг ажиглан, тэгш ба тэгш бус болохыг хэлээрэй.
 - В. Хэлэхдээ шүлгээс жишээ татна уу.
 - Г. Ийм холбох арга нь шүлгийг айзам хэмнэлтэй болгож байна уу? Тийм бол яагаад гэдгийг тайлбарлаарай.
3. Шад бүрийн доторх үгсийн тоо хэмжээ адил тэнцүү байна уу?
- А. Шүлгийг айзам хэмнэлтэй болгоход шад бүрт байгаа үгсийн тоо адил байх нь нөлөөлөх үү? Багаар ярилцаарай.

Уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжилье.

1. Тодруулсан үгсийн дүрслэлийг тайлбарлана уу.
 - А. Хөх дан сууцыг одтой адилтгахын учир юунд вэ? Зохиолч юу хэлэхийг хүсэв?
 - Б. Яагаад оддыг салхинд зүлгэгдэх гэж бичсэн бэ?
 - В. Шувуу монгол аялгуугаар жиргэх сайхан гэснийг уншаад юу мэдрэв?
 - Г. Сүлдний нар, соёмбоны галыг мандах, ноцох гэж бичсэнээр зохиолч юуг илэрхийлэв?
2. Зохиолч утгыг шилжүүлж, урнаар дүрсэлсэн байна уу? Яагаад ингэж дүгнэж байна вэ? Тайлбарлана уу.

Зохиолчийн үг сонголтыг судалъя.

Зохиолчийн дотоод сэтгэлийн ертөнцийг үгийн сонголтоос судлахдаа дараах асуултыг өөртөө тавиарай.

- А. Зохиолч яагаад “сайхан” гэдэг үгийг сонгож хэрэглэсэн юм бол?
- Б. Монгол ахуйг дүрсэлсэн ямар үгс байгаа бол?

БИЧИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолын сэдэв, утга санаа, үг хэллэгээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж бичье.

Сэтгэгдлээ илэрхийлэхдээ:

Дэмжлэг болох асуулт

1. Хамгийн их сэтгэл хөдөлж уншсан шүлгээ сонгоно уу.
2. Үгийн сонголт нь хамгийн их гайхшируулж байсан ямар шад, бадаг байсан бэ? Яагаад гайхшируулж байсныг жишээлэн тайлбарлаарай.
3. Зохиолчийн илэрхийлэх гэсэн санааг дэмжиж байсан уу? Яагаад гэдгээ тайлбарлаж бичнэ үү.
4. Уншсан шүлгийн чинь утга санаатай адил өөр ямар шүлэг байдгийг эргэцүүлж, харьцуулж бичиж болно.
5. Шүлгийн аль хэсэг, аль үг, ямар уран дүрслэл сэтгэлийн олон өнгө аясыг мэдрүүлсэн бол? Гайхах, хайрлах, өрөвдөх, гомдох, догдлох гэх мэтээр

сэтгэлийн ямар өнгө аяс илэрснээ мэдэрсэн үү?

Мэдрэмжээ илэрхийлэхдээ:

Дэмжлэг болох асуулт

1. Уншсан шүлгүүдээс хамгийн их дуу чимээ сонсогдсон нь аль вэ? Яагаад ингэж үзэв?
2. Эсвэл юу ч сонсогдоогүй, аниргүй шүлэг байсан уу? Ямар үг нөлөөлөв?
3. Шүлгийн үг хэллэгээс мэдэрснээ зургаар илэрхийлж болно. Тухайлбал, “Салхины үзүүл залгихад” гэсэн утгыг зургаар яаж илэрхийлэх бол?
4. Зохиолчийн харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх мэдрэмжийг үнэлж бичиж болно. Ингэхдээ зохиолоос жишээ татна уу.

Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж бичихдээ дараах төлөвлөгөөг баримталж болно. Эсвэл хүүхдүүд та бүхэн цогцолбор бүрийн утгыг өөрийнхөөрөө зааглан, санаагаа цэгцтэй илэрхийлж болох юм.

1. Эхлэл хэсгийн эхний цогцолборт ямар шүлгийг яагаад сонгосноо бичих
2. Дараагийн цогцолборт урьд өмнө уншиж байсан шүлгүүдээсээ юугаараа ялгаатай болохоо илэрхийлэх
3. Гол хэсгийн эхний цогцолборт шүлгийн сэдэв, утга санаанаас төрсөн сэтгэгдлээ бичих
4. Гол хэсгийн дараагийн цогцолборт шүлгийн үг хэллэг, уран дүрслэлээс төрсөн мэдрэмжээ бичих
5. Төгсгөлийн цогцолборт уншигчдад заавал унших сэтгэгдэл төрүүлэхүйц байдлаар итгэн үнэмшүүлж бичих гэх мэт

Төлөвлөсний дараа ноороглоорой.

Нооргоо засахдаа найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаа байгаа эсэхийг засаарай.

Дахин сийрүүлж бичээрэй.

Бичих чадвараа үнэлэх шалгуур

Шалгуур	Тийм	Үгүй	Сайжруулах шаардлагатай
Сэтгэлийн өнгө аясаа илэрхийлж бичсэн үү?			
Мэдрэмжээ илэрхийлж бичихдээ үгийн сонголтыг анзаарсан уу?			
Эхлэл, гол, төгсгөл хэсэгт санаагаа уялдаа холбоотой тусгасан уу?			
Уншигчдад унших сэтгэгдэл төрүүлэхүйц бичсэн үү?			
Бусдад ойлгомжтой бичиж чадсан уу?			

Бие даан гүйцэтгэх даалгавар

Дорнын нэрт яруу найрагч Б.Явуухулангийн яруу найргаас сонгон, даалгаврыг гүйцэтгээрэй.

1. Шүлэг дэх үгийн утга, дүрслэл, айзам, хэмнэл, орчин, сэдэв, санаа, зохиолчийн үг сонголтын шалтгааныг тодруулж, асуулт зохиож, мэдлэг чадвараа сориорой.
2. Шүлгийг хэн нэгэнд унших санал тавибал юуг онцлох вэ?

Бэгзийн Явуухулан

Вансэмбэрүү

Аглагхан ойн зах сийрээд
Орой нь халзрах уулын тагт
Ариухан горхины эх шургаад
Авиа нь тасрах асганы шилд
Төөлөөд үзвэл бие чацуу
Тоолоод үзвэл нас чацуу
Үзэсгэлэнт хоёр вансэмбэрүү
Үүд хоймрын зайтай ургажээ
Үр тоосоо хүртдэг хэрнээ
Үдшийн бүрийгээр бараагаа алдаж
Үүд хоймрын зайтай хэрнээ
Үүрийн туяанаар биесээ үзэж
Илбийн юм шиг хосгүй сонин
Ихэр ботго шиг хорвоод ховор
Сэрүүн хангайн хоёр цэцэг
Сэтгэл бахдам гоёмсог ургажээ.
Торомгор хөөрхөн хоёр ботго
Тоглож нэгийгээ хөөж явах шиг
Тоорцог өмссөн хоёр хүүхэд
Тойрон бүжиг хийж байх шиг
Үзэх бүрий өөр үзэгдэж
Үүлгүй тэнгэр дээр нь цэлийх юм.
Харах бүрий сонин харагдаж
Хавь орчим нь нам гүм байх юм.
Дэгдэж ирсэн хээрийн салхи ч
Дэргэд нь ирээд намддаг болов уу
Хангайн дэгжин буга согоо ч
Хажууд нь гайхан зогсдог болов уу?
Уранхан цоморлигийг нь илээд үзвэл
Унаганы уруул шиг зөөлхөн байлаа.
Хүрэнхэн тэргүүнд нь хүрээд үзвэл
Хүүгийн минь зулай шиг бүлээхэн байлаа.
Өвөг дээдэс минь энэ цэцгийг
Өнө эртэд олсон гэнэм.
Алжаасан бие эдгээдэг чадлыг нь
Аль хэзээнээс мэдсэн гэнэм.
Тэгээд энэ вансэмбэрүүг

Тэнгэрийн цэцэг гэж нэрлэсэн гэнэм.
Ахар бодолтон сүйтгэчих вий гэж
Айлгах домог зохиосон гэнэм.
Үүлэн нүүдэл өөхийгөө зүсдэг
Үзүүрт модон ургаагүй хярд
Зуны бороо мөндрөөрөө унадаг
Зуурам хөлдүү хангайн царманд
Хосоор ургадаг вансэмбэрүү
Хорвоогийн нэгэн гайхамшиг байна.
Хорвоогийн амьдрал хөлдүү царманд
Хосын хүчинд амилдаг байна!

Монголын дорнод тал

Монголын дорнод тал
Талбиун болоод цэлгэр
Монгол хүний сэтгэл
Талаа дагаад тэнэгэр
Арвин сүрэг нь үржихдээ
Өвсөн ширхэг тэнцмэл
Ард олон нь амьдрахдаа
Үнэн санаа нэгдмэл
Талын хүний нүд нь
Гэрлийн адил холчтой
Таанат нутгийн хөрс нь
Гүн дороон баялагтай
Бууж үдлэм холоос
Айл нь харагдах хачин
Бугуйл хаям ойроос
Нар нь мандах сонин
Энэ хорвоо дэлхий дээр
Талын минь нар агуу том
Эзэн биднийхээ хөлийн дор
Төрөлх нутаг минь уужим
Монголын дорнод тал
Талбиун болоод цэлгэр
Монгол хүний сэтгэл
Талаа дагаад тэнэгэр

Эх сурвалж: Б.Явуухулан. Би хаана төрөө вэ?
(Монгол уран зохиолын дээжис 108 ботийн 28-р
боть) УБ., 2005. 171, 184-185-р тал



ХҮҮРНЭЛ ЗОХИОЛ

Энэ бүлгээс бид ямар чадвар эзэмших вэ?

- ❖ Хүүрнэл зохиолыг уншиж, амьдралын үнэ цэнийг уран сайхны аргаар дүрслэн үзүүлснийг мэдэрч ойлгох
- ❖ Зохиолын үйл явдал, дүрийн холбоо хамаарал, үг үйлдэл, орчин нөхцөл, сэдэв, санааг тайлбарлан үнэлж дүгнэх
- ❖ Уран зохиолын хэлний тансаг сайхнаас суралцаж, үгийн баялгаа нэмэгдүүлэн, бүтээлчээр хэрэглэх



4. ТУУРЬ, ӨГҮҮЛЛЭГ

Уншихын өмнө:

1. Б.Ринчен “Нууцыг задруулсан захиа” туурийг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, хосоороо ярилцаарай. Зохиогчийн талаарх өөрсдийн мэддэг зүйлийг нэмж яриад цааш нь баяжуулан судлаарай.



(1905-1977)

Төрсөн он, газар: 1905 онд Булсарай (Одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум)-д төржээ.

Боловсрол: Орос, чех, польш, франц, англи, эсперанто, герман хэлтэй соён гэгээрүүлэгч бичгийн их хүн. 1956 онд “Монгол хэлнүүдийн харьцуулсан түүхэн хэлний зүй” бүтээлээрээ Унгар улсад хэл бичгийн ухааны эрдмийн зэрэг хамгаалж, Монголын анхны доктор цолтой эрдэмтэн болжээ.

Уран бүтээл: “Цогт тайж” киногоороо 1945 онд Маршал Чойбалсангийн нэрэмжит шагнал хүртсэн. “Үүрийн туяа” гурамсан роман, “Заан залуудай”, “Бэр цэцэг”, “Гүнж”, “Сандоо амбан”, “Их нүүдэл”, “Нууцыг задруулсан захиа”, “Шүхэрч Буниа”, “Ану хатан” зэрэг түүхэн сэдэвтэй зохиол бичжээ. Б.Ринчен гадаадын утга зохиолыг орчуулах ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулж, М.Горький, В.Маяковский, М.Шолохов, Г.Мопассан, Н.Хикмет, Галидас нарын бүтээлүүдтэй монголын уншигчдыг танилцуулжээ.

2. Зохиолын эхлэл хэсгийг уншаад, асуултын дагуу түүхийн хичээлийн мэдлэг, чадвараа ашиглан ярилцаарай.

Баруун Монголын Галдан Бошготын цэрэг, Манжийн Энх-Амгалан хааны цэрэгт Туулын Зуун модны газар ихэд дарагдаад, Зүүн гар хэмээх Монголын хүчин мохож, Орхон голын үерт авхуулан сарниж дутаасан Цорос омгийн Гөлөгдэй баатар цэрэг өрхийн хамтаар баруун зүг тэмцэн, говьд манжийн цэрэгт гүйцэгдэж, дийлсэн цэргийн хурц сүрт автагдан, арга буюу дагасан билээ...

- А. Монгол Улсын хэдий үеийн нийгмийн амьдралын тухай гарч байна вэ? Энэ цаг үеийн тухай та нар юу мэдэх вэ?
 - Б. Өмнө нь ямар үйл явдал болсон байх боломжтой вэ?
 - В. Галдан Бошгот гэж хэн бэ? Гөлөгдэй баатартай ямар холбоотой вэ?
3. “Хэлэх үг элчийн аманд” гэсэн хэлц үгийн утгыг таамаглаж, хосоороо ярилцаарай.
 4. Туурийн тухай 147 дугаар хуудаснаас уншиж ярилцаарай. Өгүүллэгээс юугаараа ялгаатай байна вэ?

Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя.

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглэн уншаад, өмнө нь сурсан аргуудаасаа ашиглан, утгыг тайлж, ангийнхантайгаа санал солилцоорой.

Тайлбарлах үгс:

хуарагнах -	хазавч -	харилхаг сонсогдох -
зусардах -	сачану -	юлд -
хөлтрөг -	өрлөх -	сумны булцуу -
өвч хуяг -	чинэрэх -	бага үд -
хантайрах -	нумын хөвч -	хазавч -

Бямбын Ринчен

НУУЦЫГ ЗАДРУУЛСАН ЗАХИА (туурь)

Монгол Улсын арван тавдугаар онд залуу оюутан байхдаа алс Ленинград хотноо шинжлэх ухааны академийн Азийн музейд оросын олон эрдэмтний Ази тивээс олж хуримталсан ховор нандин бичиг судар үзэж, тод монгол хуучин захидалд амар мэндийг асуун “Хэлэх үг элчийн аманд бий” гэсэн үг цөөн утга битүүлэг байдагт нь их гайхдаг билээ. Тэр дээр цагт захидалд гагцхүү тийм хүнээр явууллаа гэж уг мэдэгдэх зүйлээ элчид итгэмжилдэг нэг учир байсан байх гэж миний багш академич Владимирцов хэлдэг байлаа.

Хожим Ховдын хязгаарт ардын аман зохиол, нутгийн аялгуу тэмдэглэж, эртний бичиг үсэгтэй хөшөө чулуу сураглаж, өртөө уургын улаагаар явж байхдаа Цорос овогтой, авдраараа дүүрэн хуучин тод монгол ном судартай Халтар өвгөнийд өнжин хонон саатаж, бичиг судрыг нь шохоорхон үзэхдээ «Захиx үг элчийн аманд бий» гэсний учрыг тэр хөдөөний түүхч өвгөнөөс олж сонссоноо гуч шахам жил цээжиндээ хадгалж яваад, одоо үс буурал зохиолч болсон хойно эвлүүлэн бичиж, үзэгч олондоо уламжлах хүсэл төрлөө.

Арван долоодугаар зууны үеийн манай ард түмний түүх эмгэнэлт явдал олонтой бөгөөд сударчин хүн судлан гүйцээгээгүйн учир (балар үе) гэдэг тэр эрин цагийн гунигт домгийн тоймыг нь найруулан өгүүлбээс ийн буюу.

Баруун Монголын Галдан Бошготын цэрэг, Манжийн Энх-Амгалан хааны цэрэгт Туулын Зуун модны газар ихэд дарагдаад Зүүн гар хэмээх Монголын хүчин мохож, Орхон голын үерт авхуулан сарниж дутаасан Цорос омгийн Гөлөгдэй баатар цэрэг өрхийн хамтаар баруун зүг тэмцэн, говьд манжийн цэрэгт гүйцэгдэж, дийлсэн цэргийн хурц сүрт автагдан, арга буюу дагасан билээ.

Дайнд дарагдсан цэргийн Туулын Зуун модны тэнд олсон шарх гүйцэд эдгээгүй, сэтгэлд түмэн гашуудал зангирсан нь алдраагүй, манж хааны цэрэгт өнгөндөө дагавч, өшөө хорсол хөндий цээжээр дүүрэн байжээ.

Гөлөгдэй баатрын өргөөнөөс өртөө хэртэй газар, манж цэрэг хуарагнаж сүрийг бадруулагч гэдэг цолтой манж жанжны луут туг жанжны өргөөний өмнө хээрийн салхинаа намиран, манж цэргийн эргүүл харуул хамаагүй хүнийг хуарандаа ойртуулдаггүй байлаа.

Сүрийг бадруулагч жанжин Фү гэдэг бие өндөр, туранхай, чийрэг өвгөн өглөө бүр цэргээ сургууль хийлгэж, хахир дуут цэргийн бүрээ үлээж, манж цэрэг саран бай харвах, морин сургууль хийхийг хоньчин хүүхэд холоос сонирхон хардаг байлаа.

Гөлөгдэй баатар, Фү жанжныд хааяа ирдэг болж, манж цэргийн ноён, өвгөн баатрыг ирэх бүр өргөөнөөсөө гарч угтан улам дотно байдалтай болсон мэт, саяхан дайсагнан байлдаж байсан хоёр цэргийн жанжин бие биедээ ижилсэн дасаж манж ноён, монгол шатар сураад, Гөлөгдэй заримдаа өнжин шатар нүүдэг боллоо.

Отог цэргээ удирдсан өвгөн Гөлөгдэй баатар, манжийн сүрийг бадруулагч Фү жанжинтай гэнэт дотно найртай болж байн байн манж жанжны өргөөнд айлчлан очдог болсонд хөгшин залуугүй гайхавч, өвгөн баатар маань арай ч дайсанд зусардамгүй шударга журамт хүн, лав нэг учир бий гэж шаг шуг хэлцдэг болжээ. Тэгтэл өвгөн баатар, сүр бадруулагч Фү жанжныг төрсөн өдрийнхөө найрт урин хуримлах чимээ гарч, зуутын тушаалаар аравны дарга нар найрын хэрэгсэл, айраг цэгээ, цагаан идээ сархад бэлдүүлжээ.

Ийм цагт найр цэнгэл хийх гэдэг юу билээ? гэж өвгөд эмгэд, идэр цэргийн эрс бие биеэс асуун, арван, зуун цэргийн даргаас лавлацгаавал “Өвгөн баатрын захиа элчийн үг” гэж зууны дарга битүүлэг инээмсэглэн илүү дутуу үг хэлэхгүй ажээ.

Болзсон өдөр тэнгэр цэлмэг, маш сайхан байжээ. Манж цэрэг туг далбаа барьцгаан, өвч зэвсэглэж, сүрийг бадруулагч Фү жанжин хуарандаа буу талбин, торгон цэргээрээ хүрээлүүлж, Гөлөгдэй баатрын хүрээнд хүрэлцэн ирээд өвгөн баатар идэр залуугийн жавхлан бүрдсэн ганц хүүгээ дагуулан хатантайгаа гарч хүндэт зочныг холоос угтав. Манж жанжин мориноос бууж, найрсаг байдлаар өвгөн баатрыг ёслон, арван ханатай улаан халзан хөлтрөгтэй өргөөнд нь оржээ. Жанжны цэрэг баг багаараа жагсан, цэргийн дохионы бүрээ хангинаж, дарга нарын өндөр дуугаар тушаах манж цэргийн үг өвгөн баатрын хүрээнд дуурсаж, манж жанжны торгон цэрэг өргөөний дөрвөн этгээдэд хүндэт харуул зогсов.

Гөлөгдэй баатрын тугийн дэргэд манжийн луут туг зоож, өвч хуягт цэрэг туг тойрон жагсав. Фү жанжны шадар бие хамгаалагч өндөр чийрэг хэдэн солоон цэрэг жанжнаа дагаж өвгөн баатрын өргөөнд бэлгийн зүйлс барин орцгоож, удалгүй гаднаас сонсвол сархад барин, хөгжим өргөх чимээ сонсогдлоо.

Гөлөгдэй баатрын өргөөнөөс зайдуухан, саахалт хэрийн газар нийтийн найр зарласан газар, найр хуримын гоёл чимэгтэй сайхан хувцастай хүн цуглан, өргөн талын тэр хэсэгт нь эмээл хазаартай хэдэн мянган морь хад мэт хантайраастай, хайрцаг мэт тушаатай, хоймор талын асраар өвгөн баатар, манж ноёдын суудал засаатай баруун талд отгийн өвгөд хөгшид, эхнэр, охид талын цэцэг мэт эрээн мяраан, цөм Гөлөгдэй баатрыг Фү жанжны хамт ирэхийг хүлээжээ.

Тэр завсар өвгөн баатрын өргөө гэрт эгшигт сайхан хоолойт эмэгтэйчүүд хундага барихад өргөх хуримын ая гүйцээгээд, зочныг хүндэтгэн сархад сөгнөж байсан өвгөн баатрын ганц хүү, нүдэндээ галтай нүүртээ цогтой Шуну хаш хундаганд дахин архи дүүргэж, өвгөн баатар хундага тосон жанжинд өргөх гэтэл Фү жанжин нүд ирмэхийв. Тэр дохиогоор хазавчийн хоёр талд жанжнаас нүд шилжүүлэлгүй зогсож байсан солоон баатрууд гэнэт ухасхийж Шуну, Гөлөгдэй хоёрыг даран унаж, хаш хундага няц гишгэн, хоромхон зуур хүлж орхив.

- Көк тэнгэр гэж цочин хэлмэгдсэн эмэгтэйчүүдийн уулга алдахад чийрэг манж цэрэг эгшин зуур аманд нь таглаа хийж, гарыг нь хүлээд, том гэрт чив чимээгүй болж, гагцхүү ноцолдож амьсгал давхацсан хүний уухилах нь сонсдох ажээ.

Фү жанжныг толгой дохимогц нэг баатар нь гадагш гарч, цэрэгтээ ямархан нэгэн тушаал өгөөд, эргэж өргөөнөө оров. Фү жанжин инээмсэглэн, хүлээстэй, амандаа таглаа шаалттай Гөлөгдэй, Шуну, өвгөн баатрын хатан, охидын зүг хандаж,

- Эрхэм гэрийн эзэн уучлах ажаамуу. Таны нууц аргад үл автагдахын учир жанжин миний бие урьдчилан сэргийлэх арга хэрэглэсэн билээ. Эс чингэвэл, миний цэрэг даруй толгойгүй чөтгөр болох юмсанж. Би ч таны далд хорт аргад орж болзошгүй байлаа. Гагцхүү Энх-Амгалан хааны догшин сахиус Гэсэр Гуаньлооэ ивээж таны явуулсан захиа бичгийн нэгийг өгүүлсэн нь задран мэдэгдэж, би хариу арга хэрэглэлээ.

“Хараат тугаа сачуна, би
Хар бухын арьсаар бүрсэн
Бүрхрэн бүхүй дуут хэнгэргээ
Бүгдийн дунд дэлдүүлнэ, би
Харь манж цэргийг тэр дохиогоор
Хавчин хядаж хуримлана, бид
Урт хараат тугаа сачуна, би
Үхрийн арьсаар бүрсэн хэнгэргээ
Үй олны дунд дэлдүүлнэ, би
Өстэй манж цэргийг тэр дохиогоор

Өрлөн хядаж хуримлая, бид” гэж нууц захиа явуулсныг манай чэрэг, элчийг барьж жанжны хамт над хүргэж билээ.

Төрсөн өдрийн найр хэмээн манай манж цэргийн жанжин дарга нарыг урин ирүүлж, сархдаар согтоон хүйс тэмтрэх хэмээн сэм хуйвалдсан хорт хэргийн баримт энэ гэж өврөөсөө зурвас бичиг гаргаад, хүйтнээр инээмсэглэн цагаас өмнө сэжиг үл авхуулахын учир энэ бичгийг үлдээн, үсэг дуурайн хуулсан бичгийг шаламгайлан элчид өгч явуулсан билээ гэхэд Гөлөгдэй баатрын хүрэн царай барайж, Шунугийн зүг харав. Шуну түмэн буруутайн шинж илэрч, толгой даран гагцхүү шүүрс алдав.

Манж жанжныг толгой дохимогц баатар нь Гөлөгдэй, Шуну хоёрын амнаас таглааг нь сугалаад,

- Та нар хашхираад дэмий, манай цэрэг байлдахад бэлэн. Та нарыг хашхирвал тэр чимээгээр танай энд цугласан бүгдийг дайран орж хядан ална. Та нар хамгийн түрүүнд гэр хотлоороо алуулна гээд Гөлөгдэй баатрын хатан, охид хүүхдийн амны таглааг суга татаад, хатны хүлээстэй гар чинэрснийг ажиглан хүлээсийг нь тайлжээ.

Өвгөн баатар, хүүгийн өөдөөс хараад гуньхарсан сул дуугаар:

- Хүү минь, яав даа, чи? Дайн хөл ихтийн цаг, элчдээ итгэхгүй бичиг захидалд юунд итгэв дээ чи? Шуну эцгийн өөдөөс харж чадалгүй толгойгоо дотогш даран:

- Миний түмэн буруу. Очиж очиж, тэр захидал буруу гарт орно гэж мэдсэнгүй гэж шивнэн хэллээ.

Гөлөгдэй баатрын өргөөнд ийм явдал гарч байх завсар гадна байсан манж цэрэг өвгөн баатрын ойр шадар хүний гэрт орж, нумын хөвч, сэлэм хураан авч, “Дуу тавьсан хүнийг ална. Гэрээс гарсан хүн амь алдана” гэж чангалан тушаагаад, зэвсгийн сан, найрлах асрыг морьтон цэрэг бүслэн тэнд байсан хүнийг “Сууцгаа босвол харвана” гэж хотон дахь хонь шиг хашин хүрээлжээ.

Үл мэдэх манж түшмэлийн үг, чимээгүй хэлмэгдсэн олны чихэнд харилхаг

сонсдож, нэгэн хэсэг манж цэрэг мориноос буугаад монгол аравт, зуутын сэлэм хурааж авахад өндөр биетэй, өргөн цээжтэй, урт соёо сахалт нэг өвгөн мянгатан:

- Гэнэн залуу Шунугийн захианаас боллоо гэж гашуудан хэлээд есөн үеийн мисир болд юлдийг ингэж хураалгахыг үзлээ гээд жийжүү мөнгөн хуйд нь нал эрдэнэ шигтгэсэн юлдээсээ адис авч, манж цэргийн аравны даргад өглөө.

- Закаанд илүү үг үгүй гэж бодоод, манж цэрэгт зам зуур баригдсанаа эс хэлсэн миний буруу боллоо гээд нэг залуу чийрэг цэрэг эр хутгаа суга татан, өвгөн Эргилийн юлдийг авч сонирхон үзэж байсан манж аравтны хоолойн тус бариулд нь тултал шаагаад, мисир болд юлдийг шүүрэн авч хуйнаас суга татан, зэвсэг хурааж байсан манж цэргийг дайран орж агшин зуур хэдэн хүнийг цавчин унагав. Цоохор царайтай нэг солоон цэрэг морин дээрээсээ яаран эрэн нумаа шүүрч сумаа булцуунд нь хүртэл татаад харвамагц хар хийж хавирга яс нэвт цохих чимээ сонсдон араас нь туссан сумын зэв залуу эрийн цээжнээс гялсхийн гарч, хөөрхий залуу юлдээ атган далайсаар ойчлоо.

Цочсон олон уулга алдаж, манж цэрэг нум сумаа харвахад бэлдэн манж цэргийн дарга,

- Гар хөдөлбөл цөмийг харван ална гэж хахир дуугаар хашхиран тушаав. Чингээд Гөлөгдэй баатрын өргөөний зүг нэг цэрэг давхиулж, найрын талбайгаас үхэгсдийг зайлуулах тушаал өгчээ.

Удалгүй өргөөний зүгээс нэг манж баатар давхин ирээд өндөр дуугаар,

- Чонос Гөлөгдэй баатар нь сүр бадруулагч жанжин Фү, тэнгэрийн цэрэг сэлтийг хорлох муу санаа өвөрлөн сэм хуйвалджээ. Эзний сүлд харж, буруу санаат муу хулгай Гөлөгдэйг жанжны гарт тушаан өгчээ. Муу хулгайн хорхой мэт амь хэрхэн болохыг аюун эмээн хүлээ, хөдөлбөл харвана гээд манж цэргийн дарга нарт ямар нэгэн тушаал өгч даруй өргөөний зүг довтлон одов.

- Көк тэнгэр тэнэг муу би, баатар ноёноон дайсантай элкэ нэгдлээ гэж килэнц хурааж явлаа. Көөркий баатар ноён минь, көөркий баатар ноён минь гэж нэг өвгөн үнэн сэтгэлээс гаслан, олон хүний гашуудах чимээ зөөлөн салхинд хулс зэгсний шуугиан мэт, зарим хүн цг цг гэж гашуудан шагширч, зарим хүн гашуунаа шүүрс алдав. Гөлөгдэй баатрын гэрт хойморт нь эрхэмсэг сүр үзүүлэн лаглайж суусан манж жанжин найрын талбайд будилаан гарсныг сонсож дотор эмээсэн боловч цэргийн дарга хүрч ирэн, сэтгэл тайтгарах мэдээ сонсгосонд баруун хацартаа сэлмийн сорвитой хүрэн царайд нь ялсан баяр тодорч, соёо хар сахал доорх уруулын завжинд бахархах мишээл нуугдан, Гөлөгдэй баатрын зүг ширтэс хийж,

- Таны хар санаа өвөрлөснөөс болж, миний хэдэн цэрэг эвтэй сайхнаар найрсан найрамдах гэж ирээд одоо амиа алдсанд үнэхээр гашуудалтай. Энэ цөм таны ял. Хэлтрүүлж үл болно. Самуун чагийн цэргийн чаажаар гүйцэтгэвээс, таны харьяат олны арван хүн тутмаас нэгийг чаажаар аваачин сүрдүүлж, хойчийн чээрлэл болговоос зохих билээ. Эх булинггар ахул адаг тунгалаг байх ёсонгүй тул таны гэрийн хотлоор ял шийтгэл хүлээж есөн үе хүртэл албанаа зүтгэх хэрэг. Энэрэлт богд эжэн Энх-Амгалан хуанди хааны өршөөлт жарлигт тэрслүүг цээрлүүлэн, номхон иргэнийг илбин тохинуул хэмээсэн учир таны цэрэг ардаас ял үл асууна. Гагцхүү таны нэгэн гэрийн төдийхнийг цэргийн цаазаар аваачиж ялсан баатартай түмэн үед зүрхэлж тэмцэлдэх санаа сэдэхгүй болгохын тулд эхнэр, хүүхдийн нь нүдний өмнө хорон санаат хэргийн гол эжэн эцэг, хүү хоёрыг зоосны нүхээр сүвлэн чаажлаад дараа нь хайртынхаа жовохыг үзэж сэтгэлээр тарчилсны нь бодож үлдсэн хүмүүсийг нь жүгээр сэлэмдэн чаажилна гэхэд Гөлөгдэй, Шуну хоёр сэтгэл түмэн түгшүүртэй

боловч харь хүнд муугаа үзүүлэхгүй гэж хоёр бага хүүхдээ тэврэн, хатуужиж суусан хатны царайг ажин суув.

- Уг хэргийг үүсгэн сэдэвчилсэн эзэн би билээ. Зүүн гар улсын цэргийг дарсан та нарыг хөгшин цэргийн эр би яахан боол мэт дагаж, зарц мэт сөгдөх билээ. Эр хүн гэрт төрөөд эрэлхэг баатраар дайсантай тулалдаж хээр үхэхэд гомдолгүй хэрэг. Харийн халдан түрэмгийлсэн этгээдтэй зэвсэг барин тулалдахаас үл эмээх миний бие таны гарт ороод толгой авхуулахаас өчүүхэн ч үл зовно. Гуйх үг амнаас гарах нь түмэн бэрх боловч үхлийн өмнө үг хэлж, миний өвгөд дээдсийн гал голомт залгамжлах ганц хүү Шуну баатрын амийг хэлтрүүлмүй гээд өвгөн Гөлөгдэй баатар, Фү жанжны өөдөөс хариу юу хэлэхийг ширтэн хүлээв.

- Аав, яаж болох вэ? Эртний мэргэн ёс алдаж, элчдээ итгэлгүй эрээн захидалд итгэж, нууцаа задруулснаараа хамаг ялыг би ганцаар эдлэх ёстой. Эцэг, эх гэгч биеийг нь төрүүлэхээс биш санааг нь төрүүлэх ёсгүй. Зоосны нүхээр сүвлэж, хэрчин тамлах битгий хэл хүний ухаан хүрч бодож сэдэж олж чадах ахул түүнээс илүү ялаар ганцхан намайг л цаазалж эцэг эх, дүү нарын амийг хэлтрүүл гэж Шуну манж жанжны зүг мэхийн хэлэв.

- Төрсөн ганц хүүгийнхээ мууг үзсэнээс түрүүлж би үхье, үр хүүхдийнхээ мууг бүү үзье. Эх хүн гэж байхгүй бол энэ ертөнцөд хүү хаанаас төрөх вэ? Гэнэн болгоомжгүй өсгөсөн нь эх миний л мянган буруу. Үр хүүхдийн минь оронд зоосны нүхээр намайг л сүвлэж цаазал, үр хүүхдийг минь өршөө. Хөөрхий тэр минь алтан нарны гэрлийг ханатлаа үзэж амжаагүй яваа юм шүү гэж Гөлөгдэйн хатан уярангуй дуугаар хэлэв.

Манж жанжин тав ханасан байдалтай гэдийн сууж, баригдан олзлогдсон тэдний сэтгэлийн зовлонг бахархан харж нэгэн хэсэг дуу чимээгүй байснаа,

- Эр хүн нэгэн сэтгэл, нэгэн амтай байвал зохино. Улс төрийн хүнд ялыг хэлтрүүлж үл болно. Гагцхүү Гөлөгдэй баатрын өвгөд дээдсийн тахилга тасарч, гал голомт балрахын гашууныг бодон, нэгэн болзол тавьж, гуйн хүссэн ёсоор Шунугийн амийг хэлтрүүлье. Шуну, чи эцэг эх, дүү нарын толгойг өөрийн гараар авбал тэнгэрийн хишиг хүртэж, эцэг хүү хоёрыг зоосны нүхээр сүвлэх ялыг өөрчлөхөөр барахгүй чамайг амьд үлдээж, Чонос Гөлөгдэйн гал голомт залгамжлуулъя. Миний санал нэгэнт тогтов. Үүнээс өчүүхэн ч өөрчлөх ёсгүй. Бүгдээр цаазаар авхуулах, Шунуг амьд үлдээхийг та нар зөвлөн тогт гээд цаазаар аваачихын бэлтгэл хийх тушаал өгсөнд шадар баатрын нэг нь гадагш гарч, төдхөн манж цэргийн бүрээ хангинах чимээ гарав.

- Хэрэг нэгэнт ийм болсноос хойш хүү минь зориг хатуужин бидний толгойг ав. Эр хүний жолоо урт. Чи амьд явбал нэг учир бий. Битгий гутар. Сэтгэлээ хатамжил гэж Гөлөгдэй баатар Шуну хүүгээ энхрийлэн зоригжуулж хэлэв.

- Би та нарын түрүүнд толгойгоо авхуулъя гэж Шуну намхан дуугаар хэллээ.

- Тугалган жад мэт битгий зориг шантар. Үхлээс зайлсан хүн энэ ертөнцөд байдаггүй. Чамайг амьд явбал нэг учир бий гэсэн аавынхаа сургамжийг дага. Хүний гарт эцэг, хүү хоёроо зүрх хагарам тамлуулахыг үзсэнээс хүүгийнхээ гарт үхье гэж бид санал тогтлоо. Эцгийнхээ тамлуулах эсэхийг үрийн минь зориг л мэдэх нь байна. Жанжин та хэлсэн үгэндээ эзэн болдог юм бол Шунугийн биед гар үл хүрэхийг цэрэг олны өмнө амла даа. Биднийг цаазаар аваачин, Шунуг үлдээ гэж сэтгэл хатамжилсан дуугаар хатныг хэлмэгц Шуну, эцэг эхийн өмнө сөгдөн мөргөж,

- Эртний бичгийн ёс алдсанаас би та бүхэнд ийм гамшиг зовлон даллан ирүүлсэн болохоор би амьд явсны хэрэг алга. Энэ дэлхийд хүн болгосон хэмжээгүй

ачтаныхаа өөдөөс юлд яаж далайх вэ? Яалаа ч сэтгэл түвдэхгүй нь гэж Шуну хэлэхэд,

- Үрийн сэтгэлээр төрүүлж өсгөсний минь ачийг санаж мэдэж яваа бол үхэхийнхээ өмнө эцэг эхийнхээ захисан сургаалыг дагах нь ёстой дээд элбэрэл гэгч тэр шүү. За хүү минь зориг хатамжил. Үүнийг давж гүйцээж чадвал ёстой хүү төрүүлсэндээ ээж, аав нь бахадсаар үхнэ гэж эх нь хэлэв.

- Аав, ээжийн алтан сургаалыг өгүүлшгүй бэрх ч гэсэн чин их хайрлах сэтгэлээсээ хүндэтгэж яая гэх вэ дагая даа гэж зүрх алдан байж хэлээд манж жанжны зүг эргэж “Би бэлэн” гэж сэтгэл хатуужиж хэлсэнд:

- Ингэвээс та нар харилцан хагацах ёс хийтүгэй.

Цаазын газар хүргэхэд жүй нь та нарын гарыг хүлбээс зохих бүлгээ. Зоригт баатрын гэр бүлийг хүндэтгэж гар хүлээсгүй явуулна гээд гарахад нь үүдний хазавчийн тэнд хоёр манж баатар, гэрийн гадна харуулын цэрэг үлдэн, сүрийг бадруулагч жанжин Фү найрын талбайд шадар цэргээр хүрээлүүлэн очиж, Гөлөгдэй баатрын асарт цэргийн ноёдын хамт суув. Найрын газар цугласан олныг манж цэрэг гоё эрээн асрын өмнө этгээдэд нум мэт тойруулан суулгаад Фү жанжны тушаалаар манж цэргийн ноён асрын өмнө гарч ирэн Гөлөгдэй баатрын ялыг тоочин, тэнгэрийн хишиг хүртээн, хүү Шунугийн гараар дайчин улсын Богд эзэн хааны дайсан Гөлөгдэйн гэр бүлийг цаазаар аваачих жанжны тушаал сонсгов. Олон цөм хирдхийн цочиж, сүрт тушаалын үгийг чив чимээгүй сонслоо. Манж ноён нэгэн хэсэг дуугүй зогсоод дахин өндөр дуугаар сонсон өвгөн баатар Гөлөгдэй, хатны хамтаар гуйж, хүүгийнхээ амь хэлтрүүлэхийг хүсэн илэрхийлснийг сүрийг бадруулагч жанжин Фү эе эеэ тогтоож, Шуну хүү, эцэг эх дүү нарын толгойг өөрийн гараар авбал амь хэлтрүүлэх зөвшөөрөл олгосныг мэдэгдсэнд олон цөм цочин санаа алдав.

Тэгтэл өргөөний зүгээс манж цэргээр туулгасан Гөлөгдэй баатар, хатан, хоёр бага охины хамт хүрч ирсэнд асрын өмнө манж цэрэг тушааж тэднийг сөгтгөн суулгажээ. Цэргийн бүрээ татаж, нам гүм болсон олон хүний нүд, баярт зориулж барьсан гоё эрээн асрын өмнө сөгдсөн дөрвөн хүний зүг ширтэн, манж цэргийн дарга, цаазын сумаар дохио өгмөгц Шуну, эцгийн өмнө сөгдөн мөргөөд, өвдгөөс нь мөлхөн адис аваад, босож сэлмээ далайн гялсхиймэгц өвгөн Гөлөгдэй баатрын толгой өнхрөн унав. Олон мянган хүний хөндий цээжнээс ганц хүн шиг санаа алдах чимээ сонсдож, эмэгтэйчүүд ханцуйгаараа нүүрээ халхалцаав. Шунугийн өргөн цээжин дотор нь хорслын гал бадарч байгаа боловч утааг нь хамрынхаа нүхээр гаргалгүй царай нь чулуун хүний царай шиг огт хөдөлбөргүй гагцхүү нүдний харц туйлын хачин болжээ. Эхийн өмнө сөгдөн хормойноос нь адис аваад, доголон нулимс хацарт тогтсоныг нь хараад сэтгэл үл түвдэх мэт байдал царайд мэдэгдсэнийг эх нь үзээд,

- Харьтанд муугаа бүү үзүүл. Хатуужин түргэл! гэж зоригтой дуугарсныг нь асрын өмнө чимээгүй хүрээлэн суусан олон элэг эмтрэн сонслоо.

Жаргал зовлон хамтатгасан буурал Гөлөгдэй баатрынхаа амьгүй биеийг нэг хараад, хатан хүзүү сунган, огцом дуугаар “За” гэж дуугармагц, сэлмийн жур хийх чимээ гарч хатны толгой дэргэд нь өнхрөн ойчоод, чихэнд нь нэг юм хэлж байгаа юм шиг наалдан тогтов.

Шунугийн дүү үг дуугүй, нарийхан хүүхэд хүзүүгээ сунгахад хонгор үстэй толгой нь бага дүүгийн хормойн өмнө нүдээ харан ойчиход тав зургаан настай отгон бага охин эгчийнхээ толгойг нүд цавчилгүй харан, хүзүүгээ сунгаад хүүхэд хонгор

хоолойгоор,

- Ах аа, миний энд хатиг гарсан юм. Хөндвөл их өвддөг. Энүүгээр цавчаарай. Хатиг битгий хөндөөрэй гэж гараараа зааж хэлсэн нь амьсгаагаа дарж, чимээ аниргүй байгаа олонд тов тод сонсдон зүрхийг шөвгөөр чичих шиг болов.

Отгон охины толгой ойчмогц манж цэргийн бүрээ хангинаж, Шунуг манж цэрэг дарга дундаа авч, өглөөний мандах улаан нарнаар элэг бүтэн айл байсан бага үдийн нарнаар өнчирсөн гэр өргөөнд нь хүргэж өгсөн билээ.

Нууцыг задруулсан захидлын гайгаар Цорос Гөлөгдэй баатрын нэгэн гэрийг хүйс тэмтрэн хядсан тэр явдлаас хойш өвгөд, эмгэд Хүйсийн говь гэж тэр нутгийг нэрлэдэг болсон гэдэг хуучны үг бий. Шуну яасан бэ гэвэл тэр шөнөдөө хэдэн цэргийн хамт оргон босож, манж цэргийг ганц нэгээр, бүлгээр явахад нь хядан устгаж, сүрийг бадруулагч Фү жанжин ч гадагш гарах бүр хамгаалах баатар цэрэггүй гарахаа байж, Шунуг уулын хулгайч гэж амьд барьсан хүнд түмэн лан, толгойг нь хүргэж ирсэн хүнд таван мянган лан шагнана гэж зарлавч, амьсгал тасартлаа өшөө зангирсан Шунуг барьж санаа амарч чадсангүй. Өдөр бүрийн цэргийн мэдээнд хэд хэдэн амь хохирсныг хөмсөг зангидан сонсож, "Уулын хулгай" хэзээ надаас хариу авах бол? гэж манж нутаг эгэх зөвшөөрлийн бичиг алс Бээжингээс хүлээсээр байсан гэж урьдын гунигт домгийн үг сонссоноо энд чадан ядан эвлүүлэн бичлээ.

Эх сурвалж: Б.Ринчен "Гүнж" түүвэр УБ., 1969, 61-84 дүгээр тал

2. Зохиолыг бүхэлд нь өнгөөр илэрхийлбэл танд ямар ямар өнгө төсөөлөгдөж байна вэ? Яагаад ийм өнгөөр дүрслэн төсөөлснөө дүгнэж бичээрэй. Жишээлбэл:

Би Фү жанжныхан Гөлөгдэйн найрт уригдан ирж байгаа үеийг өнгөөр илэрхийлбэл: Гөлөгдэй баатрын хот хүрээнд өрнөж байгаа үйл явдлыг

.....өнгөөр илэрхийллээ.

Учир нь:

Харин Фү жанжин, түүний цэргүүдийн ирж байгаа үеийг

.....өнгөөр илэрхийллээ.

Учир нь:

Энэ бүгдээс дүгнэвэл:

3. Энэхүү зохиол нь туурь болохыг нь 147 дугаар талд байгаа онолын ойлголтыг уншаад, баталж тайлбарлаарай.

Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэе

1. Өгүүллэгээс аль нэг дүрийг сонгон дараах дарааллын дагуу багаар ажиллаж, дүгнэлт хийгээрэй. Үүнд:

- ✓ Аль нэг дүрийг сонгон авах
- ✓ Тухайн дүрийн зорилгыг тодорхойлох
- ✓ Дүрийн зорилгодоо хүрсэн арга замыг тодорхойлох
- ✓ Энэ арга зам зөв байсан эсэхийг дүгнэх
- ✓ Ямар үр дүнд хүрснийг дүгнэж бичих
- ✓ Хэрвээ энэ дүрийн оронд чи өөрөө байсан бол яах байсан талаар бичих

✓ Нэг дүр дээр хэд хэдэн ийм зураглал гаргаж дүрийн талаар нэгдсэн дүгнэлт хийх

2. Дээрх даалгаврыг яаж хийх аргачлалыг Гөлөгдэй баатрын дүрээр жишээлэн үзүүлж байгаа тул та нар эхлээд дутууг нөхөж гүйцээх явцдаа яаж ажиллах аргад суралцаарай.

	Зорилго 1	Зорилго 2	Зорилго 3	Зорилго 4
Зорилго	Гол хүчтэйгээ нийлэх	Фү жанжны итгэлийг олох	Фү жанжны нууц аргад оруулж дарах	Шунуг амьд үлдээх
Зорилгодоо хүрэх арга зам	Баруун зүг буюу нутгийн зүг явах		Төрсөн өдрийн найрт урих	
Сонгосон арга зам зөв эсэх Яагаад?	Зөв байсан. “Хүн ядарвал нутгаа, тураг ядарвал уулаа” гэдэг шиг сарнисан бусад цэргүүд ч гэсэн нутаг руу явсан байх магадлалтай тул нийлж хүчээ зузаатгах	Зөв байсан. Цаг хожих, боломжийг хайх, эсрэг талаа судлах		Зөв байсан. Өөрийн үр удмаас нэг нь ч гэсэн үлдэх цаашлаад эр хүн үлдэж байж л эх орноо аврах
Ямар үр дүнд хүрсэн		Фү жанжны итгэлийг олж дотносож чадсан.	Хүү Шунугийн буруугаас гэр бүлээрээ хүйс тэмтрүүлсэн	
Хэрвээ би байсан бол...	Гөлөгдэй шиг шийдвэрийг гаргах байсан байх эсвэл муу амьдрахаар сайн үх гээд л эцсээ хүртэл тэмцэх			Гөлөгдэй баатар шиг хэн нэгийгээ үлдээх боломж байвал ямар ч сонголтыг хийх л байсан байх
Дүрийг тодорхойлбол:	Уйгагүй, ухаалаг, нөхцөл байдлыг зөв дүгнэж шийдвэр гаргах чадвартай	Холын бодолтой, хүлээцтэй, уран аргатай, ухаалаг		

3. Дээрх дүгнэлт дээр нэмээд бусад дүрүүдийн яриа болон өөрийн хэлсэн үгээр түүний дээрх шинжүүдийг баталж, дүгнээрэй. Үүнд:

Хэн хэлсэн	Зохиолын эшлэл	Дүгнэлт
Хүмүүсийн ам дамжсан яриа	“...өвгөн баатар маань арай ч дайсанд зусардамгүй шударга журамт хүн, лав нэг учир бий.”	Зусарч биш, шударга
Зуутын дарга нар	Өвгөн баатрын захиа элчийн үг гэж битүүлэг инээмсэглэх	Бусдын итгэлийг хүлээсэн
Гөлөгдэй баатрын элчээр	...Урт хараат тугаа сачуна, би Үхрийн арьсаар бүрсэн хэнгэргээ Үй олны дунд дэлдүүлнэ, би Өстэй манж цэргийг тэр дохиогоор Өрлөн хядаж хуримлая, бид
Гөлөгдэй баатар хүүдээ	Хүү минь, яав даа чи? Дайн хөл ихтийн цаг, элчдээ итгэхгүй бичиг захидалд юунд итгэв дээ, чи?
Нэг өвгөн	Көк тэнгэр тэнэг муу би, баатар ноёноон дайсантай элкэ нэгдлээ гэж килэнц хурааж явлаа. Көөркий баатар ноён минь, көөркий баатар ноён минь.
Гөлөгдэй баатар Фү жанжинд	Уг хэргийг үүсгэн сэдэвчилсэн эзэн би билээ. Зүүн гар улсын цэргийг дарсан та нарыг хөгшин цэргийн эр би яахан боол мэт дагаж, зарц мэт сөгдөх билээ. Эр хүн гэрт төрөөд эрэлхэг баатраар дайсантай тулалдаж хээр үхэхэд гомдолгүй хэрэг. Харийн халдан түрэмгийлсэн этгээдтэй зэвсэг барин тулалдахаас үл эмээх миний бие таны гарт ороод толгой авхуулахаас өчүүхэн ч үл зовно. Гуйх үг амнаас гарах нь түмэн бэрх боловч үхлийн өмнө үг хэлж миний өвгөд дээдсийн гал голомт залгамжлах ганц хүү Шуну баатрын амийг хэлтрүүлмүй
Гөлөгдэй баатар хүү Шунуд	Хэрэг нэгэнт ийм болсноос хойш, хүү минь зориг хатуужин, бидний толгойг ав. Эр хүний жолоо урт. Чи амьд явбал нэг учир бий. Битгий гутар. Сэтгэлээ хатамжил.

Дүрүүдийн холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэе

1. Дээрх аргачлалаар багаар ажиллан бусад дүрүүдийг дүгнээрэй.

Шуну	Хатан	Фү жанжин
------	-------	-----------
2. Багаар ажиллаж гаргасан дүгнэлтээ хооронд нь харьцуулж, дүрүүдийн холбоо хамаарал болон өсөлтийг дүгнээрэй.
3. Зохиолд өрнөж байгаа зөрчлийг нөхөж гүйцээн бичээд, дүрүүдийн холбоо хамаарлыг тайлбарлаарай. Үүнд:
 - Дийлэгдсэн ойрад цэргийн баатар Гөлөгдэй, Манжийн түрэмгийлэгч цэргийн жанжин Фү нарын хоорондын дайсагнал
 - Фү жанжинтай ойртон нөхөрлөсний төлөө ард олны доторх хардалт, Гөлөгдэй баатрын битүүлэг байдал
 - Шуну элчдээ итгээгүйгээс болж үүссэн зөрчил
 - Шунуг үлдээхийн төлөөх гэр бүлийн зөрчил
 - Дүрүүдийн дотоод зөрчил
 - Шуну, Фү жанжин нарын хоорондох зөрчил гэх мэт.
4. Багаар хамтран ажиллаж, түүж бичсэн зөрчлөөрөө холбоо хамаарлын зураглал хийгээрэй.

Зөвлөмж:

- ✓ Зохиолын далд утгыг ойлгоход туслах нийгмийн зөрчил байгааг гаргах
- ✓ Зөрчлүүдээс аль нь үндсэн зөрчил, аль нь алинаас хамаатай зөрчил болохыг гаргах гэх мэт.

Орчин, нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг дүгнэе

Дараах асуултын дагуу багаар ажиллан, орчин, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийгээрэй.

- А. Зохиолын үйл явдал нь:
 - Аль улсын нутаг дэвсгэрт
 - Ямар нэртэй газар
 - Хэдэн оны үед өрнөж байна вэ?
- Б. Өөрийн нутаг орондоо байгаа хүний хувьд ер нь давуу тал бий юу? Зохиолын хувьд энэ нь давуу тал болж чадаж байна уу? Яагаад?
- В. Нийгэм ахуйн таатай, таагүй байдал зохиолд хэрхэн туссан байна вэ?
- Г. Фү жанжны болон Гөлөгдэй баатрын өргөө орчмын дүрслэлийг харьцуулаарай.
- Д. Найр эхлэх гэж байх үеийн орчны дүрслэл ямар үүрэгтэй байна вэ?
- Е. Монголчуудын эдэлж хэрэглэдэг эдийн болон оюуны соёлын зүйл зохиолд хэрхэн дүрслэгдсэн төдийгүй зохиолд ямар үүрэгтэй байна вэ? гэх мэт асуултыг сонгон ажиллах.

Жишээ нь:

“...Гөлөгдэй баатрын өргөөнөөс өртөө хиртэй газар, манж цэрэг хуарагнаж сүрийг бадруулагч гэдэг цолтой манж жанжны луут туг жанжны өргөөний өмнө хээрийн салхинаа намиран, манж цэргийн эргүүл харуул хамаагүй хүнийг хуарандаа ойртуулдаггүй байлаа...”

Энэ хэсэгт манж жанжны луут туг өргөөний өмнө намиран байгаа нь ялсан цэргийн сүр хүч, давуу талыг харуулж байна. Мөн хуаранд ойртуулахгүй байгаагаар хэдийгээр ялсан боловч хүний нутагт эзлэн түрэмгийлж байгаа тул маш их болгоомжлол байгаа болон аюулгүй байдал, сүр хүчний давуу талыг илтгэж байна гэх мэтээр тайлбарлана.

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэе

1. Дараах асуултын дагуу багаараа ярилцаж, зохиолын сэдэв, санааг тодорхойлоорой.
 - А. Гөлөгдэй, Шуну болон зохиолын бусад дүрүүд ямар цаг үед, юуны төлөө тэмцэл хийв?
 - Б. Үүгээр зохиолч юу хэлэхийг хүсэв?
 - В. Зохиолыг яагаад “Нууцыг задруулсан захиа” гэж нэрлэсэн бэ?
 - Г. Энэ зохиолоос чи юу ойлгож авав?
2. Дараах асуултын дагуу хосоороо ярилцаарай.
 - А. “Хэлэх үг элчийн аманд” гэсний учир юу байв?
 - Б. Зохиолч энэ үгийн учрыг хаанаас мэдэж, хэрхэн эргэцүүлж, ямар үнэ цэнтэй бүтээл туурвисан бэ?
 - В. Тухайн цаг үед монголчуудын эдэлж, хэрэглэж байсан эдийн соёлын талаар аль аль хэсэгт ямар зорилготой дүрсэлсэн байгааг олж тайлбарлаарай.

Эшлэл - 1	Эшлэл - 2	Эшлэл - 3
“...жийжүү мөнгөн хуйд нь нал эрдэнэ шигтгэсэн юлд”	“...хэдэн мянган морьд хад мэт хантайраастай, хайрцаг мэт тушаатай...”	“...арван ханатай, улаан халзан хөлтрөгтэй өргөө...”
Уншигчдад үзүүлэх нөлөөлөл	Уншигчдад үзүүлэх нөлөөлөл	Уншигчдад үзүүлэх нөлөөлөл
.....
.....
.....

БОГИНО ӨГҮҮЛЛЭГ

Уншихын өмнө:

1. Ж.Лхагвын “Эвэр” өгүүллэгийг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, та нар өмнө нь ямар уран бүтээлийг нь мэддэг байсан талаар хосоороо ярилцаарай.



(1942-1998)

Төрсөн он, газар: 1942 онд Дорноговь аймгийн Хөвсгөл суманд төржээ.

Боловсрол: 1966 онд Киевийн политехникийн дээд сургууль, 1987 онд Москвад Утга зохиолын дээд курсийг төгссөн.

Уран бүтээл: 1960 оноос уран бүтээлээ эхэлж “Саарал даага” (1970), “Толгодын цаана ингэ буйлна” (1972), “Сарны шороо” өгүүллэг, тууж (1977), “Хулангийн тоос” (1978), “Шөнө ногоо ургадаг” (1983), “Ахыг даасан хүн” (1985), “Атга чулуу” (1990), “Алаг чулуу” (1991), “Дутуу хөрөг” (1994) зэрэг ном бичжээ.

Тэрээр орос, испани хэлнээс олон ном орчуулж, хэд хэдэн кино зохиол, теле кино, теле жүжиг бичжээ.

2. Зураг, хэлц үг, өгүүлбэрээс ямар зохиол унших гэж байгааг таамаглан ярилцаарай.



*Сүрлэг эвэртэй болж
Сүргийн манлай болох юмсан*



*“Эвэр ургалаа
Ээжээр яах вэ?”*

3. Янгирын эрийг нь тэх гэдэг. Тэхэд урт, том эвэр яагаад чухал вэ?
4. Зохиолч энэ өгүүллэгээр ямар сургамжтай санааг бидэнд хэлэхийг хүссэн бол? Ухаарч уншаарай.

Зохиолыг мэдэрч, ойлгож уншъя.

1. Зохиолыг унших явцдаа танил биш үгийг тэмдэглээд “Монгол хэлний тайлбар толь” ашиглан утгыг мэдэж аваарай.

Жагдалын Лхагва

ЭВЭР (богино өгүүллэг)

Алтайн хүрэн цохионы нөмөрт хавсаргатай өдөр эхээс мэндэлсэн янгирын бор ишиг наран наашлах тутам хөрвөжин торниж, шөрмөс чангаран туурай хатахын хэрээр толгой дээр нь хоёр газар товойж, арьс загатнах болов. Ишиг эхлээд яах гэж загатнаж байгааг үл мэдэн хаданд хааяа үрчхээд л ээвэр газар тагшин тоглож сүрэг даган тачигнаж явах бөлгөө. Удахгүй арьс загатнахаа болиод өвдөж эхлэв.

Өвдөх нь өвчин биш зүгээр л нэг хүлээлт - албан тушаал дэвших гэж байгаа хүнд дээд газрын шийд ирж өгөхгүй удах мэт аятайхан шаналгаа байлаа. Тэг тэгсээр товойсон газар нь үс халцарч, арьс нимгэрсээр хоёр хөөрхөн эвэр цухуйв. Энэ үеэс л ишиг тэх болох гэж байгааг там түм гадарлан урт сүрлэг эвэртэй болохын дон тусчээ. Тэрээр цохионы орой дахь тогтоол уснаас уух бүрийдээ тугалмай нь бяджаагүй бяцхан эврээ харан харан чамлаж, тэр л өдрийнхөө талыг сэтгэл гунин өнгөрөөх болжээ.

Шүдлэн насанд эвэр нь овоо хэвээ олж дугуйран, хэдэн сайхан эржгэртэй болоод үзүүр нь шовхорч ирэв. Аргил тэхийн долоон төө эвэр, эцэг тэхийн таван төө эвэр гадаад анчны ганзага мялааж, Берлин, Парис одсон болохоор эдүгээ бор халиун сүрэгтээ эхний дөрөвт орох болжээ. Энэ нь хэдийгээр шүдлэн ямаанд багадахааргүй байр суурь боловч сүрэг тэргүүлэх хүсэлд эрт донтсон залуу янгирт шившигтэй санагдана.

Нэгэн өдөр янгирын сүрэг байрлал солих болж, хавцлын ирмэг нарийн жимээр бэдрэв. Янгирын хуулиар бол ганц ганцаар цувран явах ёстой боловч эх янгир бор шүдлэнг туурай гүйцэд хатаагүй юм хэмээн хамгийн хавцал талаас нь түшиж явлаа. Удаан ургаж байгаа эвэр, ургаж ядсан цаг хугацаа хоёрыг зүхэн бухимдаж явсан залуу янгирын цус дээшээ огшин эврийн үзүүрт халуу оргин чинэрээд ирэв. Хадан хана руу хадарч орхивол яс тугалмай янгинан тархи дүйрээд уурандаа эргэж эхийн бөөр лүү сэжив. Санаандгүй явсан эх янгир ганц тэрсхийгээд хавцлын харанхуй руу пижигнэн одоход залуу янгир айсан ч үгүй, ичсэн ч үгүй, гэмшсэн ч үгүй гагцхүү яах гэж тэр хөгшин зөнөг цувж явалгүй зэрэгцэн чихэлдээд байсанд л баахан гайхаж, зай чөлөөтэй болсонд баярлах бөлгөө.

Эхээ ольсон эврийн үзүүрт арьс үс шалбарч, дусал цус наалдаад байвч залуу янгирт анхаарч мэдэх зав байсангүй.

Харин хожим нь тогтоол уснаас уухдаа тольдон харахад тэр талын эвэр арай дотогшоо дугуйраад байгаа нь ажиглагдах болжээ. Хоёр өөр эвэртэй байх нь сүргийн тэргүүний сүр хүчинд сайнгүй ч гэсэн урт л ургаж байвал учиртай гэж тэр бодно.

Хоёр жил өнгөрлөө. Дахиад хоёр тэх ногоон мөнгөний золиосонд одож, бор халиун сүргийн тэргүүнтэн болоход ганц хуруу дутаа. Гэвч түүнд тэргүүн болохын хүслэнгээс өөр нэг бодох юм бий боллоо. Юу гэвэл нөгөө дотогшоо дугуйрсан эврийн үзүүр явсаар чамархайд тулжээ. Яагаад тэгснийг тэрбээр яаж бодоод ч эс ухаарна. Эвэр хэдхэн сарын дотор арьсаа хонхойлгон дарж өвтгөх болов. Тэгснээ арьс цоороод цус шүүс гоожиж ялаа батгана салахаа болилоо.

Залуу янгир дэндүү хурдан ургаж байгаа эвэр, хайр найргүй довтолгох цаг хугацаа хоёрыг зүхэн бухимдавч эвэр хэдийнээ маханд шигдэн оржээ. Бусдын эвэр толгой тойрон ургаж, эсвэл дээшээ сэрийж байхад миний эвэр яагаад ...? хэмээн тэрбээр шаналан бодовч хариу үл олдоно. Эвэр ургасаар ясаа цолов. Тэсгэлгүй өвдөхийн манан дотор “яагаад” гэсэн асуултын хариу төөрсөн янзага шиг сүүтийвч бие нь үл баригдана. Эвэр тархиндаа тулжээ. Тархины бор хальс цоорох хоромд л “Миний эвэр буруу ургажээ” гэсэн там тумхан ухаарал янгирын толгойд нэг орж ирээд үүрд замхарсан нь шувуу суунгуут үргэн нисэхийн адил бөлгөө.

Монгол уран зохиолын дээжис 46-р боть, УБ., 1998, 310-312 дугаар тал


2. Янгирыг сүргийн тэргүүн болохоор маш их яарч байсан гэсэн санааг зохиолч хэрхэн гаргасныг таваас доошгүй үг хэллэгээр баталж бичээрэй.
 - а.
 - б.
 - в.
3. Янгир юунаас болж сүрэгтээ эхний дөрөвт оров? Энэ нь эврийн хэмжээтэй холбоотой юу?
4. Хоёроос доошгүй хэлц үгийг сонгон авч, зохиолд ямар үүрэг, зорилготой ашигласныг тайлбарлаж бичээрэй.
 - а. “Ганзага мялаах” -
 - б.
 - в.
5. “...залуу янгир айсан ч үгүй, ичсэн ч үгүй, гэмшсэн ч үгүй...” гэсэн хэсгээр янгирт хандах өгүүлэгчийн ямар үнэлэмж илэрч байна вэ? Энэ хэсэг төгсгөл хэсэгтэй хэрхэн, яаж холбогдож байна вэ?

Орчин, нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг дүгнэе

1. Дараах мэдээллийг уншаад, зохиолч үйл явдлыг яагаад Алтайн хүрэн цохионд хавсаргатай өдөр эхлүүлж байгааг тайлбарлаж ярилцаарай.

Янгир ямаа нь Алтайн өвөр говь болон Хангайн гол нуруу, Хөвсгөлийн зарим уулсын ойн бүсээс дээших асга хадаар нутагладаг. Тэх нь арагшаа махийсан 75-140 сантиметр урт эвэртэй. Янгир хээлээ 6 сар орчим тээж, 5 дугаар сарын дунд үеэр төллөнө. Агнахыг хориглосон дархан цаазтай амьтан.

2. Зохиолч "...наран наашлах тутам хөрвөжин торниж..." гэснээр ямар санааг хэлэхийг хүссэн бэ?
3. Зохиолын үйл явдлын үргэлжилж байгаа цаг хугацааг гүйцээн бичээд, дүртэй холбон дүгнэж, ярилцаарай.




4. Өгүүллэгт гарч байгаа янгирын сүрэг хавцлын нарийн жимээр явж байгаа хэсгийн дүрслэлийг түүж бичээд, ямар үүрэгтэй дүрслэгдсэн, энэ хэсэг байхгүй бол дүрийг тодорхойлж байгаа ямар өгүүлэмж орхигдох байсныг тайлбарлаж бичээрэй.

Эшлэл	Уншигчдад үзүүлэх нөлөөлөл
"Хавцлын ирмэг нарийн жимээр бэдрэв"	

Дүрүүдийн холбоо хамаарлыг тогтоож, дүрийг дүгнэе.

1. Зохиолд аргил тэх, эцэг тэх болон сүүлийн хоёр тэхийн тухай дурдагдаагүй бол ямар ямар чухал өгүүлэмжүүд орхигдохыг жагсаан бичээрэй.
 - а. Ан амьтныг ашиг олохын тулд хэрхэн хөнөөж, устгаж байгааг шүүмжилсэн.
 - б.
 - в.
 - г.
2. Эцэг тэх амьд байсан бол бор шүдлэнгийн аяг ааш өөрчлөгдөх байсан болов уу? Бие гүйцсэн сүргийн манлайг устгах нь сүрэг доторх бусад амьтдын амьдралын хэвшилд нөлөөлөх боломж бий болов уу? Яагаад?
3. Янгир юунаас болж, хэнээс болж эмгэнэлт байдалд оров? Янгирын бодлоор бол эх янгираас болсон уу?
4. Янгирын тухай шүүн хэлэлцээрэй. Бодит амьдралд залуу янгир шиг хүн олон бий юү? Тэдэнд хандаж энэ зохиолоос жишээ татаж юу хэлэх вэ?
5. Залуу янгирын дүрийг бодол санаа, үйлдлээр нь дүгнэж бичээрэй. Жишээ нь:



6. Залуу янгирын дүрийг Б.Явуухулангийн “Тэхийн зогсоол” дуулийн хэсэгт байгаа тэхийн дүртэй харьцуулж ярилцаад, сүргийн тэргүүн ямар байх талаар ярилцаарай.

“...Эхээс төрсөн ууландаа эргэж
Ирдэг юм гэнэ лээ
Эхээс унасан газраа олж
Хэвтдэг юм гэнэ лээ.
Насныхаа эцэст оргил өөд мацаж
Гардаг юм гэнэ лээ
Нартад түүнийг нь
”Тэхийн зогсоол” гэж
Нэрлэдэг юм гэнэ лээ.
Өндөр оргил дээр олон хоног
Зогсдог юм гэнэ лээ
Өнгөрүүлсэн амьдралаа эргэж нэг
Хардаг юм гэнэ лээ.
Умдаалдаг ариухан усаа үзэж нэг
Баярладаг юм гэнэ лээ
Идээлдэг сайхан бэлчээрээ харж нэг
Баясдаг юм гэнэ лээ.
Ижил олон сүргээ эцсийн удаа
Үздэг юм гэнэ лээ
Эх болсон нутгаа сүүлчийн удаа
Хардаг юм гэнэ лээ...”

Б.Явуухулан “Тэхийн зогсоол” дуулиас

7. Хэрвээ залуу тэх амьд байсан бол сүргийн сайн тэргүүн болж чадах болов уу? Яагаад?

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэе

1. Зохиолч янгирыг шүдлэн насандаа эхээ хөнөөж байгаагаар шийдэл хийсэн нь ямар учиртай, үүгээр юу хэлэхийг хүссэнийг тайлбарлаж бичээрэй.

.....

2. Ишгийг дүрслэхдээ “дон тусчээ” гэсэн үгийг яагаад хэрэглэв? Энэ нь уг зохиолын

санааг цааш хэрхэн гүнзгийрүүлж, ямар санаанд чиглүүлж байна вэ?

.....

3. Д.Урианхай зохиолчийн бичсэн өгүүллэгийн талаар дүгнэлтийг уншаад, зохиолын үйл явдлаар батлан тайлбарлаарай.

“... Ж.Лхагва энэ өгүүллэгтээ Алтайн нурууны нэг аргил янгирыг дүрсэлсэн боловч хүн төрөлхтний гол элэглэл-буруугаа дэндүү хожуу ухаардаг аймшигт алдааны тухай жигтэй уран, хураангуй, бараг Манзушир¹ бурхан л өөрөө бичвэл яаж бичихийн үлгэр төгс сайхнаар өгүүлсэн юм...”

Д.Урианхай

4. Та нар энэ өгүүллэгээс өөрт хэрэгтэй ямар санааг олж авснаа жагсаан бичээрэй.

а.

б.

в.

Уран дүрийн үгийн сан, уран дүрслэл (бэлгэдэл)-ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлая

1. Дараах хэсэглэлийг уншаад зохиолч ямар зорилгоор ёгтолсон болохыг хэлэлцээрэй.

“...өвдөх нь өвчин биш, зүгээр л нэг хүлээлт...”

“...аятайхан шаналгаа байлаа”

“...тэх болох гэж байгаагаа там тум гадарлан...”

“...урт сүрлэг эвэртэй болохын дон тусчээ...”

“...ганц хуруу дутах...”

“...яагаад? гэсэн асуултын хариу төөрсөн янзага шиг сүүтийвч бие нь үл баригдана”

2. Зохиолоос төгсгөлийн өгүүлбэрийг дахин уншаад юуг юутай, яаж адилтгасныг хэлэлцээрэй.

БИЧИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолд дүр, дүрслэл нэмэн дэлгэрүүлж бичье.

Уншсан хоёр өгүүллэгийн аль нэгийг сонгож, дүр дүрслэл нэмж бичээрэй. Жишээ нь:

Шуну дайсны хүрээнээс оргож гарахад тусалж байгаа хэд хэдэн дүрийг дэлгэрүүлэн нэмж бичээрэй. Дараах зөвлөгөөг төлөвлөлт хийхдээ ашиглаарай.

- А. *Эхлэл хэсэгт:* Шуну хэн хэнд хандах тухайгаа бодож байгаа эсвэл Шунуг оргуулах аргыг зуут аравтын дарга нар сэдэж дуулгаж байгаа
- Б. *Гол хэсэгт:* Шунуг хэн хэнтэй хамт хэрхэн оргуулж байгаа болон ард үлдсэн хүмүүс ямар холбоос хийх талаар ярилцаж байгаагаар
- В. *Төгсгөл хэсэгт:* Санаанд оромгүй сонин төгсгөл хийх

1. Эрдэм мэдлэг оюун ухааны бурхан

5. ТУУЖ, БЭСРЭГ РОМАН

Уншихын өмнө:

1. Хүүхдүүд ээ, та нар “Хүний сайхан сэтгэл” (1980) кино үзсэн үү? Юу бодогдож байсан бэ?
2. Хүний амьдралд хамгийн чухал зүйл юу юу байдаг вэ? Энэ зохиолд зохиолч юуг дэвшүүлж тавьсан бол? Ухаарч уншъя.



(1933-1997)

Төрсөн он, газар: 1933 онд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд төржээ.

Боловсрол: МУИС (1955), А.М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд курс (1971)

Уран бүтээл: 1950 оноос “Тугтай чарга” шүлгээр уран бүтээлийн гараагаа эхэлсэн. “Газар бид хоёр”, “Тээрэмчин”, “Тээрэмчний охин”, “Үер” зэрэг тууж, “Нандин эрдэнэ”, “Найрын ширээний ууц”, “Нэгэн няравын паян” зэрэг жүжиг, “Балын амт” (1965), “Анчин Дорж” (1968) зэрэг ном хэвлүүлжээ.

Дэмбээгийн Мягмар

ҮЕР (туужаас)

*“...Өвөл, хавар, зун, намар дөрвөн улирал ээлжилж
Уул, ус, нар, сар дөрөвтэй нөхөрлөнө.
Хүн бүр өтгөсийг үдэн нялхасыг угтан
Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө завгүй”*

Д.Нацагдорж

Их мөрний тохойн чийглэг хөрсөнд тэжээгдэн, тэнгэр өөд түмэн мөчрөө сарвайн ургаж, он жилийг элээхдээ амьдралын хатуу зөөлнийг ханатлаа эдэлсэн хөгшин буурал улиас, хэд хоногийн турш догшрон шуугьсан үерийн усанд орвонгоороо булгаран, урсгалын дагуу нам цохиулан унахдаа бас ч ул мөргүй алга болохгүйг мэрийсэн мэт, нүцгэн шар үндсээ үерийн усны эсрэг сарвайлган сэргийлгэсэн нь аймшигт хүчнийг хориглон тогтоох гэж арга буюу алгаа сарвайлган хамгаалсан амьтан шиг ажээ. Тэрхүү үхэтхийн унасан хөгшин моддын үндсийг үерийн ус ууртайяа эрчлэн мөргөж, саргиатуулан улаан хөөсөөр цахран шуугина.

Их мөрний хөвөөнд үнэт эрдэнэ гээчхээд эрж яваа юм шиг урагш хойш тонголзон холхих нэгэн хүний хэлбэр төрхийг алсаас харахад, нар шингэх үеийн модны сүүдэр шиг тахир агаад нэн өндөр. Түүний нүцгэн хөлийн

нарийхан урт шилбэ, голын эргээр загас жараахай шүүрдэн яваа хөх дэглийн мөч чацыг санагдуулна.

Ойртон очвол тэр өвгөний урагш ягжийсан хөх эрүү нь он удаан жил эдлэгдэж, усанд байн байн бамбайтлаа хөөж, наранд яхиршин хатаж, хөв хөх болсон завины эрүүтэй нэн төстэй ажээ.

Шил рүү нь унжсан тав гэзэгний шодон үзүүрийг даруулан сүлжсэн нарийн суран боолт нь гээгдсэн бололтой. Салхинд сэрвэгнэн хийсэх буурал үс нь хавар цагийн өлөн цагаан хагд өвсийг санагдуулна. Тэр өвгөн тайрга тайрга бөгтгөнөн алхалж, амандаа үглэх нь үерийн усны шуугианд өөрт нь ч үл сонсдоно.

Үнээнд долоолгосон тугалын үс шиг, усны долгионд илбүүлэн ханарсан, ногоон зүлгэн дээр бурзайн хоцорсон хөөсийг нүцгэн хөлөөрөө ажиг ч үгүй гишгэлэхэд үерийн усны сэвсгэр хөөс, өвгөний ясархаг тавхайд наалдан замхарна. Тэр өвгөн үерийн усны шаагин шуугихыг тонгойж чагнах бүрдээ:

- “Үгүй ээ мөн, ид иссэн намрын айраг л хөхүүрэндээ саган хөөрч, ингэж шаагьж байдаг сан” гээд нүдээ онийлгон инээмсэглэж, шүлсээ хүд хүд залгив. Тэгснээ уртаар шүүрс алдаад бөгтөр нуруугаа цэхлэн, алцайн зогсож, Сэлэнгэ мөрний тэртээ эрэг рүү саравчлан харлаа. Гүн хадан хавцал бүхий үрчлээ суусан цэнхэр уулсын дээгүүр цухуйж байгаа өглөөний нар улаан хүрээ татаж, нарны хурц туяанд булингартан гүвэлзэх их мөрний ус түүний дээгүүр суунагласан будан манан цөм улайран тунарч, мөрний тэртээх зах нь үл үзэгдэнэ.

Өвгөний нүдний чалх үнэхээр муудсан ажээ. Хүүхэн хараа нь цийдэмтэн цайж, тунгалаг хар өнгөө хэдийн алдсан учир наран сөрөг эгцлэн харж чадахгүй далдирахад хөнхөр ухархайн дээрх өтгөн буурал хөмсөг нь сэрвэлзэн хөдөлнө. Тэгээд хоёр гараа давхарлан саравчлан харах гэж оролдовч хар бор ажилд мойнийж тойнийгоод хоорондоо хэдийнээ эвлэхээ больсон хуруунуудын завсраар нарны туяа сийгэн нүүрэн дээр нь тусахад өөрийн эрхгүй нүдээ аньж,

- Муу алга маань нарны туяа ч хааж чадахгүй шүүрэн шанага шиг сад тавих болоо шив гэж шивэгнээд:

- Тэр лав манай бирвааз мөн дөг өө. Монш чинь ханаад нь гэснээ нар салхинд гандаж, онгосон задгай энгэртэй даалимбан цамцныхаа том том мөнгөн товчийг мултлан хүлхгэр цамцаа тайлж, нямбайлан эвхээд салхинд хийсгэж алдахаас болгоомжлон, довон дээр орхисон хоёр том гутлынхаа хооронд хавчуулан зөрүүлж тавиад босоход түүний янхигар цээжний хавирга сүврэг арьсныхаа цаана зуралзан хөдөлж, бүүр хэнхдэг цээжий нь халхлах юмгүй болоод ч тэр үү, нүд далдирам атлаа нэн сүртэй ажээ. Энэ ханхар цээжийг одоо яг наран сөрөг харуулаад сайтар ажиглавал уушги зүрх нь арьсаа нэвт харагдаж мэдэхээр агаад аягүй бол тэр том цээжинд ганц зүрх... Тэгэхдээ аварга том ганцхан зүрх ч энэ үерийн ус шиг булгилж байгаа юм бил үү, хэн мэдэх билээ. Өвгөний нүцгэн хэнхдэг дээр хэдгэнэ, шумуул улайран суувч тэр дороо нисэн одохыг нь харахад арьсны цаадах ясанд хошуугаа булгалахаас болгоомжилсон болов уу гэлтэй.

Өвгөн хуучирч онгосон хөх даалимбан өмднийхөө түрийг сүүжнийхээ толгойд тултал шууж, усны зах руу ягуухан орж, алдлан зогсоход үерийн ус өвгөний суганы хонхорхой дахь урт шар үсийг сэрвэгнүүлэн, бүх биеийг

нь найгуулан, садран шуугьж байв. Усч өвгөн, хуурай газар хэмжиж байгаа юм шиг усны гүвэлзэн хүрэнхэн толиог алдлан хэмжиж цааш ахихад түүний хоёр далны нь маяа ээлжлэн хонхойж, гуу жалга шиг харагдана.

...Хүн орчлонг хэмжих дуртай. Тэгэхдээ янз бүрээр хэмжинэ. Харин энэ өвгөний хувьд бол алдлан хэмжиж явна. Орчлон ч бас хүнийг хэмжих дуртай. Тэгэхдээ он жилээр хэмждэг нь нэг бодоход болхи бүдүүвтэр хэмжүүр гэлтэй. Орчлон энэ хүнийг жаран таван жилээр хэмжихээд байгааг усч өвгөн ер анзаарахгүй зогсож байгаа нь энэ ээ. Тэгээд:

- Гучин нэгэн алд гэж давтан хэлснээ,

- Дөчин жил усны эрэг сахисан гэхэд даанч дээ. Бас болоогүй байна. Усч хүн гэхэд усаа муу л мэдэж байна даа. Урьд шөнө үерийн усны хүрхрэн шуугих чимээг чагнан, цурам хийлгүй хоносон атлаа хэр зэрэг нэмсний нь ташаарч шүү. Уул нь би гучин алд нэмсэн гэж итгэж байсан юм. Гэтэл гучин нэгэн алд гэж урамгүйхэн үглэсээр усны зах руу эргэн гэлдрэв...

...Усч өвгөн:

- Сэлэнгэ ээж минь ингээд үерлэхээд байхдаа нээрээ сүртэй шүү. Эр чадлаа багтааж ядсан амьтан шиг гээд инээмсэглэснээ тэр дороо хөмсгөө зангидан:

- Ээ хөөрхий, мөн ч олон хоног амьтны хөл хорих нь дээ гэж уртаар санаа алдаад:

- Хүн гэдэг даанч богино настай амьтан юм уу даа гэж бодлоо...

Өвгөн үерийн ус руу ширтэн сууна. Сэлэнгэ мөрний хөлтэй хөлгүй таван татуурга, түүний хоорондох арал нуга, булан тохой усаар нэлийтэл дүүрч, бургасан шугуйн зөвхөн үзүүр л усны толиог шүргэн, их салхинд ханаран бөхөлзөх тариалан шиг усны урсгалд үелзэн тонголзоно. Гүрвэлзэн хүрэнхэн долгион дунд хөвж яваа моддын салаа мөчир сарвалзан эргэлдэх нь:

- Үерийн уснаас авраач гэж ямар нэг амьтан гар сунган даллан дуудах шиг агаад тэгснээ сарайж сэрийсэн салаа мөчир усны долгионд цохигдон далд орох нь тэнхэл тасарсан амьтан живж байх шиг санагдана.

Өвгөн унтарч байгаа тамхиа уртаар сорж, гал улалзуулан:

- Үгүй ээ бас, залуу мод гэдэг мөн ч үндэс бөхтэй юм даа. Тэргүүнээ газар шигдтэл гулзайн нумарсан ч гэсэн үерт ховх явчихгүй тэсээд байна шүү. Тэгэхэд:

- Хөөрхий, энэ хөгшин модод тэргүүнээ даалгүй үндсээрээ сэндийлэгдэн тэр дороо л хажуулдаад өгөх юм. Энэ ч бас орчлонгийн жам аа гэж бодлоо.

...Үерийн усны ширүүн давалгаанд бяцхан завь дээш цогнолзон хөөрснөө, давалгаа өнгөрмөгц доош нам бууж, үелзэн хөвсөөр хоёр дахь татуурга эсэн мэнд гаталж, арал хоорондох намуухан урсгалд орлоо.

- Бие чинь ямар байна? Хүүхээ? гэж асуув.

- Зүгээр гэж жирэмсэн бүсгүй баярласнаа мэдэгдэх гэж өвгөний урдаас арай ядан инээмсэглэхэд, Дэнзэн өвгөн яаралгүйхэн босож, хатгуур модоо аваад завины сүүлэнд алцайн зогсож, бяцхан завиа хатгуурдан хурдлуулсаар явав. Өмнөөс үлээх сэвэлзүүр салхинд өвгөний шодон буурал гээг тугийн хиур шиг намиран хийснэ...

...Сандарч тэвдсэн нөхөр нь:



*“Хүний сайхан сэтгэл” (1980)
киноны Дэнзэн өвгөний дүрд
Ардын Жүжигчин Д. Чимэд-Осор*

- Өвгөн гуай. Одоо горьгүй нь дээ гэтэл жирэмсэн бүсгүй холбирон эргэж, усан дунд бөхийсөн бургасны үзүүрээс шүүрэн, бүх тэнхээгээрээ чангаахад завь тэр дороо хүрд шиг эргэлдэн далбилзан хөвөв. Үерийн усан дээр ув улаан тэргэл сар унаад ирсэн юм шиг тэр бүсгүйн царай зэс шиг улайн минчийсэн харагдав. Өвгөн Дэнзэн завиныхаа тэнцвэрийг алдахгүйг хичээн чамархайныхаа судсыг лугштал, хоёр сэлүүрээ ягштал доош харахад өвгөний гар бадайран чинэрч байв.

- Яаж ийгээд усны цаана л гарчих юмсан. Түргэхэн шиг явбал гайгүй байгаа гэж залуу эр өгүүлэв. Өвгөн Дэнзэн эцсийнхээ тэнхээг шавхан, шүд зуун сэлүүрдэж эхэллээ. Ширүүн урсгалд орлоо. Төдий л холдоогүй байтал:

- За болохоо болилоо. Ус нь гарчихлаа гэж залуу шивэглэв. Бүсгүйн аймшигт дуу үерийн усны шуугианд үл дарагдана. Өвгөн эргэж ч харсангүй. Оволзон хөвж яваа завиа хүчлэн сэлсээр... Нэг харахнаа өрөөсөн халбага нь ээлтрэн цуурсан байв. Өвгөн шорвог амтагдсан хөлсөөрөө уруулаа чийглэн “Сэлүүргүй боллоо ч гэсэн заавал ус гатална. Энэ хоёр хүүхдийг ямар ч байсан усны цаана л гаргахдаа л гаргана. Хоёр ясан сарвуугаараа ч гэсэн сэлж байгаад усны цаана гаргана” гэж амандаа шивэглэв.

Гэтэл өвгөний зүүн гарын шөрмөс татчих нь тэр. Одоо завиныхаа хоёр сэлүүрийг ганц гараараа ээлжлэн татаж, шөрмөс татсан гартаа уурсан, шүдээ хавиран нулимтал хэдий нь ганхаж байсан соёо нь булга үсрэн шүлстэй нь хамт үерийн усанд унав. Өвгөн Дэнзэн өрөөсөн гараараа сэлүүрдэж яваагаа хажуугийнхаа залууд мэдэгдэж, сэтгэлий нь зовоохоос болгоомжлов.

- Хүүхээ. Одоо ч ширүүн урсгалаас гарах дөхлөө дөө гэж хэлтэл ард нь нялх хүүхдийн часхийн орилох дуу өвгөний ясанд янгинатал хадав. Тэр дууг сонсоод өвгөн уртаар амьсгаа аван, суудлаа засаж суухдаа л,

- Би одоо гурван хүний амийг дааж явна шүү. Хүн гэдэг чинь ингэх л гэж... Чухам ингэх л гэж амьд явдаг юм байна гэж бодон сэлүүрдэхэд завь нь улам ч хүнд болчихсон юм шиг санагдав.

- Өвгөн гуай. Хүүхдийн хүй боочихмоор юм байна уу? гэх дуунаар цочин, эргэж харах гэснээ болиод завин доторх юу байдаг цөмийг эргэцүүлэн бодсоноо, дал мөр лүүгээ унжсан шодон буурал гээгнээсээ хуруундаа ороож, гэнэт угзран татсанд өвдсөн ч үгүй зөвхөн л ширхийх чимээ гаран, туг үс өвгөний гарт сулран ирэв. Өвгөн чичирсэн гараа мөрөн дээгүүрээ давуулан сарвайхад түүнийг авах шиг болох нь мэдэгдэв. Залуу эр хүүгийнхээ хүйг боолоо. Боох боохдоо яг номын ёсоор боов. Үнэхээр ч залуу оюутанд өнгөрсөн жил эх барихын хичээлд багшаар заалгасан бүхэн нь тус болов. Одоо энэ залуу эцэг, ганцхан зүйлд тулгамдаж байв. Эх хүү хоёрыг холбож байгаа тэр нарийхан хүйг огтлох юм даанч ухаанд нь орохгүй байлаа. Тэгээд залуу эцэг, шийдмэгээр тэр хүй рүү тонгойв. Дараа нь хүүгээ цамцандаа боов. Одоо эхийн орилох дууны оронд нялх хүүгийн часхийх дуу чихэнд хадсаар...

Өвгөн сая нэг эргэж харлаа. Энэ бяцхан завин дээр яваа гурван том хүний хэний нь ч гэсэн хувцас усанд орсон юм шиг нэвт хөлөрсөн байв. Өвгөн юуны өмнө нөгөө бүсгүйн царай руу харлаа. Зэс шиг улайсан царай нь шингэрэн ягаарсан харагдав. Тэгээд өвгөн,

- Эх нь яаж байна? гэж залуугаас асуухад:

- Зүгээр гэж нөгөө бүсгүй сулхан дуугаар хариулахыг сонсоод:

- Ээ хүү минь, цаана чинь миний дээл бий. Наад бүсгүйдээ давхарлаж нөмрөг гэж хэлээд завь руугаа хартал түүний ёроолд тунасан цусыг үзэж,

- Ээ бурхан минь, Их усанд цус оруулчих вий гэж айх сэтгэл төрөн, завины хөндөл дээр тавьсан цамцаа сэм унагаад, тэдэнд мэдэгдэхгүйгээр арчих гэж оролдтол, өвгөний толгой эргэн, газар дэлхий дайвалзан хөмрөх шиг болоход нүдээ анилаа.

Өвгөн хамгийн сүүлчийн татуургыг гатлан “Ямар ч гэсэн захад нь гарах нь гарлаа” гэж бодоод завиа усны ирмэгт тулган хайрдуулж зогсоогоод,

-За хүүхэд минь, одоо санасан хэрэг бүтлээ. Та нар түр хүлээж бай.

Би тэр дэнж дээрх айлуудаас унаа хөсөг олоод ирье гээд үерийн усыг амар мэнд туулсандаа хүч зориг нэмэгдсэн бололтой, завинаасаа үсрэн бууж амьсгаадан хэд алхсанаа үерийн усанд орвонгоороо булгаран ойчих хөгшин улиас мэт намаг шавар дунд намсхийн унав.

Зуны нар ямар нэгэн юманд хоргодсон шиг аажуухан шингэн шингэснээр... баруун уулын цаад руу тонгойн сүүлчийн туяа замхрахад бараан сүүдэр бууж, Сэлэнгэ мөрний үерийн хүрэн өнгийг тас харлуулав. Их мөрний догшин урсгал ч уртаар санаа алдах мэт намуухнаар гүвэлзэн долгиолж, үүл манан нэгэн их энгүй хөшиг лугаа адил Сэлэнгэ мөрний усыг нөмрөн хучиж, тунарсан үүлнээс хэдэн ширхэг бороо тов тов дуслав. Нялх үрээ элгэндээ тэвэрсэн залуу эцэг хөөрхий өвгөнийг сая харж, хүүгээ тэвэрсэн хэвээр, завинаас үсрэн бууж өвгөний дэргэд харайлган хүрээд босгох гэж өрөөсөн гараараа өргөхөд нялх хүүхдийн час хийх дуу дахин хадав. Орчлон ертөнц түм буман жил эргэлдсэн хуучин замаараа тэнхлэгээ тойрон эргэсээр...

1966 он

Эх сурвалж: Д.Мягмар “Үер” Монголын уран зохиолын дээжис
108 боть (40 дүгээр боть) УБ., 2005

“Үер” туужийг сонсох хувилбар:

1-р хэсэг: <http://mglradio.com/home/audiocontent/128318>

2-р хэсэг: http://mglradio.com/home/index.php?mid=audiocontent&listStyle=list&page=1&document_srl=128323

Үгийн тайлбар:

Бирвааз - Перевоз гэсэн орос үг.

Ханаад - Канат буюу төмөр татлага, төмөр аргамж

Яхиршин хатах - Наранд хөв хөх юм уу үнсэн саарал өнгөтэй болтлоо өгөршин хатсан утга.

Манапаал - Монополь, тухайн үеийн орос архи

Давирхай - Шилмүүст мод ургамлаас гарах наалдамхай эд, нааж тогтооход хэрэглэнэ.

Этэх - Бөөгнөрсөн зүйлийг хамж нэг тийш болгох

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛБЭ.

Зохиолыг мэдэрч ойлгож уншъя.

Зохиолыг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

- Энэ туужийн эхлэл, төгсгөл хэсэгт хөгшин модны тухай дүрсэлжээ. Өвгөний дүртэй холбоотой гэж мэдэрсэн үү?
- Зохиолос ямар дуу чимээ сонсогдож байна вэ? Нэрлээрэй.
- Ямар үг хэллэг, дүрслэл, өгүүлбэрийн утга сэтгэлийг чинь хөдөлгөв?

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэнэ

- Амьдралын мөн чанар, амьдрах утга чанарын тухай ярилцаж, мэтгэлцээн зохионо уу.
- Зохиолын эхэнд Д.Нацагдоржийн шүлгээс эш авсны утга учрыг хэрхэн ойлгож байна вэ?
- Зохиолын төгсгөлд дүрсэлсэн байгалийн зураглал, зохиолын эхэнд дүрсэлсэн байгалийн зураглалыг харьцуулж, үүгээр ямар утга санаа холбон илэрхийлснийг ярилцаарай.
- Д.Мягмарын “Үер” туужийг Эрнест Хемингуэйн “Өвгөн тэнгис хоёр” зохиолтой харьцуулж үзнэ үү.




Дүрүүдийн үг, үйлдлийг харьцуулан зан чанарыг дүгнэнэ.

- Уг туужийг бүрэн эхээр нь дэлгэрүүлэн уншаад, дүрийн зан чанарыг харьцуулан дүгнээрэй.

Дэнзэн өвгөн			Дориг		
Юу бодож байна?	Хэнтэй юу ярилцаж байна?	Юу юу хийж байна? Тоочоорой.	Юу бодож байна?	Хэнтэй юу ярилцаж байна?	Юу юу хийж байна? Тоочоорой.
.....				
Зан чанарыг тодорхойлоорой. Дэнзэн ямар хүн бэ?			Зан чанарыг тодорхойлоорой. Дориг ямар хүн бэ?		
Та нар энэ дүрүүдээс юу суралцав?					
.....					

2. Дэнзэн өвгөний дүрийн сэтгэлзүйг дараах бүдүүвч дээр тулгуурлан нээн ярилцаарай. Бүдүүвчийг өөрчилж болно.



Зохиолын дүрийн холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэе

1. Зохиолын дүрүүдийг нэрлэн, дүр бүрийн хоорондох холбоог зурж, тэмдэглээрэй.
2. Хамгийн их холбоотой дүрүүдийг юугаар, ямар үзэл бодлоор холбогдож байгааг тайлбарлаарай. Хэн нь хэнээсээ учир шалтгааны хувьд шалтгаалж, дүр байдал нь тодорч байна вэ? Хэрвээ ... дүр ингээгүй байсан бол ийм байдалд орохгүй байх байсан гэх мэтээр ярилцана уу.
3. Хүүхэд төрөөгүй мэтээр бичсэн бол зохиолчийн санаа тодрох байсан уу?
4. Гол дүрийн өсөлтийг дүгнээрэй.
5. Өвгөн эмгэн хоёрын харилцаанаас тэдний бие биедээ хандах хайр хүндэтгэл, зан чанарыг зохиолоос эшлэн тодорхойлно уу.

Орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулахад нөлөөлж буйг дүгнэе

1. Үйл явдал хаана өрнөж байна вэ?
2. Яагаад их ус, мөрнийг сонгож, үйл явдлаа өрнүүлсэн бэ? Энэ нь дүрүүдийн зан төрхийг тодруулахад нөлөөлж байна уу?

Хүний төлөө гэсэн сэтгэлтэй Дэнзэн өвгөний зан төрхийг тодруулахад:

- Их үерийг өчүүхэн өвчүүн завиараа Дэнзэн өвгөн туулсны хүч нь юунд байна вэ?
- Хүний амьдрал үргэлжид тэмцэл дунд өрнөдөг гэдгийг харуулахдаа зохиолч нөхцөл байдлыг хэрхэн өөрчилсөн бэ?
- Завины ёроол руу яагаад цамцаа шидсэн бэ? Энэ үед ямар нөхцөл байдлыг зохиолч бүтээв?

Жирэмсэн бүсгүйгээр дамжуулан зохиолын санааг тодруулахын тулд дараах асуултыг хэрэглээрэй.

- Ямар нөхцөл байдал дунд хүүхдээ төрүүлсэн бэ? Яагаад ингэж зохиомжлов?
- Зохиолч яагаад ширүүн урсгалд орох үед “хүүхний ус нь гарсан” гэж бичсэн юм бол? Ширүүн урсгалаар зохиолч юуг хэлэхийг хүссэн бол?

Зохиолын далд утгыг шинжилж, хам сэдвийн хүрээнд хэлэлцэн дүгнэе.

1. Их усны цаана далд утга илэрч байна уу?
2. Зохиолд хүний сайхан сэтгэлийн тухай өгүүлэхээс гадна гүн ухааны хам сэдэв хөндөгдсөн болохыг эргэцүүлнэ үү.

3. Зохиолд байгалийн дүрслэл ямар үүрэгтэй байна вэ? Туужийн агуулга, дүрийг тодруулахад ашигласан байгалийн дүрслэлүүдийг ярилцаарай.
4. Зохиолд төрөх төгсөх, сайн муу, тэмцэл ялалт зэрэг орчлонгийн жам ёсыг багтаасныг хэрхэн ойлгож байна вэ?
5. Багштайгаа хамтран ёр бэлгийн далд утгатай хэсгийг зохиолоос сонгоно уу.

Уран дүрийн үгийн сан, уран дүрслэл (бэлгэдэл)-ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлая

1. Дэнзэн өвгөн юуг шүүрэн шанага шиг сад тавих боллоо гэж хэлдэг вэ?
 - а) Завь
 - б) Мөрний үерлэсэн ус
 - в) Гар
 - г) Хөл хүнд бүсгүйн нулимс
2. Яагаад ингэж дүрслэв? Шүүрэн шанага болон шүүрэн шанага шиг харагдаж байгаа зүйл хоёрын адил төстэй шинжийг задлан шинжилж ярина уу.
3. Моддыг дүрсэлсэн хэсгийг дахин нягтлан уншина уу. Эхлэл хэсэгт хөгшин буурал улиасны тухай бичсэнийг Дэнзэн өвгөний тухай бичсэн гэж дүгнэж болох уу? Үг бүрийн утгыг ухаарч, адил төстэй ямар шинжээр нь адилтгасныг дүгнээрэй.
4. Усны гарам бүр нэртэй, замтай байна. Тэгвэл “Гамингийн эргүүлэг” гэж нэрлэгдсэн нь ямар учиртай вэ?
5. Дэнзэн өвгөний гадаад төрхийг хэрхэн дүрсэлснийг түүж бичээд, түүгээр дамжуулан уншигчдад ямар нөлөө үзүүлж, зохиолч юу хэлэх гэснийг тайлбарлан ярилцаарай.
 - Өвгөний бие, гар, хөлийг ямар үг сонгон дүрслэв?
.....
 - Дотоод сэтгэлийг нь илэрхийлэхдээ ямар үг сонгон дүрслэв?
.....
.....
 - Нүдний чалх, өнгөө алдсан.
.....
.....
 - Далны маяг нь
.....
.....
6. Доорх үгсийн зүйрлэн дүрсэлсэн харгалзах утгыг олж тэмдэглээрэй.

Өвгөний эрүү	Хавар цагийн өлөн цагаан хагд
Буурал үс	Үнэнд долоолгосон тугалын үс
Ногоон зүлэг	Наранд яхиршин хатсан завь

ТУУЖ

Уншихын өмнө:

1. Д.Цэдэв “Улаан хамбан зодогт буюу тавын даваа” туужийг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад хосоороо ярилцаарай. Зохиогчийн талаарх өөрсдийн мэддэг зүйлийг нэмж ярих буюу судалж мэдээд ангийнхандаа танилцуулаарай.



(1939)

Төрсөн он, газар: 1939 онд Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд төржээ.

Уран бүтээлийн төрөл: Яруу найраг, хүүрнэл болон жүжиг, кино зохиол

Боловсрол: 1963 онд МУИС төгсөж, “Монголын нууц товчооны бэлгэдэл зүй” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, эрдэмтэн зохиолч.

Уран бүтээл: 1956 оноос бага сургуулийн сурагч байх үеэсээ шүлэг зохиол бичиж эхэлсэн. Яруу найрагч, үргэлжилсэн үгийн зохиолч, судлаач. 1998 онд Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит шагнал, 2006 онд МЗЭ-ийн шагнал, Соёлын гавьяат зүтгэлтэн цол, 2007 онд С.Буяннэмэхийн нэрэмжит шагнал авчээ. Шүлэг найраг, тууж, өгүүллэг, кино зохиол, судалгааны олон арван бүтээл хэвлүүлжээ.

2. “Хууччуулын өгүүлэхийг сонсвол монгол газар бөхийн удам тасрахын учир үгүй гэлцэнэ” гэсэн туужийн хажлага үгийн шалтгааныг таамаглаж ярилцаарай.
3. Зохиолыг нэрлэхдээ “тавын даваа” гэсэн үгийг яагаад оруулсан юм бол? Бөхийн барилдаанд энэ нь ямар учиртай даваа болохыг ярилцаарай.

Д.Цэдэв

УЛААН ХАМБАН ЗОДОГТ БУЮУ ТАВЫН ДАВАА (туужаас)

Хууччуулын өгүүлэхийг сонсвол монгол газар бөхийн удам тасрахын учир үгүй гэлцэнэ.

1

Улаанбаатараас баруун урагш холгүй орших Буянт-Ухаагийн уужим талбайд өнгө өнгийн асар майхан хаяа хаяагаа дэрлэх шахам ярайжээ. Тэдгээрийн дундуур гоёж гоодсон хүн зон, машин тэрэгтэй хийгээд морьтой, явганаар нааш цааш тасралтгүйеэ сүлжинэ.

Хөлтэй болгон хөдөлсөн эл талбайгаас навч ногооны хурц ааг, айраг сархдын

эсгэлэн үнэр хамар цоргин ханхлах ажээ. Энд ч хүүхэд багачуудын гийнгоо, сурын уухай хадаж, тэнд ч “бөх-чүүл зодоглоод”, “бөх-чүүл зодог-лоод” гэж засуулчид хоолой мэдэн дуудаж сонсогдоно.

... “Төв асар”-ын өмнө, наадмын талбайн хойморт байрлуулсан алтан соёмбот төрийн далбаа өндөр өргөгдөж Ардын хувьсгалын ... жилийн ойн их баяр наадам нээгдсэнийг зарлан цэлмэг хөх тэнгэрт алгуурхнаар намирлаа. “Төв асар”-аас монгол ардын уртын дуу “Түмэн эх”-ийг нарийн цээл хоолойтой дуучин бүсгүй хадааж:

...Эртний ариун буянаа
Элбэгжүүлэн нэмж
Эсэргэн мэндийн бэлгээр
Хуран чуулж
Үүнээс хойшид нь
Зө хө улам улам өрнөхийн

Бэлэг мандах болтугай зэ” хэмээн дуулав. Хурдан морьд уралдааны гараа руу хөдөлж, бөхчүүл барилдааны талбайд гарахад дуулдаг уламжлалтай тул эл дууг жил жилийн долдугаар сарын арван нэгэнд хийдэг монголын үндэсний их баяр наадмын оршил сүлд дуулал гэж нэрлэж ч болмоор.

Энэ дуунд наадамчин олны зүрх сэтгэл догдолж, бөхчүүлийн цог хийморь сэргэн бадардаг билээ. Наадмын талбайн баруун зүүн жигүүрт эрээлэн ханхайж харагдах монгол үндэсний угалз мэтгэсэн асраас зодог шуудагт бөхчүүл хангарди, халих бүргэд, харцага шонхрын дэвэлтээр дэвэн дэвсээр хоёр эгнээлэн зайтайхан зогссон засуулуудын дэргэд ам учраагаа дагуулан гарч ирлээ. Газрын хол, усны уртыг эс хайхран аймаг аймаг, сум сумаас ирж, энэ жилийн наадамд барилдахаар онооны цэцэд нэрээ бичүүлсэн нэгэн мянган хорин дөрвөн бөхийн түрүүч магнай ийнхүү наадамч олонтойгоо нүүр учрав. Зүүн талын магнайд хуучивтар улаан хамбан зодог шуудаг, дөрвөн талт малгай өмсөж, шаа угалзтай монгол гутлаа бат баглаж боосон янхигар хөх өвгөн гарч ирсэн нь наадамчин олны анхаарлыг эрхгүй татав. Хавирга нь завсаргүй, харцага нь үегүй мэт авч нуруу нь ялимгүй бөгтийж, мах мариа нь шуугдсаны учир өмсгөл бүхэн нь түүнд элбэгдсэн мэт халхайна. Түүний онигор нүд, монхор хамар, урт туушин уужим магнай, навчин чих, нарийн бүсэлхий, түхгэр цээж, урт гар, өргөн аарцаг, удам салтаа, том тавхай нь яах аргагүй сайн бөхийн дөрвөн шинж бүрдсэний гэрч ажээ. Гал нь буурсан нүдээрээ асрын алс дээхнүүр тоомсоргүйхэн ширвэн халиах аралтайхан өвгөнийг үзэгч олон, эвэртэй тэмээ үзсэн мэт гайхан шохоорхжээ.

- Энэ чинь хуучин Сайн ноён ханы Насан арслантай гараа дэвээ нь яасан адилхан юм бэ! гэж нүдэндээ итгэж ядсан нэгэн өвгөний өгүүлснийг батлах мэт төдөлгүй радио хоолойгоор “Зүүн талын магнайд Насан арслан...” гэж зарлах нь тэр ээ. Ингэж нэр алдар нь тодрох арслангийн гялалзсан уран шалмаг барилдааныг мэдэх үзэгч, бөхийн хорхойтон шөнийн од шиг олон авч ойрын арав гаруй жил нүд хужирлаагүй нь гарцаагүй үнэн. Насан арслан элэг бүсээ чангалан барууны магнай тийш хараа бэлчээн учраа залууг ажсанаа засуулаа ганхтал хойгуур урдуур нь шаван тэмүүлж, хан сарьдгийн оройгоос өвгөн бүргэд халин дэгдэхийн сүр хүчийг илтгэн зогсоно. Өвгөн бүргэдийн сүр жавхланг улам сэргээн нэмэх мэт:

“Уяхан замбуу тивийн нар аа!
Орчлон хорвоогийн амьтад цугаар
Уулзан золгохыг яарсаар байтал

Огторгуйн үүлний цаадтай
Саатан хоргодохын учир юу вэ!

Та мину зэ..." гэсэн дууны аялгуу "Төв асар"-аас ахин хангинаж эхлүүт засуулууд малгайг нь аван бөхчүүлээ тавилаа. Эл дуу, даваа давааны бөхчүүлийг тавихын дохио болон дуурссаар ирсэн уламжлалтай билээ.

Уртын сайхан дууны уянга эгшиглэнд угтуул бөхчүүл ам учраагаа дагуулан "Төв асар"-ын зүг хурд хуваан гүйв. Тэдний дунд Насан арслан ажиггүй дэвэн дэвсээр "Төв асар"-ын өмнө очиж ёслон, гуяа ор мөр гартал хэд алгадаад эргэлээ. Бөхийн дэвжээний төв дунд өрж зогсоход ам учраа залуу бөх, арслангийн өөдөөс алгаа үрчин ойртов.

Энэ хүүгийн ухас ухасхийх, зоримог шийдмэгийг харсан Насан "Богд хааны долоон хошуу даншиг" хэмээх их наадамд анх зодоглосноо арга буюу нэхэн санахад хүрчээ. Хээр талд сувдан цагаан сүргээ хариулж явтал, байр байдлыг ажиглавал бөхчүүлийнх бололтой нэгэн хөсөг Насан хүүтэй тааралдсан билээ. Ачаа хөсгийг дагаад байхлаар нь:

- Чи хонио орхиод наадамд явах санаатай юм биш биз гэж хэн нэгийг нь алиалахад:

- Очиж үзмээр л байна. Даанч... гэж Насан өгүүлэн шүлсээ залгижээ. Эл үгтэйгээ л хамт залуу хүү зам дээр ганцаар үлдэв. Гэвч түүний сэтгэл, эргэлзэл тээнэгэлзлийнхээ уулзвараас огцомхон мултрав.

Насан хонин сүргээ гэрийнхээ гадаа тоос татуулан хөөж очоод айх, гайхах зэрэгцэн зогссон ээждээ "Би бөхчүүл дагаж наадамд явлаа!" гэж хариу хүлээх байдалгүй угсруулан хэлээд саях хөсгийн хойноос зам хөөж, наадамчдыг даваан дээр гарахын үес гүйцжээ.

- Хүүе! Чи чинь юу болж явна. Буцаач! гэж нэгний өгүүлэхэд хүү толгойгоо маажин газар ширтэн гэлдэрсээр байв. Хөсгөөс зайдуухан яваа нэгэн эр нөхдөдөө хандаж:

- Мулгуу тэнэг юм болов уу. Буцахгүй бол яана даа! Гэр орныхон нь юу гэдэг бол. Эрж хайж, сүйд майд болно доо гэж аяархан хэлэв.

- Харахад ухаан санаа нь эрүүл саруул бололтой юм. Хүүхэд болохоороо бөхийн дон тусаа биз гэж эмээл дээрээ хөндөлдсөн ханхар эрийн өгүүлэхэд:

- Доной гуай! Тийм ч байж болно шүү. Гэсэн ч буцаахаас горьгүй гэж нөгөө эр хэлэв. Тэгээд:

- Уулын сүүдэр хүүшлэхээс өмнө буц! гэж аргадангуй хэлэхэд Насан зориг орсон бололтой:

- Намайг та нар аваад яваач! Би улсын наадамд очиж аманд ч бол гарч үзье гэж шивнэх төдий өгүүллээ. Үүнийг тосон авсан Доной:

- Эр хүний хүсүүштэй л хүслэн! Гэхдээ санаархсан бүхэн ч амд гардаг юм биш шүү. Алив чи хаяж өгөөд эндээс түргэхэн буцаа гэж хөтөчдөө тушаангуй хэлэв.

- За! гэж хэлүүт хөтөч хүү мориноосоо буун харайж ханцуйгаа шамлан өрөн зогсжээ.

Насан, түүнийг барьж авуут ганц хавсран өвдгийг нь шороодуулав.

- Үетэй бяртай хүү байна шүү. За яахав, аваад явъя гэж Доной зөвшөөрөв. Насангийн сэтгэлд наран ургаж, бөхчүүлийн гар хурууны үзүүрт хайлсан тугалга шиг бөмбөрөн гүйх боллоо. Ингэж улсын их наадамд анх очсоноо санаад "Лав л зодог шуудаг нь сэнжлэн бариут атгаад авмаар томдсоныг үзэхэд өөрийн гэх бөхийн бүрэн хэрэглэлтэй болж чадаагүй нь ил. Миний арван долоотой үеийнх шиг

алсын алсаас хөглөж ирсэн ч байж мэднэ дээ” гэж арслан бодов. Өвгөн арсланг амьсгаадуулах гэж залуу хүүгийн тойрч гүйхэд Насан тэвдсэн шинжгүй бат суурьтай зогсоно. Хүүгийн хавсраа мэх өвгөний хөлд гурвантаа хүрсэн боловч төдий л хөдөлгөсөнгүй ээ.

“Би ч гэсэн аманд анх гараад тэр нэгэн лухгар эрийг хийгий нь тааруулалгүй хэчнээн ч хавсарч үзлээ дээ” гэж Насан арслан эргэцүүлэв. “Чамайг онооны цэцэд бичүүлсэн” гэж Доной зааны хэлсэн мөчөөс эхлээд л хавсрах мэхээ угтуул бөхөд хийх гэж Насан яалаа даа. Хөтөч залуутайгаа оройжин барилдаж, “хавсраа” мэхээ хийж түүнийг унагасаар байв. Махбод нь хөөн томорч, бяр амтагдан, онгож хуучирсан хөх даалимбан тэрлэгтээ ч ханхар цээж нь багтаж ядан байх шиг Насанд санагдана. Хэний амд очлоо ч гэсэн түүнийг ганц хавсарч орхимоор бодогдоно. Хэзээ язааны том бөх шиг цээж ханхалзуулан нааш цааш хол хол алхан холхиж ч үзнэ. Оройн бүрийд наадамчид цугларч ирэхийн үес бөхчүүлийн хоол ундыг бэлтгэн суухдаа: “Надтай ганц барилдаж өгөөч гэж гуйвал яах бол” гэж Насан бодно. Гэтэл түүний хүслэнг мэдсэн юм шиг Доной ирж:

- Чи бараг бидэнтэй л ноцолдмоор байгаа биз. Гайгүй ээ, гайгүй. Маргааш барилдана байх. Хэнээс ч болов айж сүрдэж болохгүй шүү. Шийдсэн мэхээ хийгээд л алдах онохоо үзэх хэрэгтэй. Аваргыг хаяж аварга болно гэсэн үг байдаг юм гэж зоригжуулав.

Маргаашийн бага үдийн алдад Насан ч хөтөч хүүгийн зодог хэрэгслийг өмсөв. Зохиж таарч байна гэдэг өөрт нь захиж хийсэн юм шиг. Хүн болж төрсний хэрэг бүтэж байгаа мэт бодогдоно. Улам ч эр бяр нэмэх шиг. Гар хөлөө хөдөлгөвөл зодог шуудаг нь бариу ч юм шиг.

Өндөр нуруутай, ханхар бөхийн аманд оногдож, өрж зогсуутаа л Насан угсруулан дайрч, хавсраа мэхээ хийв. Тэр бөх хүний урманд ядаж ганц удаа ч дайвсангүй. Нэгэнтээ ширүүлэн хөдлөхөд гурван хурууны өндөг түүний гуянд хүрэв үү, үгүй юу л үнэгний сүүлэнд хууртсан адил Насан холоос хол годройтов. Атан тэмээнд тийрүүлсэн мэт санагджээ.

- Хүү минь нас бага, цус шингэн байна, хаясантай л адил гэж бод хэмээн засуул, Насангийн сэтгэлийг заслаа. Энэ үгийг цуутай бөхөд зоригтой мэх хийгээд унасан үед засуул хүн хэлдэг билээ. Элэг бүсээ тайлчхаад баруун талын асрын зүг гүйн явахад нь тааралдсан нэгэн бөх:

- Хүү, хэнтэй барилдав? гэхэд:

- Чойжоо гэсэн байх аа? гэж хариулав. Тэр бөх:

- Босоо Чойжоод уу? Хэцүүхэн ч эртэй учирч дээ гэв. Улс даяар “Босоо” гэж алдаршсан суут бөхийн хоч чимгийг барилдахын өмнө дуулаагүй нь яамай. Сонссон бол би лав ганц ч мэх тэр заанд хийж чадахгүй байсан биз гэж Насан сэтгэл дэнслэн боджээ. Үүнийг эргэцүүлэн санаад Насан “Энэ хүү ч мэх хийхийн л цул зориг яваа! Гэвч уявал энэ удаа над шиг өвгөнд бас ч осолтой байж мэднэ” гэж бодсоноо ухасхийн хүүгийн зодгоос сэнжлэн барив. Арслангийн хэд хэд хүчтэй халахад учраа хөвгүүн барьцаа алдан газар онож гишгэхгүй болов. Ахин хүчлэн дугтраад түлхэхэд хүү бөгсөөрөө газарт тоос манартал лагхийтэл суучхав. Чингэснээр ч Босоо Чойжоод Насангийн унасны үлгэр энэ удаа давтагдах мэт болжээ.

2

- Аав аа! Та үлгэрээ үргэлжлүүлэн яриач гэж хүүгийн гуйхад эцэг нь зөвшөөрч, ийн өгүүлэв:

“...Нусгай бор хүү далан мөрөн гаталж, далан уул давж яваад Мангасын Тэвхэн хар гэгч бөхтэй таарч, хүч мэхээ сорин барилдах болж гэнэ. Хоёулаа тасын дэвэлтээр дэвж, хандгайн нүдээр хялайлцан, харцагын шүүрэлтээр шүүрэн барилцаж усгүй цөлөөс рашаан ундартал, устай газраас элсэн хайр оглортол ноцолджээ. Тэвхэн хар бөхийн далан дээрээс нь барьж далан гурав, гуян дээрээс нь шүүрч гучин гурав эргүүлэн ар нуруугаар нь агдлан тавьж, Нусгай бор хүү дийлэв гэнээ!”

Насан хүү зантгар толгойгоо гилжийлгэн амаа ангайж, аавынхаа яриаг чих тавин чагнаж сууснаа гүн шүүрс алдаж:

- Аав аа! Үлгэрийн баатар Нусгай бор хүү шиг тэнхээтэй бөх хэр олон байсан юм бэ? гэж лавлав.

- Хүү минь! Байлгүй яахав. Саяхан нэгэн зуун тавь жараад жилийн цаадтай 1821 оны үес Дорнодын талд нар, салхи амсан байж, чийрэг боргил өссөн Хүдэр гэдэг хүү айл айлд ачаа тээшний хүндийг өргөн зарцлагдаж явсан юм гэнэ билээ. Түүнийг баян айл илүү гэртээ унтуулахад ханын үдээс нь тас тас үсэрдэг байж гэнэ. Дахин үдэж өгөөд гэрийн эзэн өглөө эртлэн босож ажиглахад Хүдэр хүү сэрүүтээ гараа алдлах суниалтаар ханын үдээс нь ахин шад шадхийн тасарчээ. Түүнээс хойш од харан хонож, орчлон дэрлэн унтагч болсон Хүдэр шүүдрийн ус дэгдэж дуусаагүй байхад шар хөллөн аргал түлшинд ганцаар явдаг болжээ. Гэтэл шарын хөлс цувж, туйлгүй их ядарч ирэх болсныг гэрийн эзэн бас анзаарчээ. Хүдэр аргал түлээгээ түүж дуусаад шараа тэрэгнээс мултлан унагаж босгон цээжийг нь газраас хийлэн өргөж ноцолдсоор усан хулгана болтол хөлөргөдгийг мэдсэн гэрийн эзэн аргалах аргагүй болж «Долоон хошуу даншигт барилд» гэж ятган түүнийг алс явуулах мэргэн ухаан сийлжээ. Хамт яваа нутгийн бөхчүүл айл хэсэж айрагдан Хэрлэнгийн усанд биеэ булхан зам гудас олон хоног саатах тул Хүдэр тэднээс тасарч ганцаар яаран оджээ.

Хэнтийн их хөвч дундуур нэвт гарсан замаар үдшийн бүрэнхийгээр шогшуулж явтал унасан морь нь гэнэт хамраа тачигнуулан үргэжээ. Ажиглавал модон дундаас том хар юм сэрсхийн гарч иржээ. Шуудхан халз дайрч ирэхлээр нь Хүдэр мориноосоо үсрэн бууж хоёр гараараа түүнийг чихдэж аваад доош хүчлэн дарж толгойгоор нь газар мөргүүлжээ. Муухай чарлах тэр амьтныг дар дарсаар боловч Хүдэр арга буюу босгочхов. Босуут савраараа Хүдрийн зүүн мөрийг буулгаж цус нөж цувуулжээ. Хүдэр түүнийг ахин овоодон авч хар хоншоороор нь газар мөргүүлэв. Ингэж Хүдэр, нутаг усныхны зүрхэнд орсон хорхойтсон баавгайтай ана мана, ач тач үзэлцсээр одод шуулгажээ, Нэг мэдэхнээ нь хөвчийн тэр хүчит зэрлэг араатан хөл дээрээ босолтгүй болж хэдийнээ амьсгал хураасан байлаа.

Хүдэр зам даган алхсаар хөвч уулын бэлийн нэгэн айлд очиж удаан хоног асруулан тэнхэрсэн боловч тэр жилийн наадамд барилдаж чадсангүй. Хойтон жилээс нь эхлэн зодоглож Долоон хошуу даншиг, Богд хан, Хан Хэнтий хоёр уулыг тахиж хийдэг арван засгийн наадамд олон удаа үзүүр, түрүү авч явсан юм гэнэ билээ. Төр гэрэлтийн хорин нэгдүгээр оны даншигт түрүү аваад буцаж явах замдаа хэдэн бөхчүүл хүчээ сориход Хүдэр үхрийн чинээ хар чулууг өргөн ургаа хадан дээр тавьжээ. Хожим хэн нь ч хөдөлгөж чадаагүй учир «Үүнийг Санбэйсийн хошууны Хүдэр даян аварга өргөж тавьсныг хойчийн хүмүүс мэдтүгэй» гэсэн бичгийг хэн нэгэн чулуучнаар сийлүүлсэн гэдэг юм.

Хүдэр даян аваргыг бие барсны хойно зодог шуудгийг нь манай нутгийн нэгэн сайн эр сэм хулгайлан авчирснаар Сайн ноён хан аймаг бөхтэй болсон гэлцдэг юм даа хүү минь!. Хүдэр даян аваргын хүнд алхаа Насангийн чихэнд сонсдох шиг,

түүний баавгайн савар шиг бахим гар нүдэнд нь харагдах шиг болов.

- За үг олдож, үхэр холдох нь байна. Өглөө эрт босож унага барина шүү, хүү минь гэж аавынхаа хэлэхэд:

- За, за! гэж дуугарсан ч Насангийн бодол санаа нь огт өөр зүйлд хулжсан байлаа. Тооноор од анивчихыг ажиглан хэвтэхэд Насангийн нүдэнд Хүдэр даян аварга ер харагдаад болохгүй байв.

«...Хүдэр даян аварга ярьж байна, сонсогтун!» гэж баргил бүдүүн хоолойгоор хэлэхийг хад асга хэдэнтээ цуурайтуулан давтав. Монголын алдар цуут Намжилжав аварга, Баянмөнх аварга нарыг залгах хувьтай төрсөн шөрмөстэй хүү байвал гараад ир ээ! гэж хүнгэнэхэд нь Насан урагш алхав.

- Аль нутаг хошууны хэн гэгч вэ? гэж, лавлахад:

- Сайн ноён хан аймгийн Насан! гэж хариу өчив.

- Насаан! Мөнх тэнгэр, алтан нар, хөрст дэлхийдээ өчил үг айлтгаж, хүч шөрмөсөө сэлбэж ав! гэж Хүдэр даян аварга дахин хүнгэнээд алслан алга болов. Насан, Хангай ханы орой дээр нисэх мэт дүүлэн гарч:

- Хөх тэнгэр минь ээ! Нарийн хураараа угаан, үүрдийн тэнхэл хайрла гэж гараа сунган өндөр дуугаар өчихөд огторгуйн үүлнээс намираа бороо шаагин асгарав.

- Алтан нар аа! Шижир цацралаараа гийгүүлэн мөнхийн тэнхэл соёрх! гэж Насанг гар сунгахад тэнгэр цэлмэж наран илч гэрлээрээ тэтгэв.

- Эх газар минь ээ! Буман үндсийн үржилтэй алтан хөрсөөрөө эгэл биед минь эсэн энхийн тэнхэл ивээ! гэж Хангай хандаа өгүүлэхэд Насанг цэцгийн үнэрт анхилуун салхиараа таалав. Насангийн биед хурж цогцолсон тамир тэнхэл нь багтаж ядан байх мэт. Баруун гартаа Баян хайрханыг, зүүн гартаа Зүрх хайрханыг барин дэвж гарлаа...

- Зөв, зөв! Чи алтан нарыг атгаж, хөх тэнгэрийг мөрлөж, хөрст газрыг хөлөөрөө тулсан болохоор хэнд ч, хэзээ ч дийлдэх учиргүй. Миний санаа амарлаа хүү минь! гэж Хүдэр даян аварга хүнгэнэв...

Хүү минь, босооч! Унага уях гээд аав чинь зэлэн дээрээс дуудаж байна гэж эхийнхээ хэлэхэд Насан зүүдэндээ харамсан, нүдээ нухлан өндийв...

5

- Дөрөв давсан бөхчүүл ирж амаа аваарай! гэж радио хоолойгоор хэдэнтээ давтан зарлах нь Буянт-Ухаа даяар цуурайтав. Эл зарыг сонссон угтуул бөхчүүл онооны цэцийн зүг хэд хэдээрээ хөшилдөн алхална. Хэн хэнийг амлах нь наадамчдын сонирхлыг хамгийн их татдаг билээ. Арга ч үгүй биз ээ. Тав давсан бөхчүүл шинэ цол чимэг нэмнэ. Тиймээс дөрөв давсан бөхийн хэний боловч зүрх түгшин цохилно. Ялангуяа алдар цолгүй бөхчүүл «хэний амд оногдоо бол» гэж түгшин, чих тавин чагнадаг үе мөнөөс мөн. Нас сүүдэр өндөр зарим угтуул, өсөх идэр залуусыг амлан авч сайн бөх болох аяны алтан шар замыг ерөөдөг юм. Улаан хамбан зодгоо бүсэлсэн Насан онооны цэц рүү халбалзтал алхан очиж давсан бөхчүүлийн цэс ч харсангүй.

- Өвөрхангай аймгийн арслан Цоодолыг над дээр тавьчих! гэж шуудхан л хэлээд эргэжээ. Энэ үгийг сонссон хүн зоны дунд хоёр таавар дэгдэв.

- Аргагүй ээ, аргагүй! Нутгийнхаа хүүг Улсын начин болгохоос өөр яахав гэж нэг хэсгийн ярихад:

- Арслан гуай энэ жилийн наадамд Цоодолтой л барилдах гэж зорьж ирсэн юм гэнэ лээ. Ёстой сонин барилдаан болно доо гэж зарим нь өгүүлэв. Үүний хоёр дахь

таавар чухамхүү оносон ажээ.

Ноднин зун Өвөрхангай аймгийн наадамд Цоодол гэгч бие хараа сайтай залуу үзүүрт гарч иржээ. Тэр шороо атган, өрсөлдөгч, бөхийнхөө нүүр нүд өөд цацлан гүйн орж өргөж хаяхдаа хавирган дээр нь албаар гайхуулан өвдөглөж хүнд гэмтээн, босохдоо толгой дээгүүр нь харайн гарч бөх хүнд нийцэмгүй авир гаргажээ. Түүнийг үзэж суусан Насан тэсэж чадалгүй очиж:

- Дүү минь нар эрт, нас залуу байна. Энэ эвгүй зангаа тат! Сарсуу зан сайн бөхөд тушаа гэж мэд! гэжээ.

- Би сарсуудаа яагаав. Танаар заалгахгүй ээ. Таны бөх явсны сургийг сонссоноос биш зодоглосныг чинь хараагүй юм байна. Ам бардам гуя шалдан болсон зөнөг юмнууд урьд балрын гавьяагаараа гайхуулцгаадаг юм. Ханатал сонслоо, үзлээ! Наад үгээ надад хэлснээс хаданд очоод хашгир! гэж Цоодол биедээ хэр халдахгүй байв. Энэ үгэнд арслан, яс махнаасаа гомдож:

- Ингэж цээж өргөж байж нутаг усны нэрийг гаргахгүй. Барилдаж явсныхаа үнэн худлыг чамд мэдрээх нас тэнхэл хоёр даанч үлдсэнгүй дээ. Хойтон улсын наадамд барилдахыг чинь үзэх ганц жил надад хоцроогүй байгаа даа гэж гомдолтойхон хэлээд Насан, Цоодолын дэргэдээс нүүр хийх газаргүй болж шалавхан холджээ. Аймгийн наадмаас их л гутарч цөхөрсөн байдалтай уруу царайлан ирсэн арсланг үзээд гэрийнхэн нь ихэд гайхаж:

- Бие чинь зүгээр биз? хэмээн асуухад:

- Зүв зүгээр гэж өвгөн хариулжээ. «Би хорвоо дээр тоос хөдөлгөж явна гэдгээ үнэмшүүлэх л хэрэгтэй» гэж амандаа цаг ямагт бувтнана. «Хэн нэгэнтэй түр тархийж дээ» гэж гэрийнхэн нь гадарласан авч түүнээс онцолж лавласангүй. Насан гэртээ хэд хоноод сумын төв орж ирэхдээ:

- Энэ жил жинд явахаар хэлцлээ. Одооноос зэхнэ гэж хэлжээ. Уг нь Насан жил алгасалгүй жин тээж аяны урт замд гардаг байснаа сүүлийн таван жил гэрээс холдож, гэдэс дундлаагүй билээ.

- Аав аа! Та юу болоов. Хөхөө өвлийн хүйтэн, хөр цасны арвинд даарч хөрнө шүү дээ. Яах гэсэн юм бэ! гэж хүүгийнхээ учирлахад:

- Жин тээгээд хөлдсөн хүнийг өдий хэр наслахдаа би дуулаагүй л юм байна. Энэ чинь улсын ажил биш гэж үү! гэж амы нь таглажээ.

- Танаар жин тээлгэлгүй бид халуун амиа бөөцийлөхтэй байна. Яах гэсэн юм бэ! гэж охиныхоо өгүүлэхэд:

- Аян жин хийнэ гэдэг чинь мөнгө олж, баяжихын нэр юмуу. Мөн ч нялхаараа байна даа, та нар! гэж сургамжилжээ. Тэгээд тэр намраа жингийн даамлаар алсыг зорин хөдөлжээ. Малгайн үс сэргээгээд ирэхлээрээ эр хүний хийморь сэргэдэг гэдэг үнэн юм. Насан жинд яваа нутгийн залуусын хэнээс нь ч хуруу дутахгүй ачаа тээшийг бярдан ачиж буулгана. Алхаа гишгээ нь хөнгөрч, яриа хөөрөө орж:

- Хүүхдүүд минь! Аян жин гэдэг чинь ёстой л эр хүний хийгүүштэй сайхан ажил юм хуна. Намайг бараг насаараа энэ замд явсан гэхэд худал гэх хүн гарахгүй биз. Ноцолдож явсан маань ч үүнтэй холбоотой байж мэднэ гэж хуучилна...

...Тэгээд улсын баяр наадам эхлэхээс сарын өмнө хуучирч онгосон зодог шуудгаа авдраасаа авч адислан, майхан, тээшээ моринд ачаад хөдлөв. Ингэж л Насан энэ жилийн наадамд ирсэн бүлгээ.

Ам учраагаа аваад Насан майхандаа ганцаар бодолд автаж «Хорвоод тоос хөдөлгөн яваагаа үзүүлэх л ёстой» гэж шивнэн сууна...

- Арслан минь! Тавын даваа эхлэх ойртож байна шүү гэж засуулын гүйн ирж

хэлэхэд Насан зодгоо авч яаран босов. Энэ үес Цоодол майхандаа тарган мах алаглуулан огтолж, үслэг гүрээгээ гүвс гүрсхийтэл айраг хол хол залгилж суужээ.

- Нутгийн ахын аманд очиж дээ Цоодол арслан минь! Насан арслан чамайг амласан дуулдана гэж нэгэн бөх ирж дуулгав. Цоодолын гэрэлтэн байсан царай хувьсхийн улайж, уурлаж улайрсан бухын нүдээр харц нь хувирав. Тэгснээ цээжээ ханхалзуулан:

- Бөх явснаа надад ноднин үзүүлнэ гэж гайхуулсан юм, аргагүй дээ, зөөлхөн боорцог! Ийм боорцог ч ахиад надад таарахгүй шүү. Хэм суусан яс нь үйрчихгүй бол... Муу дүү нь нэгийг үзүүлээд өгнөө, гайгүй хараарай! гэж өгүүлснээ бөхийн асар тийш зодоглохоор алхжээ...

- Баруун талын засуулчид сонс оо! Бөхөө амлая! гэж зүүн талын магнайд байгаа Насан арслангийн засуулч өндөр дуугаар аялгуулан дуудав. Үүний сацуу баруун талын засуулчид:

- За! гэж нэг зэрэг өндөр дуугаар хариулав.

- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүхт... жилийн ойн их баяр наадамд барилдах саруул шаламгай, тун ч гарамгай үнэн хүчит, үлэмж баясгалант, өнөд цог нэмэх, лут бэх, маш гайхамшигт, бат ерөөлт, өлзийт дуурсах, онц түрэмгий, хичээнгүй нягт, хэтэрхий зоригт, улам өрнөх арслан Насаан! Өвөрхангай аймгийн харьяат арслан Цоодолыг амлан авч олны өмнө барин авч уран мэхийг уралдуулан хийж хүчийг үзэн барилдъя гэв ээ гэж засуулчийн цоллоход баруун талын засуулчид «Баярлав аа» гэж хэлэв. Насан ч засуулаа хагас тойрч дэвж дэвэн тэлүүлж байв. Энэчлэн баруун талын магнай бөхийн цолыг бас дуудлаа.

Мянга гаруй бөхөөс шалгарч үлдсэн хүчтэний хэн хэнтэй учраа таарсныг нүд салгалгүй, ам булаалдан ярьж маргаж ширтсэн наадамчид ч «Төв асар»-аас «Уяхан замбуутивийн наран» гэсэн сэтгэл сэргээм аялгуу хангинахын сацуу алга нижигнүүлэв. Өөдөөс нь хоёр гараа ээлжлэн самарч тойрон байгаа Цоодолын бие, Насанд нэг л хөнгөн санагдаж байв. Гэтэл яг тулаад зодгоос нь бариад халж эхлэхэд Цоодол бас ч дороо суурьтай, дотроо ухаантай нь илхэн, «Салтаа нь их зайтай харагдах нь алаг нүдний эндүү биз. Зүүн сүвэгчээр ч багтаад гүйчих залуу цаг биш шүү дээ. Гүйнгүүт зайлаад орхивол би яах вэ! «Нүд хурц, хөл чанга залуугийн өмнө тоосон дунд харуулдахаас өөр замгүй. Тиймд миний хийх мэх энэ биш» гэж Насан бодно. «Лавлан барилцаж авах уу. Шуудагт нь хоёр гар хүрч барьц ханавал өөр хэрэг. Үүнээс өрсөн надад мэх хийвэл би сөхөрчхөж магадгүй. Тэгэхлээр лавцаж болохгүй»

Цоодол, зодгоос нь сэнжлэн барьж хэд халснаа арслангийн зүүн суган доогуур нь толгой гар хоёроо хийв. Барагтай л бол тас гэдрэгээ харж эргэлдэн унагадаг «Сээрэн дунгуй» хийх гэж байгааг Насан мэдэж толгой, гар хоёрыг нь хоромхноо хорьж хаав.

- Өвгөн арслан мөн ч егзэр барилдаж байна шүү. Цоодолын сээрэн дунгуйд орсон бол ч өнгөрлөө шүү гэж наадамчдын дунд яриа дэгдэв. Бүхний хараа улсын арслан, аймгийн арслан хоёрт тунажээ.

- Цоодолд буухгүй нь дээ хашир эр! Цоодол ч улсын начинг гуйж олохгүй гуядаж авах эр дээ гэж зарим нь мэдэмхийрэхэд:

- Өтөлснөөс өөр өө байх биш! Арслан ч үзэж тардаг нь зөв өө гэж зарим нь Насанг өмөөрнө.

Үзэгчид хоёр талцаж сэтгэлээрээ наадмын талбайд барилдах ажээ. Цоодол уран хурц мэхээ хорионд орсныг мэдэж түүнээ өөрчлөв. Тэр цэрвүүнхэн барьж аваад

арсланг тонгоров. Насанг дэмжигчид түүний хамт хазайж ирлээ. «Тонгоролтыг хариулахад биеэ сулхан байлгавал сайн» гэж өвгөн арслан бодуутаа хөвчилж чангалсан булчин шөрмөсөө султгав. Цоодол ахин тонгоруут Насангийн зүүн хөлд дотуур дэгээ ороов. «Энэ дархан ташаа талын хөлд мөн ч олон аавын хүү дэгээ ороосон доо. Уул нь дэнж тэвсэг нь булгичихгүй бол тэсэж өнгөрөөдөг сөн» гэж санаснаа дэгээдүүлсэн хөлөө атирснаа гэнэт хүчлэн тийрэв. Цоодолын дэгээ аргагүй мултарлаа. Насан амьсгаадах нь тун бага. Өвгөний амьсгаа үнэхээр задарсан байлаа. Харин Цоодол хэд хэдэн мэх хийсэндээ ч тэр үү амьсгаагаа дарж ядна.

- За удаж, биедээ их дасгаж болохгүй шүү. Одоо сэрмүүн барилдаж өрсөн мэх хийх зөв гэж засуулын хэлүүт Насан элэг бүснээс нь барьж аваад эргүүлэх гэтэл гурамсалж сүлжсэн мяндас тас үсрэв.

- Шив шинээрээ тас үсэрдэг байна шүү, Еэ өгөр! гэж Цоодол үглэх зуур элэг бүсээ ахиулан зангидаж залгав. «Сая би буруу мэх хийх шахлаа шүү. Элэг бүс тасраагүй бол дүүгүүрдэлт дундаа муу хөл минь сөхрөх байсан даг аа. Хүн ер нь хэзээ ухаан орж дуусдаг байна» гэж бодсоноо:

- Гарын хүч ч байна бололтой. Одоо л хийдэг хэрэг гэж арслан сэтгэлдээ шивнэв. Цоодолын зодгийн мөрнөөс сэнжлэн хэдэнтээ хүчлэн халснаа Насан тавилаа. Чингэснээ зүүн гараараа Цоодолын эгэм алгадан гэдрэг түлхэж баруун хөлийг нь шүүрэн авав. Наадмын талбай даяар «Уухай, уухай!». «Хөлөө тавьж болохгүй шүү». Өвгөн минь гүйцээж хийнээ» гэх үг шуугиан наадмын талбай түмний уухайд дээш өргөгдөх шиг болов.

- Хөл өргөөд удаж болохгүй шүү! гэж өөртөө шивнэснээ зүүн хөл дээр нь баруун хөлөөрөө хавсран цохингуут түүнийг зүүн гараараа хамав. Ингэж олон мэх угсруулан хийх талаараа онцгой явсан учир «Сүлжээ Насан» гэсэн нэрийг цөөнгүй дуулж ирсэн билээ. Цоодол ч аргагүй тоосон дунд дэмжигчдийнхээ хамт тэнгэр харлаа. Насан түүнийг ямар ч будлиан булхайгүй орхилоо... Дуу уухай... Алга ташилт... Радио хоолойгоор нэвтрүүлэгчийн ярих... Чухам юу ч дуулдахгүй болов. Арсланг тэвхийтэл үсэрч тоосноос холдож зогсоход засуул нь гүйн очиж малгайг нь өмсгөв. Насан арслан «Төв асрын» зүг алгуурхан дэвэв. Энэ хүний ханхар цээжинд юу эс багтав! Бөх хүн нэгийг унагах агшиндаа дараагийн давааны амыг боддог гэлцдэг. Үнэхээр ч Насан арслангийн цээжинд «зургаагийн даваанд тун ч бузгай барилдсан Булган аймгийн Түвдэндорж гэдэг хүүг амлая. Зэгсэн бөх болох хүү шиг харагдана билээ. Түүгээр зодог тайламз. Эр хүн зорьсондоо хүрэхээс сайхан юм хаа байхав. Хорвоод тоос хөдөлгөж яваагаа Цоодолд ч, бөхчүүлдээ ч, наадамчдадаа үзүүллээ» гэсэн бодол зүрхэн цохилттой зэрэгцэнэ. Зориг хүсэл, итгэл тэмүүллийн далбаа нь огтхон ч гудайгаагүй, далан насныхаа давааг давж яваа өвгөн бүргэд Насан арслан олон онд барилдаж, газар газрын хүчтэнийг орхиж омог хав, жаргал баяслаан хувааж, идээний дээжийг ивгээлт тэнгэрт нь өргөн явсан их наадмынхаа талбай дундуур шижир алтан соёмбо гэрэлтсэн төр улсынхаа далбааг нүд цавчилгүй ширтэж хүчит хоёр гар даль жигүүрээ дэлэн дэлсээр л байж билээ.

Хужирт 1976

Д.Цэдэв “Тавын даваа” УБ., 1983, тал 154-176

Соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээн авъя

1. Монгол бөхийн мэхийг дан мэх, давхар мэх, угсраа мэх, хариулт мэх гэж ангилсан байдгаас зохиолд ямар мэхийг хэн хэдийд ямар зорилгоор ашиглаж байна вэ? Үүгээр тухайн дүрийн ямар шинжийг илүү тодотгохыг зорьж байгааг ярилцаарай.
2. Монгол бөхийн цол нь ойролцоогоор 1600-гаад жилийн түүхтэй гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Зохиолд ямар ямар цолтой бөхчүүдийн тухай өгүүлж байна вэ? Учир нь юу вэ?
3. Монгол бөхийн цолны чимэг нь XVIII зууны үед үүссэн гэж үздэг. Зохиолд цолны чимгийг хэдийд ямар зорилгоор ашигласныг ярилцаарай
4. Бөхийн өмсгөлийг хэрхэн хийдэг, ямар бэлгэдэл шингээдэг байсныг зохиолыг бүрэн эхээр нь Д.Цэдэв “Тавын даваа” УБ.,1983 номын 165-166 дугаар тал буюу зохиолын 4 дүгээр хэсгээс уншиж мэдээрэй.

Өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлая

Зохиолд үйл явдлын өнгөрснийг дурссан хэсгүүдийг олоод, хүснэгтийн дагуу ажиллаж гүйцээгээрэй.

№	Зохиолын өнгөрснийг дурсахад хүрсэн шалтгаан	Үйл явдлын аль хэсгийг нэмэн дэлгэрүүлсэн	Ямар санааг гаргасан	Өгүүлэгдэхүүний аль хэсэг
1	Насан аваргатай барилдах залуу хүүгийн зоримог шийдэмгий нь	Насан аваргын “Богд хааны долоон хошуу даншиг” наадамд анх зодоглосныг...	Анх бөхчүүдтэй учирч, бөх болох зам нь эхэлсэн	Зохиолын эхлэл хэсэг нь зохиолын дунд орж өнгөрснийг дурссанаар...
2	Залуу бөхийн хавсраа мэх			

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэе

1. Зохиолын утга санааг “...улсын баяр наадамд даваа бүртээ өмнөх үеийн барилдааныг дурсан санаж улмаар тав давж, ивгээлт тэнгэрт идээний дээж өргөн, алтан соёмбот тугаа тойрон дэвж байгаа ханхир өвгөний дүрийг бүтээхдээ насан өндөр болсон боловч эр хүний хийморийн далбаа гудайдаггүй гэсэн санааг илэрхийлсэн юм” гэж зохиолч Д.Цэдэв (“Зууны мэдээ” сонины “Хүн судар” булан 2017.10.16)өөрөө дүгнэж хэлсэн байдаг. Үүнийг зохиолын хэсгүүдээр баталж дүгнээрэй.
2. “Д.Цэдэвийн эл туужийг, ер нь хүний ёс мөсийг гол сэдэв болгож, монгол ахуй сэтгэлгээний өвөрмөц сонин хөрсөн дээр идээшүүлэн суулгаж үзүүлсэн. Насан арслангийн хувьд далан насандаа зодоглох болсон нь аваагүйгээ авах гэж бус, харин хүн олондоо, хойч үедээ хэлээгүйгээ хэлэх гэж “зодоглосон” хэрэг мөн. Тиймийн учир биеийн хүчийг үзэж, бөхтэй барилдахаасаа илүүтэй, санааны хүчийг үзэж, “хорвоотой барилдсан” барилдаан гэж харагдахаар болсон байна...” гэж доктор Л.Хүрэлбаатар (“Дуун утгын яруу зохист” УБ.,2005, 454 дүгээр тал) дүгнэснийг зохиолын үйл явдлаар баталж тайлбарлаарай.

БЭСРЭГ РОМАН

Уншихын өмнө:

1. Адал явдалт зохиол гэж ямар зохиолыг хэлдэг вэ? Энэ төрлийн ямар зохиолууд уншсанаа санаарай.
2. “Алтайд” гэж нэрлэсэн энэ зохиолд юуны тухай өгүүлдэг хэмээн төсөөлөн бодож байна вэ?

... “Геологич бол өндөр уул, өргөн говийг гаталж машинтай, морьтой, явган явж зарим газар мөлхөж яваад газрын хөрсөнд нуугдсан баялгийг байгалиас булааж авч олны төлөө зориулан ашиглах үүдийг нээдэг хүмүүс юм” гэж шивнэн хэлэв. Энэ үгээр Улсын их сургуулийн геологи, газар зүйн ангийн нэгдүгээр жилийн сурагчдад лекцээ эхэлдэг юм. Гэхдээ Эрдэнэ бол хүн бүхэнд мөнхөд дурсагдах юм бүтээх тухай ярьж өгдөг юм.

(Зохиолын хэсгээс)



(1917-1970)

Төрсөн он, газар: 1917 онд Говь-Алтай аймгийн Тайшир суманд төржээ.

Уран бүтээлийн төрөл: Хүүрнэл болон жүжиг, кино зохиол

Боловсрол: МУИС (1954) - ийг төгсөж, ЗХУ (одоогийн ОХУ) - д дэд эрдэмтэн (1959) - ий зэрэг хамгаалжээ.

Уран бүтээл: “Алтайд”, “Тунгалаг тамир” романууд, “Манай сургуулийнхан”, “Малгайтай чоно”, “Шаргачин” “Солонго” тууж, өгүүллэгүүд, “Гарын таван хуруу”, “Итгэж болно”, “Энэ хүүхнүүд үү” кино зохиол туурвижээ.

Чадраабалын Лодойдамба

АЛТАЙД (романаас)

Алсын замд (Нэгдүгээр хэсэг)

Зуны эхэн сарын тунгалаг өглөө. Улаанбаатараас баруун өмнө зүг үргэлжлэн хөвөрсөн засмал замаар нэлээд их ачаатай, ачааны “ЗИС-150” гэдэг машин алсын замд гарлаа. Энэ бол Алтай орох шинжилгээний анги юм. Машины кабинд жолооч Идэр, Эрдэнэ хоёр суужээ.

Эрдэнэ хуучивтар боловч толийтол индүүдсэн хөх комбинзон өмсөөд энгэрийг нь товчийг нэгийг ч орхилгүй товчилжээ. Эрдэнийн аманд үл салагч гаанс нь хэвээр бөгөөд хэд сороод зогсох тул унтравч дахин дахин асаана. Ханцуйгүй цамц өмссөн Идэрийн сүрхий түлэгдсэн хүрэн хар булчин нь ил харагдаж, жолоогоо эргүүлэхэд нь мушгиралдан зангирна. Идэр бүдүүн хоолойгоор дуу аялан, замаа

ширтэн жолоогоо чадамгайгаар зална. Эрдэнийн хааяа юм асуухад хэдхэн үгээр хариулаад дуугаа үргэлжлүүлнэ. Идэр бол 10 гаруй жил жолоо барьж байгаа хүн бөгөөд шинжилгээний ангийн жолоочоор олон удаа явсан тул энэ ажилд нэлээн дадлагатай болсон хүн. Машин нь сайн л явж байвал дуу нь ч сайн, ая хөгтэй болж явдаг юм.

Машин дээр Панов, Бат, Баяр, Төмөр дөрөв суужээ: Панов нь эх орны дайны үед салаан даргаас эхлээд дивизийн орлогч хүртэл ажиллаж бүх дайныг туулан байлдсан хүн. Дайны үед Жигмэд гэдэг монгол хүнээс Зөвлөлтийн армид бэлэглэсэн хурдан борлог морийг унаж явсан ба тэр Жигмэдтэйгээ харилцаж чадахгүй болсноо, уулзъя гэвч хаа байдгий нь мэдэхгүй, радиогоор зарлуулбал олж болох болов уу гэх зэрэг ярьсан билээ.

Бас Бат түүний нүүр дэх цагаан сорвий нь тухай асуусанд дайны шарх гэж цөөн үгээр хариулсан юм. Гэвч чухам ямар явдалтай холбогдсоноо ярьсангүй тул хэн ч мэдсэнгүй. Харин холын замд яриа их байдаг тул мэдэгдэх биз ээ!

...Саяхан сургуулийн ширээнээс босоод анх удаа шинжилгээний ажилд яваа инженер геологич Баярт ингэж явах нь гоёл, хээнцэрийн хэрэг биш, харин мэргэжилдээ дурласан, бас шинжилгээний ажилд анх гарч байгаагийн тэмдэг биз ээ. Баяр олон жилийн өмнө геологич болно гэж түүнд өөрийн амьдралын нэлээд хэсгийг зориулжээ. Харин өнөөдөр геологич инженер болоод сэтгэл нь хөдлөхгүй байж хэрхэн болох билээ. Хүн, хүч гаргаж олсон юмандаа дуртай ч байдаг, хайртай ч байдаг юм. Энэ учраас Баяр дээд сургуульд 5 жил болж, шалгалтуудыг догдлон өнгөрүүлж, ихийг мэдсэн өдрөө баярлаж, зарим юмыг мэдэж ойлгоогүйдээ гомдон, өөрийгөө зөмлөж, олж авсан бөгөөд олон шөнийг нойргүй өнгөрүүлснээр барахгүй, зарим өдөр хоол идэлгүй явж олсон инженер гэдэг нэр, мэдэц бол үнэхээр бахархалтай агаад хүч зарж баймаажин олж авсан зүйл юм. Энэ учраас түүндээ хайртай нь ч аргагүй биз, дуртай нь ч аргагүй билээ...

Замын хажуугаар ном, дэвтэр бүсэндээ хавчуулсан хүмүүс хэсэг хэсгээр зэрэгцэн морио гуядан довтлох нь машинаас бараг үл хоцорно. Энэ хүмүүс бол замын дагуу алсад харагдах сумын төв дээр байгуулагдсан түр сургуульд очиж хичээллэх гэж яваа хүмүүс болой. Тэднийг хараад Батын сэтгэлд 50 гаруй жилийн өмнө энэ замаар хөл нүцгэн, уранхай өмд, цамцтай гүйж явсан нь санагдана. Тэгээд сэтгэл нь хөдөлсөн Бат тэр явдлаа нөхдөдөө ярив.

-Би 50 гаруй жилийн өмнө энэ замаар гүйж явсан сан. Тэгэхэд энд цөм өөр байсан. Энэ зам хүртэл тэр үедээ зам биш жим байлаа. Урьд эцэг минь намайг 10 настай байхад лам болгох гээд Гандан дээр аваачиж, нэгэн гавжид тушаан өгөв. Эцэг миь хоёр хоноод буцсаны дараа ламын зан авир өөр болсоор сүүл сүүлдээ тэсвэрлэшгүй болов. Өдөр бүр Дунд голоостом хавчиг үүрч, ус зөөнө. Өглөө нэг тагш хар цай, дугуйн хэлтэрхий, үдэд нэг тагш хоол, орой нэг тагш хар цай ууж идэж байв. Түүнээс илүү идэж уувал ухаан муудна гэдэг байлаа. Би өлсөхдөө нохойд өгөх гэсэн тогооны угаадаснаас хүртэл уудаг байсан юм сан. Эвгүй л хөдөлбөл зодно. Бас зүгээр байвал зодно. Учир нь зодсоноор барцад арилж сайн лам болно гэнэ. Би зодуулаад хэдэн өдөр хөдөлж чадахгүй халууран дэмийрч байсан юм. Хэчнээн зодох тутам би улам хэдэр болно. Би хоол л бодохоос биш цээжлүүлэх гэсэн хоёр гурван шад номы нь тогтоохоо болив. Тэгэхдээ миний тэнэг мангууд минь хүрч зодно. Нэгэн удаа хурал хураад, өлсөхдөө балин хулгайлж идэж байгаад баригдаж, хавьтсан бүхэнд зодуулав. Эцсийн эцэст орчны бүхнийг зананаг болов. Үнэнээ хэлэхэд өршөөлгүй болохоор худал хэлж сурав. Зодох тусам заль мэх минь

их болов.

Тэгээд эцэстээ арга барагдаад нэг өглөө усанд явах гэж гараад оргов. Тэгэхдээ энэ замаар гүйж явлаа. Тэр үед энэ замд уранхай ноорхой дээлтэй бадарчин, Богдод мөргөх гэж аялан замд ядарсан явган нүцгэн хүн, баяд ноёдын мал хариулсан өлсгөлөн хүмүүс тохиолдож байсан билээ. Бас зэрлэг ноход барьж идчих гээд явуулдаггүй байсан гэж хэлээд Бат үгээ таслав. Тэгэхэд нь:

-Та тэгээд харьсан уу? гэж Баяр асуув. Бат замын дагуу машинтай уралдан хөгжилдөж яваа хүмүүсийг зөөлөн нүдээр ажиглан харснаа,

-Үгүй, чадаагүй юм. Би хөдөө харьж явсан лам нартай таарч баригдан хүргэгдээд, хэдэн өдөр зодуулж, заримдаа ухаангүй болж байлаа. Гэвч хэд дахин оргож байгаад харьсан сан. Би нутаг руугаа хэрэггүй зүтгэсэн юмсан гэж хэлээд Бат санаа алдаж, дуугүй болов. Батын яриаг нүд цавчилгүй чагнаж явсан Төмөр,

-Яагаад тэр билээ? гэж асуув.

-Зүтгэж явсаар арайхийж нутагтаа очиход эцэг минь гүтгэлэгт ороод, эрүүдлэгийн шархын халууныг даасангүй үхээд, эх маань сэтгэлээр унаж шаналсаар өлбөрч үхсэн байж билээ. Би зовлон гэж юу байдгийг мэдсэн хүн шүү. Тэр үзсэн зовлон минь миний духан дээрх гурван гүн атирааны цаана бунхлагдсан юм гээд, дээш харахад нь духан дээр нь хуруу зэрэгцүүлэн тавьсан юм шиг гурван гүн атираа тодорно. Бат бага насандаа эцэг эхээс өнчрөөд, баячуудын хүнд ажлыг хийж, тогоо өнгөлзөн, хоолтой хоолгүй хэдэн жил тэнүүчлэн явсан юм. Тэгж явахад Батын сэтгэлд аяга хоол хэрхэн олж идэхээс хэтэрсэн зорилго байгаагүй юм. Дараа нь хошуу захирагчтай эвгүй харилцсанаас болж автономитын цэрэгт хөөгдсөн билээ. Бас цэрэгт очоод Бат хаалгын тулалдаанд сайн байлдаж явсан боловч хүрээнд буцаж ирсний дараа өвдөж, хэвтэх газар олдохгүй хавчигдсаар эцэст нь хог дээр хаягдаад золбин нохойтой хамт сар гаруй хэвтээд эдгэсэн аж. Бат үүнийгээ цааш үргэлжлүүлээд,

-Би энэ бүхний эцэст бүх ертөнцийг занахад бэлэн байлаа. Би анх хүнд чадах чинээгээрээ тусалъя гэж бодож байсан бол энэ байдлаас хойш хүн бүхэн надад дайсан, би хэнд ч хэрэггүй гэж бодож эхэлсэн. Би ингэж хэвтэж байхдаа үхье гэж бодоогүй юм. Тэгэхдээ хүний төлөө биш өөрийнхөө л төлөө амьдаръя гэж бодож байсан. Гэтэл нэг өдөр тос даавуу хоёр нь үл мэдэгдэх дээлтэй хөгшин чавганц ирж, надад халуун цай, шөл өгөв. Би түүнийг авахгүй, идэхгүй гэж хэлээд хараан хөөн явуулав. Учир нь би түүнийг надад сайн сэтгэлээсээ өгч байгаа биш намайг ашиглах гэж, хорлох гэж байна гэж бодсон юм. Бүх үзэж өнгөрүүлсэн зовлонгийн дараа хүн хүндээ тус болно гэдгийг нь миний бодолд ангид хэрэг байв. Хүн өөрийнхөө юмыг хүнд өгөх, ялангуяа над шиг хариугүй болсон хүнд өгнө гэдэг бол миний бодолд орж ирэхгүй байсан юм. Чавганцын сургаж хэлсэн үгийг амий нь авах гэж байгаа жад шиг хүлээн авч, улам ширүүнээр харааж хөөсөн боловч явсангүй. Харин тэр хөгшин миний духан дээр үнсээд,

-Хүү минь, үхэхийг хүсээд хэрэггүй, амьд явбал алтан аяганаас ус уудаг юм гэж хэлээд нүднээс нь гарсан нулимс, үрчгэр хацры нь судлыг даган урсаж байсан юм. Би тэгэхэд эхэр татаж уйлаад дараа нь өгсөн юмыг нь идэж уусан билээ. Түүнээс хойш миний ижил амьтад, Монголд түм бум бий, тэр нь надад туслах, надаар туслуулах гэж хүсэж байдаг гэж мэдсэн юм. Учир нь намайг хог дээр хэвтэж байхад нөгөө чавганц болон түүний ижил хүмүүс өөрийн ховор хэрэглэдэг зүйлээсээ илүүчилж, намайг тэжээж байсан юм. Энэ бүхнээс хойш би хүнд хэрэгтэй, хүн над хэрэгтэй гэж бодож эхэлсэн юм. Энэ бодол маань намайг хүний их хүчинд итгэдэг

болгосноор барахгүй ертөнц бол миний дайснаар биш, миний нөхдөөр дүүрсэн юм гэж итгэдэг болгосон юм. Батын энэ бүх хатуу амьдрал тэр гурван гүн атирааны цаана бунхлагджээ. Ардын төр байгуулагдаж, анхны сургуулиуд хаалгаа нээж, Бат мэтийн хүмүүс А-гаас эхлэн суралцаар эрдэмтэн болсон аж. Батын хүнд итгэсэн, хүнд туслах сэтгэл нь энэ хөгжилд хүргэсэн билээ. Бат хэсэг зуур дуугүй сууснаа, цааш үргэлжлүүлэн,

-Анх намайг сургуульд ороход хоол унд, орон сууцнаас эхлээд цөм дутмаг, чадвартай багшгүй хэцүү л байж билээ. Гэвч тэр бол их юмны эхлэл байсан юм гээд хажуудаа суусан Пановын мөрийг алгадан “Бидний хийсэн, олсон бүхэн бол та бүхний, Орос хүмүүсийн ач юм. Тийм ээ, биднийг цөмөөрөө үндсээрээ сөнөх гэж байхад эд, Пановууд аварсан юм. Тэгээд зогсохгүй барьж байгуулахад хүртэл харамгүй тусалсан. Чухам энэ учраас монгол хүн оросыг ах, эгч, аврагч, туслагчийн нэгдэл гэж үздэг” гэж хэллээ.

Батын яриа дууссанаас хүмүүс нэг хэсэг дуугүй явлаа. Төмөр, хүрээн дээр сууж байгаад нутагтаа харих гэж оргох замдаа чононд баригдаж үхсэн ахынхаа амьдралыг харамсан бодно. Ер нь хүн бүхэн Батын амьдралыг эргэцүүлэн бодно. Баяр, Батын адил тэр хэцүү амьдралыг үзээгүй. Гэвч өөрийн дэлгэр баялаг, дүүрэн жаргалтай амьдралыг тэр хэцүү амьдралтай холбож үзэхэд үнэхээр тэнгэр газар хоёр шиг ажээ. Батын ярьсан зүйл Баярт үлгэр мэт бодогдоно.

1. Энэ хүртэл уншаад юу бодогдов?
2. Ямар ямар хүмүүс юуны төлөө явж байна вэ?
3. Батын ярьсан түүхийг өнөөгийн хүүхдийн сургуулийн амьдралтай харьцуулан ярилцана уу.
4. Хувьсгалаас өмнөх, хувьсгалын үеийн Монгол орны соёл, нийгмийн байдлыг ярилцаад, зохиолд хэрхэн тусгасныг илрүүлэн хэлэлцээрэй.

Шөнийн дайн (Нэгдүгээр хэсэг)

Шинжилгээний анги явсаар гурав дахь өдрөө өргөн говьд орж ирлээ. Зэрэглээ татсан хязгаар нь үл үзэгдэх говийн дундуур өдөр турш хурдлав. Явах замын дагуу тохиолдох элдэв худгаас малыг тасралтгүй усалж байгаа нь хааяагүй тохиолдоно. Хэдхэн жилийн өмнө ямар ч усгүй байсан энэ зэрлэг бэлчээрт ингэж арвин ус бий болсон нь монгол хүн эзэнгүй байсан өргөн говь нутгаа амжилттай довтлон эзэлж байгааг гэрчилнэ. Заримдаа маш их бударгана, багалуур тохиолдоод машин явахад сүрхий саад болно. Энэ өргөн говийн дунд хулан, зээр, хар сүүлт хэд хэдэн зуугаар сүрэглэн, машиныг хараад хуйлран давхиж хурднаа шалгая гэсэн юм шиг заавар өмнүүр нь гарахыг тэмцэн хурдална. Зарим газар говийн хуурай сайрын дагуу хулангийн ухсан худгууд гэрийн буйрын чинээ дугуйран харагдана. Хулан өөрийн хурц туурайгаар говийн хуурай хөрсийг ингэж ухаад ус гаргаж уусныг үзэхэд энэ амьтад амьдрахын төлөө байгальтай тэмцэлдэж, ямар их хүч гаргадаг ба тэдний хатуу амьдрал нь ямар нэгэн нарийн зүйлд сургасныг тодорхой үзүүлнэ. Метр хүрэхгүй газар ухаад ус гарах тийм газрыг энэхүү ангамал хуурай хөрснөөс олно гэдэг тийм амар хэрэг биш юм. Гэвч хулангууд ийм худгийг өдий төдийгөөр ухаад ус гаргадаг нь үнэхээр гайхамшигтай ажээ.

Тэд явсаар үргэлжилсэн ааргийн зах руу орлоо. Орчмын газраас хэдхэн метрийн өндөр эдгээр толгод нь хэдэн зуун мянган жилээр нарны хурц гэрэлд

шарагдаж түлэгдсэн хүрэн хар чулуугаар бүрхмэл байвч, ажиглан харахад хэдэн олон өнгө гялтганан хосолсон маш сайхан байгаль ажээ. Хааяа ихээхэн усархаг үер буухад сайрыг дагаж, ус урсаж, түүнд хажуугийн толгодоос хурц улаан ягаан элсэн тунадасыг авчран маш гоёмсоор олон өнгийн туяа гарсан хөрс тогтоно. Зарим газар энэхүү сайрын эргийг тав зургаа, түүнээс ч илүү метр өндөр болоод сүрхий эгц гацаа мэт болжээ. Үүнийг холоос харахад зарим нь маш урлагаар байгуулсан ордон, барилга мэт харагдана.

Шөнө болоход шинжилгээний ангийнхан машинаа зогсоон, хайрга чулуун хөрсөн дээр хонохоор болов. Энэ хүмүүс юутай, хортой амьтад байдаг нь үл мэдэгдэх говьд харанхуй шөнө ирээд унтах нь сэтгэлд тавгүй мэт юм. Ямар нэгэн хортой амьтан гарч ирээд амий нь хорлоход болохгүй гэж шалтгаан огтхон ч үгүй юм. Гэвч энэ бүхнээс айгаад байвал юу ч бүтээж чадахгүй юм.

Бүгд унтсаны дараа гагцхүү Эрдэнийн нойр үл хүрэх тул дэмий л ийш тийш хөврөлдөн хэвтэж, элдвийг бодож байлаа. Хэдэн жилийн турш геологийн хайгуул хийсэн Монгол орноо бодож,

“Яндаж болдоггүй далай шиг

Яасан баян нутаг вэ?

Ямар их хувь заяагаар

Бид нар эзэн нь болж төрөв...” гэж үргэлж хэлж явдаг шүлгээ шивнэн хэлээд “Үнэн шүү. Үнэндээ бид нарын хэвтэж байгаа энэ газрын хөрсөн доор ямар эрдэнэ хэчнээн хэмжээтэй байгаа юм гэдэг нь судлагдаагүй байна шүү дээ. Манай энэ өргөн нутагт хэчнээн баялаг нуугдаж байгаа вэ? Геологичийн жаргалын орон шүү. Ганц ч геологич ч биш л дээ. Нэгэн үед бус, мөнхөд дурсагдах тийм юм бүтээх бололцоо бидэнд байна. Тэгвэл юу бүтээх хэрэгтэй вэ? Юу ч бүтээж болно. Геологич бол өндөр уул, өргөн говийг гаталж, машинтай, морьтой, явган явж, зарим газар мөлхөж яваад, газрын хөрсөнд нуугдсан баялгийг гарган авч, олны төлөө зориулан ашиглах үүдийг нээдэг хүмүүс” гэж шивнэн хэлэв.

Эрдэнэ иймэрхүү юм бодоод хэвтэж байтал...гэнэт алсад ямар нэгэн юм дуугарах шиг болов. Бодлоо тасалж, чих тавин чагнавал их бууны дуу нижигнэн, сум дэлбэрэх сонсогдов.

-Юу вэ? Энэ хүн амьтангүй, цөл говьд юун их буу дуугарч, нисэх онгоц нисэн, бөмбөг дэлбэрдэг билээ? Ямар хачин юм бэ? Аль би буруу сонсож байна уу? гэж бодоод хэвтрээсээ өндийн, амьсгалаа хураан чагнавал гарцаагүй ажээ. Нэг л сүрхий тулаан болж буй мэт байв. Гэвч энэ цөл говьд дайн болж байна гэдгийг итгэхгүй нэлээд удаан чагнав. Гэвч сонсох бүр улам тод болж эргэлзээгүй болов. Тэгээд нөхдөө чанга дуудан хашхирав. Ер нь тийм сайхан бодол бодож байсан хүн ингэж гэв гэнэт дайны чимээ сонсоод сандрах нь аргагүй биз ээ. Эрдэнийн чанга дуудалтад сэрсэн нөхдүүд гайхан “Юу болов?” гэж ам амандаа асуув.

-Та нар чагнаач! Их буу, нисэх онгоц гэж хэлээд баруун хойш харна. Гэнэт сэрсэндээ нойрмоглосон нөхөд аль ч учрыг ололгүй, дэмий л Эрдэнийг ширтэн байтал, Баяр,

-Үгүй, энэ чинь... юун дайн бэ? Сум, бөмбөг дэлбэрч байх чинь! гэхэд нөхөд нь сая тэр чимээг сонсов.

Эрдэнийн сонссон чимээ бүгдэд сонсогдов. Ингээд цөм хувцаслаж эхлэв. Бүгд “зэрлэг суманд оногдохгүй юм сан” хэмээн сандралдаж, Эрдэнэ “Энэ хүмүүсийг ахалж яваа тул ямар шийдвэр гаргах вэ?” гэж бодож байв. – Сайн чагнаж учры нь олъё гэж Эрдэнэ хэлэв. Панов анх энэ чимээг сонсоод гайхах сандрах хавсарсан

юм. Гэвч яарах тусам улам хянамгай болдог хүн болохоор хөдөлгөөн нь хүртэл аажим болж, бүхнийг дахин шалгаж үзсэн хянамгай байдалд шилжив.

Гэтэл удалгүй нөгөө дуу чимээ зогсов. Ямар ч чимээ аниргүй болоод ганцхан салхины үл мэдэг шуугиан сонсогдоно. Хүмүүс бүр ч гайхав.

-Дайн ингэж гэнэтхэн зогсох гэж үү? Дахин дуугарах болов уу? Эсвэл их буу, нисэх онгоцны ажиллагаа нь одоо дуусаад жинхэнэ тулалдаан нь эхлэхийн өмнө түр чимээгүй болж байгаа юм уу? Ер нь энэ говьд юун дайн болдог билээ дээ, эсвэл байгалийн сонин үзэгдэл үү? гэх зэргээр өдий төдий янз бүрийн юм хүмүүсийн сэтгэлд орно.

Ер нь санаандгүй байсан юм заавал сонин байдаг юм.

-Энд дайн болох ёсгүй. Энэ нь заавал өөр нэг юм байх... гэж Пановын хэлэхэд нөхөд нь хариу хэлсэнгүй. Учир нь дахин чимээ гарч, хүмүүсийн анхаарлыг татав.

Энэ удаа гарсан чимээ бол ямар нэгэн дайны чимээ бус, Оросын их хөгжмийн зохиолч Чайковскийн хөгжим “Евгений Онегин” гэдэг оперын Ленскийн дууллыг тенер хоолойгоор дуулж эхлэв. Хүмүүс дайны чимээ байх гэж бодож байсан тул бүр ихээр гайхав.

-Ямар жигтэй юм бэ? Саяхан дайн болж байгаагүй билүү? Харин одоо хөгжим болох чинь юу юм бэ? гэж Төмөр бусдаасаа асуув. Одоодоо юу гэдгийг нь хэн ч мэдэхгүй тул Төмөрийн асуудал хүн бүхний сэтгэлд эргэлдэж байгаа юм.

- Энэ бол байгалийн нэгэн чимээ бололтой. Тэгэхдээ чжхам юу билээ? гэдгийг би л мэдэхгүй байна. Гэвч байгалийн нууц бол өнөө биш боловч маргааш тайлагдах ёстой юм. Маргааш биш боловч нөгөөдөр заавал тайлагдана гэж Панов хэлээд Баярын мөрийг түшин чагнав.

Ингэж байтал нөгөө хөгжим зогсоод хэдэн минут нам гүм болсны дараа дахин чимээ гарсан нь үндэсний хөгжмийн ансамблийн найруулгаар морин хуур хүнгэнэн “Суман дээр” гэдэг эхлэл хэсгийг тоглов.

-За нөхөд минь, энэ нэг сонин үзэгдэл бололтой. Юу ч болов одоо унтаж амраад чадвар маргааш учры нь олцгооё тийм биз дээ Николай Владимирович аа! гэж асуухад,

-Тэгэхээс өөр энэ шөнө яах вэ дээ гэж Панов хэлэв. Тэд хэвтэцгээн, энэ шөнийн явдлыг янз бүрээр таамаглан, тайлбарлах гэж нэлээн ярилцсан авч бие биеийнхээ тааврыг бут цохисоор ямар ч амжилт олсонгүй. Тэгээд унтацгаав. Харин маргааш нь эрт босоцгоож, эргэн тойрон бараг таван километр газрыг нэгжин үзсэн боловч урд шөнийн дуу чимээний нууц нь хэвээр үлдэв. Нэгэнт тэд нарын зорилго Алтай орж шинжилгээний чухал ажил хийх тул шөнийн явдал хэдий сонин боловч аргагүй орхиж, үдээс хойш цааш явлаа.

Гангантөгс (Гуравдугаар хэсэг)

Эрдэнэ хоол цайгаа ууж идсэний дараа шинжилгээнийхэн унтахаар хэвтэцгээв. Харин Идэр манаанд гарлаа..

...Цөм хэвтсэний дараа Панов бүдүүн дуугаар,

- Өнөөдөр Дамдин гуай нэг юм ярих ээлж болоод байх шиг байна. Гэвч та нар юу гэж бодож байна? гэж асуув.

- Би юу ярихав дээ. Харин та нарын л яриаг сонсмоор байна. Ер нь би та нарын сонирхмоор юу ярих билээ дээ гэж Дамдин хэлэхэд... цөм Дамдинг юм ярихыг шаардав.

Дамдин ханиаж хоолойгоо зассанаа,
- Би нэг сайн эрийн тухай ярья даа гэв...
- Сайн эрийн тухай бол маш сайн байна гэж хөнжлөө засах зуур Панов хэлэв...
- За тэгвэл 1909 онд, миний нагац ах Ням, нутгийн хэдэн хүмүүстэй хамтран жин тээхээр Хөх хот руу аялжээ. Хятад нутагт ороод, хоёр хоног яваад нэгэн шөнө мичид гудайхын үед буудаллаад, тэмээгээ уян хонож гэнэ...

- За тэгээд өглөө босоход нь манай нагацын авч явсан тэмээнээс гурван ат, бас нөхдийнхөөс нь дөрвөн ат үгүй болсон байв гэнэ.

Цөмөөрөө бууцаа тойрч мөрий нь харвал хоёр морьтой хүн хөтлөөд баруун тийш явсан байв гэнэ. Тэгэхэд нь ойр зогссон байж магад гээд явж мөрдвөл зогсолтгүй шууд явчихсан байна гэнэ. Ингээд нагац маань мөрдөн явах болжээ. Тогоо, шанага, хоол хэрэглэл аваад сайн тэмээ унаж мөрий нь мөшгөн явсан гэнэ. Хоёр өдөр яваад гурав дахь өдөр үдийн хирд маш их уулын савд оржээ. Тэгээд нарийхан замаар зогсолтгүй явсаар хагас өдөр болж харанхуй бүрэнхий болохын үед тэмээ авагсдын буудаллаад хөдөлсөн газрыг олжээ. Гурван чулуу тулж, гал түлсэн байр нь цасан дээр харлан эргэн тойронд нь хонины дал чөмөгний яс, цайны шаар зэрэг хэвтэнэ. Голомты нь өмнөхөн хуйгүй том хутга байсныг авч үзэхэд нь бариулы нь бөгжилсөн гурван төмөр бөгж дээр таван хошуу малыг маш урлагаар сийлж хийсэн байв гэнэ. Нагац маань тэр хутганы хийцний сайхныг үргэлж бахархан ярьдаг сан. Бүснээсээ огтлон авч иший нь гарган ороогоод ардаа хавчуулж гэнэ.

Бүр харанхуй болж орчны юм бараг харагдахгүй болов гэнэ. Сар гарахыг хүлээх зуур, богцноосоо мах гаргаж иджээ. Тэгээд удсан ч үгүй дорнодоос өрөөсөн булангүй том сар гараад, харанхуйд унтсан мэт ертөнц бүр тодхон харагдаж нойрноосоо сэрэх шиг боллоо. Ингээд цаашаа явжээ. Үүрийн гэгээ тусахын үед өндөр хадны хавцлын амаар оржээ. Хажуугийн өндөр гацааны орой толгой дээр нь нурах гэж байгаа юм шиг өнгийнө. Зам нь бүр нарийссаар сүүлдээ ганцхан хүний явах улбаа болжээ. Цааш нь цаг гаруй явтал хоёр талын эгц гацааны үзүүрийн зааг газар хүрчээ. Зам нь энэ заагаар гарсан бололтой боловч маш том чулуу хөндлөн хаажээ. Гэтэл нөгөө мөр тэр чулуунд тулаад үгүй болсон байжээ.

Ажиглавал чулууны доорх газар луу л орчихсон юм шиг ажээ. Нагац маань нэг хэсэг гайхан зогосноо “Миний тэмээг энгийн хүн авсангүй, уулын савдаг сахиус лусын эзэд юм уу, бурхан авсан бололтой” гэж бодоод, буцах гэснээ чулууны цаана нь юу байгааг хармаар санагджээ.

“Лус савдгийн буюу бурхны орон харагдаж магад, хэрэв харагдах юм бол заяа буян дэлгэрэх болно” гэж бодоод тэмээнээс бууж өндөр хад өөд авирч гарав гэнэ шүү. Мацсаар арай гэж оройд нь гарахад нь, цаад руу нь зам нэлээд өргөн болсон ажээ. Бас нөгөө хүмүүсийн явсан мөр нь тодорхой харагджээ.

Нагац маань ар луу нь бууж, хэсэг зуур юм бүхнийг ажиглан зогсжээ. Хүний сэтгэл сонин юм шүү. Ингээд ажиглаж байхад юм бүхэн л өөр ертөнцийн юм шиг байсан юм гэж манай нагац маань яриад инээдэг байж билээ гээд Дамдин хоолойгоо засав.

- Нөхөд нь цөм хэцийлдэн бараг амьсгалах нь үл сонсогдон чагнана. Эрдэнэ ч алга аль хэдийн тамхиа унтраагаад гаансаа дэрнийхээ булан дор хийжээ.

- За тэгээд гэж Дамдингийн хоолойгоо зассан өчүүхэн зайг тэсвэрлэж ядсан Бат хэлэв.

- Гэтэл баруун уулын хажуугаар явган хүний мөр гарсан нь харагджээ. Тэр мөрийг дагаж явсаар маш өндөр элгэн хаданд ойртон очиход нь, тэнд агуй байж.

Тэр агуй руу ороход төдий л хэцүү биш, чулуугаар аятайхан шат тавьжээ.

Нагац маань нөгөө олсон хутгаа бариад агуйд оржээ. Тэнд юу ч харагдахгүй харанхуй ажээ. Нэгэн хэсэг түдгэлзэн зогссоноо, цааш хэд алхахад хөлд нь юм тээглэхэд шүдэнз зурж харах гээд шүдэнзээ зуртал маш их дуу гаран хөх улбар гал гараад хадан агуй нурах шиг болж, нагац маань ухаан алджээ. Ер нь мэдэхгүй газар там гэдэг үнэн шүү гээд хучлагаа засахад нь Баяр,

- За тэгээд гэв. Нэг ухаан ороход гэгээтэй газар хэвтэж байсан ба дэргэд нь хүн ярилцах шиг болоход нь цочиж, өндийн харвал цагаан нэхий дээлтэй үнэгэн лоовууз сөхөж өмссөн хоёр залуу хүн дэргэд нь зогсож байжээ. Газрын байдлыг ажиглавал нөгөө агуйн шатны дэргэд ажээ. Нагац маань чих нь дүнгэнэн, нүд нь эрээлжлэх тул тэр хоёрын юу ярьж байгааг үл ойлгоно.

- Та нар чинь жирийн хүн байна уу? Аль бурхан байна уу? гэж асууж гэнэ. Тэр хоёр инээлдсэнээ нэг нь

- Бид жирийн хүн. Харин та чинь юун хүн байна даа? гэхэд нь нагац маань өөрийн явдлыг ярьж өгчээ.

- Аавын хэлдэг үнэн байна уу? гэж нөгөө нь хэлээд, нөгөө рүүгээ харснаа, эргэж нагац руу эрс хараад,

- Бид бол Гангантөгсийн хүү нар! Манай гэр эндээс хол биш. Тэр тэмээгээ олж авъя гэвэл мөрөөр нь явагтун. Хагас өртөө яваад манай гэрт хүрнэ. Аавд учраа хэлбэл тэмээгий чинь өгнө дөө гэв.

- Нөхөд минь тэмээгээ ч олохыг хүсэлгүй яахав дээ. Ганцхан замы минь том чулуу боочоод гарч болохгүй байна. Үгүй тэгээд та нар чинь үнэхээр жирийн хүн юм биз дээ гэв.

Тэр хоёр зэрэг инээв. Нагац маань тэр хоёрыг гайхан харжээ.

- Бид яах ч аргагүй жирийн хүн. Харин та энэ хутгыг хаанаас олов? гэж нөгөө олсон хутгыг үзүүлжээ.

Нагац маань хутгыг хаанаас олсноо ярьж өгөв.

Бид энэ хутгыг авна. Харин одоо таны нүдийг бооно. Бид таны унааг хадны наад талд гаргаж өгье. Та нүднийхээ боолтыг битгий тайлаарай. Хэрэв тайлсан байвал аминд чинь хүрнэ шүү. Бид хоёрын хашхирахтай хамт боодлоо тайлаарай. Мэдэв үү.

Нагац маань анхандаа нүдээ боолгохгүй гэж хэлэх юм уу гэсэн боловч “За даа энэ хоёр намайг алья гэвэл нүд боолгож юу хийх юм бэ? Зүгээр л хутгалчихна биз” гэж бодоод нүдээ боолгожээ. Нүд боох зуур тэдгээрийн нэг нь,

- За та замаараа явсаар байтал чинь нэгэн хөндийд хүрнэ. Түүнийг хөндлөн огтлоод хойд захад нь гарахад чинь эгц ханан хад болсон уул байна. Түүний элгэнд таван гэр байх нь бий. Түүний баруун талын жижиг гэрт ороорой. Нэгэн өвгөн байна. Түүнд учир явдлаа гаргаж хэл гэж хэлэв гэнэ.

Ингээд нагац маань нүдээ боолгоод явжээ. Заримдаа хажуугаар нь хүн явна, заримдаа хүний хөлийн чимээ алслан холдоно.

Тэгэж явсаар нэлээд болсны дараа,

- За одоо тайлж болно гэж хашхирах нь алсад цуурайтжээ. Нүднийхээ боолдыг тайлаад харвал дэргэд нь хүнгүй ажээ. Тэгэхэд нь нөгөө чулуу руу очвол тэмээг нь хадны наад талд гаргажээ.

Харин нөгөө талд нь хүмүүсийн ярих чимээ сонсогдоно.

- За би ингээд явах уу? гэж нагац асуужээ.

Хадны цаанаас чанга дуугаар,

- Тэг, харин хутганы тухай аавд битгий хэлээрэй. Юндэн гэдэг хүнд нууцаар хутгыг бид хоёрын авсныг хэлээрэй гэв.

Нагац тэмээгээ унаад цаашаа явахдаа тэр хоёр жирийн хүн гэдэгт эргэлзэнэ. “Амьдаараа бурхны оронд очих нь уу” гэж бодож явсан гэж ярьдаг юмсан. Нар шингэхийн үед нөгөө хэдэн гэрийн гадаа хүрээд уяан дээр нь бууж, тэмээгээ уятал зүүн талын гэрээс нэг хүн гарч шууд чиглэн ирээд,

Юун хүн бэ? гэж асуухад нь нагац маань өөрийн ирсэн учрыг товчхон ярьж өгөв.

- Би таны тэмээг авсан юм. Та аав дээр ор. Зам дайврын хятад хамт явсан юм гэж хэлээрэй гэв.

- Таны алдар хэн гэдэг бол? гэж нагац угтан асуужээ. Ингэхдээ нагац хутганы тухай хэлэх үгийг эзэнд нь хэлэхийг эрмэлзсэн юм байжээ. Юндэн гэдэг гэхэд нь нагац маань хутганы тухай хэлж өгчээ.

Тэгээд нагац маань баруун талын гэрт ороход нь зүүн талын орны өмнө элгээ хүрсэн цагаан сахалтай, ханхар цээжтэй өвгөн цай ууж сууснаа нагацыг орохтой зэрэг хөмсгөө зангидан ширтсэнээ,

- Хэн орж ирэв? Жаргал уу? гэжээ.

- Үгүй өвгөн гуай, би явуулын хүн байна гэж хариулах зуур нагац маань баруун талд нь нэлээд дээр гараад суужээ.

- Тэмээний эрэлчин үү? гэж өвгөн асуув.

- Тийм байна гэж нагац маань хэлсний дараа өвгөн нутаг усы нь угтан асуужээ.

Жаргал! гэж өвгөн хүнгэнэсэн бүдүүн дуугаар дуудав. Удалгүй нэгэн жижигхэн хүүхэд орж ирээд өвгөний өмнө зогсов.

- Түшиг, Юндэн хоёрыг дууд. Бас Чулууныг дууд. Бушуу! гэхэд хүүхэд гүйн гарчээ.

- За чи хө, хаалга яаж гарав? гэж өвгөн хүнгэнэсэн бүдүүн дуугаар нагацаас асуужээ. Нагац тэгэхэд нь хоёр хүн гаргаж өгсөн тухай ярьжээ.

Удалгүй гаднаас дуудсан хүмүүс нь орж ирээд өвгөний өмнө зэрэгцэн зогсжээ.

- За та хоёр халх хүний тэмээ авчраад Хятадын тэмээ гэж хэлэв? Гангантөгсийнхөн монгол хүнээс өнчин ишиг ч авахгүй. Гангантөгсийнхөн үнэнч байх ёстой гэдгийг та нар мэдэх үү? Чулуун чи энэ хоёрыг тавь тавь ташуурд гэж маш ууртайгаар хэлэв.

Зогсож байсан гурван хүний нэг нь хананд хавчуулаастай байсан ташуурыг авч ирэв. Тэгэхэд нь нагац маань,

- Өвгөн гуай минь бидэнтэй дайврын хятадууд явж байсан юм. Тэгээд андуурсан байлгүй дээ гэж хэлжээ.

- Тийм аав минь, бид майханд нь хятад хүн дуу гарахаар цөм хятадууд гэж бодоод тэмээгий нь авсан юм. Үүнээс хойш бид хянамжтай явъя гэж Юндэн хэлээд өвгөний өмнө сөхөрчээ. Нагац ахын үгэнд баахан тайвширсан өвгөн гарцгаа гэж зандарчээ. Тэр гурав гүйн гарчээ. Нагац минь ч гарахаар босчээ. Өвгөн инээмсэглэж,

- Та суу, би хүүхдүүдийг гар гэж хэлсэн юм шүү гэв.

- Ингээд нагац маань буцаж суусан ба өвгөн Жаргалыг дуудав.

- Төдий Жаргал орж ирлээ.

- Чи явж, энэ хүнд хоол хийлгэж ир гэж өвгөнийг хэлэхэд Жаргал за гээд гарчээ.

- За хүү минь наашаа суу. Одоо хүүхэд хоол хийгээд ирнэ. Хоол иртэл цай уу гээд нагацад өөрийнхөө мөнгөн том аяганд цай хийж өгөв. Өвгөний эгц өмнө нь сууж аагтай халуун цай ув. Өвгөн, нагацын маань хошуу нутгийг асууж танилцаад хоол идсэний дараа унтахаар хэвтжээ. Өвгөн ахаас нутгийн байдлыг нь асууж танилцаад, дараа нь өөрийн түүхийг ярьсан юм...

- За тэгвэл тэр өвгөний ярьсан нь:

- Би бол Гангантөгс гэдэг хүн. Уул нь Сартуулын хошууны юм. Үүнээс гуч гаруй жилийн өмнө албан татварт оногдсон зуун ланг Да-шин-хүүд төлөх болов. Байгаа хэдэн хонио барагт нь өгөв. Бас дөрвөн гүү байснаа өгөв. Хүрсэнгүй. Да-шин-хүүгээс хойшлуулахыг гуйхаар очиж, учраа гаргавал, омогтой нэг хятад “Чи өгөхгүй бол хонгоны мах чинь хорсоно шүү” гэж хэлээд дооглон инээхэд нь уур нь хүрээд илжиг лууст нь хүрчхэв. Бас тэгээд ч зогссонгүй монголоос идэж ханадаггүй мангас, гэдэс чинь хагарна. Хэдэн манжтай чинь хамт хөөж, зайлуулбал зохино гэх зэрэг нэлээд олон үг хэлсэн чинь баригдаж, төр дайрсан хэрэгтэн гэж хэдэн өдөр банздуулан гуядуулаад Улиастайн Бат гүнд хоригдов.

Бат гүн гэж юу вэ? гэж Баяр, Дамдингийн яриан дундуур асуув.

Бат угтаж аваад,

- Улиастайд байсан шорон, нэг л ёсны манжуудаас Монголд байгуулсан, Бастели¹ юм гэв.

- Бат гүнд хоёр сар гаруй болоод хэдэн хүмүүсийн хамт оргож гараад, жингийн зам тосож Хятадын юм дээрэмдэн явсаар дараа нь тэр ууланд суурьшсан ажээ. Бид арван гурван хүн анх шоронгоос оргоод эрхийнийхээ толь өндгийг хагалж, цусы нь ууж “Монгол хүнээс нэг ч ишиг авахгүй харин хятадаас хайр найргүй авна, хулгайлна, дээрэмдэнэ” гэж тангарагласан юм байжээ.

Энэ хооронд тэд нэлээд хятадыг дээрэмдсэн, нэлээд юм хулгайлсан, анх хамт гарсан нөхдийн нь ихэнх нь үхсэн, зарим нь алагдсан, гэвч баригдаж алагдсан хүнгүй. Тэр залуучууд бол цөм сүүлд нийлсэн хүмүүс, харин Жаргал гэдэг хүүхэд бол хятадад зарцлагдаж зүдэрсэн хүүхэд, оргож яваад чононд бариулах гэж байхад нь түүний нөхөд олж ирсэн юм байна билээ.

...Энэ бүхнийг Гангантөгс тоочин яриад миний эхнэр хоёр хүүхэдтэйгээ нутагтаа үлдсэн юмсан. Хойно сураг дуулбал өлбөрч үхсэн гэнэ билээ гээд санаа алдаж нүднээсээ нулимс бөмбөрүүлэхэд нь нагацын сэтгэл уяран бас санаа алджээ. Тэгээд та чинь дээрэмчин хүн юм шив дээ гэж нагац минь лавлан асуужээ. Өвгөн хэсэг дуугүй байснаа,

- Үгүй би дээрэмчин ч биш, хулгайч ч биш, би өшөөгөө авагч. Манж, хятадын ноёд түшмэд Монголын хөрөнгийг дээрэмдэж байна. Би бол тэр дээрэмдсэн хөрөнгийг эргүүлэн авч байгаа юм гэжээ. Дамдин яриагаа тасалж, хэсэг зуур дуугүй байв. Сонсогчид цөм Гангантөгсийг дүрслэн бодно. Гэтэл гэнэт Дамдин ухаан орсон юм шиг Гангантөгсийн түүх ийм юм гэв.

- Би, урьд Засагт хааны аймгийн материалаас судалж байхад Гангантөгс хулгайчийг барьсан хүнд хоёр мянган лан шагнана гэж нэг улаан шугамтай бичиг байсан. Тэр Гангантөгс мөн байх нь ээ гэж Бат хэлэв.

Тэгээд таны нагац чинь хэдийд яаж буцсан юм бол гэж асуув. Өглөө босоход нь тэмээнүүдийг нь авчирч өгсөн ба бас чирэгдэл болгосных гэж 50 лан мөнгө өгчээ. Харин нөгөө хаалгат замаар Түшиг, Юндэн хоёр гаргаж өгсөн юм гэнэ билээ гэж Дамдингийн хэлэхэд

- За тэр чулууг яаж зайлуулсан юм бол Панов асуув.

- Урьд адилаар нүдийг нь боосон тул яаж зайлуулсныг мэдсэнгүй гэдэг юм гэв.

- Гангантөгс яасан бол гэж Баяр асуув.

- Мэдэхгүй дээ. Ер нь Гангантөгс шиг эрчүүд олон байсан юм. Монгол-чууд

1. Францад байсан харгис шоронгийн нэр

гадаадын боолчлогчдын өмнө номхон сөгдөөгүй юм. Ширүүн тэмцэж байсан. Харин нийлэлдэж, эвлэлдэж байгаагүйгээс олон зоригтон эр буруу замаар Гангантөгс шиг тэмцсээр амиа үрж байв. Тэдэнд зориг байсан авч нэгдэл байгаагүй юм даа гэж хэлээд Дамдин санаа алдав.

- Шүдэнз асаахад юу тэгэж, сүрхий дуу гарсан юм бол? гэж Төмөр асуухад,
- Тэр ч яахав. Зарим агуйнуудад маш их тэсрэгч хий хуралдаж байгаад, шүдэнз зурмагц тэсэрдэг юм. Харин тэр чулууг яаж өнгөрсөн юм бол гэж Панов дахин асуужээ. Ингээд цөм Гангантөгсийн тухай шүүмжлэн ярилцав. Ярилцаар байтал бүр орой болов. Эрдэнэ яриагаа тасалж, маргааш эрт босох тухай нөхдөдөө сануулсанд цөм дуугүй болон унтацгаав.

1. Гангантөгсийн амьдарч байсан үеийг түүхийн хичээлийн мэдлэгтэй холбон яриарай.
2. Гангантөгсийг яагаад буруу замаар тэмцсэн гэж дүгнэсэн бэ?

Юм олдов (дөрөвдүгээр хэсэг)

Маргааш өглөө шинжилгээнийхэн эрт босоход, намираа бороо орж, маш их цахилгаан цахиж байлаа.

Ялангуяа майхнаас баруун хойш харагдах уулын цаад руу сүрхий их цахилгаан цахиж байгаа нь бүхэнд бүр тодорхой харагдав. Заримдаа газар ба хуралдан бөөгнөсөн үүл, газрын хооронд гялалзсан утас татсан юм шиг цахилгааны зурвас гэрлүүд гялалзана. Эрдэнэ, Бат, Төмөр гурав урьд өдөр Баярын олсон пирит¹ бүхий кварцийн үеийн үргэлжлэлд нь хагас метр шахам ухаад орхисон хоёрдугаар худаг дээр очиж ажиллахаар явлаа. Эрдэнийн урьд нь орхиод эргэж, эрээд олоогүй юм барагцаалбал тэр худгийн орчим тул урьдаар түүнийг эрж олоод дараа нь худгаа ухаж шинжлэхээр төлөвлөжээ. Баярын гаргасан зургаар бол барагцаалбал гурван метр хэр ухахад кварцийн үед тулах байлаа. Тэр гурав уг пирит, алт байх үгүй хоёрыг нь шийдвэрлэх үүрэгтэй юм. Тэр гурав Эрдэнийн юмыг цаг гаруй эрсэн боловч олсонгүй тул аргагүй мухардаж гайхсаар худаг руугаа явлаа. Худаг дээр ойртож очсон Төмөр гэнэт зогсож,

- Эрдэнэ гуай! Таны юм энэ байна гэж нүх рүү заав. Эрдэнэ, Бат хоёр очиж үзвэл, нүхэн дотор Эрдэнийн юм хэвтэж байв. Тэр нь бүрэн бөгөөд харин бороонд нэлээд норжээ.

- Та газар тавилаа гээд нүхэнд хийж л дээ. Ер нь нэлээд сандарсан бололтой гэж Бат хэлээд инээмсэглэв.

- Сонин л юм байна даа. Би газар л тавьсан юмсан гээд Эрдэнэ худгийн амсрыг тойруулан ажигласнаа урд ирмэгийг зааж,

- Энэ... юун мөр вэ? гэв.

Хоёр нөхөр нь хартал үнэхээр нүхнээс гаргасан шороон дээр хоёр хөлийн мөр байх нь тодорхой ажээ. Тэр мөр цаашаа хайрга чулуун хөрсөнд ороод мэдэгдэхгүй болжээ.

- Бидний мөр шив дээ гэж Төмөр хэлээд доошоо харлаа.

- Биш, бидний мөр энэ байна гэж Эрдэнэ хэлээд өөрсдийн мөрийг заав.

Нүхийг тойрч гаргасан тэр гурвын шинэхэн мөр, Эрдэнийн заасан мөрнөөс бүр ялгаран харагдана...

1. Эрдэнийн хайсан зүйл нь юу байсныг зохиолыг бүрнээр нь уншиж, мэдээрэй.

1. Пирит - (грек. pyritos - галаас), төмрийн сульфид FeS. Цохиход оч үсэрдэг.

2. Эрдэнэ юу юу алдсан байсныг, юуны мөр болохыг эх зохиолоос дэлгэрүүлж уншаарай.

Галт угалз (тавдугаар хэсэг)

Тэр өдөр Баяр Панов хоёр майхныхаа баруун хойд талын уулыг давж ажиллахаар явлаа. Хэдийгээр хайрга хөрстэй авч, газар нь удаан хугацаанд бороо орсон тул нэвтэртэл норсон газар дээгүүр явахад сүрхий гулгана.

Замын чулуунуудыг түүж, урьдчилсан шинжилгээ хийх, заримыг алхаараа бутлан хэлтэлж авах бас зарим үе давхаргын уналт, дэлгэлтийн өнцөг, шугам зэрэг хэмжээнүүдийг авч, геологийн урьдчилсан зургийн тухайллыг гаргах тул маш удаан явна.

Ингэж явсаар нар жаргахын үед уулын нуруун дээр гарч ирлээ. Уулын цаад талд өндөр биш ажээ. Хормойноос нь цааш маш өргөн талбай үргэлжлэн харагдана. Талбайн энд тэнд нь хэдэн мянган жил халуун наранд шарагдсан хүрэн хар хад сүндэрлэн харагдана.

Тэр талбай руу цахилгаан цахилах нь ойроос харахад бүр ч сонин ажээ.

Тасралтгүй үргэлжлэн цахилах цахилгаан нь тэнгэр газрын хооронд татсан гэрэлтэй алтан утас мэт харагдана. Нэгэн хэсэг зогсож, өмнөө тодорсон үлэмжийн сонин үзэгдлийг гайхан харцгаав.

- Николай Владимирович аа! Яасан сонин юм бэ?

- Тийм байна. Байгалийн ховорхон бүтээлийн нэг байна гэв.

Тэнгэрийн хаяа баруун хойноосоо ярагдан, үүл шингэрэн нүүж, бороо удахгүй арилах төлөвтэй ажээ.

Тэр хоёр, уулын бэл рүү бууж, нэлээд явав. Харанхуй болж эхлэв. Үүл цоорч бороо арилав. Бас нөгөө цахилгаан харагдахгүй болов. Тэр хоёр, лүглийн харагдах хаддын дундуур сүлжлэн элдэв юм ярилцсаар нэлээд яваад эргэв. Ингэж явсаар нэгэн өндөр хадны хажуугаар тойртол гэнэт хад чулуу нурж, ямар нэгэн том амьтан өмнүүр нь гарах шиг болоход цочиж зогсвол бүр ч гайхалтай үзэгдэл тэдний өмнө тодров. Тэр давхисан амьтны биеэс хөх гал сүүмэлзэнэ.

Сайн ажиглан харвал угалз бололтой.

- Хөх гал! гээд Пановын заахад Баяр юу ч дуугаралгүй гайхамшигт угалзны хойноос гөлрөн ширтэв. Хэдхэн секундийн дараа өнөөх угалз харагдахгүй болов. Дахин харах гэж хойноос нь нэлээд гүйсэн боловч олж харж чадсангүй.

Ингээд тэр хоёр хөх гал сүүмэлзэн бадарсан угалзын тухай ярилцсаар цааш явлаа. "Юу вэ" гэдэг асуудал сэтгэлд нь үлдэв.

Арван цагийн үед майхандаа очиход нь нөхөд нь цуглараад хоолоо идэж байв. Тэр хоёр галт угалзын тухай нөхдөдөө ярьж өгөв. Тэгэхэд Дамдин энэ уулын савдаг, сахиусын тухай урьдын анчдын ярилцдаг гайхалтай тааврын зүйлүүдийг ярив. Шинжилгээнийхэн галт угалзын тухай зэрэг зүйлүүдийг Галдан өвгөний ярихад огт үнэмшээгүй билээ. Гэтэл хоёр нөхөд нь түүнийг нүдээрээ харжээ. Гагцхүү ямар учраас галт угалз байдаг юм бэ? гэдэг нь тааврын хуримтлалд нэмэгдэв.

Хэрэв энэ явдлыг тайлбарлалгүй таавар хэвээр үлдээгээд олонд тараавал савдгийн тухай, Бичигт Богдын эзний тухай ярианы санд нэмэр болох нь эргэлзээгүй юм. Гэтэл энэ нь тайлагдах уу? Үгүй юу? гэдэг нь одоодоо шийдвэрлэгдээгүй ажээ. Гэвч энэ удаа шинжилгээнийхэн тааварлаж чадаагүй бол дараагийн шинжилгээнийхэн эрт орой боловч заавал тайлбарлах нь дамжиггүй. Тийм боловч өмнөө тулгарсан асуудлыг гэдрэг нь тавьж, хойч үедээ үлдээх нь шинжилгээний жинхэнэ хүмүүсийн

хэрэг биш, байгалийн нууц арвин тул хойч үеийнхэнд тайлбарлах юм олонтой болно. Энэ ч учраас хөх гал сүүмэлзэн бадарсан угалзын нууцыг тайлбарлах сэтгэл хүн бүхэнд оргилно. Ялангуяа Баярын сэтгэлд тэдгээрийн тухай бодол тогтвортой эргэлдэнэ. Байгалийн нууцтай анх удаа нүүрэлдэн тулгарсан залуу инженерийн учирсан бүхнийг тайлбарлах хүсэл хэмжээгүй арвин ажээ. Харин Панов, Эрдэнэ хоёр бол олон удаа хачин сонин таавартай тулж байсан догь толгойнууд тул сэтгэлийн шунал нь Баярыг бодвол тайван юм. Гэвч өмнөө тулгарсан гайхалтай, нууц явдлыг тайлбарлах эрхэм хэргээс буцах эрдэм шинжилгээний хүмүүс юунд байх билээ дээ. Галт угалзын учрыг тайлбарлах хүсэл хүмүүсийн сэтгэлийг маажиж эхлэв. Галт угалзын тухай яриа шувтарсны дараа Эрдэнэ, притийн үс олдсон авч алт олдоогүй тухай ярил.

- Байх ёстой л юмсан даа. Та нар газрын нь байдлыг бод л доо гэж Баяр урамгүйгээр Эрдэнэ, Панов хоёрыг ээлжлэн харлаа. Өдөржин шахам ажиллаж тодорхойлсон юм нь амжилтгүй болсонд залуу геологичийн сэтгэл их л аягүй ажээ.

Анх гарахад Баяр сэтгэлдээ бараг л алхам бүрдээ арвин их юм олно гэж бодож байсан юм. Гэтэл тэр нь ажил дээр шал өөр болжээ. Баярын урамгүй нүд Пановын ажигч хараанаас мултарч чадсангүй. Панов, Баярын мөрөн дээр алгадан,

- Баймаар л газар байдаг шүү дээ. Гэвч дүрс аваачаад лабораторид шинжлэхэд бас найдвар байдаг юм. Ер нь тэгээд шинжилгээний ажилд 99 дахин амжилтгүй хоцроод харин 100 дээр нь гялалзсан амжилт олдог явдал олонтоо байдаг шүү дээ гээд Баярыг тэврэн сэгсэрнэ. Баяр үл мэдэг инээмсэглэв.

1. Галт угалз гэж юуг хэлж байна вэ?

2. Хайгуулчдад ямар ямар адал явдал тохиолдсоныг үргэлжлүүлж уншаарай.

Эх сурвалж: Ч.Лодойдамба “Алтай” роман I, II дэвтэр. УБ., 1949, 1951.

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолыг бүрэн эхээр нь уншсаны дараа ажиллах даалгавар

Зохиолыг мэдэрч ойлгож уншъя.

1. Геологичдын хатуужил тэвчээрийг шалгасан хэсгүүдийг уншаад юу гэж бодсон бэ? Жишээ татна уу.
2. Хайгуулчдад тохиолдсон адал явдлууд сонирхолтой байсан уу? Хэрэв чи бусдад ярихаар бол юуг онцолж ярих вэ?
3. Дүрүүдийн ярьсан сонирхолтой хууч яриа, домог, санаанд оромгүй үйл явдлууд таалагдсан уу? Яагаад?
4. Эрдэнийг шөнө явж байхад ямар ямар чимээ гарсан бэ? Эдгээр дуу чимээг ямар амьтад юунаас болж гаргасныг нөхөж бичээрэй.

Дуу, чимээ	Авиа гаргасан амьтан ба бусад	Юуны учир эдгээр чимээ гарав?
- “Хүүе” гэж дуудах - Инээх - Шүгэлдэх		

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэе

1. Зохиолын хэсэг тус бүрээс асуулт зохиогоорой.
2. Геологичид, сэхээтнүүдийн бүтээлч үйл ажиллагааг хэрхэн ойлгож байна вэ?
3. Байгаль, хүн чанар, хайр сэтгэл, зориг тэвчээр, тусч зангийн тухай хөндөж бичсэн хэсгүүдийг сонгон ярина уу.
4. Дуртай мэргэжлээрээ ажиллавал амжилтад хүрдэг гэдэгтэй санал нийлж байна уу? Ярилцаарай.

Зохиолын үйл явдлын холбоо хамаарлыг тайлбарлая.

1. Зохиолын бүтэц, зохиомж ямар онцлогтой байна вэ?
2. Зохиолч адал явдлыг хэрхэн бүтээв? Гүйцээн бичээрэй.
 - А. Геологичдыг айлгасан сонирхолтой дуу, авиа
 - Б. Бичигт хадны нууц
 - В. Хаалга, цоожтой хад
 - Г.
 - Д.
 - Е.

Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэе

1. Баяр, Гэрэл хоёрын үерхэл, үл ойлголцлын шалтгааныг онцлон ярилцаарай. Гэрэлийн гаргасан шийдвэрийн талаар харилцан маргаарай.
2. Баяр эрдэмтэн болно гэж багадаа хэлсэн амлалтдаа хүрэхийн тулд ямар ямар алхмууд хийсэн бэ?
3. Бусад дүрийн тухай эргэцүүлээрэй. Тэд бие биедээ яаж нөлөөлөв?
4. Дүрүүдийн ижил ба ялгаатай талыг харилцан дүгнээрэй.

Гол дүр нь хэн бэ?	Ижил талууд	Ялгаатай талууд
Эрдэнэ		
Баяр		
Панов		
Бат		

5. Дүрүүдийн зорилго, ярилцаж байгаа байдал, зан чанараас юу суралцав?

Орчин, нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг дүгнэе

1. Бичигт Богд уулын байршлыг олж тэмдэглээрэй.
 - А. Алтайн салбар
 - Б. Говийн молцог
 - В. Хангайн нуруу
2. Бичигт Богд ууланд болсон явдал Бат, Баяр хоёрын зан төрхөд яаж нөлөөлөв?.
3. Бичигт Богд ууланд ямар нөхцөл байдал үүссэн бэ? Чингис хааны цэргүүдийг зохиолч юу гэж дүгнэв? Та нар санал нийлж байна уу?
4. “Алтайд” романы үйл явдал өрнөх орчныг зураглаарай.

ЯРИХ, СОНСОХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолын талаар төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж, зохиолыг үнэлж дүгнэж бичье.

1. Уншсан тууж, романаас сонгон сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлээрэй.

Сэтгэгдлээ илэрхийлэхдээ:

 - А. Зохиолын аль хэсэгт сэтгэл чинь хөдөлсөн бэ? Яагаад? Жишээ татна уу.
 - Б. Зохиолын дүрийг ямар үед их хайрлаж, гайхаж, өрөвдсөн бэ? Ямар үг, ямар дүрслэл чамд нөлөөлөв?
 - В. Таагүй санагдсан хэсэг байна уу? Жишээ татан, сэтгэгдлээ илэрхийлнэ үү.
 - Г. Зохиолчийн үг сонголт чамд ямар санагдав? Юуг хамгийн сайн дүрсэлсэн бэ?

Мэдрэмжээ илэрхийлэхдээ:

- А. Үерийн усыг сэтгэлдээ төсөөлөөд, хоёр хүнийг гол гаргах үеийн өвгөн Дэнзэнг сайн хараарай. Юу юу их тод харагдаж байна вэ?
- Б. Зохиолоос дуу чимээ илэрсэн хэсгийг сонгон тэмдэглэнэ үү. Юу юу сонсогдож байна вэ? Хүчтэй, сул аль нь болохыг хэлээрэй.
- В. Дэнзэн өвгөний гадаад дүр байдлыг зураад, юуг мэдэрснээ яриарай.

Үнэлж дүгнэж ярихдаа:

Зохиолын сэдэв, санаа, дүр, уран дүрслэл, орчны дүрслэл зэрэгт үнэлгээ өгнө үү.

	“Үер” тууж	“Алтайд” бэсрэг роман
Зохиолч ямар сэдэв хөндсөн бэ? Ямар асуудал дэвшүүлсэн бэ? Дүгнээрэй.		
Дэвшүүлсэн асуудлаа зохиолч сайн илэрхийлж чадсан уу? Үнэлээрэй.		

Зохиолч дүрээ хэрхэн бүтээсэн бэ? Дүгнээрэй.		
Бүтээсэн дүр нь уншигчдын амьдралд нөлөөлж чадах уу? Үнэлээрэй.		
Ямар ямар уран дүрслэлийн аргыг хэрэглэсэн бэ? Дүгнээрэй.		
Уран дүрслэлийн хэрэглэсэн арга нь оновчтой, сэтгэл хөдөлгөхөөр байсан уу? Үнэлээрэй.		

2. Ярихдаа өөртөө итгэлтэй, бусдын сонирхлыг таттал яриарай.
3. Хэрхэн ярьснаа найз нараасаа асууж, зөвлөгөө аваарай.

БИЧИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Дүр орчныг хувирган, үйл явдлыг төгсгөн богино өгүүллэг зохион туршъя.

Багаараа, эсвэл хосоороо ажиллацгаая.

1. Юуны тухай, ямар асуудлыг дэвшүүлж богино өгүүллэг зохиохоо эргэцүүлээрэй.

Дэмжлэг:

- “Үер” туужийн гол санаа шиг хүний сайхан сэтгэлийн тухай
- “Алтайд” романы үйл явдал шиг сонирхолтой, адал явдалтай бичиж болно.
- “Эвэр” зохиолын гол санаа шиг алдаагаа хожим ухамсарладаг хүний тухай, ээжийгээ хайрлах учиртайн тухай
- Хүүхдүүд та бүхэн цаг үеийнхээ онцлогоос шалтгаалж, юуны тухай бичихээ, уншигчдад юуг хэлэхийг хүсэж байгаагаа илэрхийлж сэдэв, санаагаа эргэцүүлээрэй.

2. Уншсан өгүүллэг, туужуудаасаа сонгоно уу.

3. Сонгосон зохиолынхоо аль нэг дүр, эсвэл орчныг өөрчлөн туршаарай.

Дэмжлэг:

- Эсрэг дүр бол эерэг хандлагатай болгох
- Дүрийн зан төрх, дүрийн зорилго, үг, үйлдлийг өөрчлөх, дүрийн зан төрх, үйлдлийг гаргаж бичихдээ бусдыг эргэцүүлэнбодох, ухааруулах зорилгоор бичих
- Ухааруулахын тулд ямар үг хэрэглэхээ төлөвлөх
- Зохиолд тусгаснаас өөр орчинд үйл явдлыг өрнүүлж турших
- Орчныг дүрслэхдээ тэмдэг нэр, тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг хэрэглэх
- Уншигчдад хэлэх гэсэн санаа бодлоо хувиргасан орчин, бүтээсэн дүрдээ шингээн илэрхийлэх

4. Дүр, орчноо төлөвлөсний дараа үйл явдлын дэс дарааг байрлуулаарай.

Дэмжлэг:

- Эхлэл хэсэгтээ дүр, орчноо танилцуулах

- Гол хэсэгтээ үйл явдал өрнөх шалтгааныг, сонгосон баатруудад тохиолдсон үйл явдлыг, бэрхшээл, бэрхшээлийг даван туулсан түүх, эсвэл баатруудад тохиолдсон боломжууд, боломжийг зөв ашиглаж байгаа мэтээр үйл явдлыг ургуулан зохиох
 - Гол хэсэгтээ баатруудын хоорондох харилцан яриаг бүтээх
 - Төгсгөл хэсэгтээ уншигчдад хэлэх гэсэн санаагаа илэрхийлэх 5. Ноороглон бичээрэй.
6. Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагаа хянаарай.
 7. Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд дэх утга нь уялдаа холбоотой байгаа эсэхийг хянаарай.
 8. Дахин сийрүүлж бичээрэй.

Зохион бичих чадвараа дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур	Тийм	Үгүй	Сайжруулах саналтай байна.
Уншигчдад хэлэх гэсэн санаагаа дүр, орчиндоо илэрхийлж чадсан уу?			
Дүрийн зорилго, үг, үйлдлийг өөрчлөхдөө эргэцүүлэн бодох, ухааруулах өнгө аясыг шингээсэн үү?			
Орчныг дүрслэхдээ тэмдэг нэр хэрэглэн сонирхолтой бүтээсэн үү?			
Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд нь утгын уялдаа холбоотой байна уу?			
Үйл явдлыг өрнүүлэх шалтгааныг гаргаж бичсэн үү?			
Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагүй байна уу?			



ЖҮЖГИЙН ЗОХИОЛ

Энэ бүлгээс бид ямар чадвар эзэмших вэ?

- ❖ Монголын болон гадаадын жүжгийн зохиолын утга, дүрийн зөрчлийг мэдэрч, ойлгож унших
- ❖ Жүжгийн агуулга, хэл найруулга, төрөл зүйлийн онцлогийг судалж, дүрийн хөгжлийн учир шалтгааныг тайлбарлан үнэлж дүгнэх
- ❖ Зохиол дахь нийгэм, шашин, соёлын олон янз байдлыг ойлгож тайлбарлах



6. ЭНЭТХЭГИЙН ЖҮЖИГ

Уншихын өмнө:

1. Олон мянган жилийн өмнө зохиогдсон уран бүтээлүүдийг өнөө үе хүртэл унших дуртай байдгийн учрыг та нар юу гэж боддог вэ?
2. Энэтхэгийн алдарт “Шакундалаа” жүжгийн үнэт зүйл нь юу бол? Шакундалаа гэж хэн бэ? Ухаарч уншъя.

Шри Галидас

“ШАКУНДАЛААГ ТАНИХ ТЭМДЭГ” (жүжгээс)

Дэлхийн сонгодог уран зохиолын санд орсон энэхүү зохиолыг олон хэлнээ орчуулж, Лондонгийн театр зэрэг нэртэй театруудын тайзан дээр тоглож байжээ. Монгол хүн XIV зууны үеэс Төвөд хэлээр дамжин танилцаж байсныг эрдэмтэн, зохиолч, Бямбын Ринчен тэмдэглэсэн байдаг.

Жүжгийн дүрүүдтэй танилцъя.

Душьянд - Бүрүү аймгийн хаан

Шакундалаа - Ойд амьдардаг Аршийн охин

Бриянвадаа, Анасууяа – Шакундалаагийн найз охид

Алиа салбадай - Хаан Душьяндын ордны хүн

Годам – Шакундалаагийн эгч

Канва – Шакундалааг өсгөсөн эцэг, ойд суудаг Арш,
бясалгагч

Шарангарав – Канва аршийн шавь

Жанжин – Хааны өрлөг жанжин

Түшмэл – Хааны ордны хүн

Загасчин – Бөгж олдог хүн

УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолын утгыг мэдэрч ойлгож уншъя.

Дүрүүдийнхээ дотоод бодлыг сонсоорой.

Жүжгийн үйл явдал. Жүжиг 7 бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэг. Хаан Душьянд сүйх тэргэн дээр зогсон нум сумаа онилон зугтаж яваа гөрөөсний араас давхина. Хөтчийнхөө магтах үгэнд баясах хаан, гөрөөсний зугтахыг хараад, морьдын хурдыг биширч

байлаа. Намнахын даваан дээр хатамжлагч нар гарч ирэн “Авлах амьтан биш, амьдын нүглийг тэвчин соёрх” гэв. Хаан мэхийн ёсолж, нум сумаа буулгахад, хатамжлагч нар баярлан талархан “Сайн үйлийн тань үрээр сайхан үр заяах болтугай” гээд өршөөлт багш Канвагийн охин үзэсгэлэнт Шакундалаатай танилцуулахаар болжээ. Шакундалаагийн амьдардаг газарт нь очоод хөөсөн зүр нь үргэх айх юмгүйгээр, өөрийн дураар тайван, өөдөө уруугүй зорчиж байгааг, голын захаар тарьсан модод шаширлан харагдаж, модонд саатсан утаа мултарч ядан цэнхэртэхийг, мэргэд санваартангууд шувуунд тариа будаа тараахыг хараад гайхан биширч, айн эмээн, морьдынхоо амыг татаж, хөдөлгөөн явдлыг зогсоож, хээнцэрлэн өмссөн гадуур өмсгөлөө тайлж, нум саадгаа авлаа. Аашрамын гэрт орохтой зэрэгцээд охидын дуу гарсан зүг харвал “Эрдэнийн чимгээр нэвсэртэл даруулж, эдлэн хөрөнгөөр ханатал туйлж, эздийн ордонд дураар эрхэлдэг, эрх танхи ганган охидоос байгаль дэлхийгээр орон хийж, бадам цэцгээр гоёл хийсэн” аашрамд амьдардаг эгэлгүй охид байв. Модны холтсоор хувцас хийн гоёсон Шакундалаа хоёр найз бүсгүйтэйгээ цэцэг, модоо тордон усалж байхыг харсан хаан “Ордны сарнайнаас ойн сарнай илүү бус уу” гэж бодон “Уруулы нь хараач Шакундалаан, уран хөөрхөн дэлбээ мэт, мутры нь хараач түүний, мөнгөлөг туяхан гишүү шиг, цогцы нь хараач түүний, цоморлигоо дэлгэсэн сарнай шиг” хэмээн дурлан биширч, нэлээн ажиглав. Охидын ярианаас Арш Канвагийн охин болохыг, дурлалт ханиа мөрөөдөж байхыг сонсоод баярласан хаан Шакундалаатай танилцлаа.

1. Душьянд хаан ан хөөсөөр ямар газар ирсэн бэ?
2. Шакундалаа юу өмссөн гэж бичсэн бэ?
3. Душьянд юунд, хэнд дурлав? Яагаад?
4. Шакундалаагийн гоо үзэсгэлэнг тодруулахдаа ямар үг хэрэглэсэн байна вэ? Чамд хэр санагдав?

Хоёрдугаар бүлэг. Энэ бүлэгт хаан Душьяндыг ан хийсэнд дургүйцсэн алиа салбадай, нэр төр олж авахын тулд ан агнахыг дэмжиж байгаа түшмэл хоёрын зөрчлийн тухай, Душьянд хаан Шакундалаад хоргодон ойд үлдэж байгаа тухай, Алиа салбадай хааныг шүүмжилж байгаа тухай тус тус гарна. Алиа салбадай хаанд:

Тансаг харшаа орхин давхиж

Тайгын амьтдыг намнан хороох нь тандаа л зөв юм байгаа биз

Тааллын тань эсрэг юу гэхэв.

Гэхдээ би брахман болохоор

Гэмгүй амьтад гэж гүйсээр байтал

Гишгэх хөл минь цуцаж гүйцлээ

Гэдийх нуруу минь бөгтийж дууслаа.

Ганц өдөр ч болов аваа зогсоовол гань бие минь амсхийх болов уу гэж хэлэхэд хаан:

Ав хоморго зогсоо гэж ахмадын хэлдэг зөв өө

Амраг хайртай Шакундалааг бодохоос амьтныг хөнөөсөндөө би гэмшив.

Шакундалаатай наадан эрхэлдэг сайхан гөрөөсийг нь яахан намнах

билээ гэв. Энэ үед өрлөг жанжин нь хааныг харж, өөрөө өөртөө “Ан гөрөө хийнэ гэдэг амьдын хар нүгэл” гэж бодсон атлаа хаанд зориулж, гөрөөс намнана гэдэг нь эр хүний хийморь сэргэх үйл гэж магтана. Жанжин Алиа салбадай руу хандан амаа гараар хаагаад “Эзэн хааны сэтгэлд нийцэх энэ тэрийг би ярина” гэхэд Алиа салбадай “Буянт хааны ариун сэтгэлд бузар нүгэл бүү оруул, дуртай юм бол чи өөрөө хортой нүглээ өөрөө үйлд” хэмээн хилэгнэнэ. Душьянд хаан:

Алдарт сайн жанжин минь алан хядахыг цээрлээ
Араатан жигүүртэн амьтад нь айх эмээхгүйгээр яваг
Сүрэг олон зээр гөрөөс нь сүүдрээ бараадан тайван хэвтэг
Нүгэлт хар нум минь нэгхэн ч өдөр болов амраг
Цэрэг олондоо зарлан тунхагла
Хатамжлалын энэ ойд хашхираан шуугиан бүү гарга
Тайван энхийн энэ ой тайгад тахилгын гал байдгийг мэдтүгэй

Танхайран үймээн дэгдээвэл тайж ч бай, харц ч бай буруушаана гэв. Душьянд хаан Шакундалаагийн тухай “Тэнгэрийн дагинаас төрсөн гэнэ, Канва арш хажуудаа авч өсгөсөн гэнэ, сарнай цэцэг хийсэн ирээд царс модонд наалдсан шиг энэ охин энхрий хайранд өсчээ” гээд сэтгэл татагдсанаа хэлэхэд Алиа салбадай “Эрхэм дээд минь, бурам чихрээс уйдсан амьтан бусармаг гашууныг долоодгийн адил ордны ганганаас уйдаад та, ойн борхон охиныг таалах болов уу” гэж ёжлов. “Шакундалаагийн гоо үзэсгэлэн сансар хорвоод ганц” гэж итгэсэн хаан охинд сэтгэл татагдсанаа хэлж, Шакундалаа бас хаанд татагдсаныг “гэнэн томоогүй уулын охидын үнэн санааг мэдэх хэцүү, эгц харалгүй далдираад байсан нь үгээ хэлэлгүй инээмсэглээд байсан нь, сэтгэл зүрхэнд нь хайрын сум харваж, итгэл сүжиг нь оргих шиг болсон шүү” гэж тайлбарлалаа. “Тэгвэл тэр чинь танд халуун сэтгэлийн бялуу өмхүүлж, хатамжлал буяны энэ ойгоо хайр дурлалын өлгий болгоо шив” гэж зоригтой хэлнэ. Удалгүй хааны ордноос гэртээ ирэхийг сануулсан утгатай захиа ирэхэд хаан Шакундалаад хоргодон явахыг түдгэлзэн, алиа салбадайг цэргүүдийн хамт явуулна. Дахин дахин энэ газар яаж ирэх аргыг асууж байсан хаан харин алиа салбадайг явах үед Шакундалаагийн тухай очоод элдвийн юм ярих вий гэж болгоомжлон “Ариун хутагт багшид мөргөхөөр ирсэн билээ би, буяны замыг сонгосон охин дээр бусармаг харцаа тусгах гээгүй, инээдэм наадаан болгож түрүүнд ярьсныг минь өршөөнө биз ээ” гэв. Алиа салбадай “Одоо л би учрыг нь ой тоондоо ухлаа, инээдэм тоглоом хийсэн хэрэг үү?” гэжээ.

1. Душьянд хаан юунд гэмшив?
2. Хоёрдугаар бүлгийг уншихдаа хэнийг жигшиж байв? Хэнийг хайрлаж байсан бэ?
3. Шакундалаагийн хайранд өссөнийг хэрхэн дүрслэв? Ямар үг хэрэглэсэн байна вэ?
4. Алиа салбадай гэж хэн бэ? Түүний тухай хэн нэгэнд яривал юуг онцлох вэ?

Гуравдугаар бүлэг. Энэ бүлэгт хаан, бүсгүй хоёр сэтгэлийнхээ үгийг хэлэлцэн, дотносч байгаа тухай гарна. Шакундалаа хоёр найз охины хамт агуу хүчит Душьянд хаантай таарснаас хойш сэтгэл нь түүн рүү тэмүүлж байгаагаа ярилцахыг хаан сонсон, баярлана. Шакундалаа Душьяндтай уулзахыг мөрөөдөн том навчин дээр шүлгийн мөрийг хумсаараа

шигтгэн дурайлган бичих үед Душьянд хаан далдаас гарч ирэн сэтгэлээ илэрхийлж, хатнаа болгон, үр хүүхдүүдээр нь удам угсаагаа залгамжлуулах хүсэлтэйгээ хэлсэнд хоёр найз нь Шакундалаагийн өмнөөс ихэд баярлав. Ингээд Душьянд, Шакундалаа хоёр хэн хэнийхээ эцэг эхэд хэлэлгүй ойд хуримаа хийлээ.

Дөрөвдүгээр бүлэг. Энэ бүлэгт найзууд нь Шакундалааг Душьянд хаан ордондоо очоод мартчихвий гэж санаа зовж байгаа тухай, Шакундалаа хайртай хүнээ санан мөрөөдөж байгаа тухай, санасан сэтгэлээсээ болж орчин тойрноо анзаарахгүй болж, хараалчийг тоохгүй болсноос болж хараагдаж байгаа тухай, Канва арш охиноо хааны ордон руу явуулж, сургаал айлдаж байгаа тухай тус тус гарна. Шакундалаа өдөр бүр Душьяндыг мөрөөдөн суух үед гэрт нь ирсэн Дурваасаа хараалчийг анзаарсангүй. Тэрээр “Хаан Душьяндыг хараад чи хатамжлагч биднийгээ тоохоо байв уу, хайртай гэх Душьянд чинь харж үзсээр байсан ч хэлж, сануулсаар байсан ч хэнээтэй галзуу юм шиг болж, хэзээ ч чамайг бүү таниг, хээрээр орон хийж, хэцээр дэр хийж хэрэн тэнэж, зовон шаналаг” гэж хараав. Анасууяа, Брианвада хоёр найз нь хараалчаас аварч айлдахыг гуйхад бөгжөө хараад таниг гэж хэлүүлж чадлаа. Душьянд хаан явахынхаа өмнө дурсгал болгон нэрээ бичсэн бөгжөө үлдээсэн байжээ. Душьянд ордон руугаа яваад сураг чимээгүй байх үед хоёр найз нь Шакундалаад санаа зовж, түүнийг хайрласаар л байв. Хараалчийн хараалыг хүртэл эр нөхрөө санан зовж байгаа хэвлийдээ үртэй Шакундалаад хэлж зовлон дээр нь зовлон нэмэхийг хүссэнгүй, сэтгэлийг нь зовоохгүй гэж ярилцан, тэрхүү бөгжийг нь тэсвэртэй сайн хадгалахыг Шакундалаад хэлэх юм сан, хаан руу өгч явуулах юм сан гэж хүртэл санаа зовцгооно. Удалгүй Канва өсгөсөн охиноо Душьянд хааны ордон руу явуулахаар болов. Танхил охин Шакундалааг ордны гоёлд умбах нь хэмээн найз нөхөд нь баясна. Хөвчин ойтой хүйн холбоотой учраас “нэг мод нь намирсан саарийг хөврүүлж, нөгөө мод нь нарийн савхин гутал гаргаж” өгч байна. Шакундалаа хариуд нь “Навч цэцгээрээ ноён мэлрэг минь, намайгаа тэврэн өршөөн соёрх, аав минь та үүнийг арчлан хамгаалж байгаарай, миний тавьж байсан хайрыг мартуулж ердөө болохгүй шүү” гэж захиана. Канва аав нь ч ханийн заяагаа түшсэнд итгэж, охиндоо аз жаргалыг ерөөв. Охиныг Канвагийн их шавь Шарангаравын хамт хөдлөх агшинд хошуу аманд нь угж углан тэжээж, хондлой биеий нь илэн таалан өсгөсөн хонгор үр шигээ хайрлаж явдаг хөөрхөн бяцхан янзага нь хөлнөөс нь салахгүй чаргууцалдан байна. Канва эцэг нь хааны ордонд очоод мөрдөх сургаалиа ийнхүү хайрлав.

Хадам эцэг эх дээдчүүдээ халамж тавьж, хүндлэн ёсол
Хажуугийн хатад гүнжнүүдтэйгээ халуун сэтгэлээр дотно нөхөрлө
Хань нөхөртөө үнэнч байж хардаж сэрдэхээс холхон яв
Албат зарц дагуул олонд ая зүйтэй өрөвчхөн ханд
Хаан буянд ташууран бардамнаж харилцах зангаа бүү өөрчил
Өшөө хорсол муу санаа бүү өвөрлө
Өөрийгөө бүхний дээр бүү тавь

Энэ бүхнийг сахиж дагаваас эргэх цагт хатан ээж болно

Эс чингэж эсрэгээр үйлдвээс энэ бие удам угсаагаа бузарлана гэжээ.
Хоёр найз бүсгүй нь “Хаан Душьянд чамд хааш яаш хандвал, нэрээ

сийлсэн бөгжий нь нүдний нь өмнө бариарай” гэж захилаа.

1. Дурваас хараалч яагаад хараав? Зөв үү?
2. Хараалч ба Шакундалаа хоёрын нөхцөл байдлаас ямар уур амьсгал мэдрэгдэв?
3. Шакундалаагийн найз охидоос эерэг ямар зан чанарыг олж харав?
4. Шакундалаа байгаль эхтэй хэрхэн харилцаж байна вэ? Ямар санагдав?
5. Канва эцгийн сургаалыг дахин уншина уу. Та нар хэрхэн хүлээн авч, юуг ойлгож байна вэ?
6. Хоёр найз бүсгүй нь “Хаан Душьянд чамд хааш яаш хандвал, нэрээ сийлсэн бөгжий нь нүдний нь өмнө бариарай” гэж хэлэхэд Шакундалаа юу бодсон бол? Таамаглаарай.

Тавдугаар бүлэг. Энэ бүлэгт Душьянд хаан өөрийн ордондоо Шакундалааг танихгүй, хөөж байгаа тухай, Шакундалаа бараа бологчийн хамт хааныг буруутган хөөгдөж байгаа тухай гарна.

Хааны ордонд Шакундалаа бараа бологчийн хамт ирэхэд Душьянд хаан таньсангүй. Шарангарав,

Эрдмийн далай Канва багш эзэн танд ийн соёрхуулав аа
Хоёр биеийн сэтгэл нийлж та хонгор охин Шакундалаатай нь
Өвөг дээдэст мэдэгдэлгүй өөрсдийн дураар хуримласан гэнэ
Хөвч дэлхийн эзэн хаан таныг хүргэнээ болгоход зохимжтой гэж
Хүүхэн үр Шакундалаагаа хүний ёс шажин төрийг дагана гэж итгээд
Та хоёрын нууц хуримыг таалж соёрхсон гэнэм, тэрээр
Заяа тавилан нь тохирсон ийм хос замбуулин хорвоод ховорхон гэнэ
Таны хатан Шакундалаа энэ байна, таалан соёрхон өргөн авна уу.

Давхар биетэй байгаа болохоор даамай сайн анхаарах буй за гэж хэлэхэд хаан машид гайхан, “Хий хоосон энэ явдлыг хийх нь байтугай бодоо ч үгүй, худал бузрыг надад тулгах гэсэн хуудуухан бодлоор та нар иржээ, бутач хүүхэд төрүүлэх буянаа яахин хуваалцах билээ?” гэж бухимдан хариулав. Шакундалаа дотроо “Нийлж ханилсан гэдгээ нэгэнт няцааж байгаа хойно итгэл найдвар минь хоосон болж, эргэх хорвоод төөрчээ би” гэж өөрийгөө зэмлэн бодно. Улмаар “Бүрүү удмын хаантан та буяны аашрамд морилохдоо болчимгүй гэнэхэн надтай богтлохын ёсыг гүйцээгээд цэцэгт сүүдрэвчийн дотор цэнгэн жаргаснаа оргүй ингэж мартана гэдэг огтоосоо байж болох уу?” гэж санаж бодсоноо хэлж, үлдээсэн бөгжийг нь үзүүлэх гэтэл замдаа ариун нуурт орж байхдаа гэсэн байлаа. Хаан бүр ч итгэхээ больж, амттай үгээр уяруулах улс байна гэж хэлтэл Шакундалаагийн бараа бологч Гоудам “Буяны газар өссөн охинд булхай бузар яаж байх вэ?” хэмээв. Шарангарав, Гоудам хоёр Шакундалааг буруутган ордонд орхин буцах тэр агшинд хүүхэн хүн шиг хурц гэрэл хурмаст тэнгэрээс бууж ирээд Шакундалааг өргөж аваад явав.

1. Душьянд яагаад Шакундалааг таньсангүй вэ?
2. Гоудамын “Буяны газар өссөн охинд булхай бузар яаж байх вэ?” гэж хэлснийг юу гэж бодож байна вэ?
3. Шакундалаа, Душьянд хоёрын харилцаанаас юуг мэдрэв? Мэдэрснээ илэрхийлээрэй.

4. Шарангарав, хааны ордонд Шакундалааг үлдээхдээ хэрхэн буруутгасан бол? Таамаглаарай.

Зургаадугаар бүлэг. Энэ бүлэгт хаан бөгжөө харснаар Шакундалааг санаж, хөөж явуулсандаа гэмшиж, ухаарч байгаа тухай, Индра хүүгийн гуйлтаар дайсныг нь дарж байгаа баатарлаг явдлын тухай тус тус гарна.

Тор дэгээгээр загас барьж, тогоогоо тосолдог нэгэн ядуу загасчин том загасны гэдэснээс эрдэнийн бөгж олж, зах дээр зарах гэж яваад ордны цэргүүдэд баригджээ. Хаан бөгжийг үзээд тэртээ мартсан явдлаа санан, зүс царай нь жигтэйхэн болжээ. Хаан Шакундалаагаа хөөсөндөө өөрийгөө зэмлэж, хаврын уламжлалт баяраа хорьж, ор дэрнээсээ ч босохгүй, унтах идэхээ ч огоорч, ажил албаа ч ярьдаггүй, амраг хатдаасаа хөндий болж, амнаас нь гагц Шакундалаа гэдэг болжээ. “Угалзан хуй босовч уул хангай хөдөлдөггүй, урамгүй явдал тохиолдовч ухаант нэгэн гутардаггүй, энүүхний төлөө гонсойх нь эр хүний шинж биш” гэж алиа салбадайг хэлэхэд хаан ийнхүү гэмшинэ.

Надад хөөгдөөд гарахдаа тэр маань нандин сэтгэлд нь сүүдэр харваж
Хэчнээн өрөвдөлтэй байсны нь хэлж ярихы нь ч хэрэг алга
Хөөж туугаад болохгүй болохоор хүргэсэн улсаа дагаж билээ
Багшийг нь орлосон Шарангарав баалж түүнийг буруутгаад
Эрийн гэрт чи үлдэх ёстой эргэх газар чамд байхгүй гэхэд
Хөөрхий амьтан тэндээ зогтусаж хоёр нүд нь нулимсанд живсэн юм.
Хорсол дүүрэн ширүүн харц нь хорт сум шиг намайг харваж

Өнөө болтол би тэр суманд өрөө зүсүүлэн зовж явнам гээд энэ бүхэн хаягдсан бөгжөөс боллоо гэж хэлэхэд алиа салбадай “Энэ хаанд чинь л одоо эргүү солио тусах нь уу” гээд

Нуруу шулуун намайг нумлан бөхийлгөх чинь юу вэ гэж

Энэ муу таягандаа ч би эгдүү гомдол гаргах хэрэг үү” гэж хааныг ёжлов. Хаан,

Ухаж санахгүй энэ эд ч яахав
Ухаант хүний төрлийг олсон би
Хайрт амрагаа гомдооно гэдэг
Хаацайлах аргагүй хилэнц буюу
Чи минь наддаа эргэж ирээд

Чимэг хорвоог баяслаар дүүргээч гэж өөрийгөө буруутган өршөөл гуйв. Төд удалгүй Индра бурхан өөр лүү нь дайрдаг тэрслүү аймгийг дарж авахыг хүсэж, хаан ёсоор болгон, дайтан ялав.

1. Шакундалаа бөгжөө хаана хаясан байв?
2. Хаан бөгжөө үзээд юу бодсон бол? Таамаглаарай.
3. “Энэ бүхэн хаягдсан бөгжөөс боллоо” гэхэд алиа салбадай юу гэж ёжлов? Та нар энэ үед юу бодож байсан бэ?
4. Өршөөл гуйж байгаа хааныг буруутгаарай, эсвэл зөвтгөөрэй.

Долоодугаар бүлэг. Энэ бүлэгт Душьянд хаан төрсөн үрээ олж, хайрт хатнаасаа уучлал эрж байгаа тухай гарна.

Сүйх тэргэнд суугаа хаан Душьянд дээд тэнгэр Индрагийн зарлигаар тэрслүү аймгийг дарж агаараас бууж ирнэ. Их мэргэнээр адислуулахаар

хангалуун амьдралаар жаргахаас илүү хатамжлал бясалгалын ёсыг сахидаг орноо Ашок модны сүүдэрт түр амсхийх болов. Хаан дээш харан,
Баруун нүдний дээд зовхи байн байн татаад байх чинь
Баясгалант явдал тохиолдохын бэлгэ дэмбэрэл ч биш биз
Аманд орсон шар тосыг хэлээрээ түлхэв гэх шиг
Азгүй би бээр амраг хайртай Шакундалаагаа аргагүй гомдоон явуулсан даа

Шакундалаагаа эргэж олно гэдэг санаснаар бүтэхгүй хэрэг биз ээ хэмээн дээшээ харан бодож байтал нэгэн хүү арслангийн зулзагыг дэлдэн чангаасаар гарч ирнэ. Хоёр хатамжлагч “Байг, байг” гэж хориглох авч үл тооно. Хаан хүүг хараад нэг л дотно санагдаж, хатамжлагч нарынхаа үгэнд орохгүй байгаа хүүхдийн гараас татан ярилцаад үзэхэд Шакундалаагийн хүү байсныг мэдлээ. Хүүгийн хамгаалах сахиус газарт унасныг үзээд автал хатамжлагч нар айн сандарч, хүү болон төрүүлсэн аав ээжээс нь өөр хүн хүрдэггүй, хүрвэл эрээн могой болон хатгадаг гэдгийг хэлэв. Хаан төрсөн үрээ олж, “Хүү минь, хүү минь” хэмээн энгэртээ наан эрхлүүлэв. Шакундалаа ч Душьяндын гэмшиж байсныг сонссон тул бие биеэ өршөөн уучилна. Хаан,

Сэтгэл татсан хань минь

Чамайгаа гомдоосон ёсгүй явдлыг чи минь мартаж намайгаа өршөө

Хүн яахаараа заримдаа мунхарч хөндлөнгийн хүчинд сохроор мунхарч

Сайхан бүхнээ умартан мунхарч саар бүхэнд өртөн будилдаг вэ?

Өнөөдөр ингээд учран золгох өлзий ерөөл байсан аж.

Шакундалаа,

Хайрт хань минь намайгаа хамаагүй нэг мартсан биш болох нь

Урд хийсэн миний үйлийн үрээр урагшлах замд минь садаа орж гэхэд

Заяа дээд эзэнтэн минь заларч дээшээ өндийгтүн

Замбуулин хорвоод урт насалж, удаан жаргаарай хэмээн хэлэв.

Эх сурвалж: Галидас “Шакундалаа” (Хинди хэлнээс Ж.Гэндэндарам). УБ., 1991.

1. Шакундалаа хүүтэйгээ ямар оронд амьдарч байсан бэ?
2. Арслангийн зулзагыг дэлдэн чангааж яваа хүүг хаан хараад юу бодсон бол? Таамаглаарай.
3. Хүүгийн хамгаалах сахиус ямар учиртай байв?
4. Шакундалаа яагаад Душьяндыг өршөөсөн бэ? Та нар Шакундалаагаас юу суралцав?
5. Душьянд хаанд хүний сайхан ямар чанарууд байна вэ? Тоочоорой.

Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэе

1. Дараах эшлэл жишээг уншаад, юуны тухай зохиолч хөндөн бичсэнийг зөв харгалзуулаарай.


1	Энэ гөрөөсийг бүү намнагтун Их нямбатны дархан гөрөөс Авлах амьтан тань энэ биш Амьдын нүглийг тэвчин соёрх	а	Хүн төрөлхтөн байгалиасаа шим тэжээл авч, байгаль эхийнхээ хүчинд амьдардаг гэсэн санаа.
2	Бүрүү удмын Душьянд хаан та Буяны үгийг таалан сонсож Булбарай гөрөөсийг өршөөсөнд Баярлаж талархсанаа илэрхийлье Сайн үйлийн тань үрээр Сайхан үр заяах болтугай	б	Хүний ёс зүйн тухай, зөв явах учир утгын тухай өгүүлсэн.
3	Нэг мод нь бидэнд Намирсан саарийг хөврүүлж өгөв Нөгөө мод нь бидэнд Нарийн савхин гутал гаргаж шидэв...	в	Шударга, зөв бодлоготой хаант төрийн тухай өгүүлжээ.
4	Төрийн жолоог атгана гэдэг Түвдэх сэтгэлийг амраахаас биш Төрсөн цогцыг алжаан зовоох Тэргэшгүй хүн ачаа буюу Хаантан та хар аминыхаа төлөө бус Харц олныхоо төлөө алжаах ёстой	г	Хааны ордонд суугч ихэс дээдсийн муу зан суртахууныг шүүмжилсэн утгатай.
5	Хадам эцэг дээдчүүдээ Халамж тавьж хүндлэн ёсол Хань нөхөртөө үнэнч байж Хардаж сэрдэхээс холхон яв Өшөө хорсол муу санаа бүү өвөрлө Өөрийгөө бүхний дээр бүү тавь	д	Байгаль ан амьтнаа хайрлах асуудлыг хөндсөн.
6	Эзний ёсоор шажин төрөө хөгжөөж Эцгийн ёсоор харц олноо асардаг нь Эзэн Душьяндын хүсэл зориг ажээ.	е	Мууллаа гэж гуьндаггүй, магтууллаа гэж онгирдоггүй хүний сайн зан чанарын тухай өгүүлсэн.
7	Харц олон хаад дээдэс гэж ялгахгүй Хамаг бүгдээр адил хэмтэй байдаг нь Хаант төрийн дэг жаяг буюу	ё	Харц олон, шажин төрөө дээдэлдэг сайн хааны тухай өгүүлсэн.
1д, 2..., 3..., 4..., 5..., 6..., 7...,			

2. Дээрх утга санаануудаас хамгийн чухал гол санааг аль нь гэж бодож байна вэ?
Дараах тулгуур дохиог ашиглаад, зохиолын гол санааг тайлбарлаарай.

Багаар ажиллах дасгал

- Зохиолын гарчгийн утгыг бодно. Яагаад зохиолч Шакундалаагийн нэрээр нэрлэв?
- Зохиолч Шакундалаагийн дүрээр уншигчдад юуг хэлэхийг хүссэн бэ?

Бүдүүвч дээр тулгуурлаарай.



3. Яагаад хамгийн чухал гол санаа гэж үзэв? Бусад хөндөгдсөн асуудлууд гол санааг гаргахад хэрхэн дэмжлэг болов? Гол санааг хадгалсан үйл явдлыг бусад дэд асуудлууд яаж хөгжүүлснийг дэлгэрүүлж яриарай.
4. Зохиолчийн дэвшүүлсэн гол асуудал юу болов? Дараах хариултаас сонгоод, яагаад ийнхүү үзэж байгаагаа зохиолоос жишээ татан нотолно уу.
 - А. Хайр дурлалын тухай
 - Б. Төрийн хүний тухай
 - В. Байгалиа хайрлах тухай
 - Г. Үнэнч сайхан хайр сэтгэлийн тухай
 - Д. Ёс суртахууны тухай

Сурагчдын жишиг яриа:

Зохиолын... энэ хэсэгт (эсвэл энэ дүрд) бичсэнээс үзэхэд зохиолч ... ийм утга санааг шингээж энэ дүрийг бүтээсэн байна. Хэрвээ зохиолч энэ дүрийг бүтээгээгүй байсан бол зохиолчийн дэвшүүлсэн ...ийм асуудал тодрохгүй байх байсан гэх мэт.

Зохиолч Галидас хамгийн нандин сэтгэл болсон хайр дурлалын асуудлыг дэвшүүлэхдээ нийгмийн амьдрал, хүмүүжлийн орчин, байгаль хүн хоёрын салгахын аргагүй нэгдэл дунд дүрслэн үзүүлжээ. Ингэхдээ Шакундалаа Душьянд хаан хоёрын холбоо харилцаагаар гаргасан. Бусад дүр нь эдгээр дүрийг тодруулсан байна гэх мэт.

5. Зохиолчийн дэвшүүлсэн гол асуудалтай санал хэр нийлж байна вэ?
 - А. Тийм
 - Б. Үгүй
6. Шакундалаа, Душьянд нарын дүрийг орчин үеийн хүмүүсийн хандлага, харилцаатай харьцуулбал та нар юу гэж хэлэх вэ?


Дүрүүдийн холбоо хамаарлыг тогтооё.

1. Бүдүүвч зурагт зохиолын дүрүүдийг нэрлэн, дүр бүрийн хоорондох холбоог зурж, тэмдэглэнэ үү.
2. Хамгийн их холбоотой дүрүүдийг улаан өнгөөр холбон зурж, ямар үзэл бодлоор холбогдож байгааг тайлбарлаарай. Хэн нь хэнээсээ учир шалтгааны хувьд

шалтгаалж, дүр байдал нь тодорч байна вэ?

Хэрвээ дүр ингээгүй байсан бол ийм байдалд орохгүй байх байсан гэх мэтээр ярилцана уу.

3. Бие биеэсээ хамаарч байгаа ямар дүрүүд байна вэ?



Дүрүүдийн үг, үйлдлээс зан чанарын өсөлтийг дүгнэе.

1. Харьцуулах дүрээ сонгоорой.
2. Сонгосон дүрийнхээ дотоод бодлыг мэдрээд, хэлсэн үг, хийсэн үйлдлүүдийг түүж бичээрэй. Хүснэгтийг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй.

Сонгосон дүрийн нэр	Дотоод бодол нь:	Сонгосон дүрийн нэр	Дотоод бодол нь:
	Хэлсэн үг нь:		Хэлсэн үг нь:
	Хийсэн үйлдэл нь:		Хийсэн үйлдэл нь:
Хоёр дүрийн зан чанарын ялгаатай тал нь:			
Хоёр дүрийн зан чанарын ижил тал нь:			

3. Аль дүрээс нь зан чанарын хувьд юуг суралцсанаа ярилцаарай.
4. Д.Равжаагийн «Саран хөхөөний намтар» жүжгийн Номунбаясгалан хан хүүгийн хоёр хатны дүртэй Шакундалаагийн дүрийг харьцуулж, адил ба ялгаатай талыг дүгнээрэй.
5. Зохиолч аль аль дүрүүдээр дамжуулж, өөрийн үзэл бодлыг хэрхэн яаж илэрхийлснийг хэлэлцээрэй.

Орчин нь дүрийн зан төрх болоод зохиолын сэдвийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тайлбарлан үнэлье.




Түлхүүр нэр томьёо:

Түлхүүр нэр томьёо: Орчин гэдгийг ойлгохдоо зохиолч тодорхой зорилгоор дүрийг илэрхийлэхийн тулд ямар нэг орчин, орон зайг сонгон дүрсэлдэг. Жишээлбэл, Шакундалааг байгальд ойр болгон, тэнгэрийн оронд гэж орчныг сонгон бүтээснээрээ түүний эвдрээгүй сайхан зан чанар, ариун нандин сэтгэлтэйг тодруулсан юм. Тиймдээ ч Душьяндыг уучлуулж, ан амьтадтай ярилцуулж, ой модыг гуньж байгаагаар зохиосон аж.

Зохиолч тодорхой зорилгоор дүрээ бүтээхийн тулд ямар нэг орчин, нөхцөлийг төсөөлөн бичдэг.

1. Жүжгийн үйл явдал хаана хаана өрнөж байна вэ?
2. Зохиолыг уншихад ямар орчин төсөөлөгдөж байна вэ? Яагаад ингэж төсөөлөв? Зохиолын аль үгээс ийнхүү төсөөлөв?
3. Зохиолчийн төсөөлсөн орчин, нөхцөл нь гол санааг гаргахад ямар үүрэгтэй орсон байна вэ? Хэр үнэн санагдсан бэ?
4. Дараах бүдүүвчээс мэдээлэл боловсруулан илтгээрэй. Орчин нь дүрийн зан төрхийг тодруулж байна уу? Мэтгэлцээрэй.



5. Мэтгэлцэхдээ дараах асуудлыг ярилцаарай.
 - А. Шакундалааг ариун сайхан сэтгэлтэй гэж гаргахын тулд ямар орчин (орон зай)-г зохиолч сонгов?
 - Б. Душьянд хаан үргэлж тэнгэрийн эсвэл ойн орчинд байсан бол хайртай хүүхнээ гомдоох байсан уу?
 - В. Ордны өрлөг жанжин зөв үйлдэл хийсэн үү? Ордонд амьдарснаараа буруутай юу? Үгүй юү?

Нөхцөл байдал нь дүрийн зан төрхийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тайлбарлан үнэлье.

1. Зохиолын ямар нөхцөл байдал дунд дүрийн зан төрхийг тодруулж гаргасан байна вэ? Дараах жишээг ашиглаарай.

...Душьянд хаан ойд амьдрах охидыг хараад,
 Хээрийн энэ сарнайнууд хэмжээлшгүй гоц увдусаараа
 Байгалийн мод цэцэрлэгийг барьц алдуулан согтооноом
 Эрдэнийн чимгээр нэвсэртэл даруулж
 Эдлэн хөрөнгөөр ханатал туйлж

Эздийн ордонд дураар эрхэлдэг
 Эрх танхил ганган охидоос
 Байгаль дэлхийгээр орон хийж бадам цэцгээр гоёл хийсэн
 Аашрамд амьдардаг эдгээр охид
 Аргагүй л нэг давж байна
 Ордны сарнайнаас ой сарнай илүү бус уу...

- Хараалч Дурваасыг тоохгүй байх үеийн нөхцөл байдал ямар байсан бэ? Шакундалаагийн ямар зан төрх ялгарч байна вэ?
- Шакундалаа Душьяндтай зохиолын эхлэл, гол, төгсгөл хэсэгт тус тус өөр өөр орчин нөхцөл байдалд уулзсан байдаг. Тодруулж ярина уу. Ялгаа нь юу байна вэ? Тэдний хоорондох таагүй уур амьсгал аль үед хэрхэн илрэв? Зохиолч яаж ямар үгээр бичив? Тэдний хоорондох таатай, эерэг дулаан сайхан харилцааг ямар байдлаар бичив? Та нар яаж мэдэв? Ямар үг тэрхүү уур амьсгалыг мэдрэхэд нөлөөлөв?

Уран дүрслэлийн үүргийг нарийвчлан шинжилье.

- Уран дүрслэлт хэсгүүдийг уншаад, зохиолч ямар зорилгоор ийнхүү бичсэнийг задлан шинжлээрэй.

Юуг дүрсэлсэн бэ?	Яаж урнаар дүрсэлсэн бэ?	Зохиолчийн зорилго юу байв?
Шакундалаагийн амьдардаг ойн байдлыг	“Модонд саатсан утаа Мултарч ядан цэнхэртнэм”...	Утааг мултарч ядан гэж амьшуулж дүрсэлснээр зохиолч модны гоо сайхан, цаашлаад тэр орчны байгалийн гоо сайхныг магтан дуулах зорилго тавьжээ. Утаа хүртэл саатмаар сайхан мод, сайхан ой юм гэдэг хэтрүүлэлт уран санаа илэрчээ. Ийм л орчинд Шакундалаа амьдардаг гэдгийг үзүүлэхийг зорьжээ.
Душьянд хааныг сайхан үг хэлэхэд Шакундалаагийн баярлаж байгааг	“Хараач найз минь Шакундалаагийн баярлаж байгааг Аагим халуунд тарчилсан тогос Аадрын хурд сэргэдэг шиг Түймэрт идэгдсэн модыг Тэнгэрийн хур тэтгэдэг шиг	Тогос болон модны байдлаар хэний ямар байдлыг адилтган дүрслэв? Энэ дүрслэл зохиолын утга болон дүрийг тодруулахад үүрэгтэй байна уу? Зохиолч ямар зорилгоор ийнхүү дүрслэв?

Жүжгийн харилцан ярианы үүргийг нарийвчлан шинжилье.

- Зохиолч ямар зорилгоор харилцан яриаг ийнхүү өрнүүлэв?

А. Шакундалааг ордон руу явах үед ийн харилцан яриа өрнөжээ.

Канва,

Авралт хангай лусын эзэн минь аашрамын мод навч цэцэгс минь
Та нарыгаа услан тордохоос өмнө тавлан ууж цайгаа ч уудаггүй
Навч дэлбээг чинь илбэн таалдаг атлаа нэгийг ч болов

тасалж гэмтээдэггүй

Анхны чинь цэцэг жимс цухуйхад алаг үрээ үзсэн юм шиг баясдаг
Алагхан хонгор Шакундалаа чинь өнөөдөр харь хадамд
очихоор боллоо.

Шарангарав,

Хөвчин ойтойгоо цуг байсаар бид хүйн холбоотой болжээ бид
Хөөрхөн хөхөөнийхөө уянгат эгшгээр хүүхэн Шакундалаагаа үдлээ

Бриянвада,

Аашрамаас салан одож байгаад анд минь чи ганцаараа гуниглаагүй
Амтлах хивэхээ мартан алагхан цоохондой гансарнам
Тоглох бүжихээ цэглэн тогос шувууд гонсойном
Алтан навчаа унаган аашрамын модод уйлнам

Шакундалаа,

Мэргэн дээд эцэг минь өршөө
Мэлрэг цэцгэн дээр очоод би
Мэхийн ёсолж уучлал гуйя
Аав минь та үүнийг арчлан хамгаалж байгаарай

Б. Шакундалааг ордонд очиход Душьянд хаан таниагүй, хэлсэн үгэнд нь
үнэмшихгүй байх үед ийм харилцан яриа өрнөжээ.

Гоудам,

Их эзэн хаан минь, ингэж яаж болох вэ?
Буяны газар өссөн охинд булхай бузар яаж байх вэ?

Хаан,

Хөхөө шувуу үр зулзагаа хөөрхий хэрээгээр асруулдаг шиг
Буяны газрын ухаантай байтугай бөглүү ойн барлаг хүүхэн ч
Төрөлх бач мэхээрээ түмнийг дөнгөдөг ёс бий.


Шакундалаа,

Худал хуурамчийн балчиг чи өөрийгөө
Хорвоогийн амьтантай зүйрлэх гэж үү?
Шударга үнэний өмсгөл дор хурж
Шажин ёсны бамбайгаар халхалж
Сүүн сэтгэлт гэмгүй олныг
Сүрлээр хучсан зангандаа унагаах
Чам шиг ийм бузар амьтан замбуулин хорвоод хаана байна?

2. Зохиолыг бүрэн эхээр нь уншаарай. Уншихдаа харилцан яриа бүр ямар үүргээр,
зохиолчийн ямар зорилгоор бүтээгдсэнийг бодож уншаарай.

Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцье.

Алхам 1. Уншсан жүжгийнхээ дэвшүүлсэн асуудал болон хам сэдвүүдийн талаар дахин эргэцүүлэн бодно уу.



Мэтгэлцэх сэдвүүдээс сонгоно уу.

- Душьянд хаан маш сайн удирдагч мөн.
- Жүжгийн хамгийн гол дүр бол Алиа салбадай юм.
- Орчин цагийн хүн ба өр нимгэн сэтгэл, хайр

Алхам 2. Сэдвийн дагуу судалгаа хийнэ үү. Нийгэм, түүхийн холбогдолтой мэдээ, баримтыг сурвалжлан дэлгэрүүлэн уншина уу. Баримт, нотолгоог мэтгэлцэхдээ хэрэглээрэй.

Алхам 3. Нотлогч, няцаагч талууд цуглуулсан нотолгоонуудаа боловсруулж, хариултыг бэлдэнэ.

Алхам 4. Мэтгэлцэхдээ нотлогч тал асуудлыг нотолж, няцаагч тал тодруулж асууж болно.

Мэтгэлцэх чадвараа дараах шалгуураар үнэлнэ үү.

Шалгуур	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай гэж бодож байна.
Бусдын саналыг ойлгож, мэдэрсэн үү?			
Мэтгэлцээнд зөрчлийг шийдвэрлэж чадсан уу?			
Нийгэм, түүхийн хам сэдвийн хүрээнд хамгийн үнэ цэнтэй нотолгоог дэвшүүлж чадсан уу?			
Идэвхтэй оролцоотой сонсох чадвартай байж чадсан уу?			
Өөрийн үзэл бодлоо бусдад ойлгуулж чадсан уу?			
Шүлгийн утга, сэдэвтэй холбоотой түүхэн баримтуудыг сурвалжлан уншсан уу?			
Санаа бодлоо нотлох, эсвэл бусдын саналыг няцаахдаа жишээ баримт хангалттай ашигласан уу?			

Зохиолын сэдэв, утга санаа, дүр дүрслэлээс сонгон, баримт жишээ ашиглан, үнэлж дүгнэж бичье.

1. Жүжгийн үйл явдлын дарааллыг зураглан бататгая.
2. Жүжгийнхээ сэдэв, утга санаа, дүр, дүрслэлийн алиных нь тухай бичихээ бодоорой.

Дэмжлэг:

А. Сэдэв, утга санааны тухай сонгосон бол ямар асуудлыг дэвшүүлснийг жишээгээр батлах, соёл, түүх, нийгмийн хам сэдвийг хөндсөн бол зохиолоос жишээ татах, ямар сэдэвтэй зохиол гэж үзсэнээ дүгнэж бичээрэй. Ингэхдээ түүх, нийгэм судлал, соёлын тухай мэдлэгтэй холбож, жишээ баримтаар өргөжүүлж болно.

Б. Дүр, дүрслэлийн тухай сонгож бичихээр бол ямар дүрийг ямар үг хэрэглэн, дүрсэлснийг зохиолоос жишээ татан бичих, зохиолын эхнээс аваад дуусах хүртэлх дүрийн зорилго, зан төрхийн өөрчлөлт зэрэгт үнэлгээ дүгнэлт өгч бичээрэй. Жишээ нь:

Душанд хааны зорилго нь байсан учраас зохиолын эхэнд ...ийм дүр төрх, зан байдалтай байсан. Харин зохиолын гол хэсэгт бодол нь ийнхүү өөрчлөгдсөн учраас ...ийм шийдвэр гаргасан, энэ нь миний хувьд зөв эсвэл буруу санагдлаа. Учир нь зохиолд бичжээ. Дүрийг тодруулахад ...энэ үг их хүчтэй сэтгэгдэл төрүүллээ гэх мэтээр бичиж болно.

3. Ноороглож туршаарай.
4. Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаа байгаа эсэхийг хянаарай.
5. Дахин сийрүүлж бичээрэй.

Шалгуур	Тийм	Үгүй	Сайжруулах шаардлагатай
Зохиолд дэвшүүлсэн асуудал болон соёл, нийгэм, түүхийн тухай асуудлыг тусгасан жишээг зохиолоос олж сонгож чадсан уу?			
Зохиолын сэдвийг тодорхойлж, дүгнэж чадсан уу?			
Дүрийг тодруулсан үг хэллэг, уран дүрслэлийг зохиолоос авч хэрэглэн, бичиж чадсан уу?			
Зохиолын эхнээс дуусах хүртэлх үйл явдлаас дүрийн зан төрх, зорилгын өөрчлөлтийг ажиглаж, дүгнэж чадсан уу?			
Үнэлгээ дүгнэлт чинь жишээ баримтаар батлагдсан байна уу?			
Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагүй байна уу?			

1. Бичих болон ярих, сонсох чадвараа сайжруулахын тулд юун дээр илүү анхаарах шаардлагатай байв?
 - ✓ Зохиолоос оновчтой санаа, эшлэл авч санаагаа дэмжин бичих, ярих
 - ✓ Бусдад дэмжлэг болохуйц идэвхтэй сонсогч байж, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх
 - ✓ Хэл ярианы сонголт, нүүрний хувирал, хөдөлгөөнийг ашиглаж сурах
 - ✓ Утга зохиолын хэлний дүрэм журам, уламжлалыг ойлгож, бичиж найруулахдаа оновчтой хэрэглэж сурах
 - ✓ Өөрийн үзэл бодлоо илэрхийлж бичиж сурах
2. Уран зохиолыг шинжлэхэд хэрэг болохуйц ямар ямар ойлголтуудыг гүнзгийрүүлж судлах шаардлагатай байв?
 - ✓ Уран зохиолын төрөл зүйлийн онцлогийн тухай
 - ✓ Айзам хэмнэл, холбоцын тухай
 - ✓ Дүрслэх хэрэглүүр (хэтрүүлэл, тойруулал)-ийн тухай
 - ✓ Хам сэдвийн тухай
 - ✓
3. Үгийн урлагийн сонгодог бүтээлээс өөрт хэрэгтэй ямар ямар зүйлийг сурч эзэмшив?
 - ✓ Эртний үг хэллэгийг мэдэж, бичиж ярихдаа ашиглаж, үгийн сангаа баяжуулах
 - ✓ Дүр, санааг үгээр хэрхэн урладаг аргаас сурах
 - ✓ Хэлц үгийн толь хөтөлж, тайлбарлах
 - ✓ Үгийн далд утгыг ойлгож, тайлбарлах
4. Өөрийн амьдрал ахуйдаа хэрэглэж болох ямар санаа авав?
 - ✓

9 дүгээр ангидаа уншсан зохиолуудынхаа талаар дараах цахим хаягийг ашиглан дэлгэрүүлж уншиж, судалъя.

1. Д.Мягмарын “Үер” туужийг сонсох хувилбар 1-р хэсэг
<http://mglradio.com/home/audiocontent/128318>
1. Д.Мягмарын “Үер” туужийг сонсох хувилбар 2-р хэсэг
http://mglradio.com/home/index.php?mid=audiocontent&listStyle=list&page=1&document_srl=128323
2. “Монголын нууц товчоо” зохиолын бүрэн эх
www.mglnews.mn/content/read/8508.htm
3. Зохиол болон зохиолчдын намтрын талаарх мэдээлэл
<https://mn.wikipedia.org/wiki/Гэсэр>
4. Яруу найргийн зохиолуудын бичлэг
<https://www.youtube.com/user/MongolianVideos>
5. Б.Ринчен “Нууцыг задруулсан захиа”(сонсох ном)
<https://www.bookstore.mn/index.php/abmore/2065>

Сурагчийн лавлах

Айзам	Шүлэглэсэн зохиолд тодорхой хугацаанд давтагдах эрэмбэлэгдсэн хөдөлгөөн, бадаг, шадын хоорондын төсөө бүхий хэллэгийн тодорхой эрэмбэт давтамжид суурилсан зохирол. <i>С.Байгалсайхан Уран зохиол шинжлэлийн удиртгал УБ., 1995. 107 дугаар тал)</i>
Багасгал	Юмсын бага хэмжээ чанарыг тод болгохын учир жижиг тийш нь хэтрүүлэн дүрсэлснийг багасгал гэнэ. <i>(Ш.Гаадамба “Утга зохиолын онолын үндэс” УБ., 1989, 130 дугаар тал)</i>
Бэлгэдэл	Эхэн үедээ сайн сайхныг мөрөөдөн итгэж бишрэхийн үүднээс нэг бодит юмс үзэгдлийг нөгөө зүйлээр төлөөлүүлэн бэлгэдэн шүтэж байсан ард түмний сэтгэлгээтэй холбоотой байсан байна. Сонгодог утга зохиолд энэхүү чанар нь аажмаар гүнзгийрэн утга санаа, дүрийн зан төрхийг бэлгэдэн үзүүлэх гүн, нарийн утгатай болж иржээ. <i>(С.Байгалсайхан Уран зохиол шинжлэлийн удиртгал УБ., 1995. 102 дугаар тал)</i>
Давталт	Уран сайхны зорилгоор үг, хэллэг, өгүүлбэр, шад, бадгийг дахин давтах уран маяг. Давталт утга гүнзгийрүүлэх, дүрслэлийг хүчжүүлэх, эрчимжүүлэх, утга салгах, нэгтгэх, хэмнэл хэмжээ тааруулах, зохиолын баатрын хувийн онцлогийг гаргах, уран сайханжуулах... зэрэг олон үүрэг, хэв маяг бүхий хувилбаруудтай. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 119 дүгээр тал)</i>
Далд (гүн) утга	Алив бичвэр ил хийгээд далд утгын давхар бүтэцтэй. Далд утга зохиолын өгүүлэмжээр шууд илэрдэггүй, тусгай судалгаа, тайлал, тайлбар (интерпретация) хийхийг шаардана. Зохиолч уран дүр, өгүүлэмжээр дамжуулан уншигчийн сонирхлыг татах ба тэрхүү үйл явцыг дагаж бүрдсэн өнгөн утгын гүнд зохиолчийн гол санаа буюу гүн утга цогцлон бүрэлддэг. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 120 дүгээр тал)</i>
Дуулалт жүжиг	Шүлэг болон жүжгийн зохиолыг олон нийтэд хүргэхийн тулд аялгуулан хэлэх, үйл явдлыг жүжиглэн үзүүлэх өвөрмөц аргыг хүн төрөлхтөн эртнээс нээн олжээ. Монголчууд дуулал шүлгийн төдийгүй дуулалт жүжгийн өв уламжлалтай. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 135 дугаар тал)</i>
Егөөдөл	Юмс үзэгдлийн гол мөн чанар, аль нэг шинжийг шууд утгаар бус харин эсрэг утга болгон сэргүүлж гаргах, тэдгээрийн хооронд агуулагдах зөрчлийн эрчмийг ихэсгэх, уран сайхны шоглолын аргыг егөөдөл гэнэ. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 142 дүгээр тал)</i>
Ёгтлол	Олон талаараа төстэй үзэгдлийг нэгийг нь нөгөөгөөр орлуулан бичиж, хэлснээсээ өөр зүйлийн тухай утга санаа далдуур гаргах дүрслэлийг ёгтлол гэнэ. <i>(Ш.Гаадамба “Утга зохиолын онолын үндэс” УБ., 1989, 132 дугаар тал)</i>
Ихэсгэл	Юмсын онцлог тал, чанар шинжийг гойд товойлгох зорилгоор үнэн байдалд байгаагаас нь хэт их болгох чиглэлээр үгийн утгыг шилжүүлэн хэрэглэхийг ихэсгэл гэнэ. <i>(Ш.Гаадамба “Утга зохиолын онолын үндэс” УБ., 1989, 129 дүгээр тал)</i>
Нөхцөл байдал	...Дүрийн өсөлт, зан араншин, үйл хэрэг, сэтгэл санааны байдал, амьдралын орон зай, зөрчил тэмцлийг өрнүүлж шийдэхэд тохирсон, уран сайхны аргаар бүтээсэн орчин ахуйн хүрээллийг хэлнэ. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ, 2012 он, 250 дугаар тал)</i>

Өгүүлэг	Нэг гол баатартай, эсвэл цөөн тооны туслах дүрээс бүтдэг. Гол төлөв баатрын амьдрал, үйл хэргийн нэг жижиг хэсэг, учрал тохиолдлыг өгүүлэх ба цаг хугацааны хувьд амьдралын нэгэн агшин хормыг харуулж, түүгээрээ хүн-нийгмийн утга чанартай анхаарал татсан эгзэгтэй нэг гол асуудлыг хөндсөн байна. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 275 дугаар тал)</i>
Өчил	Зохиомжийн нэг зүйл. Үглэл яриа нь өөрөө өөрийн явдлын тухай өөртөө ярих ярианы нэг хэлбэр, гадагш илэрдэггүй, баатрын сэтгэлийн дотоод яриа юм. Баатар тайван амгалангаар тунгаан бодох, сэтгэл эргэж хөрвөх, учраа олохгүй самгардалд орох, сандран тэвдэх, харамсах, уйтгарлах, санагалзах, бодлогошрох зэрэг сэтгэл хөдлөлийг илэрхийлнэ. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 285 дугаар тал)</i>
Роман	Туульсын зохиолын дотор агуулгын их багын хэмжээгээр их туулийн дараа орох шүлэглэсэн эсвэл үргэлжилсэн үгийн (хүүрнэлийн) зохиолын нэгэн төрлийг роман гэнэ. Романы дотор хүмүүсийн аж төрлийн түүх, нийгмийн зан суртахууны зураглал, анги нийгмийн нөхцөл байдлын дүрслэл, элдэв янзын хүний зан байдлын зэрэг өргөн дэлгэр дүр зургийг туурвин зохиосон байдаг. <i>(Ш.Гаадамба Утга зохиолын онолын үндэс. УБ., 1989 он, 192 дүгээр тал)</i>
Тойруулал	Бодит үзэгдэл юмсыг шууд бус далд (битүү) утгаар өөр үгээр орлуулан илэрхийлдэг арга. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 350 дугаар тал)</i>
Толгой холбох ёс	Шадын эхний авиа ба үе, үг, холбоо үгийг ижил болоод ойролцоо, төсөөтэй дуудлага, үгийн дуудагдах хэмжээгээр шадын эхэнд ижилсүүлэн холбох аргыг хэлнэ. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 350 дугаар тал)</i>
Тууж	Тууж нь хэмжээгээрээ өгүүллэгээс том, романаас бага. Өгүүлэг баатрын амьдралын нэгэн үе агшин, учрал тохиолдлыг үзүүлдэг бол тууж нь гол дүрийн амьдралын аль нэг талыг сонгож, харьцангуй чөлөөтэй өгүүлдэг. Ер нь тууж бодит амьдрал, дүрийн оюун санааны ертөнцийг уран сайхны аргаар нээхэд тохиромжтой, туульсын зонхилогч төрөл зүйл. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 359 дүгээр тал)</i>
Төлөөлөл	Шинж байдлаараа адил төсөөгүй боловч ямар нэг талаараа холбоотой хоёр үзэгдлийг тэмдэглэсэн хоёр үгийн нэгийг нөгөөгөөр нь орлуулан түүнд утгыг нь шилжүүлснээр товч бөгөөд уран яруу илтгэх хэрэглүүрийг төлөөлөл гэнэ. <i>(Ш.Гаадамба Утга зохиолын онолын үндэс. УБ., 1989 он, 135 дугаар тал)</i>
Туурь	Хурц зөрчил, хураангуй өгүүлэмж, үйл явдлын эргэлт бүхий уран тайллаараа ялгардаг богино хэмжээтэй хүүрнэл зохиолыг туурь гэнэ. <i>(Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл), УБ., 2012 он, 362 дугаар тал)</i>
Уран асуулт	Уран найруулгын асуух маяг нь уншигчдаас хариу авахын тулд биш, харин тэдний анхаарлыг уг дүрсэлж байгаа зүйлд хандуулахын тулд зохиол дотор асуусан байдалтай найруулсныг асуух маяг гэдэг байна. <i>(Ш.Гаадамба Утга зохиолын онолын үндэс. УБ., 1989 он, 139-р тал)</i>
Хэмнэл	Шүлгийн жигд айзам хэм. <i>(С.Байгальсайхан Уран зохиол шинжлэлийн удиртгал УБ., 1995. 109 дүгээр тал)</i>
Юмшуулал	Амьтан хүнд байгаа шинжийг амьгүй юм үзэгдлийн нэрээр урлан дүрсэлж хурцаар илтгэх сөрөг хэрэглүүрийг амьгүйчлэл буюу юмшуулал гэнэ. <i>(Ш.Гаадамба Утга зохиолын онолын үндэс. УБ., 1989 он, 138 дугаар тал)</i>

Ном зүй

1. Амартүвшин.С "Уран зохиол шинжлэлийн орчин үеийн арга, үзэл баримтлалууд" УБ., 2005
2. Байгалсайхан.С "Уран зохиол шинжлэлийн удиртгал" УБ., 1995
3. Байгалсайхан.С "XX зууны монгол өгүүллэгийн туурвилзүй" УБ., 2010
4. Гаадамба.Ш "Утга зохиолын онолын үндэс" УБ., 1989
5. Галидас "Шакундалаа" (Орчуулсан Ж.Гэндэндарам), УБ.,1995
6. Галбаатар. Д "Уран зохиолын нэвтэрхий толь (онол, түүх, шүүмжлэл)" УБ., 2012
7. Галбаатар.Д "Уран зохиолын задлан шинжилгээний онол, арга зүйн ойлголтууд" УБ., 2011
8. Дагвадорж.Ч "Уран утгын яруу тайлал" УБ., 2003
9. Дамдинсүрэн.Ц, Цэнд.Д "Монголын уран зохиолын тойм" II УБ., 1976
10. Дулам.С "Монгол Гэсэрийн туужийн домог зүйн удиртгал, өгүүлэмжийн бүтэц". "Монгол судлалын чуулган" УБ., 2017, №22, 123-126-р тал)
11. Kathryn Stockett. The Help (Hardcover). (shelved 2 times as high-school-literature) UK.,2009
12. Лхагва.Ж "Эвэр" (Монгол уран зохиолын дээжис 46-р боть, УБ.,1998, 310-312-р тал)
13. Лхагвасүрэн.Б "Боржигины бор тал" ("Хос уянга" УБ.,1991, 9-11-р тал)
14. Lois Lowry. The Giver (shelved 3 times as high-school-literature) USA., 1993
15. "Монголын нууц товчоо" УБ., 1986
16. "Монголын орчин үеийн уран зохиолын түүх" IV боть, УБ., 2014
17. Монгол уран зохиолын дээж бичиг (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн). УБ., 2011, 102-103-р тал.
18. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив (Эрхлэн хэвлүүлсэн Ц.Дамдинсүрэн) УБ., 1959, 60-73-р тал, 181-183-р тал.
19. "Монголын уран зохиолын товчоо" III боть. УБ., 2007
20. Мягмар.Д "Үер", Монголын уран зохиолын дээжис 108 боть (40-р боть) УБ., 2005
21. Нямсүрэн.Д "Дөрвөн цаг" ("Хаврын урсгал", УБ., 1984, 21-р тал)
22. Ринчен.Б "Нууцыг задруулсан захиа" (Б.Ринчен "Гүнж" түүвэр УБ.,1969, 61-84-р тал)
23. Сампилдэндэв.Х "Монголын шинэ үеийн уран зохиолын туурвилзүйн зарим асуудал" УБ., 2006
24. "Утга зохиол шинжлэл" МУБИС, Утга зохиолын тэнхим УБ., 2004
25. Уэльк, Уоррен нар "Утга зохиолын онол" УБ.,1998
26. "Уран зохиол, соёмбо нэвтэрхий толь" УБ., 2012
27. "Уран зохиол VIII", УБ., 2009
28. "Унших-1" УБ., 2002, "Унших-2" УБ., 2003
29. Хаадын үндсэн хураангуй алтан товч (МУИС) УБ., 2002, 58-60-р тал
31. Хөвсгөл.С "Өрнө дахины уран зохиол" (түүхэн найрууллууд) УБ., 2006
32. Цэвэл.Я "Монгол хэлний товч тайлбар толь" УБ., 1966
33. Цэвээндорж.Д. "Монголын утга зохиолын дүрийн онол" УБ., 2008
34. Д.Цэдэв "Тавын даваа" УБ., 1983
35. Цэнд.Д "Монголын уран зохиол" 10, УБ., 1978
36. Энхбаяр.С "Утга зохиолын онол" УБ., 2011